

**ЭРТНИЙ ЧЕХ
ДОМОГ ТУУЖ I**

Йираасек Алоис

Йираас ек Алоис

ЭРТНИЙ ЧЕХ ДОМОГ ТУУЖ

Тэргүүн дэвтэр

“УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ХЭРЭГ ЭРХЛЭХ ХОРОО” Улаанбаатар
хотноо 1965 онд эрхлэн хэвлүүлсэн номыг

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн
газарт 2020 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

Уг номыг “Болор дуран” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

Б
БОЛОР ДУРАН 2.0
АЛДА ШАЛГУУР

**"БОЛОР ДУРАН"
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР
БОЛОР

Alois Jirasek

STARÉ POVESTI CESKÉ

Z cestiny přeložil akademik [prof. dr. Rincen](#)

Чех хэлнээс академич [др. проф. Ринчен](#) орчуулав.

Черны Венцеславын зурсан зураг

Бид Йираасект ханддаг — тэр хүн бидэнд дотно хүн бөгөөд хуучин хөрөнгөт нийгэмлэгээс бидэнд илүү ойр дотно хүн, зохиолдоо манай ямар уламжлал нь урагш удирдаж, ард түмний бадралд хүргэдгийг бидэнд маш чадамгай үзүүлсэн байна. Түүний зохиол нь биднийг манай өнгөрсөн түүхийг зөв үзэхийг сургаж, манай ардын өөрийгөө мэдэх мэдлэгийг зузаатган, түүхийн үүднээс юмыг зориг бадран сайхнаар үзэх үзэлтэй болгож, ард түмний бүтээлч хүчинд итгэх итгэл төрүүлэх зохиол болой.

Готтв альд Клемент

ОРШИЛ

Энэ [Йираасекын Алоис](#) зохиолыг чех нутагт мэдэхгүй хүн байхгүй. Нутагт нь хүн бүр тэр эрхэм бичгийн хүнийг хүндэтгэн нэрээр нь нэрлэхгүй багшийн нутаг, багшийн музей гэр, багшийн хэрэглэж байсан юм, явж байсан газар, багшийн тэр тэр зохиолд гардаг хот балгас шилтгээн орд гэж хэлэлцэхийг би чихээрээ сонсож, нүдээрээ үзэж, түүний нутгаар 1956 оны намрын сүүлээр явахдаа, эх орон, ард түмэндээ хайртай тэр их зохиолчийг ард олон нь чингэж хүндэтгэдэг юм байна гэж бахдан үзэж явлаа.

Чингээд, зохиолоос нь монгол уншигч олондоо шууд чех хэлнээс нь өөр ямар нэгэн хэл дамжуулалгүй орчуулж танилцуулах юм сан гэж, нух нухсаар энэ нэгэн дэвтэр, «Эртний чех домог тууж» гэдгийг амтархан үзэж, чадан ядан орчуулсаар одоо хэвлэлд өгч ах дүү улсын нэг алдарт зохиолчийн сайхан зохиолын дээжээс хайрт монгол олон уншигчдын ширээний өмнө толилуулах завшаан олдсонд сэтгэл бахдаж, үүгээрээ ах дүү, ард түмний харилцан мэдэлцэх явдалд зохиолчийн хувиар өчүүхэн нэмэр болох гэсэн санаандаа хүрлээ гэж чех хэл өөрөө Улаанбаатартаа үдшийн шөнө нухсаар сурсныхаа хэрэг бүтээх асан гэж мэрийснийхээ эцэст хүрсэндээ баярлаж, намайг эрдэм сурах бололцоо олгосон түмэн олондоо ачийг нь хариулахын өчүүхэн нэгэн зүйл болгон толилуулав. Манай уншигч олон, Йираасек багшийн олон боть зохиолоос энэ нэгэн дэвтрийг сонирхон уншиж, миний адил амтархах болбол, манай уншигчдын номын тавиур ташингатад ах дүү улсын нэгэн алдарт зохиолчийн нэг сайн зохиол нэмэгдлээ гэж миний хүсэл ханах нь тэр бөгөөд бас хүсэх минь, энэ завсар чех хэл мэдэх болж, Чехословак улсад утга зохиолын сургууль хийсэн монгол залуучууд бий болцгоож байгаад нэнд баярлаж, залуугийн зориг төгөлдөр тэднийг номд дуртай монгол уншигч олондоо чех хэлнээс Йираасек болон бусад олон сайн зохиолчдын зохиолоос орчуулах болоосой гэж нэнд хүсэн хүлээнэ.

Алоис Йираасек бол 1851 онд Хронов гэдэг хөөрхөн сайхан бяцхан хотод төрөөд 1930 онд нас барсан билээ. Эцэг эх нь ядуушиг улс байжээ. Эцэг нь талх барьдаг хүн байсан гэдэг.

Дунд сургууль төгсөөд Йираасек Прагын их сургууль төгсгөж, Литомышл гэдэг хуучин түүхт хотноо түүх зааж, хожим хорин жил Прагад багшилсан байнам. Түүний зохиол-олон роман нь чех түмний

эрх чөлөө, тусгаар тогтнолоо баатарлан тэмцсэн түүхээс үндэслэсэн сэдэвтэй бөгөөд ардын засаг мандсанаас хойш чехийн ард түмэн тэр эх оронч их зохиолчийнхоо дурсгалыг нэн ч хүндэтгэж, зохиол, роман, жүжгийг нь үргэлж хэвлэдэг болжээ.

Чехийн нэрт эрдэмтэн Неедлы Зденекийн бие энэхүү эртний чех домог туужийн сүүлд төгсгөл үг бичсэнийг уншигч нөхөд уншин үзвээс, миний олон таван үг нуршсаны хэрэг илүүц биз ээ гэж хэдэн үгийн товч оршлыг үүгээр төгсгөж, уншигч олны амрыг эрэн, Йираасекийн энэ сайхан зохиолыг уг зохиолчийн адил сайхан үгээр хөрвүүлж эс чадсандаа хүлцэл өчив.

1961 оны намрын адаг сар

Ринчен



Хуучид өдрийг сэтгэн амуу би.
76 (77) т амалга.

Эрт цагийн домгийг айсан сонсмуу. Манай элэнц хуланц өвгөд дээдэс яахин манай нутгийн захад хүрч, Лаба Влтав зэрэг тэр нутгийн мөрөн гол дагуу оршин суусныг сонсмуу.

Балар эртнээс бас уламжилсан үг сонсож, хөгшин хөвчийн харанхуйд онгодоо тайж, нам гүм хөндийн булаг ус, нуур гол, ариун бадрангуй галаа тахиж байсан өнгөрсөн үеийн хүмүүсийн үлгэр шиг үг ярианаас үлдэж ирснийг сонсмуу.

Манайхныг энд бий болохоос урьд энэ нутгийн маань байдал ямар байсныг, мөн анх тэр үеийн эхэн нэгэн цагийн байдлыг дурдмуу.

Хот балгад байсангүй билээ. Гацаа тосгон өөр хэлтэн хуучин нутгийнхны үлдээд байсан зарим нэгэн буйд газар л хааяа ховор цөөхөн, архай тархай байж, анжисны хошуу шигдээгүй газар атаршиж, эвгүй зэлүүд, гуу жалга, тал хөндий байж билээ.

Зузаан их ой хөвч уул бүрхээд, нам руу навсайн бууж хар шивэр ой дунд намирсан өтгөн өлөн өвс цоорхойгоор нь налран ургаж, ой

талаар тоо томшгүй балчиг бамбалзууртай, усны шувуу донгодсон өдий төдий хөлгүй өрх намаг болсон газартай, буурал хөвд хаг сагсайн ургасан бүдүүн хөгшин мод өнхийсөн, чив чимээгүй айдас хүрэм харлан харагдавч хүлэрт шавар балчиг өдий төдийтэй байсан билээ.

Хүний мөр маш ховор, ан гөрөө элбэг, багтаж ядтал өсөн үржиж байсан гэдэг. Хингэнэн бужигнах түмэн зөгийт хөндий модон хонгилд зөгийн бал хараачилж, хар шивэр модонд баавгай, зэрлэг бодон гахай, ойн хөрсийг хага урвуулан, сүлжилдсэн өтгөн зулзаган модон дундуур үнэг цоохондой гүйлдэж, модны гишүү дээрээс гавшгай шилүүс, булгийн зүг буюу усны гармын зүг чиглэж яваа бух гөрөөсний алсын мөөрөх чимээ дуулдаж байгаа зузаан ойг хурц нүдээр ширтэнхэн харж, марал дагуулсан буга гүйн өнгөрч, бор гөрөөс нугаар бэлчин, хөвч хөдөөгөөр хүйлэн хөх чоно олз идэш хайн давхицгаадаг байж гэнэ.

Нармай тэнгэрт уул хөвчийн дээгүүр жигүүртний эзэн хадын бүргэд, шадар жигүүртэн нь халин нисэж, хад уул, ой модонд махчин шувуу, начин шонхрын аймаг, харцага турамтай, ууль шар шувуу мэт бичил махчин шувуу үүрлэдэг байжээ. Гол горхи, нуур усанд загас дүүрэн. Зэрлэг сургар сүлжин ургасан нигүрс, уд модны ёроолоор байдаг халиу цадталаа загас агнаж, үргэж жигшиж үзээгүй минж, уран барилга далангаа саадгүй барьдаг байжээ. Урсгал гол усны чимээ нь сайхан модны шуугиантай нийлж, цайвар цагаан элсэнд нь энд тэнд улбар шар алт наранд гялалзах бүлгээ.

Дэлхийн баялаг нь хөрсний гүнд нээгдээдүй, уурхай ордыг уудалж, ховор төмөрлөгийг эрэх эзэнгүй эрин цаг байжээ.

Газар сайгүй дэлхийн их баялагтай, атар их үржил чадалтай газар шороо, ашиглах чадалтай хүн олныг хүлээсээр байсан байжээ.

Тэр эзэн улс нь хүрч ирээд, атрыг нь эдэлж, газар дэлхийгээ хүнд хүчир хөдөлмөрөөрөө эрхэм дээд болгож, олсон газар нутаг, хэл үгээ хамгаалж, олон тулаанд урсгасан цус, хөдөлмөр зүтгэлийнхээ хөлс гоожуулснаараа нутаг усаа амилан ариулсан байнам.

Слован эх нутаг уснаас тэр зүг улс олон, Чех гэдэг удирдагч сарт ваахиараа манлайлуулан ирсэн юм шүү, манай өвгөд дээдэс.

Тэдний домгийг үүсгэн өгүүлсүгэй.



ЧЕХ ЖАНЖНЫ ДОМОГ

I

Татра уулын тэртээ, Висла мөрний хөндийгөөр эрт балар цагаас Слован их нутгийн зах хорват нутаг байсан билээ. Тэр нутагт хэл ёс, аж төрөх байдал төстэй аймаг улс оршин суудаг байжээ.

Тэгээд өөр зуураа нутаг ус, гацаа тосгоноо булаалдан эвдрэлдэж, цус урсган байлдан, омог омгоороо тулалдан төрөл садан, төрөл саднаа байлдаж, тэмцэлдэн алалджээ.

Тэр цагт чадал ихт нэг омгийн ах дүү Чех Лех хоёр сэнгүн жанжин, дайн дажинд эрстсэн нутгаасаа нүүн зайлахаар хэлэлцээд, манай омгийн хүн олон энх төвшин жаргал эдлэх шинэ нутаг ус эрэн хайя гэж тогтжээ.

Өвгөд дээдсийн үеэс тариа төмс тарьж, бод бог мал өсгөж сурсан омог байж гэнэ ээ. Тэгээд нутаг сонгох гэж хэлэлцсэн ёсоор хөдөлж, хоёр жанжин айл аймгаа хуралдуулж, тэнгэр тахиж, онгодоо залаад, өвгөдийн газар шорооноос хагацаж, нар шингэх зүг, үл таних газар чиглэн зорив гэнэ. Отог отгоор хөдөлж, ах дүү нөхөр садан сэлтээр нүүдэл хийж, түрүүнд нь туршуулчин, зэвсэгт эрс, дунд нь буурал

сахалтай чилгэр чийрэг Чех жанжин, дүү Лех жанжин явж, дэргэд нь бага ноёд омгийн дарга нар цөм хазаар морьтой, хойноос нь эмгэд өвгөд, эмс хүүхэд хасаг тэргэнд суух нь сууж, морь унах нь морь унаж, малаа туух нь тууж, адаг сүүлээр нь мөн зэвсэгт эрс хамгаалан явж, ойр төрөл аймгийн нутгаар анх өнгөрөн гараад, хорват нутгийн захад гарч, Одер мөрөн гатлаад уул ихтэй урьд үзээгүй таниадүй газрын захад ортол, хэл нэгтэй айл суурин дайралдаж, Лаба мөрөн хүрэхэд мөн тийм байсан гэдэг.

Цаашаа бас нэг мөрөн гаталтал, газар нутаг улам буйд зэлүүд болоод, айл амьтан ховордож, хааяа нэг дайралдавч, хүний хувцас хунар нь саарь сармай, хэлэх хэл нь мэдэгдэхгүй болж, тоо цөөн боловч зориг чанд, зэвсэг барин замыг нь хөндөлсөн хориглох болж гэнэ. Чех Лех хоёр цэрэг эрийн хүчээр тэднийг дарж, ядуу овоохой, нүхэн гэрт суудаг тэднийг хядан талаад, нэг захын хөвч модноос нөгөө захын хөвч дамжин цаашилсан гэдэг.

Тэгж явахад ширэнгэ их мод дундуур явах зам тун бэрх, зэгс өлөн өвс ширэлдэн ургасан намаг балчиг, шавар бамбалзуур туулахад хэцүү. Харанхуй мод дунд араатан гөрөөс үргээх гэж үдшээс өглөө болтол түүдэг гал өрддөг байжээ.

Тэгж явсаар буйд зэлүүд газраар урсдаг Влтав гэдэг гуравдугаар мөрөн усанд хүрч, олом гаталсан хойно, улс амьтан амар заяа үзэхгүй, захгүй их замд зовсноо тоочин гаслаад, Чех жанжин, харц олноо тайтгаруулж өргөн талын тэртээ цаана хөхрөн харагдагч өндөр уул заагаад,

— Тэр уулын хормойд хүрч, хүүхэд шуухад, хөсөг малаа амраана гэж Жийп гэдэг уулын хормойд хүрч буугаад, жанжин ахмад өтгөс, тэр хавийн газар шороог шим ургац сайтай гэж шинжин үзлээ. Тэгээд Чех сэнгүн жанжин үүрээр босож, ганцаараа Жийп уулын орой дээр үүрийн шөнийн бүрэнхийд чив чимээгүй байгаа модон дундуур явж гараад, үүр манхайтал цайсан үеэр үзвэл, зах хязгаар нь үзэгдэхгүй нүд алдам өргөн уужим нутаг алсын хөх уулс хүртэл налайж харагдаад, ой шугуй, тарианы газар, бэлчээр нуга үзэгдэн, ширэлдэм их өвс, ногоо дундуур голын ус, гоожуулсан мөнгө шиг гялалзан цайлзан үзэгдэх ажээ.

Элэнц их өвөг Чех, сэтгэл тэнийх тэр нутаг үзээд, тэнгэр юу заяаж, тэр нутаг усанд отог омог, ач үр нь ямар суух бол? гэж бодлого болоод, доошоо бууж, буцаж ирээд, нутаг үзэцгээн сэтгэлдээ машид

таашаан, гол нуур загасаар элбэг, газар шороо шим сайтай, нүдэнд дулаан нутаг байна. Оршин суухад зохистой байна гэжээ.

Тэр газар хүрч хоёр хоноод гурав дахь өглөөний мандах нарнаар Чех, дүүгээ, ахмад өтгөсийн хамт дуудан ирүүлээд, отог омгийн олныг зарлан цуглуулж, тэр нутгийн байдал үзэгдэх газар дагуулан гаргаад,

— Оршин сууж, орон сууцаа босгох нутаг ус олсон учир одоо та нарын гомдол тасрах цаг ирлээ. Эрэл хийсэн нутаг маань энэ дээ. Заан олж өгнө гэж байсан газар нутаг минь чухам энэ мөн. Хүсэл бүрдсэн нутаг ан шувуу элбэг, бал бурам бялхсан хангай маань энэ бий. Өстөн дайснаас хамгаалах өнөр элбэг орон дэлхий тань, сэтгэл сэргээн өмнө тань байна! Ганц нэргүй л юм даа. Ямар нэр нутагтаа өгөх вэ? гэхэд, олон ахмад өтгөсийн хамгийн ах зах, өл буурал урт сахалт нэг өвгөн, онго орсон юм шиг өндөр дуугаар

— Таныхаа нэрээр нэрлэе! гэж дуудваас, ахмад өтгөс, эгэл олон бүгд нэгэн дуугаар,

— Таныхаа л нэрээр нэрлэнэ!

— Таны нэрээр нэрлүүлбэ! гэхэд, олны тэр саналд Чех жанжин сэтгэл баясаж, отог омгийнхоо шинэ нутаг болсон газраас сөгдөн адис аваад өндийн босож, гараа занган өргөн нутгийг ерөөж,

— Бидэнд заяасан ариун нутаг юугаан ёсолмуу! Маныхаа энх тунх, өндөр сайхан оршуулж, үеийн үед, үүрдийн үүрд тэтгэн хартугай! гэжээ.

Тэгээд цагаан бөсөөр ороож, уг нутгаасаа заяаж явсан онгодоо баярлан босгож, их түүдэг гал асааж, тайлга тахилга хийж, бүгдээрээ баярлан найрлаж гэнэ ээ.

II

Чингээд бүгдээрээ төвөгтэй хүнд ажил хийх болж, газар шороо хуваагаад, боловсруулах болжээ. Ой мод байсан газар огтлох модыг нь огтолж, түймэрдэхийг нь түймэрдэж, хожуул сугалж нуга зүлэгтэй газар ухаж, хойтон жил нь анжсаар хагалжээ.

Орон сууц модон байшин босгож, сүрлээр дээвэрлэхдээ, омог бүр тус тусдаа оноосон газартаа суурилсан гэдэг.

Цэцэрлэг хөдөө нуга газар нь омог нийтийн өмч байсан бөгөөд, ой мод, бэлчээр, гол нуур нь хүй нийтийн эдлэх газар байж, нэг гацаанд нэг омог байсан байжээ.

Гацааны төв хүйс тойруулан шивээ хүрээтэй буюу бургас сүлжиж барьсан хашаатай айл өрхийн сууц нь ардаа малын хашаа пүнз саравч, тариа хураах цайруулах газартай байсан бөгөөд, жил ирэх тусам суурин газрын орчин тойрон тариалан нэмэгдэж, тариа будаа ургах нь улам их болж байлаа. Хөх будаа, буудай, арвай, нохойн хошуу хар будаа өргөн их тарианы газар ус мэт долгион ганхаж эрээн намуу цэцэг тарьсан газар газрын хажуугаар өндөр олс, уяхан маалинга ногоорон ургах болжээ...

Нуга газар эм дом модны ой дунд балт зөгий шунгинаж, үүрээ модон хонгилд буюу сүрэл гэр, модны хөндийд засдаг байжээ. Жил ирэх тусам хонь өсөж, гацаа тосгоны ойр агтын хашаанд хурдан унага давхилдан, сайхан гүү идээшилдэг болжээ.

Олны сонгосон ахлагч нь омгоо захирч өв өмчийг нь зонхилон эрхэлж, омгийн өмнөөс мөргөл залбирал хийж, тайлга тайж, зочдыг дайлж, хэрэг зориг шалган ялгаж, хүн бүрийн хийх ажил төрөл хуваан оноодог байжээ. Хүн бүр дор дороо хийх юм, суух сууцтай, эмс гэрийн ажил эрхэлж, ёрог зотон нэхэж, өмсгөл баринтаг уут, нөхөгчдийн жанч, эр эм хүний хувцас, дотуур өмд, нөмрөг, дах, үстэй дээл оёцгоож, эрс мал сүргээ маллаж араатнаас хамгаалан тарианы газар ажиллаж, ойд ав хийж нууцад сууж харван жадлах буюу урхи нүхэнд оруулж гөрөөлөхөд ялангуяа сүргийн дайсан чоно тэрүүнд их ордог байжээ.

Хөдөө тосгонд хөлтэй хөхиүн байж билээ. Бэлчээрээс үлээвэр цоор буюу монгол урт бүрээний чимээ сонстож, зүлэг нуга, жимслэгээс залуусын дуу хангинаж, гагцхүү жин үдийн огт чимээгүй болдог цав цагаан нөмрөг нөмрөн, талаар бараг сүүдэр мэт дэгдэж, айл гацааны зүг, эзэнгүй орхисон хүүхэд хорлох гэж үдийн эмс гарч, хүн амьтанд цорхирон уйлах өвчин тусгагч, ижил буруу нүдтэй, том гэгчийн толгойтой муухай гэгчийн зэрлэг эмс хөдөлж, оройдоо титэмтэй, цагаан баринтагтай ойн сайхан охид үзэгддэг цагаар гацаа тосгоноо нэг ч хүн аймшиггүй дуулж гиншдэггүй байжээ.

Амьтан тэднээс айж бас хүнийг унтуулаад, нүд ухдаг шулам эм, намаг балчигт хөх гал сүүмэлзүүлдэг албин чөтгөрөөс болгоомжилж, дүрсээ хувиргаж хөгшин мод сөөгийн сүүдэрт хүнийг тосож байдаг усны эзэн лус оршдог бөгөөд ногоовор баринтагтай цайвар зүстэй, мөн хүн амьтан хорлох дуртай усны охид байдаг нуур, ойн хар усыг айн тойрч, холуур зайлан гардаг байлаа.

Нэн их эмээдэг нь аянгын эзэн Перүнээс, мөн түүний аянга цахилгаанаас «тэнгэрийн элч» гэх зэргийн хүчтэй чөтгөр хүний бие зовоож, яс оюунд гэм учруулагч тэднээс айн ширвээдэж, гуйн аргадаж, булаг шандад өргөл барьц барьж хар тахиа бусад тагтаагаар тахиж, ялангуяа малын тэнгэр Велесийг мал сүргийг тахал зовлонгоос хамгаалж, өсгөн үржүүлэхийг залбиран тахидаг байжээ.

Гацаа суурины хүрээ шивээ дотор амьтны айх зовох нь арай бага байсан нь, орон гэрийг буурал аав ээж гэдэг эцэг өвгөдийн онгод сахиж, дүр сүлд нь голомтын хойморт залаатай байдаг билээ. Гар хөлдөө хумстай, бяцхан хүний дүрстэй жаалхан онгон, гэр оронд өлзий ээлтэй гэж тахиатай, голомтын эзэн онгон гэж айл аж ахуйг харж хамгаалан, мал сахиж тэвээрүүлж байдаг боловч, гэрт шөнө хүн унтуулдаггүй, тийм нэгэн онгон байдаг байжээ. Гэрт зуух буюу босго дор гэрийн урт хайрхан өвгөн эзэн хэвтэж байгаа цагт өрх өлзийтэй, айл хутагтай байдаг байжээ.

Намар цаг навч зулгарч, гадна манан татаж, газар хөлдөөд цас дарах үес амьтан хаалттай цонхтой, намхан адартай уужим модон байшинд овооролддог билээ.

Чулуугаар цогцолсон том зуух, байшин халааж, голомтын задгай галын гэрэлд орон сууцад саруул болж, улаан цогийн туяа нь бараан шир татсан бамбай, тор, нум, шилүүсээр бүрсэн модон ховд, богино юлд, лут жад хүнд чулуун алх өлгөөстэй, хананд гялав гялав хийж, буга, бух гөрөөсний эврийн тахир махир сүүдэр тусгадаг байжээ.

Тэр сүүмэлзэх гэрэлд эмс утас ээрч, эрс хэрэгслээ засаж, зэмсгээ сэлбэж, эсвээс гөрөөнд ядарсан чилээгээ гаргаж амардаг байлаа. Чингэхэд яриа хөөр болж, элдэв юм хэлэлцэн хууч дуу дуулцгаан ангуучин өтөг баавгай бух гөрөөстэй тулалдсанаа, эсвээс хүн төрүүлдэг үндэс барьж нүдэнд үл үзэгдэн, хүн амьтныг ойн ширэнгэ балчигт төөрүүлэн хорлодог үс ихтэй зэрлэг эрсийг хэчнээн гөрөөчин тэдэнд автагдан төөрч үгүй болсныг ярьдаг байж билээ.

Цал буурал үс сахалтай өвгөн, уул нутгаа дурсан ярьж анх дээр цаг яаж тулалдан байлдаж, ямар сайн баатар эр байсан, яаж чадалтай сэнгүн ноён, байлдааны өмнө шөнө дөл босож, цэргээсээ холдон, чоно шиг улихад нь хариу нэг чоно ульж эхлээд, өдий төдий чоно улилдсаныг дурдан ярьдаг байж билээ.



Бас түнэн харанхуй шөнө намаг балчиг, өргөн тал эвгүй ойд үзэгддэг сонин жигтэй юм, харанхуйд гал татуулан нисдэг жигүүртэн, жич мөнхийн хар ус сахигч муухай айсихь эм, сайн муу ёр хэлэлцэн цөм өөрийн омог аймгийн нууц домог бишрэн сонсоцгоодог байлаа.

Чингээд, гад унтрахад онгон буурал аавдаа орон гацаагаа даатгаад арьс адасга дэвссэн орондоо орж хэвтдэг бөгөөд онгон буурал аав нар нь, ач үрийнхээ эд сүрэг хичээн сахидаг асан гэдэг. Төрөл төрөгсөд үе залгамжлан бие биедээ элэгсгийн ёс, насан төгөлдрийг наснаас нөгчсөнтэй, одоо цагийг эрт өнгөрсөн цагтай холбон улам улам бадарсаар иржээ.

Бургасан сүлжмэл хашаагаар хүрээлүүлсэн гацаа айл, цасанд дарагдан, гүн шөнө чимээгүй болж, гагцхүү сэргэг нохой, ногоон галтай нүдээ гялалзуулан чонын гэтэж явсныг буюу гол мөрний зүгээс халиу чиг хийж дуугарах чимээнд шуугин хуцдаг байжээ.

Тэр цас мөсний цаг, бүрий бүдгийн үе, урт шөнийн эринд улирлыг үхэл өвөл хоёрын эзэн Морен эзэлж, наран тэнгэр, газрын зүг улам улам доошоо халуунаар удтал ширтэх болтол эрхшээсээр, мөсөөр гавласан гав нь ус болон урсаж арилаад айл гацаа бүхнээ, аймаг хотлоороо амьтан сэргэн баярлацгааж, дуу эгшиглэн усны зүг, мөснөөс мултарсан урсгал гол мөрний зүг очиж, үхэл өвлийн эзний дүрийг хаяж урин цагийн эзэн уянгат охин тэнгэрийг баясгалант үгсээр угтнам билээ.

Чингээд нар яв явсаар, замын оргилд хүрч, өргөн тариалангийн намаржин намилзаж хөдлөх ургац, нуга газрыг бүрхсэн цэцгийг гийгүүлэн байх үес нар буцахын ёслол хийж, хамгийн урт өдрийн өмнөх шөнө нэн жигтэй үзэгдэлт шөнө байдаг ажээ. Тэр шөнийн шүүдэр цавд сан цэцэг гайхам чадалтай болж, зөн төгөлдөр бөгөөд эмийн чадвартай болцгоож, тэр жиг төгөлдөр шөнө хүчин чадал нь улам нэмэгддэг чөтгөр буг, толгод, хадан хонгилд хуран чуулах айсихь эмсээс өвс үндэс бүгдийн эх болсон задын өвсний адил хамгаалан сахих болдог байжээ. Тэр шөнийн харанхуйд уулсын оргил оройгоор их түүдэг асааж, түүний гэрэл туяа нь алс хол тусч, тэд түүдгийг тойрон наран тэнгэрийн агуу чадлыг магтан эгшиглэж, амьтныг амьдруулан, хайр дурлал, өршөөгч түүнийг тахин бүжигч бөгөөд эр эм бололцох ёслол хийгч охид хөвүүдийн дуулах чимээ хол цуурайтан дуулддаг байжээ.

Зуны нар буцсан хойно тариа хадах цаг болж, тэгээд сэрүүн намар цаг болж, сүүлээр нь өвөл цаг болсоор он жил өнгөрч, омгийн хүн ам нэмэгдэж, чех аймаг өнөр олон болсоор, тэдний сураг чимээ хол дахинд тархан түгж, уул язгуур нутгаас нь тэдэн дээр бас амьтан нэмэн нүүж ирцгээсээр эзлэн оршсон газар ус нь багадаж, аймаг омог нь цаашаа зүг зүг, хойшоо урагшаа, зүүншээ барууншаа, уул ус даган тархан, шинэ айл суурин босгоцгоодог болжээ.

Ахмад дээдэс, лех тайж нартаа их бага шилтгээн босгож, хил хамгаалан, бас дайсан халдан ирэхүл мал сүргээ оруулж, өвгөд, эмс, хүүхдээ хоргодуулах газартай болгодог байжээ. Шилтгээн балгас босгохдоо мөрөн голын хэдэн хошуу, эсхүл, ой дахь ус балчгийн дунд газар сонгон халдан нэвтрэхэд бэрх гагцхүү нарийн зөрөг замаар нэвтрэлцэх газар босгодог бөгөөд балгас тойрон заримдаа гурван давхар шороон хэрэм өндөрлөн цогцолж, бүдүүн модон шивээ хийж, тэнд нь мөн хаалга дээр нь цонж цамхаг босгодог байлаа.

Чехийн дүү Лех сэнгүн ноён, бараа болоочин олонтой тул наран мандах зүг нутаг хайх гэж зориод ах Чех сэнгүн ноён бусад олон түүний явна гэж чөлөө мэдүүлэхэд явуулах дургүй байсан боловч, найртай сайхнаар ерөөн үдэхдээ, битгий холдоорой. Дайсан дайран довтолбол омог төрөлдөө тусалдаг юм шүү гэж захиж билээ. Чингэхэд Лехийн өчсөн үг нь:

— Аяа ах, хөвүүд дүү нар, чех нутгийн эрчүүд минь! Та нартаа уг үндэс нэгтэйг би хэзээ ч мартаггүй. Тэр учраас би та нараас холдон тасарч бие биеийн сураг чимээ алдах алс газар үл зорино. Чухам хаа бууснаа би та нарт тэмдэг үзүүлнэ. Бидний мордсоны хойно гурав хоноод Жип уулын оргил дээр үүрийн туяа татахаас өмнө гарч хараарай. Тэр үес би ойд их түүдэг гал асааж, түүний гэрэл утааг үзээд, та нар миний суурьших газрыг тэнд гэж мэдээрэй гэсэн гэдэг.

Чингээд тэр захисан өдөр нь үүрийн харанхуйгаар Жип уулын оргилд гарч, ийш тийш харвал, өмнө дорнын зүг будан дунд бараан огторгуйд улаан туяа татсан түүдгийн гал харж, үүр цайхад тэр зүг туяарсан тэнгэрт сэнгүн нөхөд сэлтийн их түүдгийн утаа үүлэн мэт үзэгдэхийг үзжээ. Тэр зүгт Лех газар нутаг сонгож, их хүрээ далан цогцолж, шилтгээн босгож эхэлсэн бөгөөд утаа тэмдэг тавьснаар шилтгээн балгасаа Коужим буюу Утаат балгас гэж нэр өгсөн гэдэг.



III

Чех сэнгүн чех газар гэдэг болсон нутаг сонгосоор гучаад жил болж, наян зургааны сүүдэр амсах жилд насан элэгдэж, оршуулан хайлга гэдэг үхэгсдийг тайх их ёслол хийх үес цөм тэр өтгөсийг эцэг мэт сэтгэн гашуудаж уйлан хайлсан нь:

— Чи манай сэнгүн ноён, жанжин аав билээ. Биднийг энэ зах газар удирдан ирээд, бараа болсон бидэндээ бүх аймаг олондоо шударга мэргэн эзэн байж билээ. Ай халаг хуухай, хэн биднийг одоо эзэгнэн харах билээ! гэж хүн бүхэн түүний нас элэгдсэнд элэг эмтэрчээ. Чингээд түүний сүнсийг энхжиний сайхан орон өөд заларч, алтан дэлхийд ураг элгэн дундаа байсан эрх ямбаараа орших, өвөлгүй мөнхийн зунаар байдаг оронд өөд боллоо гэж тэр үеийн үзлээр итгэн бодоцгоож, чандарт нь шинэ хувцас, хуниаст жанч, гялалзсан толь товруутай өргөн бүстэй дээл, гоё өмд гутал өмсгөж, цэл буурал урт үстэй цагаан сахалтай тэргүүнд нь булган сайхан малгай өмсгөжээ.



Чингэж хувцаслуулаад үдэш хайлуулан нисгэх өндөр индэр дээр хатгамал баринтгаар хучсан түлээнээ, хөгшин саглагар эм дом царс модны сүүдэрт ойд, сүнсний буудалтай гурван замын бэлчирт ойр газар залж, бал унд, жимс үнэртэн өвс авчирч, дэргэд нь тавиад, талх боов, мах нум өмнө нь тавиад зэр зэмсэг, жад, юлд, балт хар бамбайг нь atraад, хажууд нь тавьсан хойно эр эм тахиа алж, индэрлэсэн түлээнээ хаяад, нөгчсөн сэнгүн ноёны хамгийн шадар хүн зомгол асааж, баруун гартаа барин, түүдгийн модны зүг араараа ухран ойртоод, түүнээ гал астал, солгой гараа ардаа тавин зогсож, түүдэг асахад бусад олон цөм нэг нэг галтай зомгол барин айсаж, түүдэгт өргөжээ.

Салхи татан хөдөлж, галын дөл дараалан өөдөө бадарч утаа дээшээ дэгдэн, хүн олныхоо дунд өндөр индэр дээр сүүлчийн удаа сүндэрлэн суусан нөгчигсөд сэнгүн ноёны дүрийг халхлахад, орчин тойрны олон уй гашуун болж, эмс эмгэнэлт тамлага тамлавай.

Түүдэг шатаж гүйцсэнд яс үнсийг нь хурааж, чандраа саванд хийгээд, өөд болсон сэнгүний зэр зэмсгийн чимэг зэмсгийн зүйлийг түүж аваад, авсанд хийж оршуулаад өндөр овоо босгожээ.¹ Чингээд оршуулах ёслол гүйцэтгэж, харанхуй ойгоос бүрэнхийгээр буцахдаа

газраас чулуу, гишүү навч аваад, толгой дээгүүрээ ар тийшээ чулуудан, огт эргэж харалгүй явсан гэдэг.

Чингээд тэр оршуулсан газар хожим хойно очицгоож уйлан гашуудаж, сэнгүн ноёноос ерөөн мөргөж, байсан бөгөөд, нэр нь үе улиран уламжилжээ.



КРОК ОХИД СЭЛТИЙН ДОМОГ

Крок жанжин газар орныг захирч байсан цагт хааяагүй эв журамтай, хүн олон хоорондоо эелдэг, харилцан найрсаг байжээ. Малын пүнзэнд цоожгүй, айлын үүд хаалга түгжээгүй. Хулгай дээрмийг хамгийн муухай ялт хэрэг гэж үздэг байсан гэдэг. Омгийн хүн бүр элбэг дэлбэг юмтай асан бөгөөд гагцхүү ажил хийх дургүй учир омгоосоо хулжуулсан хүн л ядуу болдог байжээ.

Чингээд Чех ноёны нас барахад засаг даргагүй болж хүн бүр дураар болж ёс алджээ. Газар ус, нутаг зааг булаацалдан тэмцэлдэж халдан довтлох, харилцан дайралдах болж, хор хөнөөл өдөр ирэх тутам улам их болж ирсэнд омгийн ахмад өтгөс, Чех ноёны булшинд очиж, нөгчсөн түүнийг дурдан ийн хэлэлцрүүн:

— Дундаасаа жанжин сэнгүн ноёныг сонгон өргөмжилж, биднийг захиран баримталж, хууль ёсоор хэрэг шийтгүүлье гэж хэлэлцээд, Чехийн дүү Лех гэдгийг олныг захирах засаг ноён бол гэж элч явуулахаар тогтоожээ. Гэтэл Лех Коужимд удаан суух бодол үгүй тул татгалзаад нэгэн хүч бүл ихтэй омгийн ахмад Крокийг зааж тэр хүнээр засаг ноён хийтүгэй гэж ухаан заажээ.

Крок өөрийн нэрээр нэрлэсэн нэг балгаст, ой дунд Мжа голын тэнд Збечна тосгоны ойр суудаг хүн байжээ. Аму будаа элбэг, бас цэцэн мэргэнээр бусдаас илүүтэй байсан тул, отог омгийн хүнээр барахгүй, тэр хавь нутаг усны хүн цөм, үүртээ тэмүүлэх зөгийн адил, зүг зүгээс хэрэг шийдүүлэхээр очдог байж гэнэ.

Тэгээд улс, тэр Лехийн үг дагаж, нэгэн сэтгэлээр Крокийг олны хэрэг шийтгэн таслах хүн болгон өргөмжилжээ.

Чехийн авсны дэргэд ширээнд суулгаад толгойд нь Чехийн малгай өмсгөж, Чех жанжин сэнгүний барьдаг байсан сорви таяг бариулаад ёслол мөргөжээ.

Чингээд Лех, наран мандах зүг элч мордуулж, газар нутаг үзүүлээд, тэр элч нь буцаж ирэхдээ, уул нуруу давж, Одр мөрний тэртээ үржил сайтай, уудам бөгөөд хүнгүй газар үзлээ гэж хэлж ирлээ. Лех газрыг сайхан гэж сонсоод, Кроктой салах ёс хийж, төрөл саднаа дагуулан элчийн заасан нутаг усны зүг одон тэр газар хүрээд суурьшин нутаглаж, шилтгээн балгад босгосон нь нэгийг Хнездно буюу үүртийн шилтгээн гэж нэр өгсөн учир нь тэр газар бүргэдийн үүр олон байснаар нэрлэжээ. Бас нэг шилтгээн балгасыг Крок гэдэг хүүгийнхээ нэрээр Краков буюу Кракийн балгас гэж нэр өгсөн гэдэг.

Крок ноён, Чех нутагт эрх барьж, олны хэрэг шийтгэн арга ухаан заан сургаж, жанжин сэнгүн байхдаа Будчийн балгасанд суурилжээ. Тэнд нь тэр үес сургуультай байсан нь онгод тахих ёс, хуучин дуу тамлага, мэргэ төлгө, илбэ ховс заадаг байжээ. Тэр цагт илбэ ховсыг чадлын сайн гэж үзэж, онго оруулж мэргэлдэг хүнийг тэнгэрт таатай эрхэм хүн гэж үздэг цаг байжээ. Мэргэн Крок ч бас цагийн байдлыг мэдэн мэргэлдэг хүн байсан гэдэг.

Нэгэнт, өнгөрсөн ирээдүйн юм үзэж толилох гээд, гурван өдөр хөл хорьж Будчийн онгодын их асрын уудам танхимд ганцаараа ороод, ой уул усны эздийг тайжээ. Тэр үес зуны нууц төгс өлзий төгөлдөр шөнө асан бөгөөд дов толгод газар түүдэг асаж, нам гүмд охид хөвүүдийн дуулах дуу сонсогддог цаг байсан юм байжээ.

Крок тайлга тайж онгод тэнгэр дуудан, ирээдүйн байдлыг өгүүлэн, сургаал өршөө гэж залбирваас, их юм мэдэж, нарийн нууц ил далд үзэгдсэн юмыг үйсэн самбар дээр тэмдэглэж, охин хүүхэндээ үлдээн хадгалсан гэдэг. Тэгээд Лех ахмад зарлан ирүүлээд, тэнгэрийн бошгоор ирээдүйн байдал зөгнөснөөс ганц юм сонсгож, энэ газар миний удтал суух газар биш. Будеч ч тогтохгүй болж, удтал тэнд байх аргагүй тул,

өөр газар олж үзэх ёстой боллоо гэхэд нь бүгдээрээ зөвшөөж Крок зогсоогоор хэдэн элч сонгож, маргааш мандах нарнаас өмнө хөдөлж, өглөөний нар үдийн нарны хоорондох чигт зорчин, Влтава мөрөн хүрч үз. Тэнд харж хайж үзвэл тань, онгод та нарыг зохистой газар удирдан хүргэх бий гэхэд нь тэр захисан ёсоор явж, ажин ажин аялсаар Влтава мөрний баруун гар талын эрэгт, хөвч их модон дунд нэг хадан хошуунд хүрч үзвээс, хөвчийн хөх будан дунд өргөн мөрөн намуухан урсгалтай цэлийн харагджээ. Тэр цээл уснаа наран шингэхийн өмнө элчсийн хүрээд байсан өндөр хадан хясаа тусан харагдаж, тэртээ эргийн өвс ихтэй нуга, эгц бүүрэг уулнаа харлан харагдах мод ч тусан үзэгдэж, бүүрэг уулын тэнд их мөрөн зүүн зүг эргэж, балар ой модны нам гүнд боргионы ус шуугинан дуугарах ажээ. Элчис, тэр хадан хясаа, ой мод ихтэй орчин тойрны газрыг үзмэгц, цөм нэгэн амаар тэр хясаа дээрээс онгон тэнгэрийн заяавраар — энэ газар бидний хувьтай газар мөн гэж дуугарцгаасан гэдэг.



Крок ноён, бусад өвгөд өтгөс, хурдан хүлэг морио унаж, тэр газар нутаг шинжин үзэх гэж хүрч ирээд, бас л тэр үг хэлж, дархнууд хөгшин царс гачуур модоор шилтгээн босгож, бүдүүн гэгчийн баганан тулгууртай уудам гэгчийн танхим, нам гүм аятайхан өрөө байшин, улс олон хуран цуглах хашаа хүрээтэй, онгод тайсан ч, жанжин сэнгүнийг ширээнд залсан ч, тушаал тушааж хэрэг шийтгэснийг сонссон ч багтах тийм уудам шилтгээн өндөрлөжээ.

Хадан хясаагүй талд нь шилтгээнийг дайснаас батлан бэхэлж, гүн гуу ухаж өндөр шороон хэрэм цогцолж, шивээ цонж хийжээ. Гуалин модоор оньсолдог хүнд их хаалгыг бас цонжоор батлан хамгаалж, шилтгээнээс баахан зайс газар хөгшин бүг модны ёроолд нэг сүрхий булаг байснаас уух тунгалаг сайхан ус авдаг болжээ. Тэр булгаа Йезерка буюу Нуурмаг гэж нэрлээд, өндөр хадан хясаа дээр босгосон шилтгээнээ Вышеград буюу өндөр шилтгээн гэж нэр өгсөн гэдэг. Тэр шилтгээн, бүх чех аймагт алдар их нэртэй шилтгээн болоод, айл зэргэлдээ аймаг харь хэлтний газар ч түүнийг дурсган хэлэлцэх болсон билээ.

Тэр шилтгээн босгоод Крокийг төрөл төрөгсдийн хамт их ёслолоор залж, төр барих үест нь нутаг даяараа дахин өлзийтэй сайхан болсон тэр мэргэн сэнгүн жанжныг машид энхрийлдэг байсан гэдэг. Амьтан гэр цагт ажлаа санаа амар хийж, жад сум зэрэг зэр зэвсэг гагцхүү, араатныг сөнөөхөд хэрэглэдэг байжээ. Хүн амьтан, тариалан хичээн засаж, мод огтолж, хожуул сугалж, тарианы газар шороо үргэлж арвижиж, Крокийн төр барьж гуч гаруй жил ноёлоход хүн бүхэн элбэг чинээлэг, энх төвшин байжээ.

Чингээд нас элэгдэхэд нь амьтан болгон уй гашуу болж, чандрыг нь нисгээд үнс зэмсэг хоёрыг нь авсалж, Чех сэнгүн ноёны булшны тэнд оршуулжээ. Мэргэн их жанжин угсаанаас Кази, Тета, Либүше гэдэг эгч дүү гурван хүүхэн үлджээ. Бага балчир насандаа Будеч гэдэг газар аймаг угсааныхаа, залуу охид хөвүүдтэй мөн Стадиц омогт Пшемыслын адил өөр газраас ч ирсэн хүнтэй эрдэм суралцаж байсан ажээ.

Тэгээд тэр үетэн дундаа Крокийн гурван хүүхэн, хээрийн цэцэг, дунд сараана цэцэг мэт бүгдээс нь цэцэн мэргэн, санаа сэтгэл сайхан, зүс царай үзэсгэлэнтэйгээр давж бие чилгэр өндөр, хүн бүхэн гайхам тийм гурван хүүхэн байжээ.

Тэр гурвын Кази нь өвс үндэс бүгдийг таньж, эмийн чадлыг нэвтэрхий мэддэг бөгөөд элдэв өвчнийг түүгээр анааж, онгон тэнгэрийг дурдан шившихэд нь өвчин дарагддаг байсан гэдэг. Чадалтай их тамлага шившлэгээрээ охин заяан тэнгэрийг хүртэл эрхэндээ оруулж, амьсгал хураах гэж байсан хүнийг ч амьдруулдаг байсан тэр охин, эцгийн өөд болсон хойно Мжа голын Осек уулын тэнд босгосон шилтгээндээ суудаг болж, шилтгээн түүнийг Охины нэрээр улс Казийн шилтгээн гэж нэрлэдэг асан гэдэг.

Нөгөө охин Тета гэж нэртэй бөгөөд, Мжа голын хадан хясааны орой дээр маш бат шилтгээн босгож, өөрийн нэрээр Тетийн шилтгээн гэж нэрлэжээ. Онгод чөтгөрөөс айдаг тул, тахих аргадаа зан үйл тогтоож, хэрхэн тайх тавиглахын зэргийг сургадаг байсан гэдэг. Өөрөө нар шингэх зүг Тетийн шилтгээний тэнд сүндэрлэн буй Похлед гэдэг нэгэн уулнаа гарч, хадны дээр хөгшин царс модны өмнө босгосон сүртэй онгон шүтээнд мөргөж өдөр ч тэр, уйдам бүрэнхийгээр ч тэр, тайлга тайдаг байсан гэдэг.

Насаар тэр гурван охины хамгийн бага Либүше гэдэгт хүн ихэд хайртай байжээ. Гоо сайхан тэгш биетэй, эелдэг жавхлантай, үг яриа төв ихэмсэг тул, олны сэтгэл татсан түүнийг ойр хавиар нь өнгөрөхөд, ширүүн дайчин эрс ч гэсэн дуу нам, үг томоотой болж, юм их үзсэн өтгөс ч

— Эхээсээ сайхан эцгээсээ мэргэн охин! гэж магтан хэлэлцэх ажээ.

Улс амьтан бас эмээн хүндэтгэж ярихдаа тэр охины нүд царай нь заримдаа өвөрмөц сонин болж, ирээдүйн үл мэдэгдэх үйл явдлыг билгүүн нүдээр тод харж мэддэг юм гэж ярих бүлгээ.

Крокийн нас нөгчсөнд лехүүд цуглаж, өдий төдий олон хүн онгон ой модонд Нуурмаг булгийн тэнд цуглаад, Крокийн охид бас хүрэлцэн ирсэнд хөгшин бүг мод, эм дом мод, царсны ёроолд өтгөс өвгөд, ах зах хүмүүс, улс олноор цуглацгааж, түмнийг захирч, төр барих ёсыг Крокийн үр хүүхдэд үлдээн, отгон охин Либүшээр засаг ноёхонтой болгоё гэж бүгдээрээ зөвлөн хэлэлцэж, шийдэн тогтжээ.



Хөгшин ой модонд тэр хурсан олны дуу чимээ цуурайтан дуурьсаж, уламлан цааших их мөрөн, зузаан ойд цуурай нь дуулдав. Тэр залуу ноёхон Либүшийг цэцгээр чимж, сэтгэл хөдлөн царай улайсан түүнийг баяр хөөр болж, ариун Вышехрад гэдэг Өндөр шилтгээнд залж, Либүшийн хоёр хажууд Кази, Тета хоёр эгч нь олон аягач хүүхэнтэйгээ урд нь, хойно нь ихэмсэг лехүүд, ахмад, язгуур өндөр хал үзэж хашир таньсан отог омгийн сайчуул бараадан цувжээ.

Сэнгүн жанжны шилтгээн дахь уужим хүрээнд хүрээд, саглагар эм дом модны дор, эцэг мэргэн засаг ноёны суудаг чулуун ширээнд суулгасан гэдэг. Тэр залуу ноёхон Либүше өөрөө бас Либүшийн шилтгээн гэж нэрээр нь нэрлэсэн шилтгээн Збечна гэдэг гацааны зүг чиглэсэн ой модны тэнд босгосон боловч, засаг ноёхон болж өргөмжлүүлснээс хойш, эцгийн өндөр шилтгээн Вышехрадад сууж, улс орноо тэндээс засан захирч байсан гэдэг.



БИВОЙН ДОМОГ

Либушийн суудаг лут бэх Вышехрад гэдэг Өндөр шилтгээнд янз бүрийн мод, сөөг шугуй, сайхан цэцэг навчаар үзэсгэлэн төгөлдөр цэцэрлэг хөхрөн ургаж, тахиралдсан явган зам жим нь тун сонин гайхалтай ийш тийшээ нугачин, нэг нийлээд, сөөг шугуй дунд нэг салж өндөр модны доогуур, цэцэг өвсөн дундуур гардаг тэр олон зам тоомын хоорондоо жигтэйхэн адилхан тул, гаднын хүн тэр сонин сайхан цэцэрлэгт орвол, нууц булан, ав адилхан газартай цэцэрлэгээс гарч чадахгүй төөрөх асан байх.

Тэр цэцэрлэгт Либуше аягачин хүүхнүүдтэйгээ зугаацах дуртай бөгөөд, ганцаараа ч өглөө эрт наранд цэцэг навч бүхнээ шүүдэр гялалзаж байх үес, мөн үдэш наран шингэхийн улбар туяанд модны өнгө нь ондоо болж байх үес буюу, үдшийн бүрэнхийд модны орой мөчир харлаж, цайж харагдах явган зам тоом нь харанхуй сүүдэрт харагдахгүй болох цагаар зугаа хийн явах дуртай байжээ.

Тэгж явахдаа залуу ноёхон, бие өндөр, цагаан хувцастай, үсээ задлаад, өөрөө тунгалаг цагаан сүүдэр мэт, толгойгоо бодлого болж бөхийлгөн, хөнгөн алхмаар алхан явах буюу сайхан нүүрээ өөд нь тэнгэрийн зүг хандуулж зүүдлэн бодох мэт, од буюу сарны зөөлөн гэрэлд зогсох бүлгээ.

Алхаа сайт мориороо Казийн шилтгээнээс дүүтэйгээ уулзахаар ирсэн Кази эгчээ нэг удаа тэр цэцэрлэгт дагуулан орвоос, цэцэг өвс, тоом зам нь сүүдэрт орж, гагцхүү модны орой бат шивээ хүрээ, өндөр цонж бороо хурын уснаа борлон харлаад, шингэж байгаа нарны гэрэл

тусаатай байжээ. Нар Влтава мөрний тэртээ цэнхэр будан татсан харлан харагдах ойн цаагуур жаргаж байсан ажээ. Тэр чимээгүй айван тайван үед хаалга тушаа догшин урхирах чимээ гарч, ноёхны цэцэрлэг хүртэл цуурайтан, улам тод айсуй болсоор, эрчүүдийн хашхиралдах дуу, догшин салхи ойртож байгаа мэт улам улам дөхсөөр, өндөр дуугаар хашхиралдахын хажуугаар нэг юм муухай дуугарах чимээ хутгалдан дуулдаад, гэнэт бүрээ татах чимээ гарсан нь ямархан нэг юм ялан дийлсний тэмдэг дохио болж, баярлалдан шуугилдах олны дуу чимээтэй хамт өргөн шилтгээнээ дуурьсжээ.

Эгч дүү хоёр, хэлэлцэж явснаа зогсож чагнатал, шилтгээний дарга сандан мэндэн хүрч ирээд, хүрээнд очиж, жигтэй юм сонирхон үзнэ үү гэжээ.

Өргөн хүрээнээ нэг өндөр чилгэр сайхан биетэй залуу эр, шилтгээний хуяг цэрэг шуугин гайхсан олон хүнээр хүрээлүүлж, гараараа шилэн хүзүүний ард хүнд юм барьж үүрсэн байдалтай алхан айсуй. Царай хүрэн, баахан бөхийсхийн доошоо харж, бужгар хар үс малгай дороос нь магнай руу нь унжжээ.

Эгч дүү хоёр ноёхон, амьд бодон гахайг ардаа чихдэн үүрээд явж байсан тэр хүдэр эрийг гайхан харж ажиглаваас, тэр залуу анчин, жадгүй боловч, өргөн бүснээсээ хуйтай юлд зүүж, гутал нь шавхай, гуя барьсан өмд нь намгийн шавар болж, тэр хүнд юмыг хоосон хөхүүр үүрсэн юм шиг огт ажиггүй маш хөнгөн алхаж явах нь, гишгэх нь чанга хөл огт сульдах чичрэх байдал үгүй ажээ.

Хажуугаар нь хөгшин залуус бахархан баярлалдаж, зарим нь гараар зарим нь жадаар тэр залуу эрийн ардаа үүрсэн чийрэг хөгшин бөгөөд сүрхий хурц муруй гялгар цагаан соёо цухуйсан хар хошуутай том гэгчийн толгойтой бараан шар бодонг зааж явахад, тэр бодон тийчгэнэж, хар туруугаараа хий цавчлан, шүдээ хавирч, нүдээ улаанаар эргүүлэх ажээ.

Цугласан олон хүн Либуше, Кази хоёрыг хараад чимээ намдаж, Судивой өвгөний хүү тэр зоригт анчин Бивой гэдэг залуу эр, их танхимын өмнөх том баганын тушаа шатны дэргэд зогсоод хоёр ноёхныг шат дээр гарахад, олон эрчүүдийн түрүүнд нь зогссон Бивой, догшин ан ардаа үүрсэн хэвээр Либушийг эгчтэй нь ёслоод— Алагтуут уулын энэ догшин бодонг авч ирлээ. Хүсвэл чинь, чиний өмнө сөнөөе гэхэд нь, Либуше толгой дохижээ. Олон эрс хашхиралдан, жад юлд далайцгаан шуугилдтал, Бивой: Би өөрөө тулалдана. Барихыг би

барьсан. Алахыг ч би ална. Та нар тойрч зогсоод, битгий гадагш нь тавь. Бас урьдаар миний хөлийн өмнө нэг жад тавиад өг гэхэд нь цөм тэр хэлсэн ёсоор нь болгов. Олон эрс зай гаргаж, холуур бүслэн тойрч, зогсоод, зэмсэг барьцгаан, цөм Бивойн зүг ширтэн харцгааваас, тэр баатар залуу холуур тойрон зогссон олон хүнийг эргэцүүлэн харж үзээд, галтай нүдээрээ шат дээр зогсож байсан ноёхны зүг ширтэж, Либушийг хараад, эгчийг нь ширтсэнд тэр нь, Нуурмагийн тэндэх ойд анх уулзаад, цээжинд хоногшсон тэр чийрэг чилгэр эрийг сэтгэл хөдлөн харж, эр зориг бяр чадал, баатар зүрхтэйг бахархсанаа бас Бивойг алцайн зогсоод, ардаа чихдэж барьсан том бодонг толгой дээгүүрээ давуулан газар дүнгэнэтэл хөсөр чулуудсанд, зүрх түгштэл айн эмээж, аньсага нь анив татав хийлээ. Бодонг газар цохиж ойчихоос нь урьд Бивой бөхөсхийж, хүнд жад шүүрэн аваад, хоёр гараар атган, хүлээн зогсжээ.



Чийрэг хөгшин бодон, газар цохин унаад хоромхон зуур ухаан мэдээгүй юм шиг огт хөдлөхгүй хэвтсэнээ гэдэс нь хөдлөөд, дэл нь ширхэг ширхгээр сөхүйж босоод, хар толгойд нь нүдний цагаан гялалзаж, ухасхиймэгц хөл дээрээ босож, хажуу тийшээ харалгүй, амаа ангайж, хурц соёогоо цайлзан гялалзуулж, хорсон уурласандаа нүд балай, шууд Бивойг дайран оржээ.

Бодонг тэгж дайран ороход цөм дуу чимээ хурааж, нам болсноо, ганц нэг эрчүүд, шилтгээний эмс охид уулга алдаад, бодонг Бивойн жад өөд дайран мөргөхөд эрчүүл хашхиралдан, зэвсгээрээ ширвэцгээн шуугилдтал, бодонгийн амнаас цус олгойдон, нэг цоройгоод хөсөр ойчсонд цус харван гоожиж, дэргэдэх газар нь цөм улаан нэлээ боллоо.

Бивой, жадаа суга татаж аваад, үхэж байсан догшин ангийн ширүүн хялгаст биеийг нь баруун хөлөөрөө гишгээд, нүүр магнайн хөлс арчиж ноёхны зүг:

— Одоо амьтан айлган довтолж, хор учруулахаас өнгөрчээ! гээд, толгойг нь өшиглөжээ. Тэгэхэд нь шилтгээний чилгэр сайхан нуруутай дарга нь ноёхны урд нь гарч, Бивойд өгүүлрүүн:

— Тэнгэр чамайг ивээтүгэй! Нутаг усыг аюулгүй болгож өглөө чи минь. Энэ бодон зургаан нас насалсан айхавтар ч догшин, хэцүү аюултай амьтан байсан билээ. Алагтуут уулын хавьд амьтан айлгаж сүрдүүлдэг бэрх араатан соёотой байж, хэчнээн хор хөнөөл учруулав аа? Тариа сүйтгэснийг хэлэх үү, амьтан ялангуяа тайга нохой, агт морь хядсаныг нь хэлэх үү! Божейн Сватославыг агнах гэж мордоход нь энэ бодон, унасан морины нь омруу гэдсийг хага хадарсан билээ. Тийм сүрхий өндөр цоройдог байжээ. Бас хэчнээн эрсийг алан хадарсан билээ. Барааг нь үзээд амьтан айн эмээж, эрчүүд ч хараад зугтааж хоргоддог байсан билээ. Энд чи Бивой л...гээд үг гүйцээлгүй амьтан магтан баярлалдаж шуугилдлаа. Ноёхон шатнаас доошоо бууж тэр сүрхий анг харж, Либуше яаж энэ амьтныг ингэж чихдэн барив? гэж асуулаа. Тойрон зогсож байсан олон цөм чимээгүй болоод, Кази тэр чийрэг анчны өөдөөс гялалзсан нүдээр ширтэн, олны хамт Бивойн зүг чих тавин чагнаваас, өгүүлсэн нь:

— Энэ бодон өчнөөн төчнөөн хор хөнөөл учруулж, хүн бүхэн айдаг болсонд би их л хорсож байдаг байлаа. Алагтуут уулын хөндийгөөр амьтан явахаасаа айх болж, бодон ганцаараа орогнон хэвтэж, харуйсан баруйсанд халдаж, хэчнээн хүнийг хадарч, морь,

нохойг тоолшгүй олноор алсан билээ. Тэгээд би зориглож, мөрийг нь мөрдөж, хөгшин бүг модны ёроолд хэвтдэг газрыг нь олж авлаа. Үдээс хойш тэнд хэвтэж хөрвөөдөг байжээ. Тэгээд шумуулд идүүлэхдээ царс мод шөргөөж, талд идээшлэх гэж айхгүй шууд гарахдаа хүнээс ч зайлдаггүй, дайралдсанаа хадардаг байж. Өнөөдөр агнах гэж гараад бэлчээрээс идээшилж ирэхийг нь хүлээх гэснээ, амны адагт хүрээд очтол, өвс ширэнгэ дотроос намайг гэнэт эрслэн дайрч, жадаа өөдөөс нь барихын зав өгсөнгүй. Тал газар дайрсан учир ойр хавьд нэг ч мод үгүй. Зайлахын аргагүй болоод газар ойчин зайлахад би бас дургүй.



Та бүхэнд миний энэ үг хэлэхээс хурдан над дээр хүрч ирээд хөл рүү шурган намайг хадрах гэж толгойгоороо мөргөхөөс нь урьд чихдэж аваад хөдөлгөсөнгүй. Урхираад, галзуу мэт сэгсэрч, соёогоо хавиртал нь хэдийн ардаа үүрээд, энд хүрч ирсэн билээ гэхэд нь орчин тойрон амьтан хүн баярлалдан шуугилдаж, чимээ намдсан хойно залуу ноёхон эелдгээр өгүүлрүүн:

— Онгон тэнгэр чамайг тэтгэж, бяр их чадлыг чинь бадруулаг.

Газар орноо аюулгүй болгож, тариаланг хорлолоос хамгааллаа чи.

Би болоод бид бүгд чамд талархал өчлөө. Зоригт эр одоо орж амар. Юм идэж, бие сэтгэлээ айван тайван болго гээд, шилтгээний даргад дохио өгмөгц, Бивойг шат өөд дагуулан, их танхимд оруулжээ. Хойноос нь шилтгээний эрчүүдийн эрхэм нь шилтгээний хормойн

гацааны сайчуултай бас Бивойн Вышеград гэдэг Өндөр шилтгээн орох замд дайралдаад үүрч явсан догшин антай явахад нь бараа бололцон ирсэн хүмүүсийн сэлт дагалдан оржээ.

Тэр танхим өндөр бус боловч уудам, гайхалтай сонин сийлбэр будагтай хээ угалзтай лут баганатай адрын уртааш нь маш том дам нуруутай бөгөөд, баганад хандгайн эвэр, зэмсэг бамбай, сүртэй том баавгайн арьс, бух гөрөөсний эвэр өлгөөстэй ажээ. Бивойг хойморт хүндтэй газар суулгасан хойно, олон эрс, хэдэн зуун жил ургасан бүдүүн гэгчийн царс мод огтолж, ширээ болгож босоогоор нь тавиад, хүнд гэгчийн сандал хийж тавьсан түүнээ сууцгааж, тэр хэрчим модон ширээн дээр бал сархад дүүрэн буман сав тавьж, алтан шаргал өнгөт сархад хундага, шавар модон цомд сөгнөжээ. Эрс сархад уухдаа, Бивойг ерөөн, түүний эр их бяр чадлыг шагшин гайхваас, залуу баатар эр тэр гайхан магтах үг их дуртай сонсож, Либуше ноёхон эгч лүгээ гараад одсон модон оньстой намхан хүнд хаалганы зүг байн байн харах ажээ. Санаанаас нь Либушийн эгч гарахгүй бөгөөд яаж дахин түүнийг олж үзэх билээ гэж бодон бодон суужээ.

Тэгтэл, модны орой хэрэм, өндөр цонжид шингэх нарны ягаан туяа тасарч, хүрээнд харанхуй сүүдэр тусч, гагцхүү өндөр танхимд зун цагийн үдшийн бүрийд гэрэл гэгээ, нээлттэй цонхоор нь тусч байлаа. Тэр үес баганын цаадах сүүдрээс өнөөх хаалгаар хоёр ноёхон гэгээтэй танхимд орж ирээд, нэг аягач хүүхэн, сааринд ороосон нэг юм барин дагаж, Либушийн үгээр тэр боодлоо ширээн дээр тайлбаас, эр хүний сайхан товруут бүс гялалзаж, байдал өргөн бөгөөд, улаан сураар хээлэн оёж, жижиг мөнгөн тав чимэгтэй, хүрэл аралтай, гялалзсан оосортой. Тэр нь бүсийг нугалахад эрдэнийн чимэг хавсран хангинах ажээ. Отгон ноёхон тэр бүс Бивойд өгөхдөө, үүнийг шан болгоё. Аавын эрдэнийн санд байсан түүнийг эгч бэлэглэх гэж өөрөө сонгож авсан билээ гэхэд Кази мишээж,

— Энэ бүсэнд нэг ширхэг эрдэмтэй өвс, могойн шүд дотор нь хийж оёсон юм. Үүнийг бүсэлж явбал чи харанхуй шөнө ч ой модонд төөрөхгүй, муу увдист үндэс, айсихь шулам, шөнийн буг чөтгөр чамд халдахгүй гэхэд нь залуу баатар эр хариу ёслон тал өгсөнд, идтэй баатар зоригтыг ингэж хүндэтгэсэнд орчин тойрны олон Либуше, Кази хоёрыг өндөр дуугаар магтав.

Хоёр ноёхон гарч явсан хойно найр зугаа үргэлжилсээр шөнө болгов. Тэгэхэд оройн хоолны сүүлээр зочид гэр гэртээ харих үес,

шилтгээний дарга Бивойг хонины арьсан зөөлөн дэвсгэртэй нэгэн өрөөнд аваачиж унтууллаа. Залуу эр хэвтээд өглөө болтол бөх унтжээ.

Маргааш өглөө нь Бивой гэртээ, эзэн болсон гацаандаа харих гэж завдвас, шилтгээний дарга түүнийг мэдмэгц унах морь зэхээстэй бий. Ноёхон унаа өг гэсэн. Кази бас шилтгээндээ буцах гэж байна гэхэд нь урьд оройн бэлэглэсэн эрдэнийн бүс бүсэлж, ноёхонд ёс хийж тал өгөөд гялалзсан үстэй хээр хүлгийг баярлан унаад, эгчийн нь бараа бологсдыг дагалдан морджээ.

Хэрмийн хаалга өнгөрөөд Бивой тэргүүлэн цөм эргэж харваас, хаалга дээрх модонд өчигдрийн бодонгийн сүртэй толгой хатгаастай, ширхэг дэл нь сөхүйж, мундаг хошуу нь гялалзсан цагаан соёогоо ярзайлган Бивойн бяр чадлыг сануулан үзэгдэв. Кази, Бивойг дагалдсан бараа бологчдын дунд үлдэлгүй зэрэгцэн явж, замын салаанд хүрээд, Бивой түдэлгүй цаашаа бас хамт явалцаж, Мжа голын усанд хад дээрээс лут далан нь тусан харагдаж байсан шилтгээнд нь хүргэжээ.

Чингээд намар өнгөрөхөөс өмнө Бивой, гацаа омгоо орхиод Казийн шилтгээнд бүрмөсөн суухаар очиж, Кази ноёхон Бивойд ихэд сэтгэлтэй болсон тул ханилан суусан гэдэг.



ЛИБҮШИЙН ДОМОГ

Хол ойрын амьтан, хэрэг заргаа таслуулах гэж урьд Крокт очдог лугаа адил, Амрагжин гэдэг Либүшед бас очих болжээ. Хар цагаанаа түүний мэргэн чадлаар ялгуулах гэж очицгооход, үнэн шударгаар хэрэг ялгаж эвдрэлцсэн этгээдийг эвлүүлдэг байсан гэдэг. Тэр үес хоёр эр хоёулаа омгийн ахмад, нутаг зааг булаацалдаад, дороо муудалцаж, бие биеэ зүхэж, эх эцэгтээ хүрэлцээд, хоёр айл зэргэлдээ омгийн найртай ёс арилж, харилцан өшөөтэй болжээ. Тэр тэмцэлд нэг нь ч найр тавихыг бодохгүй хоёулаа цахиур чулуу мэт хатуу болоод, эв нийлэх аргагүй байтлаа ноёхон хэрэг таслах цаг болсонд, хоёулаа өндөр шилтгээний зүг тэмцэн оджээ.

Либүше тэнд нэг саглагар эм дом модны дор, хивс дэвссэн өндөр ширээнээ, магнайдаа цагаан цэцгийн эрх зүүж, хэрэг зарга таслан сууж, зүүн баруун гар, ич солгой этгээд арван хоёр зайсан, нэн алдар

чадалтай омгийн ах зах нь болсон чилгэр сайхан биетэй, бууралтсан сахалтай эрс сууж, урд зай гаргаж олон хүн, тэр хэрэг зарга таслахад ирсэн буюу өөр өөрийн омгийн хүнийг өмгөөлөөр ирэгсэд харчуул, эрэгтэй, эмэгтэй хүн ахмадууд тойрон зогсож байлаа гэнэм.

Муудалцсан хоёр хөрш хүн, ноёхны өмнө заргаа мэдүүлж, бага нь ихийг ёсон бусаар нутаг зааг булааж авах гэлээ гэж хорсон мэдүүллээ. Нөгөө хүн нь бие бялдар махлаг, сахал сахлаг, бараан үүл мэт баргар царайтай хүн, үгийг нь таслаад, миний хүслээр болох ёстой гэж эрс хатуу хэлж, хөршөө хохируулахад хүрэхийг огт бодохгүй байжээ.

Либүше, тэр хоёрын үг сонсоод, хоёр жигүүрийн зайсангийн ахлахад нь зарга хэрхэн таслах саналаа хэлэхэд, зайсангууд хоорондоо тэр заргын учир байдал, ноёхны таслах саналыг зөвлөн хэлэлцээд, тэгж таслах нь зөв зүйтэй гэж саналаа хэлсэнд, ноёхон шударга үнэн гэж бодсоноо зарлан хэлж, бага ахмад зарга авах ёстой, нутаг зааг нь тэр хүний нутаг зааг мөн байна. Нөгөө ахмад нь багыг хилсдүүлж, гэж хэлж гүйцээгүй байтал, тэр зарга алдсан их ахмад тэсгэлгүй уурлаж өндөр сорви таягаараа газар гурав дэлдэж царайгаа барайлган нүдээ гялалзуулан, хашхиран харааж ширүүн үер бороо орсон адил, хараалын үер урсгаж:

— Ийм ёс цааз гэж байдаг бил үү? Зарга хэн тасалж байгааг бид мэдэхээ байв уу? Эм хүн тасалж байна шүү дээ! Үс урт ухаан охор эм хүн! Оёх нэхэхийг чадах байж болно. Хэрэг ялгаж яаж чадах вэ? Тэр чаддаг оёдог нэхдэгээ оёж нэхэг, хэрэг л бүү ялгаг! Аяа эрчүүл бидэнд юутай шившиг! гэж хашхиран хэлэхдээ толгойгоо шааж, шүлсээ сахал дээрээ үсэргэж, юутай шившиг, юутай шившиг! Эм хүн эр хүнийг захиран шийтгэх ёс өөр хаа газар аль омогт байна? Ганц манайд тийм байгаа учир бид бусдын инээдэм тоглоом тохуу болж байна. Эмд ингэж захирагдан шийтгүүлснээс үхсэн дээр! гэж доромжлон аашлахад, тойрон зогсож байсан олон цөм хирдхийж, ноёхны хацар ичсэн зовсондоо час улаан болоод, тэр ёсон бус үгнээ хорсол гомдол төржээ. Гэвч, тэр доромжилсон хүний муу үгийг тэсвэрлэн хүлцэж, хариу үг дуугарсангүй. Зайсангуудаа, цугласан олныхоо зүг ширтэн хараад тэдний дундаас тэр хэтэрхий эрийн өөдөөс нэг ч хүн хорьж, ам эс нээхийг үзээд, хоолой нь сэтгэл хөдөлсөндөө чичрэвч олны зүг тун төв ихэмсгээр өгүүллрүүн:

— Тэр мөн. Би эм хүн болоод эм зан гаргаж, та нарыг төмөр туйвангаар шүүдэггүй учраас намайг та нар учир ухдаггүй гэж үзэв ээ.

Эм хүнээс арай хатуу засаг хэрэгтэй юм биз дээ. Тэр ёсоор болтугай! Хүсэл тань гүйцэлдэг. Одоо гэртээ сэтгэл ханан харьтугай. Бүгдийн хурал цуглаан, сэнгүн ноёныг сонгон тохоог. Сонгосон түүнийг нь би эр нөхөр болгоно гэж хэлэнгүүт, хүрээнээс шилтгээндээ ороод, Казийн Тетийн шилтгээнд хоёр эгчээ дуудуулж морьтой элч мордуулжээ. Чингээд дур булаам сайхан цэцэрлэгийн хамгийн бөглүү нэг буланд, саглагар эм дом, ширэлдэм сөөгтэй сүүдэр ихтэй бөгөөд хоёр эгчээс нь бусад хэн ч ойртдоггүй онгон газар очжээ.

Тэнд эм дом модны сүүдэрт, модон багана дээр хөх хаг хөвд ургасан хавтгай чулуун саравчид бүдүүхэн зассан үхэр чулуу дээр бүдэг гялалзах алтан сахалтай, мөнгөн авгалдайтай модон онгон байсан нь Перун гэдэг шүтээн буурал аавын хөрөг байжээ.

Либүше түүний өмнө сөгдөн мөргөөд, онгоны суурь том чулууны өвөрт модны дор харанхуй болж, оройн салхи мод шугуйд шуугьсан үдшийн шөнө болтол сууж бодлого болон хөдлөлгүй суумал хөрөг мэт сууж, сэтгэлдээ саяны явдлыг эргэцүүлэн юу болж олноороо хэнийг ноён тавих бол, хоёр эгч нь ямар бодолтой бол, санаа нийлэх болов уу гэж бодож суусаар харанхуй цэцэрлэгт Кази Тета хоёрыг орж ирэхэд нь яаран босжээ. Шилтгээний дарга, хоёр эгчийг нь хүрч ирмэгц, хаалганд тосож, цэцэрлэгт хүргэж оруулаад, гадаа хаалга дээр нь сахин хүлээжээ.

Чингээд Либүше, хоёр эгчдээ юу хэлж гурвуулаа Перүний хөргийн өмнө ирээдүй мэдэх билиг нээгдэж юу хэлэлцэн зөвлөснийг хэн ч үл мэдэх ажаам. Үүрийн шөнө өнгөрч, гэгээ орж, шилтгээний гадна, хэрмийн гадаа, модны цаагуур үүр цайж байхад, өглөөний сэрүүн салхи татах үес Крокийн гурван охин цэцэрлэгээс гарахад, хоёр эгч нь алчуур нөмөрч, Либүше магнайдаа цагаан цэцгийн эрх зүүгээд, намуун тайван, алсыг ширтэн сүүдэр мэт чив чимээгүй явж хажуугаар нь үг дуугүй өнгөрөхөд шилтгээний дарга хойноос нь гайхан харж, шатаар их танхим өөд гарч, үүрийн сүүдэрт бүдүүн баганын далд ороход харсаар хоцорчээ.

Чингээд Либүше өглөө эрт элч мордуулж, олны хурал цуглаан зарлаад, тариа хураах ажил шувтарч болзсон хурлын өдөр болоход аймаг даяараас морьтой явган олон эрчүүл, омгийн ахмад, бараа бологсод, хөгшин залуу, малгайтай, дээлтэй, цувтай, элчилгүй зэлүүд газар, ой модоор явж ирсэн нь зэр зэмсэг агсаж, дуулга, нум юлдтэй хүрч иржээ.

Нутгийн зах хязгаараас ч олон хүн ирж, наран мандах зүгийн Зличан, Пшавын хилээс, зарим нэг нь умар зүг, омогтой Лучин аймаг, Литомежицийн тэндээс, зарим нэг нь өмнө зүгээс, Нетолиц, Доудлебүүдийн тэндээс иржээ. Бас Крокийн шилтгээнээс цааш Стебнээс чанагш Домажлиц ороод цаашилж Герман Бавар газар нутаг ордог замын зүгээс ч явган иржээ.

Зочид олон ирсэн тул, шилтгээний хормойн айл гацаанд, гоё чимэгт эмээл, хазаар, дөрөө, даравч гэж гутлын өсгийд морь чичин давирах төмөр хэрэгсэл зэр, зэмсэг, хөх төмрөөр буюу улаан туяат зэсээр тоноглосон бамбай хийдэг урчуулын гэр оронд багтах шингэх зайгүй болж, унаа морь нь хашаанаас буюу модноос уяатай зогсоцгоожээ. Шилтгээний хормойн гацаа, мөрний захаар хөл чимээ ихтэй болж, хүн амьтан танил тал, төрөл саднаа баярлан мэндэлж, тариа төмс, ан гөрөө зэвсэг тулалдааныг ярилцан, ялангуяа өнөөх хоёр омгийн ахмад дарга нарын заргалдан тэмцэж, Либүшийн зарга ялгасан явдал, бас одоо юухан болж, чухам хэнийг сэнгүн жанжин болгож сонгох гэж байгааг хэлэлцэм билээ.

Хурал болох цаг ойртоход, хэрэм цонжоос бүрээ татаж, эрчүүл, цөм өндөр шилтгээний зүг цувж, шилтгээний хаалганы тэнд хоёр цамхгийн хооронд цувсан олон түр тогтож, хүн бүр толгойгоо өргөж, модонд хадаастай бодонгийн том толгойг гайхан харцгааж, гар хуруугаараа заалцан, хүн бүр гайхаж магтаж, амнаас Бивойн нэр ховхрохгүй шагшин хэлэлцэв. Тэндээс олон хүн, өндөр хаалгаар өргөн хүрээнээ засаглах, ноён ширээний зүг цутган цувж, хүрвээс, тэр гол ширээний хоёр хажууд бас хүндэт ширээ ич солгой хоёр этгээд засаж, түүнээ Кази Тета хоёр эгч нь Либүшийн хоёр талд суужээ.

Ирсэн олон цөм ноёхонд мэхийн ёсолсонд, ширээ дээрээсээ хариу ихэмсэг жавхлантайгаар толгой дохиж ёслоод өгүүлрүүн:

— Лех тайж, омгийн тэргүүн, бүх улс та бүхнийг энд зарлан ирүүлсэн учрыг минь та нар сонссон биз ээ. Та нар эрх чөлөөгөө эрхэмлэн үзэж чадахгүй улс байна. Түүнийг би танин мэдэж, туршлагатай боллоо. Онгон тэнгэр надад заан бэлгэдэж, та нар эзэн эрийг сэтгэлдээ хүсэмжлэх тул, та бүгдийг зонхилон мэдэхийг би байлаа. Та нарын хүсэж байгаа тань— хүү охины тань албандаа татаж, мал адууны тань аль сайныг таалалдаа нийлүүлж авах сэнгүн жанжинтай болох гэсэн байжээ. Урьд хааж хашиж үзээгүй алба хашиж

нэг нэг хэрэм үен, нэг нэг зах ёрог бүсний алба барих болж, зовлон зүдүүр үзэх эз тань татаж дээ.

Харин эм хүнд захирагдлаа гэж ичихгүй болох юм биз дээ. Би та нарыг айлган сүрдүүлэх гэсэн биш, онгон тэнгэрийн заан бэлгэдсэнийг л та бүхэнд хэлж, заяаг тэнгэрийн хоёр эгчид минь заяан бошигლოსныг л хэлж байна. Сэнгүн жанжин сонгохдоо сайн бодож сонгогтун. Засаг ноёныг өргөмжлөн залах нь амар, залснаа буулгах гэвэл хэцүү шүү. Та нар зорьсон санаа хэвээр бол, цөм санасан ёсоор тань болно. Хүсвэл тань, би санал зөвлөл өгч тэр хүний тань нэр, усыг хэлж өгье! гэхэд нь — Тэгж өг өө, тэгж өг!

— Санал зөвлөгөө хэл ээ хэл! гэж цөм нэгэн амаар дуугарцгааж урьд чив чимээгүй, зоомол шивээ шиг ажиггүй зогсон загнаж байсан олон цөм сэтгэл хөдөлж, ширээний зүг чихэлцэн түрж гэнэт салхи дайрсанд ургаа тариа нахилзан бөхөлздөг шиг хөдөлцгөөжээ.

Цагаан хувцастай, бас магнайдаа цэцгийн эрх зүүсэн, Либүше тэр олны өмнө өндөрлөн босож, гараа сарваймагц, цөм чимээгээ аядаж, өндөр дээр зогсож байгаа ноёхныг харан, хүн бүхэн дор дороо зогсоос, хуруугаараа умар зүгийн уул зааж, өгүүллрүүн:

— Үзэгтүн, тэр уулын тэртээ Лемузэд Белина гэж нэртэй нэгэн гол бий. Тэр голын ойр гацаа бий. Тэр гацаанд Стадич омогтон суудаг. Тэр гацаанаас асар холгүй уртаашаа өргөөшөө зуун хорь, хорин алхам хэмжээтэй нэгэн тариалангийн газар бусад тариалангийн дунд аль алинаас нь ч онцгой байх бий. Танай сэнгүн жанжин болох хүн тэр тариалангийн газрыг хоёр алаг үхрээр хагалж байгаа. Нэг шар нь толгой цагаан, нөгөө нь голоороо цагаан, гуя цагаан шар байх бий. Одоо ноён хүний хэрэглэдэг баринтаг дээл, цув, бойв аваад тэр хүнд барьж, миний болон, амьтан олны үг сонсгож, өөрсдөдөө ноён, надад эр нөхөр болох тэр хүнийг залж ирэгтүн. Нэр нь Пшемысль бөгөөд, үр угсаа нь энэ газар орны эзэн болж үүрд сууна гэхэд нь хамгийн эрхэм омгийн ахмадыг тэр Стадицын эрд барьц барьж, ард олон, ноёхны хамт санаа тогтсон үг уламжил гэж сонгосны сүүлээр Либүше тэдгээр элчид захиж,

— Та нар зам хайж сураглах хэрэггүй, миний морь та нарт зам зааж, удирдана. Сэжиг ажиггүй хойноос нь дагацгаа. Та нарыг зөв замаар хүргээд эргэж бас авчрах бий. Тэр морь ямар хүний өмнө очиж зогсоод унгалдана тэр хүн даруй миний зааж хэлсэн хүн болно гэж мэдээрэй. Тэгээд сэнгүн ноёноос төмөр ширээ дээр зоог амсахыг

үзэхийн цагт танай сэтгэлийн сэв тасрах бий гээд, дохимогц,
Либүшийн унадаг морь авч ирэхэд нь тэр цагаан морь унаган дэлтэй,
өргөн хүзүүтэй бөгөөд сагсгар үстэй хижимтэй, гоё сайхан эмээлтэй,
эмээлийн өргөн хөмөлдрөг нь хүрэл тав товруугаа гялалзуулж байлаа.

Эмээл дээр нь баринтаг, цув бойв тавимагц морь даруй хөдөлж,
ноён залах элч, хойноос нь даган замнасан гэдэг.





ПШЕМЫС ЛЫН ДОМОГ

Намрын эхээр, нартай сайхан намуун нэгэн өдөр, Либүшийн морь нь алсыг зорин хурдан алхаж, хамт явсан эрчүүдийн хэн ч тэр морийг хөтөлсөнгүй, түргэлүүлж дуугарсангүй, өөрөө л чигээрээ, гэртээ харьж яваа шиг эрслэн явах тул, тэр замаар анх удаа явж байгаа хэрэг биш, ноёхон, үдшийн бүрийгээр олон удаа явж, тахиа дуугарахаас өмнө үүрийн шөнөөр гэр орондоо буудаг байсан зам нь байлгүй дээ гэж дагасан эрс бодож явсан ажээ.

Тэр цагаас морь замаас нэг алхам ч гажсангүй, замдаа юу ч тохиолдсон саатаж чиг алдсангүй. Бэлчээрт адуу дайралдацгааж, баясгалантайяа унгалдаж, дуудах мэт боловч, цагаан морь замын хоёр хажуу тийш огт харалгүй, зорьсон зүг чиглэсээр, өргөн талд хээрийн лийр модны дор буюу улаан холтост нарсны хүүшид сууж амарсхийхэд, ноёхны морь баахан байсхийгээд, хамгийн түрүүнд замаа хөөж цаашлан явсаар, уул тал даван туулсаар хоёр хонож, хойд өглөө нь гол урссан нарийн хоолойн тэнд нэг гацаанд ойртож явтал замд нь нэг жаал хүү дайралдаж, түүнээс лавлаж,

За хүү минь, Стадиц гэдэг тэр мөн үү? гэж гацааг асуугаад, тэр гацаанд Бодлогот хэмээх Пшемьсл нэртэй хүн бий юу? гэж асууваас,

— Стадиц тэр мөн. Пшемьсл гэдэг хүн шараараа тэр газар хагалж байна гэж жаал хүү хариулжээ.

Тэр зүг харваас, өндөр нуруутай, нэг хүн, хөлдөө эм дом модны дурсаар хийсэн чархи гэдэг түрийгүй гутал өмсөж, анжис барин, шилээврээр, алаг шар тууж яваа нь, нэг шар, цагаан толгойтой, нөгөө шар нь голоороо цагаан бөгөөд хоёр хойд хөл нь цас адил цагаан ажээ. Тэр тариачин эрийн зүгт тариалангийн газрын хооронд өргөн заагаар явж очтол, ноёхны морь зогсоод, зам хөндөлдөөд, баярлан унгалдаж, анжсаа сугалж, шараа тавьсан тэр эрийн өмнө сөгдөн, толгой бөхийгөөд омгийн ахмад цагаан морь дээр ачсан ноён хүний хувцас үнэтэй үсээр эмжсэн урт дээл, үнэтэй сайхан цув нөмрөг, бойв аваад, Пшеммыслын дэргэд очиж сөгдөн ёсолж амгаланг эрсэн нь:

— Буянтай эр, бидэнд онгон буурал аав нарын зааж заяасан ноёнтон минь амар амгалан айлдаж байна уу? Шараа тавьж, баринтгаа солиод, энэ морин хүлэгтээ мордож, бидний хамт морилж айлд. Либүше ноёхон, чех бүх улс түмэн таныг бидний хамт морилон айлдаж, таны биед, таны үр угсаанд заяасан төр барин соёрхох ажаамуу. Бид бүгдээрээ таныг бидний хэрэг ялган шийтгэж, хамгаалан хаацайлах засаг ноён өргөмжилсөн билээ гэж айлтгасанд, Пшеммысл, нэгэн хэсэг дуугүй байгаад, шилээврээ газар дуугүй хатгаад шараа суллан буулгыг нь авахдаа,

— Ирсэн газраа оч гэж тавьжээ. Тэр үг хэлж бармагц хоёр шар агшин зуур ухасхийн алга болж, гацааны тэнд нэг хаданд хүрвээс, хад ангайгаад шарыг ормогц дахин урьд хэвээр битүү элгэн хад болсон гэдэг.

Тэгээд Пшеммысл, элчийн зүг өгүүлрүүн:

— Та нар арай эртдэж иржээ. Энэ газар хагалж гүйцсэн хойно минь ирвээс үеийн үед улс маань амуу будаагаар тасрахгүй амны хишигтэй болох юм сан. Та нарын яарснаар миний бэлэг зохиосон юманд саад болж, нутаг усанд маань өлсгөлөн тохиолддог болох нь дээ гэж байтал нь газар хатгасан тэр самрын модон шилээвэр нь дэлхийн шим шингэсэн адил, хавар навчлах мэт нахиа найлзуур гарч, гурван салаа салаалаад шинэ навч дэлгэрэн, самар ургажээ. Тэр жигтэй юм үзээд элч машид гайхаж, Пшеммыслыг анжсаа эргүүлээд, тариалангийн зааг дээр тавьсан дурсаар сүлжсэн сагс авч, талх бяслаг гаргаад, наранд гялалзах анжисны хошуу дээр тавьж наашаа сууж юм идэцгээ гэхэд нь,

— Либүшийн хэлсэн өнөө төмөр ширээ гэдэг нь энэ болж байна даа гэж элч бүр дотроо бодож, машид гайхав. Чингээд Пшеммыслын

хамт анжисны дэргэд сууж, идээнээс нь идээд ташмагаас нь ууж суутал, өнөөх шилээврээс салбарлан ургасан гурван салааны хоёр нь хатаж дороо ойчоод, үлдсэн нэг салаа нь өргөөшөө, уртаашаа сүрхий ургаж навч найлзуур дэлгэрсэнд зочид айн эмээж, Пшемыслээ тэр юун жиг вэ? Хоёр салаа нь хатаж ойчоод нэг нь ингэж жаргаж навчилдаг учир утга юу билээ? хэмээвээс,

— Түүний учрыг би хэлж өгсүү, Миний угсааны хүнээс ноёлох хүн олон гаравч, ганц нь эзэн ноён болж үлдэнэ гэсэн дохио гэлээ.

Элч тэгэхэд нь зоог барихдаа тариалангийн зах заагийн зүлэг дээр барилгүй, төмөр дээр идээгээ тавьсан учир юу вэ? гэж асууж гэнэ.

— Төмөр ширээ дээр идээ тавьж идсэн бэлэг бол миний удам угсааны хүн, засгийн эрх барихдаа төмөр мэт хатуу болохыг бэлгэдсэн билээ. Та нар төмрийг эрхэмлэн хүндэтгэ! Энх цагт төмрөөр газраа хагалж, бэрх цагт түүгээр дайснаас биеэ хамгаалагтун. Чехчүүд ийм ширээтэй байгаа цагт хөрш дайснаа хэзээд даран чадна. Харь дайсан гэр ширээг нь булаан эзэлхүл чехчүүд эрх чөлөөгөө алдана!

Тэгж хэлээд босож, элчийн хамт гацаандаа тийнхүү эрхэм алдарт болсон омгийнхоо хүнтэй салах ёс хийх гэж очоод, ноёны баринтаг өмсөж гялалзсан бүс бүслээд, ноён хүний бойв өмсөөд цагаан хүлгээ хүлэглэхэд нь их л баярлан унгалджээ. Замдаа омгийн ахмад, та юунд дом модон дурсаар сүлжсэн сагс чархи хоёроо авсан бэ? гэж асуувал,

— Миний ач үр минь хаанаас ямар гарал үүсэлтэйгээ мэдэж, ихэрхэг дээрэнгүйг тэвчин, харьяат хүн ардыг тэднээс илүү эрхэм язгууртай хэмээн бүү дарлаг, бид цөм тэдэнтэй нэгэн адил гаралтайг мэдэг гэж сагс чархи хоёроо та бүхэнд үүрд хадгалуулах гэж авсан² хэмээсэн билээ.

Тэгж аялан явсаар Вышеград гэдэг Өндөр шилтгээнд ойртон хүрвээс, Либүше, гялалзсан мөнгөн титэм өмсөж сайхан шүр, хув, чон цагаан хүзүүндээ зүүгээд, цагаан хувцастай, үзэсгэлэн жавхлан төгс угтан гарч, олон элчийн манлайд хүлэг морь унасан Пшемыслыг холоос харсан нүдэнд нь баярын сэтгэл тодорчээ. Ноёхон түүнийг аягач хүүхэн, сайчуул, омог омгийн эрхэм төрийн эрс, бүх хурал чуулганы олон лугаа хамт тэр элч, шинэ засаг ноёноо хүлээж байснаа угтан гарчээ.

Чингээд тэр үзэсгэлэн төгөлдөр сайхан эрийг үзээд цөм баярлалдан, ялангуяа залуу ноёхон, үүрд нөхөр болох хувьтай хүнээ Будечид үзсэнээр бүр ч баярлажээ. Хоёулаа бие биеийн гар барьцгааж,

шилтгээндээ баясгалантайяа ороход нь, бүх ард олон их баяр хөөр болон хамт дагалдан орсон билээ. Чингээд, бүгдээрээ бахдан, Пшемислыг засаг ноёны чулуун ширээнээ залж, сайн хүнийг засаг ноён болголоо гэж баярлан, Либүше ноёхонтой суух болсонд нь сэтгэл дүүрэн бахаджээ. Шилтгээний хормойн гацаанд ч уулын дээрх шилтгээнд ч их баяр цэнгэл болж, их тэнхим, уудам хүрээнд сайчуул зочид ширээ засан хуримлажээ.

Сайхан хоол идэж, бал сархад ууцгааж, дуулах нь дуулцгааж, хуурч нар хуурдаж, баатрын тууль дуу, өнгөрсөн үеийн дайн тулааны шастир дуу дуулахыг сонсон цэнгэжээ. Засаг сонгон өргөмжилснөө магтаж, ноёхноо гэрлэн төрлөснийг өдөр ч магтан шөнө дөлөм ч гал түүдэг бамбарын гэрэлд магтан хуримлаж, гал унтарцгаан, ой мод дээгүүр үүрийн гэгээ шарлах үес Өндөр шилтгээнээ найрласан хэвээр мөн шилтгээний хормойн айл гацаанд ч хуримын дуу чимээ тасраагүй, үүрийн жавар тэр найр цэнгэлийн дууг мөрний тэртээ цайвар манан татсан ой модонд цуурайтуулж байсан гэдэг.

Стадиц омгийн хүн тэр Стадице сууриндаа нэгдүгээр Вацдав ноёны үед хүртэл сууж байсан үүнд тэр ван, хөдөөгийн харц гаралтайдаа ичингүйрч, «омгийнхоо хүнийг Стадицаас хөөлгөөд сууриныг Германд өгсөн» гэж түүхч Далимил тэмдэглэсэн билээ. Тэр гацаа нь герман болсон боловч, одоо хүртэл чех нар нь газар усанд үлдэж, Пшемислын тариалангийн газрыг «поплужи» анжисны газар гэж нэрлэн, гацааны тэндэх голыг «поток» буюу горхи гэж нэрлэсээр иржээ. Балар цагаас нааш вангийн өмч сул хашаат газар байсныг Люцембургийн Яны тэр хашаа байсан гэдэг. Дөрөвдүгээр Карел ван, тэр хашааг өөртөө, мөн хойч үеийн чех вангуудад Пшемислын тариалангийн талбай гэдэг нэртэй газар үлдээж, Пшемислын самрын модноос жил бүр Прагад, вангийн ширээнээ хэрэглэх самар нийлүүлж, бай гэж тогтоосон гэдэг.

Тэр Пшемислын тарианы газар буюу вангийн тарианы газар нь Стадицаас баруун урагшаа Трмицкохлинянске замын хавьд бий бөгөөд XVIII зууны үе хүртэл хэвээрээ байсан байна. Улс төр газар тарианы хутаг үгүй гэж хэлэлцдэг байжээ. Одоо тэнд Эрвин Ностиц гүнгийн 1841 онд босгосон дурсгалын хөшөө бий. Тэр гэрэлт хөшөөнд үсэг буй ину:

ЭНД ПШЕМЫСЛ АНЖИСНААС СЭНГҮН НОЁН ӨРГӨМЖЛҮҮЛСЭН БҮЛГЭЭ МDССС ХL1 ОНД БОСГОВ

гэсэн бичээстэй бөгөөд 1945 онд Стадицыг чех болгоход бас үсэг нэмэн сийлсэн нь:

ЧЕХ ТҮМЭН ЧАМДАА ЗАСАГ ЧИНЬ БУЦААЖ ӨГЛӨӨ 1945

хэмээжээ. Тэр хөшөө эрт цагт Пшемыслын шилээврээс ургасан самрын мод байсан газар босгожээ. Тэр мод урьд модон хашаатай байсан бөгөөд ургадаг самарт нь хоосон буюу хорхой идсэн самар нэг ч байдаггүй. Тийм сонин байжээ. Тэр мод хатаад тавиад жил боллоо. Түүнээс нэг салаа Билинь голын дэргэдэх нэг усан тээрмийн цэцэрлэгт тарьж ургуулсныг 1845 онд үер тэр цэцэрлэгийг урсган үгүй хийж, мод нь үгүй болжээ. Стадицын зүүнтээ нэг хадан хясаа бий. Түүнийг Пшемыслын төр шингэн орсон хад гэж хэлэлцдэг. Голын тэртээ, гацаанаас гурван зуугаад алхмын зайс өндөр дом модны дор нэг худаг бий. Пшемыслын буюу «вангийн» худаг гэж хэлэлцдэг.



ЛИБҮШИЙН Б ОШИГ ДОМОГ

Амрагжин гэдэг Либүше Бодлогот гэдэг Пшемыслыг чингэж засаг ноёхны ширээнд суулгасан бүлгээ. Найр хуримын сүүлээр бүдүүн төмрөөр өнгөлсөн хүнд хаалгатай бөгөөд газар дор хаданд ухсан гүн танхимд нөхрөө дагуулан ороод, төмөр, хүрэл, алт, мөнгөний туяа туурга, бүдүүн ширээнд туссан түүнээ юлд, давтмал товруут бүс, шовгор дуулга, хөө хуяг, сайхан хийсэн төмөрлөг бамбай өлгөөтэй бөгөөд бугуйвч, тээг, бэлзэг, мөнгөн утсаар хийсэн титэм, шүр, хув, эрдэнийн чулуу, болор эрдэнийн төмөрлөг сондор, цул мөнгө, алтан ембүү өрсөн цар дүүрэн байжээ.



Нөхрийн өмч бололцсон гэж тэр эрдэнийн санг цөмийг үзүүлээд, тэндээс цэцэрлэгтээ дагуулан аваачиж, хөгшин модны нөмөрт байдаг онгон шүтээний тэнд хилэнт Перүн онгоны мөнгөн толгой гялалзаж байдаг газар очиж үзүүлжээ. Хавар цаг тэнд хоёулаа сууж, чухал юм ярилцдаг байсан гэдэг. Нуурмагийн тэнд, онгон ойн сүүдэрт бас очиж удтал сууж, Либүшийг хүүхэн байх цаг аягачидтай зугаацаж, усанд ороод, сайхан үсээ хүүхнүүдээр самнуулж, сэтгэлд таатай дуу дуулуулдаг газраа бас очдог байсан гэдэг.

Тэдгээр газар нөхөртэй явж, цааз хууль зөвлөн тогтоож, хэлэлцдэг байсан гэдэг. Чингээд Пшемьсл олон хууль тогтоож, дураараа улсыг дүрэмтэй болгож, үр угсааны ноёд нь тэр цаазаар олон зуун жил хэрэг шийтгэн ялгадаг байсан гэдэг. Мөн тэнд Либүше онгод орж, ирээдүйн бошиг үзүүлдэг асан гэдэг.

Нэгэнт Либүше Пшемьсл цэрэг нөхдийн хамт Влтав мөрний өндөр хадан хясаа дээр зогсож байгаад, нигүрс, агч мод, өндөр уд модны доогуур Ботич горхи урсдаг нам газар, түмэн цэцэг болсон нугад урт сүүдэр татаж, Чонын хаалга³ гэдэг Влчий браанад шар гэрэл тусаж чонын хаалганы доорх хөндий мөн баруун гар талын өргөн өндрийн тэндэх тарианы газар алтан шар өнгөтэй болон үзэгдсэнд сайхан боловсорсон тариа харж, юутай сайхан ургаж вэ? гэж баярлалдваас, цэрэг нөхдийн дунд байсан өвгөн ахмад, шинэ хот

байгуулах газар шинжин олох гэж сайн дурсгалт талийгч сэнгүн ноён, улс явуулахад, тэдний хамт явж, энэ газрыг үзэхэд урьд ямар байсныг дурдан;

— Элчилгүй буйд газар дан ой мод, яг тэрүүн шиг! гэж баруун зүг, мөрний тэртээх модот уул наранд гялавхийж байгаагийн зүг гараар зангажээ. Тэр гялалзсан өргөн усан мандалд шугуй ихтэй, мод, ширэлдэм зузаан сөөг болсон олон арал тодрон үзэгдэж, жигүүртэн дээгүүр нь эргэн нисэцгээж, шар айраг хийхэд хэрэглэдэг зэрлэг хөрөнгө өвс мод бут сүлжилдэн ороосон эргийн бараан сүүдэрт усны шувуу шуугилдан үймэлдэж байсанд, Өндөр шилтгээний хадан хясаа дээр зогсож байгсад, өвгөн ахмадын заасан газар олон арлын дээгүүр мөрний тэртээ ширтвээс, эргээс өөдөө Петжин, Страхов зэргийн толгод тэргүүтнээр өргөн их ой мод бүрхэн ургаж, хөх хүүш сүүдэр тэр эртний ой модонд тусаж оройгоор нь алс тэртээ нарны гэрэлд нэвтлүүлсэн утаа өндрөөс суунаглаж, түүнийг үзвэл, ямар нэгэн гөрөөчин хүн, зузаан ойд гал түүдэг түлсэн бололтой.

— Тэр ой мод хядахаас нааш, өлөн чоно бидний сүрэгт халдах нь мөддөө тасрахгүй. Страховын цаана, Шлахов Малепов, цаашаа бас тэр уудам хол газар хэчнээн их модтой гэж бодно. Хядаж эс гүйцвэл... гээд, тэр өвгөн ахмад үгээ дуусалгүй зогсож, дэргэдэх хүн ч өвгөний үгийн үргэлжлэлийг сонсолгүй цөм урд нь зогсож байгаа хатныг хөдөлж түйвээхээс эмээн зогсож харвай. Хатан түүний царай нь гэнэт, нүдийг нь хүртэл гялалзуулсан онгон тэнгэрийн хутаг шингэсэнд гэрэлтэй гэгээн болоод, цэрэг нөхөд цөм сэтгэл хөдлөн бишрэн эмээж зогсон авай.

Либүше дэргэд нь нөхөр, цэрэг сэлт байгааг огт үл анзааран, сэтгэлийг нь эзэлж, мөрний тэртээх хөхрөн харагдах уул толгодын зүг гар сунган, ирээдүйг бошиглон өчрүүн:

Алдар нь одон оронд дуурьсах их хот үзэгднэм.

Гучин харвалын тэртээ ой дунд Влтав мөрний тохойд нэгэн газар байнам.

Умар зүгээс гүн хавцал дахь Бруснице голоор хашуулж, өмнө талд нь Страховын ойн тэнд хадтай уул үзэгднэм.

Тэр газар хүрвээс, байшингийн босго засаж байгаа нэг хүн байх бий.

Түүгээр бэлгэдэж, газар түүнээ босгох хотыг Прага — Босго балгас хэмээн нэрийдмүү. Ноёд сэнгүн жанжин босгын өмнө

бөхийдгийн адил, миний тэр хотын өмнө цөм бөхийх болмуу.

Хотол даяар хот түүнийг өргөн магтаж, дэлхийд алдаршмуу гэж хэлээд дахин юм хэлэх ч байсан болзошгүй, гагцхүү сэтгэл хөгжөөн хөдөлгөсөн юм нь гэнэт нам болсон буюу бошиг зарлиг буулгах онгон зайлсан болов уу, чимээгүй болжээ.

Чингээд тэр дороо мөрний тэртээ өөдөө хөгшин ойд явж, хүрвээс, Либүшийн үзэн зарлигласан ёсоор нэгэн дархан хүн юм хийж байсныг олж тэнд нь шилтгээн босгож үүсгэсэн билээ. Өндөрлөн босгосоор, бат хэрэм цогцлон бэхэлж, ялангуяа баруунш Страховын ойн зүгээс халдахад хялбар гэж нэн хичээн бэхэлжээ. Тэр газар гүн гуу эрж, өндөр далан шороогоор цогцлоод, далан дээр модон хэрэм босгож, тэр хэрэм, мөн хаалганд нь өндөр цонж цамхаг бариад хэрмийг галын аюул, гал үүсгэх харвуул сумнаас хамгаалж, модон хадаас шаацгааж, сүрэл хольсон шавраар дээрээс нь шавж, цонж цамхгийг шавмал болгожээ.

Чингээд Прага гэдэг Босгон шилтгээн маш бэх бат болж, Өндөр шилтгээн Вышехрадын хамт бүх чех нутгийн эзэн хот болсон билээ.

Нэгэн цагт зарим нэгэн омгийн эзэн ахмад аймаг олондоо эрхэм болсон өтгөс Вышехрад гэдэг Өндөр шилтгээнээ ирж, Пшемислын зүг өчрүүн:

— Ноёон, бидэнд юм бүхэн элбэг дэлбэг. Мал тариа, загас ан цөм байна. Ганц төмөрлөгийн зүйл дутаж байна. Бидний өөсөө газраас ухаж гаргадаг төмөрлөг багадаад, харийн худалдааны хүнээс арьс шир, адуу мал, бал сархдаа өгч төмөрлөг авч байна. Чи мэргэн хүн, хатантай зөвлөн хэлэлцээд, ямар нууц газар алт мөнгөний зэрэг төмөрлөгийн зүйл, бас бус хүдэр байгааг бидэнд билгүүн нүдээр зааж өгөөч гэж хэлмүү гэхэд нь Пшемисл хүслийг нь сонсоод, одоо нутаг усандаа түр буцаад, арван тав хонож, энд шилтгээнд хүрч ирээд хариу сонс гэжээ. Тэр болзсон өдөр ирвээс, Пшемисл засаглах ширээнээ залран сууж, Либүше дэргэд нь тамга тэмдгээ зурсан модон ширээн дээр сууж байв. Пшемисл тэдний зүг өгүүлрүүн:

— Чех нутгийн зоригтон эзэд, эрчүүд сонсоцгоо! Эх юүгээн үг тогтоогтун: та нар болон ач үрийг тань баяжуулах үг сургаал хэлэм заа гэхэд, цөм эрхэм хатны зүг харваас, онгон орж, босоод, хүрээгээр явж, цаашаа хэрмийн захад хүрсэнд Пшемисл дэргэд нь явалцаж, хатны аягач охид, ирсэн эзэн ахмад хойноос нь дагалдаж одов. Влтав мөрний тэнд өндөр хадан хясаа дээр зогсоод өгүүлрүүн:

Хадан дотор д элхийн гүнд байгааг
Миний үгээр тэнгэр заан үзүүлнэм

гээд, наран шингэх зүг хандаж, гар занган өгүүлрүүн:

Хуст уулын оройг үзнэм мөнгөн с удал тэнд бий
Эрсэн хүн эрдэнийн зүйл тэндээс олном заа.
Өнөзүгийн хөрш, у рилгат ай урилгагүй ирж,
Эрх чадал олгох тэр эр дэнийн зүйлд шунам заа.
Сайт ар болгоомжл оорой: дэлхийн тань тэр д ээжээр
Санамсаргүй т а нарт б оолын гинж хийх бий

гээд урагшаа үдийн нарны зүг эргэж өгүүлрүүн:

Лайт уулын оройг үзнэм, алт аар дүүрэн байна.
Алтан түүнээ агуу их хүчин бий.
Энхрий сайхан сэтгэ лийн хайр алдвал,
Хүчин буурч, өнүүхэн буурай болном т а.

гээд наран мандах зүг хандаж бас бошиглоруун:

Гурван оргилт уул тэнд бий, дотроо
Үеийн үед мөнгөөр баян уул
Гурван оргилт түүнээ гурван удаа
Эрдэнэ нь хаягдаж гурав дахин сэргэх болно.⁴
Харь газрын хүнийг далах нь эм дом мод
Цэцэглэх үес болж зөгий бөгнөрөн бүжиглэх мэт
Эрдэнийг нь эр зөгий мэт дэмий суугчид олохгүй,
Балт зөгий мэт цуцалтгүй ажилтан сая олно:

гэж хэлээд умар зүг хандаж өгүүлрүүн:

Хайр чулуутын оройг үзнэм, түүний дотор
Хар цагаан тугалга бүдэг өнгөтэй гялалзам.
Хил дээр байгаа туул түүнийг хамгаалж,
Хил хайчийг сахих цагдах хэрэгтэй байна.
Нэг төгө газар тэнд өөрсдөөгч алдвал,
Нэг хэсэг газраа алдана аа гэж мэ дээрэй

гэж тэр эрдэнэ, төмөрлөгийн хүдэр гарах газрын нууцыг зааж өгөөд,
үгийг нь чимээгүй хичээнгүйлэн сонсож байсан омгийн эзэд, ахмадын
зүг ийн өгүүлрүүн:

Долоон эрдэнэ төмөр лөгийн гэрэл т анай газар т ат аж,
Үржил сайт т ариаланд алт ан будаа гялалзнам
Ах дуугийн айхан ёс гээж алдалгүй,
Харийг дагалгүй, хуучин заншаа хүндэтгэ ж,
Өгөдийн ц ус, хөдөмөр үг х элээр эрхэм болсон
Эцгэдийн нутаг усыг эрхэмлэж байгаа ц агт
Үеийн үед үр ач т ань энд оршин сууж,
Хүч чадал, хувь ерөөл төгөлдөр байна!

гэжээ.

Либүше оршин суудаг газраасаа доошоо, Өндөр шилтгээний хадан
хясааны ёроолд бууж, Влтав мөрний нэг гүнзгий цээл усны тэнд усанд
ордог буйд газраа очдог байсан гэдэг. Тэр усанд орох газрын захад нь
зогсоод, урсгал усны нууц гүнд нь харж, онгодын үзүүлсэн хэт хол
ирээдүй цагийн байдлыг билгүүн нүдээрээ үздэг байсан гэдэг.

Урсгал ус яралзан мэлтэлзэж, харлан харагдах мандалд нь түмэн
үзэгдэл тодорч, урсгал уснаа завхан одоход үзэгдлийн цуврал улам
улам гашуудан гуним болж, зүрх шимшрэн, сэтгэл чилэх бүлгээ.



Либүшийн царай нь эмээн зэвхийрч, шуугинах усны сүртэй үзэгдлийг ширтэн харж байхад нь аягач хүүхнүүд айн эмээж хатан эзнээ харваас, сэтгэл үлэмж чилж гунин гашуудсан хоолойгоор өгүүлрүүн:

— Их гал дүрэлзэхийг үзнэм, бараан усанд тэр галын дөл туснам. Суурин тосгон, шилтгээн балгас шатаж, аяа цөм сөнөн мөхөж байна!

Тэр их гал дундуур дайн тулаан болж, цустай их тулаан болж байна. Хөхрөн хэвтэх хүүр, цус шарх болсон хүүр! Ах, нь дүүгээ алж, харь дайсан шилийг нь гишгэн дарж байна. Олны гамшиг дарлал, бэрх торгууль төлбөр амсахыг үзлээ би! гэхэд нь охид, хатны анх гарсан хүүгийн алтан өлгий авчирсанд Либүшийн нүд царайд тайтгарах шинж ороод, Өлгийг таалаад, цээл усанд хийж, сэтгэл хөдөлсөн дуугаар усан дээр өнгийн өгүүлрүүн:



— Цагаа иртэл, хүүгийн минь өлгий гүн усны ёроолд байж бай. Харанхуй усны ёроолд чи лав үүрд хэвтэхгүй. Эх нутаг лав харанхуй зовлонд үүрд автагдахгүй. Цэлмэг сайхан өдөр болох цаг бий, миний ард түмний жаргах цаг бас бий.

Зовлон нь нимгэрч хайр хөдөлмөрөөрөө чийрэг болоод, хүсэн мөрөөдсөнөө олж, алдар нэрээ мандуулах цаг бий.

Тэр нэгэн цагт харанхуй усны ёроолоос өлгий өөдөө гялалзанхан дэгдэж гараад эх нутгаа аврах заяатай эрт дээр цагаас бошигтой хөвүүн үрийг өлгийдөх өлгий нь болно чи гэжээ.

Он жил, өнгөрсөөр хэмжээтэй цаг нь болоод ирэхэд, урьд өвчтөнийг ид их чадлаараа тэнхрүүлж байсан Кази өөрөө мөнх бусын дүр үзүүлж, Бэхийн муж Осек даваагаар давж ордог замын тэнд Мжа голын эрэг дэх түүний шилтгээний ойр булш дээр нь амьтан өндөр овоо босгож, дурсгал болгосон билээ.

Чингээд буянтай Тетийг эрлэгийн элч бас залж, Тетины бүх нутгийнхны хүн бүхэнд эх мэт ачтай тул, ихэд гашуудаж, чандрыг нь хайлуулан нисгээд онгон тэнгэр тахиж тайдаг хөгшин царс модны тэндэх тайлгын газарт нь ойр шиг наран шингэх зүг Похлед гэдэг Үзэлтийн уулнаа оршуулжээ.

Тэр газар их түүдэг есөн хоног асааж, онгодыг тайж, оршуулсан газар нь том чулуу босгожээ.

Чингээд Либүше хоёр эгчээ өнгөрөхөд ганцаараа үлдээд бас л насан эцэс болох цаг нь ойртсоныг онгод тэнгэрийн бошгоор мэдэж, эцэг эгчийн хойноос явах замд төхөөрч, Пшемьслыг лех гэдэг тайж, омгийн ахмад тэргүүлэгч нарт захиа гэрээсээ захих гэж зарлан ирүүлэхийг хүссэнд цөм өндөр шилтгээнээ хуржээ. Чингээд Либүше онгод тайлгаад, өргөн хүрээнд цугласан лех тайж, омгийн тэргүүлэгчийн дунд Пшемьслын хамт ороод ирэхэд нь олны хүндэтгэдэг тэр хатны зэвхийрсэн царайд энхжихийн амарлингуй шинж тодорч, нүд нь мөнхийг бясалган харжээ.

Олон бүгдэд цаг минь болж, та нартай сүүлчийн удаа уулзаж, сүүлчийнхээ үг хэлье гээд, та бүхэн Пшемьсл ноёндoo, хүүд нь итгэж, хүчин өг гэж захин хэлэхэд, ойр оршиж байсан цөм сэтгэл гуньж тэр үг сонсов. Олноо хичээн асраарай гэж нөхрөө гуйгаад гараа сунган, ерөөл үгээ хэлэхэд нь олон бүгд энэлэн шаналж, сахалтай эрс ч гэсэн, нулимсаа мэлтгэнүүлжээ.

Гэртээ эргэж ороод бүгдийн эх болсон хөрст дэлхийн газар шороо дээр хэвтээд нас барсанд нөхөр хүү хоёр нь уйлан хайлж аягач эмс, хамаг амьтан уй гашуу болж, хүүрийг нь залж галд хайлуулан нясгаад чандар үнсийг нь оршуулан, их хойлго тайлга хийжээ.

Чухам хаа оршуулсныг мэдэх хүн үгүй. Хууччуул, Либүшийн шилтгээнд оршуулсан гэдэг. Зарим хуучин үгэнд бас сайхан өвс үндэс

бүхий нууц төгөлдөр Ошкобрхын толгойноос ойр шиг Либицийн шилтгээнээ оршуулсан ч гэдэг.

Либүшийн эрдэнийн сан, нас элэгдсэн хойно нь ч, хадан агуй, зооринд нөхөртөө үзүүлсэн газраа хэвээрээ үлдэж, Пшемысл түүний зорилгыг мэдэх тул, гар хүрсэнгүй. Тэр нуусан эрдэнийн зүйл одоо хүртэл Вышехрад гэдэг Өндөр шилтгээний хаданд байсаар бөгөөд үнэ өндөр хатуу бэрх цагт гялалзан тодрох юм гэдэг. Тодрон гарч, нээгдэн олоход нь юм бүхэн элбэг дэлбэг болж, гачигдах дутагдах зовлон тасрах юм гэдэг.

Либүшийн тэр өлгий, Өндөр шилтгээний хадан хясааны хормойн Влтав мөрний ёроолд их л удсан бөгөөд, цаг үе улиран өнгөрч чех нутагт гай гамшиг цувран тохирсоор гацаа суурин, хязгаар нутаг баларч, хот тосгон галд автагдан, төрсөн нутагт байлдааны цусан бялтаж ялангуяа Либүшийн ач үрийн дунд ах нь дүүгээ хорлож, харьтан хүзүү шилийг нь гишгэж дарлаж байлаа.

Чингэвч гаслангийн шөнөд эцэс бас байжээ.

Вышехрад гэдэг Өндөр шилтгээний ёроолын тэндэх алтан өлгий, харанхуй уснаас дэгдээд, шижир алт нь цайвал зах ёроолоос гялалзан гарч, эх нутгаа аврах заяатай хүү тэр өлгийн эзэн болж эдэлсэн нь Пшемыслын уг удмын сүүлчийн залгамжлагч хүү байжээ.

Алтан өлгий, тэр хүүгийн өсөж торниход бас их бол болсоор алтан ор болоод, хэвтсэн хүү нь эр болж, эх нутгийнхаа эцэг мэт эзэн нь болсон гэдэг. Чингээд, шүтээн болсон Карлштейн шилтгээнд тэр онгон орондоо хэвтэж, төр барьж, түмэн хэрэг шийтгэн алжаасан чилээгээ гаргадаг байсан гэдэг. Насан элэгдэхэд нь тэр ор, өөр хүнийг хэвтүүлэхгүй, үл үзэгдэх болж, өлгий болж, уг байсан усандаа харангуй цээлдээ, Өндөр шилтгээний ёроолд ороод, тэнд бас цагаа хүлээ хүлээсээр бий гэдэг.



ОХИДЫН ДАЙН

I

Либүшийн нас элэгдсэн хойно түүний шадар охин цэрэг байсан хүүхнүүд, хатан эзнээ сэрүүн тунгалаг байсан үетэй адилгүй, хойшоо тавигдсаныг үзээд,

— Та нар ноёлж байсан даа. Бид та нарт ёсолж мөргөж байсан даа. Одоо та нар сүргээс тасарч төөрсөн хань боллоо гэж эрчүүдийн инээмсэглэн хэлэхэд, хор нь буцалж, хорсол нь хөдөлж, хатагтайн ганцаараа газар ус, эрчүүд бүгдийг захиран суудаг үед юутай эрхэм байснаа санаад дотроо бухимддаг байж гэнэ.

Чингэ чингэсээр битүү хорсол нь гадагшаа гал мэт зад тавьж өшөө хорсол өвөрлөсөн сэтгэлд автагдан, олон охид, юлд нум шүүрцгээгээд, хэрээ бодолгүй, эрэгтэйчүүд бүгдтэй тулж эхэллээ. Урьд Амрагжин гэдэг Либүшийн хүүхэн цэргийг тэргүүлж байсан Власта гэдэг нутагжин охин тэднийг удирдан, байлдаан хийе гэж өдөөгөөд, байлдах зэвсгээ хамгийн түрүүнд барьж, охидоо нэгтгээд, бат шилтгээн барьж эхэллээ.

Шилтгээн түүнийг орогнон хоргодох газар болгож Влтав мөрний захад, тэртээ эргийн Вышеград гэдэг Өндөр шилтгээнээс дээш барьжээ.

Охид Властыг ноёгтой эзэн гэж үг зарлигийг нь дагадаг болж, түүний зөвлөн тушаасныг дагаж, зүг зүг олон охид явцгаан, эмс охидыг хамаг юмаа хаяж Охидын шилтгээн гэдэг тэр шинэ шилтгээнд оч, эмэгтэйчүүд газрын эзэн болж, эрчүүд тэдэнд зарцлагдан, анжис барьж яваг гэж эрчүүлийг дагуулах байлдаан, хийхийн ухуулга хийлгэх гэж явжээ. Властын тэр уриа салхинд хийсэх хоосон үг бус, олон эмсийн сэтгэлд оч мэт хоногшин гал бадруулах үг байгаа тул, үүрээсээ нисэн гардаг тагтаа шиг, эмс охид, эр нөхөр, эцэг, ах дүүгээ гээж, Охидын шилтгээнээ танхим, байшин уудам хүрээ, өндөр хэрэм далангаар дүүрч, эрчүүд холоос Өндөр шилтгээний тэндээс тэднийг харж, эмс охид зэвсэг морины сургууль хийж байхыг хараад шоолдог болж, хашир өвгөд тэр эмсийг үл тоомсорлон Пшемысл ноёны дэргэд эмсийн тухай яриа үүсэхэд, эмсийн чадал үзнэ гэж дооглон хэлэлцдэг байжээ.

Носны хавийнхан цөм, одоо л эмсийн мууг нь үзэх, муухайг нь харна гэж инээлцвээс, Пшемысл санаа зовж, бодлого болон өгүүллрүүн:

— Миний та нарын хамт үл инээх учрыг сонс. Миний зүүдэнд орсныг та нар үзсэн бол, та нар ч бас ингэж тоглоом тохуу хийхгүй сэн гээд, тэднийг сануулах гэж зүүд зөнгөө хэлсэн нь:

— Нэгэн шөнө, утаа хүдэн ихтэй үес түймрийн туяанд би нэг охин үзлээ. Дуулга дотроос урт үс нь хийсэж, наг гартаа юлд, нөгөө гартаа аяга бариад явж байсан тэр охины дэргэд хөсөр цус нөж болсон эрсийн хүүр хэвтэж, тэр охин ийш тийш галзуу мэт гүйж, хүүр гишгэн, аяга дүүрэн цус уудлаад араатан адил шунан ууж байгааг үзлээ. Аяа эрчүүл тануус, тэр бол учиртай зүүдэн үзэгдэл, муу ёрын шинж билээ. Тэр дэмий үзэгдэл биш, миний энэ үг сонсож, сэрэмжлэгтүн гэж билээ.

II

Чингэтэл Охидын шилтгээний эмс байлдаан хийх гэж, ясан төрөл гэж хэлэлцэхээ байж, эцэг ах дүүдээ хатуу сэтгэлээр зарласан нь:

— Бид та нарт огт хамаагүй боллоо. Өөрсдөө өөрсдийгөө бодоцгоо! гээд, хоорондоо санаа нэгтэй байна гэж үгсэн тогтоод, санаа няцсанаас, өөрийн юлдэд үхсэн дээр гэж шахаан андгай тавьж, тэр

охид эмсийн тус бүрд байх байр хийх ажил оноосон Либүшид тангараг өгчээ.

Сэцэн нэгийг нь хууль зөвлөлд суулгаж, нямбай соргог нэгэнд нь шилтгээнээ сахиулаад, зүрхтэй нэгийг нь гадагш байлдах цэрэг болгон, морь унаж, эрчүүдийг дайран нохой алах мэт хядах үүрэг ноогдуулж, өндөр нуруутай, сайхан царайтай, эрсийг даллах нүдтэй нэгийг нь сэртэнтэж, гоо үзэсгэлэн, сайхан аашаараа эрчүүдийг сөнөө гэж эр хүйстнийг хүч арга хослон хорлох гэж санаа тогтжээ.

Эрчүүд сэтгэл төөрөгдөн Пшемьсл ноёны сануулах үг эс анзаарч, Девин гэдэг Охидын шилтгээний зүг одохдоо, найр хуримд очих адил хөнгөн үзжээ. Хүн бүр бие үзэгдэж, юлдээ гялалзуулмагц эмс эмээн сүрдэж, буурцагтай хорчигнуурын чимээгээр зугтаах мийн адил тархан дутаах бий гэж боджээ.

Гэтэл, гайхалтай юм болж, охид ер хэрэм дээр ч үзэгдсэнгүй. Айж зугтаасан ч үгүй. Шилтгээний хаалгаар шууд жагсан гараад, өнөөх Власта байлдааны жагсаал хэрмийн гадаа жагсааж, хар морь унан, хөө хуяг хуяглан, тэргүүнээ дуулга өмсөөд, гартаа жад барин, охин цэргийн зүг зориг бадруулах үг хэлж, хулчийлгүй байлдах сэтгэл бадруулсан нь:

— Дарагдахул, эрчүүд биднийг доромжилно. Тэдэнд дарагдаж бүр ч муугаа үзэж, шивэгчин нь болно. Тэднийг дагаж муугаа үзэж, муухайгаа дуудуулснаас үхсэн дээр бий. Дайран орцгооё. Амь өршөөж үл болно. Хэн ч байсан хамаагүй, эцэг ч гэсэн, ах ч гэсэн, алаад л бай цугийг нь ал ал! гэж хэлэнгүүт, морио ухасхийлгээд, хашхиран дайрч жадаа эргүүлэхэд нь, хойноос нь сүртэй хашхиралдан дайран орж гэнэ. Дайчин эмс байлдаар довтолж, магнайд нь Властын хойноос Млада, Сватава, Ходка, Радка, Частова гэдэг охид давхилдаж, эмсийн харвах сум, эрэгтэйчүүдийн дээр шороон шуурга мэт дайран бууж, тоглоом тохуу хийх байтугай! амь насаа гэж сандарч, цус урсган ганц нэгээр ч барахгүй, эгнээ эгнээгээр ойчиж эхлээд ухаан сэхээ орохын завдгүй олон охид довтлон дайрч, юлдээр хядан алж, сандарсан эрчүүдийг хатган жадалж, цавчин алав.



Хоромхон тулалдтал, гурван зуун эр хүн цусаа урсган унаж, бусад нь зугтаагаад, ойр хавьд байсан бараан ширэнгэ ойд амь зулбан оржээ. Тэр ой үгүй бол цөм хядуулах асанж.

Охидын шилтгээнийхэн, тэр хавийн олон эмс цөм дийлсэн баярын дуу шуу болж, ялснаа бахархаж, байлдах зориг нь улам ч бадраад, өдий төдий эмс хүч нэмэн цувж ирлээ. Дайснаа дарсан тэр чимээгээр, сэтгэл хоёрдож байсан эмс ч гэсэн зориг шулуудан ирцгээж, орон нутагт эрчүүд муугаа үзэх цаг боллоо. Энд тэндгүй өглөө бүр ийм ч эрийг алсан тийм ч эрийг хутгалж хороосон нь олдож, амь хорлох бий гэж хүн гэртээ хонохоос айж, ой шугуйд хонодог болжээ.

Охидын шилтгээн орчин бас эрэгтэйчүүдэд зовлонтой болж, шилтгээнд яаж ч халдаж болохгүй, хүч ч хэрэглээд, арга ч хэрэглээд яджээ. Шилтгээнд ганц ч эр хүнгүй, охид эмсийн дотроос урвах ганц ч хүнгүй. Бас Охидын шилтгээний эмс, нууц мэдэх уламжлах найзтай болж, эрчүүд юу хийх яах гэж байгааг андахгүй, хаа тосож халдахыг алдахгүй болжээ.

Чингэж илээр тал газар, далдуур нууц аргаар тулаан хийсээр удаж, нэг царай сайн хүүхэн гэнэн залуу хүүг Охидын шилтгээний цаагуурх

замаар арван найзтай явна. Тэр үеэр дайрч, намайг салгаж ав гэж хууран мэхлээд, болзсон газар тэр залуу хүүг нөхдийн хамт хүрч ирэн хүлээтэл, өнөөх хүүхэн ч есөн найзын хамт ирээд, гэнэт цаанаас нь бүгсэн олон эм цэрэг гарч, тэр залуу хүү нөхөд сэлтийг хороожээ.

Бас нэг залуу эр, Властын нэг охин цэргийн үгэнд итгэж, Охидын шилтгээнийг гарт нь оруулна гэж хуурсанд мэхлэгдээд амь үрэгдсэн нь, тэр хүүхэн нөгөөдүүлтэйгээ үгсээд, өнөөх залуу хүүг олон нөхөд сэлтийн хамт шөнө шилтгээнд сэм оруулсан хойно, нэг нь ч амь гарсангүй гэдэг.

Цтирад гэдэг Хүндбаяр хэмээх цэвэр залуу даргыг Власта байлдаанд олон ахин цэрэг алсан хүн гэж өшин үздэг тул, уран аргаар бас сөнөөн хорлосон билээ.

III

Зуны нэгэн өдөр Хүндбаяр гэдэг Цтирад, бараа бологч хэдэн хүний хамт Прагын шилтгээн орох гэж омгийнхоо гацаанаас хөдөө тал газраар цөм юлд агсаж, сагсгар хоромсого агсан явсан нь эзгүй хээр зэмсэггүй явахад осолтой, өнөөх эм цэрэг дайран халдаж болзошгүй байжээ.

Нар сүрхий шарж, бүгчим халуун бөгөөд, олс, будаа тарьсан газар нэг ч навч сүрэл хөдлөхгүй, зам дагаж модонд ороход, бас салхи сэрүү татахгүй. Гүн хавцал дахь хөгшин мод, бараан ханан хадан дунд ч гэсэн, сэрүүн амьсгал мэдэгдэхгүй, салхигүй, нэг ч найлзуур хөдлөхгүй, хадны ёроолоор шугуй дунд урсах горхи огт чимээгүй урснам бөгөөд ус, мод шувуу цөм аниргүй. Гагцхүү нэг хүний дуу тэр их чимээгүйн дунд гаслах гашуудах мэт сонстжээ.

Цтирад зогсоод цөм гайхан сонсвоос тэр гаслах дуу хадан цаана хангинах мэт дуулдаад төдхөн чимээгүй болов. Тэгтэл, Цтирадын дээр хэрээ дэгдэн нисэж, хааглан дуугарсанд, тэр ноён ч нөхөр цэрэг нь ч ёр заасан тэр бараан шувууг юмнаа бодолгүй шууд өнөөх хүний дуу гарсан зүг чиглэн, хадан хясаа тойрмогц, хирдхийж, морио зогсоон, нэг жигтэй юм гайхан харав.

Шар хаг ургасан хадны ёроолд бөөрөлзгөнө өргөсгөний цагаан цэцэг жимс ургасан бяцхан нугад нарны гэрэл тусан бургас өлөн өвстэй газар хөгшин царс мод тэр хадан хясааны ойролцоо байсны тэнд нэг охин, тэр царс модны ёроолд хүлээстэй хэвтжээ. Толгойгоо дарж, уй гашуу тавьсандаа тэнхэл тасарсан байдалтай. Задалсан үс нь

мөрнөө унжаад, гөрөөчний эвэр бүрээ сур оосроор мөрөвчлөөтэй тэр охин, морины чимээгээр толгойгоо өндийлгөсхийгээд, намайг суллан тавьж хайрлаач гэж тэр хэдэн эрсийг гуйн энсэв.



Хүндбаяр гэдэг Цтирад тэр хөөрхөн хүүхний гуйх үг, сайхан хоолойд автагдан, сэрэмжлэхийг мартваас, дагах нөхөд мөн түүний адил болжээ. Мориноос яаран үсрэн буугаад, юлд суга татан, хүлээсийг тас тас татаад, охиныг суллав. Нэг урвасан эм өчигдөр Нутагжин гэдэг Властад хэл хүргэж, Прагын шилтгээнээ өнөөдөр одохыг нь мэдэгдсэн учир Власта, буцах замыг нь таглах арга хийж, энэ сайхан хүүхнээр тосуулсан учрыг эс мэджээ. Хүлээснээс мултармагц сайхан охин, биеэ Шарка гэдэг нэртэй. Окожин нутагтай. Омгийн ахмадын охин билээ. Охидын шилтгээний хүүхнүүд модонд барьж аваад хүлж шилтгээндээ өнөөх хортдоо хүргэе гэж явтал, энд хүрэх үес холоос морины төвөргөөн дуулдахад, намайг хөдөлж болохгүй болтол тас хүлээд, энд орхижээ. Тэгээд, намайг дарлаж, хүн дуудаарай гэж хүлээстэй надад эвэр бүрээ зүүж өгөөд, амаа цангавал авч уугаарай гэж дооглон, тэр сав дүүрэн бал унд тавиад явжээ гэж хөлийн үзүүрт өвс дунд тавьсан сав заажээ. Чингээд уйлж, өнөөх эмс охид эргэж ирэхээс урьд намайг энд орхилгүй, аавд хүргэж өгнө үү? гэхэд нь Хүндбаяр гэдэг Цтирад хажууд нь суугаад сэтгэлийг нь тайтгаруулж, гуйсан ёсоор болгоном заа гээд, өнөөх савтай ундыг өгч, цангаагаа гаргаж, айж зовсон биеэ тэнхрүүл гэхэд нь уугаад, хариу бас Хүндбаярт уулгажээ. Цтирадын нөхөд бас мориноосоо бууцгааж, уяж тушаад, сүүдэрт сэрүүцэсхийн хэвтэцгээжээ. Яг үд дундын цаг нарсны шилмүүс хөглийж газрын үнэртэн цэцгийн сайхан үнэр ханхалж, халуун амьсгалт хийтэй хутгалдаж, өвс мөчир огт хөдлөхгүй, гагц эрвээхэй наран туссан зүлэгт эрвэлзэх ажээ. Хүндбаярын бараа бологсод тэнхээ алдарч, нойр хүрцгээн, эзэн нь хөөрхөн Шаркийн үг чагнаж, сайхан хоолойг нь чагнан, бал унд өгөхөд нь дуртай уугаад, хүүхнийг мөрөвчилсөн эвэр бүрээгээ авч, ямар дуутай юм бол гэхэд нь тэнхээ мэдэн үлээжээ.

Бүрээний хашхиргаа ихт дуу нь нам гүмд хангинан дуурьсаж, хаданд цуурайтан, сулран холдсоор, гүн ойд алс тэртээд цуурай нь дуулдав.

Тэгтэл тэр чимээгээр догшин салхи хөдлөх мэт гэнэт маш сүртэй хашхиралдах чимээ энд тэнд цаана наана, модны ар, шугуй, сөөгөөс дуулдаж, зэвсэг барьсан хүүхнүүд, бөөн бөөнөөр бужигнан дайрч, Цтирад гэдэг Хүндбаярын нөхөд ухасхийж мориндоо мордох юлдээ сугалах зав өгөлгүй дайчин эмс цавчихыг нь цавчиж, чичин жадлахыг

нь жадлан, Цтирад нөхдийн зүг ухасхийх гэтэл өвсөнд хэвтсэн юлд шүүрэхээс урьд эмс охид овооролдон ноцож, дарж унагаад тас хүлжээ. Чингээд Властын итгэмжилсэн охины хэвтэж байсан газар өөрөө хүлүүлж дэмий л тэгж гэнэт дайруулсандаа хараал ширээл тавьж, чөтгөр шулмыг дуудан дурдаж, байхад нь Шарка охин элэг доог хийж, олон эмс цөм инээн доромжилж тэр чилгэр эрийг Охидын шилтгээнээ хүргэхэд, Шаркийн морины дэргэд туугдан явж билээ. Нөхөд нь зөгий тэжээх тэр газрын тэнд, ноцолдон гишгэгдсэн өвс дээр цус нөж болон хоцорч шарх бүхүй нүүр нь наранд хэвтэж, хар батгана дээр нь бужигнан, түрүүн тэдэнд ёртой мэдээ өгсөн хэрээ, нөхдөө улай гарлаа гэж дуугаран дээгүүр нь нисэж байлаа.

Цтирадын бараа бологсод чингэж амь алдаад⁵ эзэн ноён нь чингэж нас эцэслэжээ. Явдал тохиолдсон хадан хавцлыг тэднийг аргаар хорлосон Шарка хүүхний нэрээр одоо хүртэл Шаркийн хавцал гэж нэрлэдэг.

IV

Манаа харуулын хүн маргааш нь Өндөр шилтгээнээ тэр муухай хэрэг гарсан мэдээ хүргэж, Охидын шилтгээний хавьд нэг мод зоож, тэр модонд хүрд зоогоод, хүрдэнд Цтирад ноёны биеийг хүлж тамлан алсныг⁶ нь олсноо мэдэгджээ.

Тэр мэдээ зүг бүр тархан дэлгэрч, эмс охидын тэр муухай хорлолд тэсгэлгүй хилэгнэсэн эрчүүд зэр зэвсгээ агсаж, зүг зүгээс Өндөр шилтгээнээ хүрэлцэн ирцгээж, Пшемыслыг удирдан морд, үгнээс чинь гарахгүй дагаж, өшөө хорслоо авна гэжээ. Зарим хүн, Пшемыслын тушаал хүлээлгүй шууд Охидын шилтгээний зүг довтолж, зам гудас тохиолдсон эмс охидыг хядаж, олныг олзлон, Өндөр шилтгээнээ хүргэсэн билээ.

Власта эм баавгай мэт хорсон уурсаж, ялан дарна гэж омгорхож, Өндөр шилтгээний зүг охидоо дагуулан, тэр шилтгээнийг байлдан эзэлж, эр хүйстнийг хядна гэж хөдөлжээ.

Чингээд хэрэмд хүрэхээс нь урьд, олон эрчүүд өөдөөс нь өшөө хорслоо авна гэж дайран орж, авалцан тулалдаад Власта олон охиноо манлайлж дайсан дунд морьтой ороод, найз нартаа зам гаргаж, догшин хилэн бадран давхихдаа, охидыг хойноос нь дагаж явна гэж боджээ. Гэтэл, охид чингэж чадсангүй, түүний адил цөмрөн орж ядсанд Власта нэг мэдэх нь ээ ганцаараа олон эрсийн дунд тун их хөл үймээн дотор

орж, тал талаас тас шахагдахдаа юлдээрээ ч гэсэн хориг хийж завдсангүй түлхүүлж татуулж, морь дээрээсээ суга татуулаад олон мэс дээр унаж алуулсан билээ.

Үлдсэн эмс дэмий л тулалдаад, эзэн ноёхноо автагдсаныг үзэнгүүт, тэсгэлгүй айн сочиж, эрчүүлийг сүрдүүлж байсан нэг нь ч эргэж зугтаасанд, цөм Охидын шилтгээний зүг амь гарах гэж дутаав.

Олон эмс тэр тулалдаанд үхээд, зугтах замдаа бас алуулаад, Охидын шилтгээн хүрч чадсан нэг нь ч бас амь гарч эс чадав.



Путаасан тэдэнтэй эрчүүд ана мана давхилдан, шилтгээний гүүр дээгүүр ана мана гаралцан, шилтгээнд нь зэрэг ороод ирэхэд эмсийн баатар чадал эцэс болох нь тэр! Юлдээ хаяцгааж, эм шингэн дуугаараа чарлалдаж, ах садан төрлөө таних болж өмнө нь сөгдөн мөргөж, гар сунган гашуудан гэмшин гуйвч...

Эрчүүл Цтирадын өшөө нэхнэ. Эмсийн гарт амь үрэгдсэн буюу тэдний уран аргад автагдаж үхэгсдийн өшөө авна гэж хайр найргүй хядаж, нэг ч охин цэргийг амь хэлтрүүлсэнгүй. Сайхан хүүхнүүдийг алцгаагаад, цонхоор хаяхыг нь цонхоор, өндөр хэрэм дээрээс хаяхыг

нь хэрэм дээрээс хаяж эмэгтэйчүүдийн цугласан бүгдийг арчин үгүй хийсэн хойно, Охидын шилтгээнийг гал тавьж үнсэн товрог болгосон гэдэг.



КШЕСОМЫС Л ХОРИМИЙР Х ОЁРЫН ДОМОГ

I

Пшемысл, нас нь үлэмж өндөр болоод, үхлийн нойроор нойрсож, сүнс нь буурал аав нартаа очжээ.

Төрийг Незамысл гэдэг Үл сэтгэгч ноён залгамжлан баривай. Түүний бие хүн бүгдийн замнадаг замаар одсон хойно цэргийн ноёны ширээнээ Миата ноён суужээ.

Түүний нас элэгдэхэд Воен ноён төр барив. Түүний нөгчихөд Внислав ноёлж, түүний бие нүд анихад Кшесомысл сэнгүн ноён болж хутагт Нуурмаг булаг худгийн тэнд өргөмжлүүлэн тайлга тайж, лех тайжийн хамгийн эрхэм нь урьд Пшемыслын өмсөж байсан малгайг Кшесомыслын тэргүүнээ өмсгөж, орчин тойрны олон цөм баярлан өчрүүн:

— Кшесомысл ноён маань боллоо! Биднээ өлзий хутаг эдлүүлнэ ээ хэмээлцэж ёслон мөргөөд, Өндөр шилтгээнээ баяр хөөр болж Өндөр

шилтгээнээ хүргээд, тэнд урьд цагт түүний элэнц хуланц эх, түүний уг удмын дээд өвгийн сууж төр барьсан сууринаа залав.

Кшесомыслын төр барих үес улс мал тарианаас ууланд явсан нь илүү байжээ. Маш олон хүн газрын гүнд буй төмөрлөг хайж, урсгал уснаас ялангуяа өмнө зүг элбэг олдох элсний алт тунгааж, сэнгүн ноён хуланц дээд эхийн бошиг үзүүлснийг эмээн бодож, нэн олон хүдэрчнийг бусдаас илүү мөнгөт Лайт, Хуст хоёр өндөрт явуулж, зүг зүгийн хүн тэнд хүдэр ухаж, хүн бүр сүрхий баяжихыг хүсэн, гэртээ хамаг ажлаа орхицгоож, бухаар тариаланг боловсруулах хүнгүй, тарианы газар атаршиж, сул хэвтэн, урьд бөднө донгодож тариа будаа өтгөн ургаж байсан газар зэрлэгшжээ.

Улс амьтан эрдэнэ төмөрлөгөөр баяжин, тариа будаагаар хоосорч, нам газрынхан гачигдан, уул уурхайнхан идэх тариа будаа Прага нутгаас худалдан авах гэж хүн явуулдаг болж билээ. Омгийн эзэн ахмад түүнд санаа зовуурьтай болоод, хориглож ядан, нам тал газар тариалан сөнөж, эрдэнийн төмөрлөгөөс болж, амьтан омгоо гээж, хуучин ёс журам эвдэж байна гэж шаналдаг боллоо. Зарим эзэд ахмад Өндөр шилтгээнээ сэнгүн ноёнд ч очиж мэдүүлсэн үүнд Неуметелийн эзэд Хоримийр манлайлан очиж, Кшесомыслд хүсэлт гаргаж, мөнгөнөөс тариаг эрхэм болгомуу хэмээн сануулж, тэр газар дор уурхай ухдаг улсыг тархаан зайлуулмуу гэж сануулбаас ноён, эрдэнийн төмөрлөгийн өнгөнд автагдаад тэдний үг үл сонссон тул, эзэд ахмад тун ч урмас алдарч, сэтгэл тавгүй буцсан гэдэг.

Уул уурхай хайгаачин, тэднийг хөөлгөх гэж оролдсон тэр явдлыг олж мэдээд, нам газар гэр орондоо гүйж ирцгээн, Өндөр шилтгээнээ омгийн эзэд зөвлөн хэлэлцсэн ялангуяа Неуместелийн Хоримийрийн тухай элчийн хэлсэн үг сонсоод, шар зөгийн үүр үймүүлсэн адил шуугилдан бужигнаж хашхиралдан занацгааж, нэн ялангуяа Хоримийрт ихэд өшжээ. Цусыг нь урсгана, хойшлолгүй урсгана гэгцгээж, зарим нь тоглоом тохуу хийж дарлан хашхиралдахдаа, Хоримийр тариа будаа үгүй болно гэж айдаг юм бол, цадтал идүүлнэ дээ. Амаар нь хахтал чихнэ дээ гэж авирлажээ.

Чингээд тэгэх юм сан гэж, буга хөөсөн догшин нохойн сүрэг адил Неуметелийн гацаа суурины зүг довтолж, тал, бухаар тариалангаар намрын үдшийн бүрэнхийгээр олон уурхайчин явсаар Неуметелийн бараа харагдаж, мод дунд байшингийн сүрлэн дээвэр үзэгдэх үес шөнө болж, өндөр нуруулдсан сүрэл тариа, саравч, шороон далан дээр

босгосон шивээ хэрэм харагдахад аяархан алхаж, дуу чимээгээ нам болгон, хот хороонд сэм гэтэх араатан мэт мярааж очтол, нэг сайн хүн, тэндээс урьдаж, аюул тохиох гэж байгааг мэдэгдсэн учир, эзэн ахмадыг сэрээтэл, харанхуйд муухай чимээ хашхирах сүртэй дуу гарч, хамгаалан хориглох зав олдсонгүй. Олон уурхайчин хэрэм шивээнд ойртон, их дуу чимээ гарган айсуу тул, оргож амь гарахаас өөр аргагүй болжээ.

Хоримийр адууны жүчээнд ухасхийн орж, хайртай хүлэг шемийк гэдгээ яаран гаргаж эмээллээд, сэмхэн нэг үг хэлмэгц хаалгаар гадагшаа ухасхийсэнд уурхайчин хараад, хашхиран хөөцөлдөж, хойноос нь морьтой хүн хөөцөлдөх чимээ дуулдав. Шемийк гэдэг хүлгээ гуядан сайх хүлэг хар хурдаар давхиж, дэл нь хийсэн туурайн дороос нь шавар шороо хийсэн, оч харанхуйд гялалзуулан давхисанд, эзний цагаан цамц нь жигүүр мэт дэрвэлзэн хөөх хүнд нь нэг хэсэг тэмдэг болж байснаа, Шемийкийг хүн яаж гүйцнэм билээ. Намрын шөнийн харанхуйд төдхөн далд оров. Моринд чадамгай эзэн нь модны захад хүрээд, хар боролжийн дунд морин хүлгээ амыг нь татан зогсоож, амь гараад, эргэж харвал, уур хорсол шатаж ар гэрт нь гал тавьсныг үзэв. Харанхуй тэнгэрт галын улаан туяа татаж улам их гэрэл гарав.

— Хамаг юм шатлаа! гэж Хоримийр хорсон бодоод, орон сууц базааж хураасан тариа будаа, хамаг хүч хөдөлмөр гаргаж цогцолсон юм маань үнсэн товрог боллоо гэж баруун гараа зангидаж, тэр их галын зүг хараал ширээл тавьсан нь:

— Хэрэв би үүний өшөө хэдэн давхар эс авбал, өр төлөөсөө эднээс эс нэхвэл, хар нүүрс мэт болж үхье, юлдээрээ тас цавчуулья! гэжээ.

II

Неуметелийн гацаа айл үнсэн товрог болжээ. Галд эс шатсан юмыг уурхайчин, түүж аваачихыг нь түүж, ачиж аваачихыг нь ачиж аваачжээ. Их олз омогтой буцацгаан сүрэг өмчийг нь олзолж, олзны тэр тэнд олзны мориор юмыг нь ачиж, Хоримийрийн нуруулдсан будааг тээгээд, замдаа, бас гэртээ хариад ч тэсгэлгүй бахархаж таваа ханаж хашхирцгаасан нь

— Өлсөхөөс айсан бол, одоо өлсөж бай! гэж байсан гэдэг.

Чингэж баярлан хашхирсан гэдэг. Тэр түймэрдсэн айл гацаанд анир чимээгүй амьтан хүнгүй болж, гал уугьж удтал утаа хэншүүг нь

намрын салхи ханхлуулж байсан ажгуу.

Хоёр хонотол Хоримийр, харьяат омгийн бүх эрсийг хуралдуулж, тэдний дээр бас айл ах дүүгийн эрчүүл, тэдгээр уурхайчны уулганд хорсон хүч нэмжээ.

Харанхуй болсон хойно цөм өвч зэвсэглэн хөдөлж, Хоримийр сайн хүлэг Шемийкээ унан манлайлж, өс нэхэн одвоос, Хустын хөндийнхөн аюул айсууг огт эс мэджээ. Уурхайчин Хоримийр оргоод гав ганцаараа тэнэж яваа биз гэж бодоод огт үл сэрэмжилжээ. Санаа амар хэвтэцгээн, харуул манаа ч гаргасангүй. Шөнө галын гэрэл, амь бүтэм утаанд сандран сэрвэл толгой дээрх дээвэр нь хэдийн шатаж ухаан мэдээгүй гадагш гүйн гарч, эд хогшлоо гаргаж, хүүхэд шуухдаа авч гарах нь авч гаргал, Хоримийрийнхан дайран хядаж, мэсээр мэсэлж, жадаар жадалжээ. Эзэн ахмад өөрөө Шемийк хүлгээрээ гартаа юлд барин, байшингуудын хооронд давхиж, бас уурхайн нүхний тэрүүгээр эргэж, хамаг юмыг нь сүйтгэж, харуйсан баруйснаа хяд гэж тушаан давхижээ. Дагагсад нь шөнийн сүүдэр адил ийш тийш сүүмэлзэн, байшин барилгыг сүйтгэж, уурхайчны төвөгтэй хөдөлмөрөөр хийсэн бүгдийг нь устган, нүхэн уурхайд нь том чулуу унаган таглаж, өдөр болохоос өмнө арилаад өгч, үүрийн үнэгэн харанхуйгаар ор мөргүй болж, Неуметелийн тэндээс тэр олон амьтан тархацгаасанд эзэн ахмад цаашлан одож, Шемийк хувилгаан чадалтай мэт огт цуцсангүй салхин адил дэгдэн, сэнгүн ноёны сууриных нь зүг чиглэн давхисаар наран гарахад Хоримийр бие үл алжаан, Өндөр шилтгээний хаалганы өмнө үл алжаасан хүлгээрээ хүрчээ.

Хойд өдөр нь сэнгүн ноёны шилтгээнд Хуст уулын тэнд болсон явдлын мэдээ хүрч, олон уурхайчин шилтгээнээ ирж цөм нэгэн тэр аюулт шөнийн сүрт уулгыг мэдүүлэн, хамаг тэр муухай хэргийн эзэн Хоримийр мөн гэж мэдүүлэн заргалджээ.

Тэгэхэд нь би чингэсэнгүй тэр шөнийн үүрээр Өндөр шилтгээнд ирсэн билээ гэхэд нь Кшесомысл, мөнгөний уурхайд хайртай тул, Хоримийрийг шоронд хийлгээд ял хэлэлцүүлнэ гэж тайж ноёдыг зарлан ирүүлж, шоронгоос Хоримийрийг гарган ирүүлбээс хэрэг таслах шүүхийн өмнө амьдаар нь шатааваас зохино гэж хүсэл мэдүүлсэн хорсол өвөрлөгч олон уурхайчны урдаас харж зогслоо. Сэнгүн ноён уурхайчны талд, олон омгийн тэргүүн ахмад Кднесомыслын талд байжээ. Амийг нь авна гэж гуйваас уурхайчны санал нийлж, Сэнгүн ноён Хоримийрийг үхэх ял унагаж, омгийн эзэн

олон ахмадад нүүр шагнаж амьдаар шатааж алах ял өөрчлөн өөрийн нь мэсээр мэслүүл гэжээ.

Чингэж хэрэг тасалсанд Хоримийр өчрүүн:

— Эрхэм сэнгүн ноён, би чиний зарлигаар үхэх ял оллоо. Нэгэнт амьд явах аргагүй болсон тул нэг зүйл гуйя. Үхэхийн өмнө хайртай хүлэг морь дээрээ мордож нэг үзэх завшаан соёрхмуу: Чингэсэн хойно намайг яавал яатугай гэсэнд

— Тэгвэл тэгье. Чиний Шемийкт ямар нисэх далавч байж туслах юм биш гэж инээгээд, хэрмийн хаалга хаа гэж тушаажээ.

Хоримийр, Кшесомыслын тохуу хийхэд үл эмээн, жүчээнд байгаа Шемийктээ яаран очиж, хүзүүдэн тэврээд, нүүрээ хүлгийн толгойд наалдуулан, илэн таалж, нам дуугаар хэдэн үг хэлсэнд эрдэмт хүлэг морь хөлөөрөө шалын мод дүнгэнэтэл баярлан цавчиж унгалдав.

Довжоо дээр байсан сэнгүн ноён тайж омгийн эзэд сэлт, дор хүрээнд байсан олон уурхайчин, харуулын цэрэг, энгийн олон цөм Хоримийрийг жүчээнээс Шемийк гэдэг хүлгээ хөтлөн гарахад нь гайхаж, юутай сайхан хүлэг вэ? гэж бахдав. Тэр цагаан хүлэг цоохор бөгөөд хүзүү өргөн, дэл урт, сүүл өтгөн, хөл нарийн туурай хомбон, буга мэт чилгэр сайхан ажээ. Нүд нь гялалзан ийш тийшээ харж, хамраа сарталзуулж хөл нь бүжих мэт хөнгөн алхан дэгдэж, Хоримийрийг мордмогц эргэн тойрон дэгдэлхийлж, эзэн ноён нь хайрт морин хүлгээ унасандаа сэтгэл сэргэн ухасхийтэл Шемийк цоройж өргөн хүрээнд хангинатал нэг янцгаагаад, дэгдэн үсэрч давхисанд, Хоримийр бас нэг ухасхийлгэж, нэг хаалганаас нөгөө хаалга хүртэл дүүлүүлээд, шороон далангийн тэнд гурав дахь удаа дүүлүүлж,

— За Шемийк минь өөдөө дэгд! гээд сайн эрийн хавчлагаар хавчиж намилзсан дэлд нь бөхийтөл, Шемийк нь

— За эзэн минь тогтож үз! гээд, нэг дүүлэн шороон далан дээр гарч, бас нэг дүүлээд модон шивээ дээгүүр харайн гарсанд бүгд гайхахын ихээр гайхлаа.

Цагаан хүлэг морин шивээ хэрэм дээгүүр шувуу мэг шуугин дэгдээд, хүлэг морины дэл, эзэн эрийн үс нь намирсхийгээд харвасан сум шиг гялсхийн үгүй болжээ.



Шилтгээний олон сочин хэлмэгдэж, тэр дүүрсэн эр, хаашаа ойчиж, Шемийк хүлэг нь цус нөж болж, аль газар хэвтэж байна гэж яаран далан өөд гүйцгээн, хэрэм цамхгаас харгал гайхан баярлаж, Өндрийнхөн тайж нар нам руу зааж баярлалдан хашхиралдсан нь Хоримийр Шемийкээ унан, хөндий хавцлаар дэгдэн давхихыг үзэв.⁷



Тэр сайн эрийг далд орж завдаагүй байтал, омгийн эзэд хүчлэн гуйж, олон тайж нар цөм тэр гайхамшигтай явдлыг хэлэлцэн гуйлгасанд Кшесомысл цааргалж чадсангүй.

Тэр дор нь Неуметелд элч явуулж, Хоримийрийг айх айлтгүй ял хэлтрүүлсэн гэж дуудуулбаас, хойд өдөр нь өөр морь унаад ноёнд бараалхан дагажээ. Чингээд сэнгүн ноён, өнөөх Шемийк хаа байна гэж асууваас, омгийн эзэн эр гунин өчрүүн:

— Гэрт минь тун муухан байна. Бодвол, сүрхий дүүлсэндээ гэм олсон болов уу гэж билээ.

Чингээд Өндөр шилтгээнээ тогтож өгсөнгүй, хэдийгээр сэнгүн ноён, олон тайж нар найрсаг сайхан байвч, харина гэж зүтгэн, Шемийкийн хойноос сэтгэл чилжээ. Сэнгүн ноён, олон тайж нарт мэхийн ёсолж, чөлөө айлтгаад, дагасан олны дахин сэргээн босгосон

айл гацаандаа бие амрахыг үл бодон унасан унаагаа хайрлалгүй давхин буцсан гэдэг.

Неуметелдээ хүрч ирмэгц, шууд хайртай хүлгийн байсан газар яаран одвоос эрдэмт хүлэг нь босож чадахгүй хэвтээд, эзэндээ одоо үхэх цаг боллоо. Ясыг минь нохой шувуунд битгий хаяарай. Орой хүрээнийхээ босго дор булж оршуулаарай гэхэд нь Хоримийр ихэд гаслан шаналж тэр ёсоор болгоно гэж ам алдаад, Шемийктэйгээ хагацах ёс гашуудан хийжээ. Чингээд тэр хайртай морин хүлгээ үхэхэд, захиа ёсоор нь болгосон гэдэг.

Гацаандаа морио оршуулсан тэр нь одоо хүртэл нутгийн хүн журамт Шемийкийн булш гэж чулуун тэмдэг босгосон нэгэн газрыг заадаг ажээ.



ЛҮКҮҮДИЙН ДАЙН

I

Кшесомысл ноёныг мөнх бусын дүр үзүүлэхэд Өндөр шилтгээнээ Неклан ноёныг ширээнээ залав. Тэр ноён чех түмнийг энх сэцнээр засаж, Литомершийнхантай, Лемузтэй эв найрамдалтай байсан тул, тэдний сэнгүн ноёд, Неклан ноёны үг зоригийг хүндэтгэдэг байлаа. Гагцхүү умар зүг, өрнө зүгт муу харгис хөрштэй байсан нь Властислав гэдэг Нутаг алдар сэнгүн ажээ. Тэр ноён, омог ихт Лүкүүдийн газар, Охарц гол, уулын Мжа голын нутгийг эзэлнэм бөгөөд, Неклан сэнгүн сэцэн нь номгон аваас, Властислав сэнгүн догшин омогтой ажээ. Неклан дайнаас эмээдэг аваас, Властислав дайтах асан гэж суудаг бөгөөд, айл зэргэлдээгийн найрсаг ёс мэдэхгүй, шударга зөвийг бодохгүй, цус урсгахдаа өршөөхийг үл мэдэх ажээ. Зах нийлсэн хөршийг хяхан дарлаж, Лемуз, Литомершүүд, Чехчүүд нутгаар догшин цэрэг нөхдөө дагуулан аялж, газар бүрээс алба авдаг байлаа.

Авдаг тэр алба нь гэвэл, нэг нэг хэрэм, нэг нэг хар үен өрх тутмаас авч, алба эс баривал, хүч тулгаад амьд хүнээс байтугай, алуулсан хүнээс ч гэсэн алба татдаг байжээ. Эд өлгийн албанаас гадна бас хүнээр алба татаж, ялангуяа эмс хүүхэд аваад олзолсон хүнийг боол

болгон худалддаг байжээ. Боол үлэмжтэй тул, боол шивэгчин аваар ирэгч Фракки худалдаачин, сахалт жууд нарт өгдөг байсан гэдэг.

Сүүлийн нэг уулга хийх үес Чех нутагт довтолж, хөөрхий тэр нутагт урьд урьдаас их зовлон учруулж, лүкүүд хүний явсан газар үнсэн товрог болж, орон байшин, цонж хашаа саравч, адууны жүчээ хамаг бүгдийг түймэрдэж, галладаггүй тосгон гэж байдаггүй, хамаг юм гал авалцан хүн амьтныг мэгдээн сүргийг түүн олзлоход нь улс гацаанаас шилтгээнд амь гарах гэж дүрвэвч шилтгээн ч тус болдоггүй байлаа.

Хил дээр байсан Дшевич шилтгээн ч Властиславын цэрэгт хориг болж чадсангүй. Сланы ч идэгдэж, будец ч үнсэн товрог болоод, тэндээс Лүкүүд талын үер дайрч онгон тахилгат Жаловаас наахна бүрхэг Живнач уул Влтав мөрний дээр сүндэрлэдэг газар Левы Храдец гэдэг Солгойн Шилтгээн хэмээхийг довтолон бүслээд, тэндээс нь Прагын шилтгээнийг байлдан идэх санаатай байжээ. Солгойн шилтгээнийг хааж байлдаад, гадагш нь ч хүн гаргахгүй гаднаас ч хүнс ачаа оруулахгүй болсон тул, шилтгээнээ бүслүүлсээр удахад идэх юмгүй өлбөрөн сандарч, байдаг малаа бараад, атга гурил эрдэнэ болж, мөлжүүргүй яс зэндмэнэ мэт болсон байжээ.

Бүслүүлсэн шилтгээнийхэн шороон даланлаг цонж дээрээс Лысолайн тэрүүгээр Үнетичэд дайран Солгойн Шилтгээн орж, Холишовицын суурин гацаагаар Летений тал дамжин Неклан ноёны суудаг Прагын шилтгээн ордог «их замын» зүг дэмий л горьдон харж, авран тэнхрүүлэх цэрэг ирэх юуны магад гэж уйтгарлан хардаг байжээ.

Гэтэл горь тасарч, Прагын шилтгээнээс тэнхрүүлэх цэрэг ч ирсэнгүй «их зам» хүнгүй зэлүүд буйд болжээ. Чингээд Солгойн шилтгээнийхэн зориг шантарч, царай эцэж нүд нь муухай гялалзан өлбөрч өлөнгөдөхдөө зэр зэвсгээ газар тавьж, өгүүлрүүн:

— Тэнхрүүлэхээс өнгөрч, турж үхэх цаг ирлээ. Лүкүүдийн гарт бууж өгсүгэй. Биднийг явал яаг албал алаг, цатгавал цатгаг гэж шийдэж байтал, Лүкүүд заншлаад, бүслэн хаахыг байж, аялан хөдөлжээ. Тэдний тагнуул, Лемүзүүд, Литомежүүд, мөн Декүүд Чехэд туслан тэнхрүүлээр хөдөлж, Лүкүүдийн ар бөөрнөөс дайрахаар айсуу гэж түгшүүртэй мэдээ авсан байжээ.

Властислав хорсож, муухай хараал тавьж, Декүүд Лемүзүүд, Литомежүүдэд бууж өгвөл Перун тэнгэрийн өршөөл алдаж, насаараа боол больё. Би яасан ч чех аймгийг эрхшээлдээ оруулж, ялсны тэмдэг

болгон, бамбайгаа Прагын хаалгад хадна гээд, тээрмийн хоёр чулуун хооронд орсон будаа шиг болохоос айж цэргээ Солгойн шилтгээнээс татан ухарчээ.

Чингээд юуны өмнө Литомежүүдээс өшөө хорслоо авч, тэдний нутагт Баавгайн уул Ээвэр уул⁸ хоёрын хооронд бат шилтгээн босгож, Властислав шилтгээн гэж өөрийн нэрээр нэрлэж, Чехчүүдэд тусалсанд нь Литомежүүдийн даруулга болгож хүчирхэг хатан цэрэг тэнд суулгажээ.

Лемүз Декүүд түүнээ эмээн сүрдэж, найрамдахыг гуйж, Чехчүүдэд туслахыг байлаа, тогтмол алба барья гэж амлажээ. Прагын сэнгүн ноён түүнийг сонсоод, гуньхарч санаа мөчид тул, холбоотон үгүйгээр горьдол тасрав гэж бодоод, байлдсанаас дагаж орсон дээр хэмээн тогтож, хэдэн омгийн эзэн ахмадыг элч болгон сонгож Лүкүүдийн сэнгүн ноёнттой эв найрамдал айл хөршийн найрсаг ёс хэлэлцэн тогтож хэдэн уут шижир алт, хоёр төмөрлөг дуулга, сайхан бамбай, арван сайн хүлэг морь эрхэм бэлэг болгон бариулжээ.

Властислав дэглийн өдөн отготой булган малгай өмсөж том товчтой сүрхий нугалаатай, харь улсын эдээр хийсэн жанч нөмрөн, сийлж будгаар гоёсон өндөр модон ширээнээ сууж, элчийн зүг хөмсөг зангидан ихэрхэг зантай харж, тоомсоргүй бараалхуулан ноёны нь захиж хэлүүлсэн үг сонсоод, бардамнан өгүүлрүүн:

— Надаас сэнгүний гуйх гэж байгааг би сонслоо. Өргөсөн бэлгийг нь ч үзлээ. Осолдож дээ. Байдаг алтаа надад өргөсөнгүй. Бүх агт морь, хамаг баялгаа явуулсангүй. Өргөсөн бэлэг гагцхүү миний хорхой хүргэжээ. Наад бэлгээ аваад буцаж ноёндоо миний хорхой хүргэсэнд баярлаж байна. Тэр бүх юмаа сайн хадгалж, сайхан байлгаж бай. Байдаг бүх юмыг нь авхуулах гэж хүн явуулна. Тэгэхэд одоо энэ буцаан өгүүлсэн зүйлийг мөн хамт хураана. Тануус бушуухан далд ор. Бэлгийн оронд толгой авхуулж магадгүй шүү! гэхэд нь омгийн тэргүүн айн эмээж, Лүкүүдийн нутгаас бушуухан холдох гэж дороо яаран буцжээ. Чингээд Прагын шилтгээнээ бүх учрыг хэлбээс, Неклан сэнгүний царай үнсэн хөх болж, Властислав омог их найдангуйдаа Чех бүх нутгийг өөрийн нутгийн адил захирна гэж бардамнаж байгаагаас айн эмээснээ нуун дарж чадсангүй.

Лүкүүд сэнгүн, Прагын элчид тэр омголон бардам үг хэлээд, Лүкүүд нутгийн⁹ таван отогт эр тоотон дайнд морд гэж зарлаж.

Зарлах элч, хурдан морьт бараа бологсдын манлайд явахдаа юлдээ агсаад, сэнгүний төмөр юлд ширэн хуйд нь хийж, өмнөө үзүүрийг нь өөд нь харуулан явжээ. Нэгэн дагагсад хажууд нь дурсаар сүлжсэн цалма зүүж, зэр зэмсэгт тэдгээр эрс салхи хий мэт хурдлан тал хөндий, ой нугаар (тэр үе тариа соёолох хавар цаг байжээ) нэг гацаанаас нэгэнд нь нэг омгоос нэгэнд нь гэгээн цагаан өдөр ч үүрийн шөнөөр ч довтолж, гацааны хүйсэд хүрч ирээд, ахмад тэргүүтэй омгийн хүн, бүх эрчүүд залуучуудыг зарлан ирүүлж, сэнгүний юлд хуйнаас нь гаргаад дээш нь өргөж, тэр юлдээс биеийн хэмжээ өндөр хүн цөм дороо цэрэгт морд. Бамбай барьж зэвсэглэ. Чехчүүдийг байлдах цэрэг, сэнгүний шилтгээнээ¹⁰ цуглаж буй тул, тэр зүг оч гэж хэлэх үг бармагц дэргэдэх хүн нь бүснээсээ цалмаа суга татан далайж, элч нь тэр цалмыг заан сэнгүн ноён, цэрэгт мордох эрийг болзол хугацаанаас хожимдохул, цалмаар боомилуулна, үүнийг хүн бүр мэдэж, уучлахыг бүү хожим гуйгтун гэж хатуу тушаасныг сонсгов.

Элч бас цэрэгт мордох хүн, начин шонхор шар шувууны зэрэг ямар нэгэн махчин шувуутай байвал, гэртээ үлдээж болохгүй, Байлдаанд хэрэглээр авч яв. Тушаал зөрчиж эс очсон буюу авах юм эс авсан хүнийг цаазалж, энэ юлдээр хороолгоно гэж сэнгүн ноёны юлдийг наранд гялалзуулан далайж, омог дотроос эрийн төөлүүрт тохирох эрс залуусыг тэр юлдээр хэмжиж, тоог нь модонд хэрчлээ гаргаж тэмдэглэн омог тус тусаас хэчнээн эр цэрэг дайнд мордохыг сэнгүнд айлтгах гэж бүртгэжээ.

Чингээд элч дахин мориндоо мордож, хөлөөрөө давиран давхиулж, нутаг зах нийлсэн омог отгоор дайран зарлах гэж явахад нь тэдний сураг мэдээ хэдийн тархаж, сэнгүний байлдах юлд хэзээ бидэнд хүрч ирнэ гэж амьтан хүлээцгээж, тэр ширүүнээ довтлох элчийг омог отгийн малчин сүрэгчин гайхан харцгааж, гацааны эрчүүл өндөр дуугаар эмэгтэйчүүд гаслан ёсолж байв. Элчийн явсан бүхэн хөл үймээнтэй болж, эмс охид бөөн түвэг зовлонтой боллоо.

Элчис сэнгүн ноёны шилтгээнээс нэгдүгээр отгийн нүднээ таатай нутаг нугаар өнгөрч, явсан газарт нь тал дүүрэн сайхан тариа, нуга, дүүрэн цэцэг зурвас, зурвасаар алтан шар улаан ягаан өнгө өтгөн өвс ногоон дунд гялалзан, хаврын нарны гэрэлд тариа тариалан, нуга цэцэглэг цувсан нутаг ажээ. Байлдааны юлд залж, тэр нутгаар явж

гүйцээд өмнө зүг Броцнице гэдэг харгил голын хоёр талаар байдаг хоёрдугаар отгоор явж, дайчлах ажил гүйцээд умар зүг Бэрх уул хөхрөн харагдах Охарка гэдэг Цуцальт голын зүг хандаж, тэнд гуравдугаар отгоор Нарийн голын зүүн баруун биеэр эрчүүдийг зарлан тоолж хэрчээс тэмдгээр бүртгэжээ.

Тэндээс наран шингэх зүг Уурхайчны горхины нутаг дөрөвдүгээр отогт хүрч, байлдааны зар тэр голоор дамжин Охарка гэдэг Цуцальт голын нарийн хавцал хүртэл цуурайтаж, горхи хүрчигнэх хад цохио хавцал амаар дуурьсжээ.

Тэндээс хаврын салхи шуурга адил уулын зүг тэмцэж, уулын Мжа гол, тавдугаар отгийн Хлумчаны гацаа тосгон хоргодсон ойн намаг балчиг мод шугуй, дов толгодоор зар тархаж, тэр нутгийн улс, сэнгүн ноёны зар санал, элчийн тэр сэнгүний юлд гялалзуулмагц их дуртай дайнд мордоно гэж баяр хөөр болцгоон, юлдээр хэмжүүлэх дургүй, хэмжүүлэхээс айх ч үгүй, тэртэй тэргүй хөгшин залуугүй цөм дайнд мордоно гэж хөлхжээ.

Тэр зэлүүд бөглүү зах нутгийн хөх царайтай зэрлэг хүмүүс, нутаг уснаас мордоход хойшоо татлаа байхгүй, бяртай чийрэг гараараа сүх, лантуу шүүрцгээн, сайн тоноглож, харласан ширээр тас бүрсэн бамбайгаа хананаас авцгааж, анч махчин шувуу, начин шонхор сар шувууг шүүрэн барьцгааж, гүн хөвчийн араатантай цус урсган тулж сурсан чонорхуу догшин зуумхай нохойгоо сүрэг сүргээр нь холбон хөдөлжээ.

III

Хлумчаны нэн буйд газар, уулын хооронд өлөн өвс, хүрэн шар хөвдөт их намаг балчгийн тэртээ цувсан эм дом агч модны дунд харласан сүлжмэл хашаатай, бараан модон байшинтай хуучин сүрэл дээвэр дээр нь ногоон хөвд, цэцэг навч ургасан тийм нэгэн бяцхан айл гацаа байжээ.

Тэнд хүн цөөт Жалан омгийнхон дээр эртнээс оршиж, омгийн ахмад нь тэрхэн үес залуу чилгэр Страба гэдэг хүн байжээ. Ах дүүгүй бөгөөд гагцхүү Чех аймгийн нэг эхнэртэй байсан нь, Лүкүүдийн уулгалж Солгойн шилтгээнийг бүслэх үес нутгаас нь олзолж авчирсан хүн байжээ. Тэр олзны Чех эмд тун хайртай болж, ямар нэгэн ов живээр эрхэндээ оруулсан мэт сэтгэл санаанаас нь ер гарахгүй тул,

— Чи олзлуулсан шивэгчин боловч, миний гэргий бол гэхэд нь үгийг нь дагаж, эхнэр нь боловч, сэтгэл санаа нь амаргүй буйд гацаанд бухимдаж, нутгаа санан, Лүкүүд, нутаг оронд нь хэчнээн гай гамшиг учруулсныг санахад дотор нь аягүй болж, гомдол хорслоо даран явсныг нь огт эс мэдэв.

Гагцхүү нас элэгдсэн эцгийн гэргий, Страбын хойд эх нэг өндөр нуруутай, баргар царайтай, ширүүн бор нүдтэй, хижээл насны боловч дэмий л өтлөөгүй авгай, элдэв илбэ мэргэ ов жив мэддэг тул баахан тэр учир төсөөлдөг ажээ.

Сэнгүн ноёны тушаал буйд Жалан хүрмэгц, омгийн дарга дайнд мордох болж, хананд өлгөөтэй бамбай, төмөр цагаригт бухын шир татсан дуулга авч, юлдээ билүүдээд, сумаа сэлбээд, хатуу нумдаа шинэ хөвч хөвчлөн, ганзагандаа лантуу зүүгээд, адуун сүргээс бие бага шиг, үзэмж муухан боловч яс сайтай, үс ширүүн боловч гөлгөр, хараацай мэт хурдан, аян даахдаа сайн, хүйтэн халуун ангах өлсөхөд алзахгүй мориныхоо сайныг сонгож, мордоход зэхэх үес эхнэр нь үг дуу гарсангүй, хэвнэг цувыг нь авч өгөөд, шурхнавчийн арьс, зөөлөн сур бэлдэж, богцонд нь хүнс, талх бяслаг сэнгүний шилтгээн хүртэл замд хүрэлцэхүйцээр хийж өгчээ.

Явахын урьд өдөр хойд эх нь Страба орой хүнд хэлэлгүй хавцал аманд очоорой гэж захиад, бүрэнхий болоход хойд эхийн захисан газар нь очих болж, их өргөн хар балчиг дагаж ойн зүг одвоос, балчиг дотроос намхан нигүрс борлож харлаж, холгүй горхины ус огторгуйн гэгээ тусан гялайж харагдав. Үдэш болж салхи хөдлөн, харлан харагдах балчгийн тэнд модны шуугинах чимээ дуулдаж байв. Харанхуй хавцал аманд тэр чимээ бүр ч их болж, хавцлын хоёр хажуугаар хад чулуу энд тэнд тачир өвс дунд бутарган хаясан юм шиг арзайж, хад чулууны дээр дор нь хооронд нь ганц нэгээр өндөр өндөр эм дом, царс, хөгшин агч мод ургаж, сагсгар орой нь сүлжин ороосон чөдөр ороонгоор дүүрч, намрын сүүл өвөл цаг нүцгэн гишүү найлзуур нь тэр чөдөр ороонгод харлан харагддаг байжээ.

Тэр харанхуй хавцал аманд царс модны дор хад дээр гал түлээд, хойд эх нь сууж байв. Үсээ задлаад, магнай, чих дээгүүр эрүү доогуур нь алчуур цайж үзэгдэв. Хуурай хүүгээ үзээд, галд автай үндэс хийгээд, тамлага тамлаж,

— Урдуур хойгуур минь манан татаж,

Улс үзэхгүй, ганц чөтгөр биднийг үзэг! гэж шившин хэлж бармагц хавцал болсон амаар цасан манан татаад доогуур битүү манан болж, дээшээ хуйлран бөөгнөрч дэгдсээр хавцал дээгүүр, нэн шуугинагч модны орой дээгүүр битүү манан болж, Страбыг голын дэргэд хүрч ирэхэд цагаан уур буданд мод сүүдэр мэт бүрэг бараг үзэгдэн, гал сүрхий дүрэлзэн асаж, гэрэл туяанд нь хойд эх нь бор нүдээр хуурай хүүгээ ширтэн зогсоод, өгүүлрүүн:

— Чи хэдий надаас гарсан хүү биш боловч, эцэг чинь миний нөхөр байсан тул, чамайг дуудаж, бусад хүнд дуулгахгүй чамд тус болох үг хэлэх гэсэн билээ.

Та нарт туслах гэж бөөлөн удгалж ядлаа. Чех удган биднээс чадал илүүтэй болоод давагдахгүй байна. Манай удганыг тэд дарсан адил та нар ч бас дарагдах нь гэж та нарын зовлонг би мэдлээ. Ай халаг хухуй! Хөөрхий та нар! Тэнгэр сахиус та нарыг дайнд дагалцан явавч, дайсны талд орон тэднийг тэтгэх юм байна. Та нар, дайнд мордох нь мордоод, дайнаас буцаж ирэхгүй юм байна. Лүкүүд чехчүүдэд автагдах нь. Сэнгүн ноён ч тэндээ ясаа гээж, бусад нь түүний нэгэн адил болох юм байжээ. Миний үг дагаваас чи л амь гарч болох байна. Дуулж бай: байлдаан эхлэхэд өөдөөс чинь довтолж орсон хүнтэй тулан зогс. Жадлаад, голыг нь таслалгүй, хоёр чихийг нь огтолж аваад, далд хийж, мориндоо мордоод эргэж давхи. Хойноос чинь урхиран бархирах чимээнээс айлгүй, гэдрэгээ огт харж үзэлгүй зугтаавал, амь чинь гарах юм байна гэж хэлтэл, нар жаргаж тэнгэр улайх нь үгүй болж, өргөн их балчиг харлаад, намхан нигүрс балчгаас хар сүүдэр шиг бараантан харагдаж, дүрс нь халцарсан үхэр бургасны ялзарсан мод нь балчгийн захад хачин бүдэг цагаан юм шиг үзэгдэх болов.

Страба захаар нь гэрийн зүг чиглэж, бодлого болон сэтгэл зовсхийж, хурдан хурдан алхалж, орон сууцдаа ойртоход нь өндөр мод дундах хашаа хороо нь гүн сүүдэрт хав хар харагдаж, гал унтраад, дэнгийн гэрэл ч үзэгдэхгүй харанхуй чимээгүй атал, хаалганд хүртэл дуулах чимээ дуулдаж, чагнавал, эхнэр нь огт үл мэдэгдэх хачин юм дуулж байгаад, харанхуйгаас ойртоод ирэхэд нь чимээгүй болж, юунд өдийд юм дуулав, юу дуулав? гэхэд нь огт хариу хэлсэнгүй.

IV

Лүкүүд нутагт Властислав ноён цэрэг татаж, их хөлтэй сураг чимээ олж сонсоод Прагын ноён тэсгэлгүй айн эмээжээ. Чингээд омог

бүхэн аймаг даяар Лүкүүдийн тэр муухай дээрэнхүйд хорсож, орон даяар бужигнан, дайтан тулна гэж байгаа мэдээ сонсовч Неклан сэнгүн зүрх зориг орсонгүй.

Зэр зэвсэг шилтгээнээ, мөн орчин тойрны Летнийн талд хангинаж зүг зүгээс цэргийн агт унгалдан, олон эр цэргийн хэлэлцэх дуулалцах чимээ гарч байхад, Неклан сэнгүн шилтгээндээ хамгийн бөглүү байшинд юм бүхнээс айж бие хатуужиж үл чадан Властиславыг дийлнэ гэж үл итгэжээ. Нөхөд нь ятгаж ядав. Бие муу байна. Чөтгөр буг яс махыг минь сулруулсан гээд хөдөлж өгсөнгүй. Чингэхэд ноёны бараа бологч Честмийр гэдэг сайхан тэгш биетэй өндөр нэгэн залуу сэнгүнд гашуун үг хэлж, та эр хүн шиг байж чадахгүй байна. Цөм дайнд мордох гэж зэхээд гагцхүү ноёныг хүлээж байнам. Удирдах хүнгүй бол олны зориг мохно гэхэд нь Неклан өгүүлрүүн:

— Би явахгүй, чадахгүй. Чи миний оронд морд.

Миний зэр зэвсэг, хүлэг морь аваад, цэрэг удирдан яв. Цаадуул чинь намайг явна гэж бодог гэхэд нь Честмийр, ноёны зэмсэг, хөө хуяг, урчуулын хийсэн нүүр чихийг хөө¹¹ халхавчаар саравчлан эрүү хоолойг хамгаалдаг харь хийцтэй төмөрлөг дуулгыг нь авч, төмөрлөг гялалзсан том бамбай барьж, ноёны нөмрөг нөмрөн, Некланы юлгам харыг унаад, цэрэг жагссан Летнийн талд лех тайж дагуулан гарахад нь цөм баярлаж, ноёноо хараад зэвсгээ хангинуулж, морьтой явган цөм байлдааны жагсаал жагсаж, зарим цэрэг дуулгатай, зарим нь сагсгар үстэй малгайтан, жад барин, махчин шувуутай нь шувуугаа барин нумтай саадагтай, сум дүүрэн хоромсоготой сайхан тэмдэгтэй жагсаж, агаарт жадны гилбэр, юлдийн гэрэл мяралзаж, олон цэргийн чихний сүйх гялс гялс хийв. Честмийр, онгод тэнгэрийг тайгаад, цэргийн жагсаалыг хар мориороо эргэн үзээд, юлдээр давших дохио өгч орь залуу эрийн хоолойгоор хашхирмагц, цэрэг хөдөлж, дайчин эрсийн алхах, морины туурайн нижигнэхэд газар дэлхий дүнгэнэж, агаарын хий түмэн эрийн хашхирах дуулах чимээнд доргилоо. Честмийрийн өмнүүр омог, тоо, хүчнийхээ хэрээр хороо хороогоор жагсан өнгөрч зарим анги нь хэд хэдэн омог нийлж нэг анги болсон байв.

Зарим анги зэвсэг сайтай, эр цэрэг олонтой их омог тул өөрийн омгийн тугийн дор нэг бүтэн анги болж явсан нь жишээлбэл, Нетвожич хийгээд Тужан Чярадиц хийгээд Дракелчиц омогтон Хөл нүцгэн гэдэг хочтон тус тус нэг нэгэн анги болж, мөн Беховиц, Ухониц,

тэрчлэн Бүдехостиц, Нахоруб омогтон, мөн Жинан, Муниц хийгээд хөгшин Тептийн омог тийм байжээ.

Их цэрэг «их замаар» Лысолай чиглэн, тэндээс бараан хадаг Ямаат нуруугаар даван, Солгойн шилтгээний баруугаар өнгөрөөд, хор хөнөөлийг нь таслах гэж Дүкүүдийн өөдөөс шуудран чиглэв.

Чингээд, Түрскод хүрээд Честмийр, Лүкүүд айсуй гэж сонсоод цэргээ зогсоож, Прагын цэргээс хүч давуу дайсны их цэрэг хар үүл шиг айсан харагдах бяцхан өндөр дээр буудаллаад дайсны цэргийн олноос айлгүй хөгшин ганц царсны дэргэд өндөр дээр зогсон, цэргийн зүг үг хэлэхэд олон цэрэг, сэнгүн ноён маань гэж бодож чагнаваас, Честмийр хэлсэн нь:

— Харав уу, тэр омголон Лүкүүд омогтныг! Манай хэчнээн эрсийг алж, хэчнээн гацааг талж, хэчнээн эмс хүүхдийг олзлов оо. Бас түймэрдэж, маньг хорлосоор бий! Маньг арчин үгүй хийж, боолчлох гэж байнам. Дуртай ч гэсэн дургүй ч гэсэн бид харилцан тулж, ар гэрээ хамгаалан, чех нутгаа доромжлуулан бузарлуулахгүйг бодох цаг боллоо. Бид эрх чөлөө амь биеийнхээ төлөө байлдах гэж байгаа тул, оргож зугтаад нэр хугарснаас ясаа энд тавьсан дээр гэхэд нь цэрэг эрийн сэтгэл хөдөлж, цөм их дуугаар

— Чиний толгой ойчсон газар, манай толгой хэвтэг!

— Бид ялна!


— Лүкүүдийг дарна! гэж хашхиртал, Турксод Лүкүүдийн цэрэг хүрч ирэн, морьтой явган, цөм зэр зэвсэг сайтай, олон эрс хуягтай, эсвээс маалингаа олбог дэглийтэй, цөм дайнд явж сурсан улс ялангуяа Трнован омог, Жлудиц гэдэг Шарнууд омог, Радониц омог, Ухаштиан омог, Храберц гэдэг баатад омог, Требиц омогтон жич тэр бүхнээс зэрлэг догшин нь хэвнэг, саарь сармай дээлтэй, сагсгар малгайтай, бүдүүн жад, хүнд лантуун зэмсэгтэй хөвчийн Довынхон гэдэг Хлумчангууд дайнд сурамгай бөгөөд өдий төдий нохой, чоно, хоточ нохой, чоно барьдаг гарз нохой хөтөлцгөөн, зарим нь гартаа, мөр дээрээ начин шонхор сар шувуу мэтийн ав шувуунд хэрэглэдэг махчин жигүүртэн суулган уудам талд урагшаа Чехчүүдийн урдаас жагсацгааж, Чехчүүд зүүн гарын цэрэг нь баруун зүгийн өндөр газрыг түшин баруун гарын цэрэг Хейнийн модот уул тулан зогсжээ.

Лүкүүд цэргийн зүгээс үүлнээ тэнгэр дуугарах мэт сүртэй нижигнэх их дуу гарч, догшин араатны янз бүрийн дуу, нохой хуцах,

хүн хашхирах, морь унгалдах, бүрээ татах дуун чимээ Турско талаар түгэн дуурьсаж байв.

Тэдний цэргийн манлайд омог дээрэнгүй Властислав гэдэг Нутаг алдар сэнгүн, тэргүүндээ давтмал төмөр дуулга, биедээ ялтсан хуяг өмсөж, юлдээ хуйнаас суга татан явсаар, Прагынхны цэрэг эмээн дутаалгүй жагсан зогсохыг үзээд, цэргээ зогсоож, морин дээрээс өндөр дуугаар өгүүллрүүн:

— Харав уу та уулгамч эмэнцрүүдийг! Уулын өндрийг түшжээ. Сэтгэл мөхөс болоод манай цэргээс хүчин буурай, чадал муутай тул тэд юу ч түшээд нэмэргүй, Маяаас айж байхыг нь үзэв үү? Энэ хөндий талд жагсахаас эмээжээ. Мань дайрмагц дутаах бий. Намар мөндөрт цохиулсан өвс шиг танай хөлд гишгэгдэн балраг. Ширүүлэн дайрч, дайран довтол. Цусыг нь ууж ханаг, нохдоо тавьцгаа. Аян авын шувууг тавь, тагтаа дайрсан шиг сүрдүүлэн сүйтгэг! гэхэд нь уяанаас тавьсан нохой харвасан сум мэт дайран давшиж, алаг эрээн сүртэй юм хуцан шуугин ортол, Лүкүүдийн цэргийн жагсаал дээгүүр махчин шувуу үүл мэт дэгдэн шуугьж, тушаа барианаас мултран тавигдаад, дээшээ цасан хуй мэт эргэн хуйларч маш сүртэйеэ нисэхэд нь өд, сөд нь шуугьж, хааглан хашхирах дуу чимээ нь нэн их бөгөөд, үүл мэт хуйларсан тэр олон махчин шувууны сүүдэр нь Лүкүүдэд тусч, урагшаа Прагын цэргийн зүг салхинд туугдсан сүрт хар үүлний сүүдэр мэт нүүжээ.



Газраар догшин нохой араатны хуцан улин дайрч орох чимээ, тэнгэрт нисэх махчин шувууны жигүүрийн чимээ, дуугарах дуу нь нийлж чих дөжрөм муухай шуугиан боллоо. Доогуур довтолох нохой дээгүүр дайран авын шувууны хойноос Лүкүүдийн байлдах уриа, бүрээний дуу нийлж, өргөн Турско дүүрэн цуурайтаж байв.

Лүкүүд байлдана гэж галзуу мэт довтолж цус урсгана гэж довтолоход нь манлайд нь Властислав сэнгүн, юлдээр даллан хашхирч, хүлгийн дэл хийсгэн давхиж, хоёр бөөрөөр нь, араас нь хоолойгоо чахруулан бархирах олон цэрэг, нүд бүлтийн царай улайж чинэрэн довтолов.

Чингэтэл Честмийр, аянга цахилгаанд уулнаас доошоо өнхрөн хамаг юм няц мөргөн өнхөрч буух үхэр чулуу мэт Лүкүүдийн уруу түрүүлж дайран ороод, хойноос нь цэрэг давхиж, омог омгийн жагсаал өрсөлдөөн довтолох үес, ноёны хуяг зэвсэгт Честмийр хошуучлан явж, хоёр цэрэг харилцан тулж, цавчих хатгах цохих зэргээр тулалдан явахад, Честмийр хамгаас ширүүлэн байлдах газар орж, цавчилдахад нь Лүкүүдийн толгой, намуу цэцгийн тоорцог шиг ойчицгоов.

Чингэтэл Властислав шахцалдсан олны дундаас цахилгаан гялбаа мэт суга үсэрч гараад Прагын цэргийн удирдагчийн зүг дайран орлоо. Бэрх тулалдаж удтал цавчилдахад нь оч гялалзан үсэрч, Лүкүүд сэнгүн жолоогоо алдаж, нөгөө гартаа барьсан юлдээ унагаад мориноосоо цус урсган, улаан нэлий болж, амь тасран, олон үхсэн шархтсан хүний дунд унатал, гашуудан шаналах, баярлан бахархах дуу тэр цуст тулалдааны газар цуурайтлаа. Прагын цэрэг чадал зориг орж дайран давшиж, дайсны жагсаал нэвтлэн тулав. Лүкүүд цэргийн жагсаал үймэн хотолзож ухрав. Тэр үес Честмийрийн морь унаад, баатар морьтон эр төдхөн босон харайж бамбайгаар биеэ халхлан дайсныг жадлан, зам, гаргаж явахад хөө хуягт нь хэд хэдэн сум шигдэж хар бамбайн ширэн бүрээсэнд хэд хэдэн жад шигджээ. Сум жад гялалзан, бамбайд нь дээр дээрээс шааж, донслуулан доргиулж, баатар залуу эрийн бамбай барьсан гар нь ч бамбайд шигдсэн жаданд дарагдаж доргин чичрээд, өөр нэг бамбай нааш нь өг гэж цэрэгтээ хашхирч бамбайгаа хаях гэтэл, нэг хүнд жад биед нь шигдэж тулалдаанд олон жад сум арзайтал шаасан бамбайгаа урдаа барьж гартаа зэвсгээ атгасаар догшин тулалдаан дунд хөсөр унажээ.

Чингээд байлдааны өмнө хэлсэн ёсоор нь болж тэргүүнийг шороодон унасанд, олон цэрэг тэсгэлгүй хорсон, улам ширүүлэн байлдаж, дайсныг хайргүй хядан давшсаар Лүкүүдийг нэгийг ч амьд үлдээлгүй сөнөөж махчин олон шувуу эмээн зугтааж нисэн одоод зуумхай ноход, алуулах нь алуулж зугтаах нь зугтаан үгүй боллоо. Лүкүүд, цус бялхсан тэр байлдааны газар, сэнгүн ноёны хамт цөм унасан нь Страбад хавцал амнаа хойд эхийн хэлсэн ёсоор боллоо.

Лүкүүдийн омог дээрэнгүй нь дарагдаж, хүч нь сөнөв. Прагынхан баярлалдавч, үхсэн удирдагчийг үзээд баяр хөөр нь нам болж, арзайн шигдсэн жадтай бамбайн хамт, хуяг дуулгатай нь үүрч оршуулах нэг толгой дээр аваачиж, нүүрийг саравчаар халхалсан дуулгыг авч, баатар эрэлхэг Честмийрийг танимагц нутаг орны төлөө амь бие үрсэн тэр баатрыг нэн харамсаж, уй гашуу боллоо.

Тэр дор нь авс хийж хөгшин царс модны дор тэр толгой дээр оршуулах гэж, байлдааны сүүлээр тэр шөнөдөө чандрыг нь хайлуулж нясгаад булж, дээр нь их овоо босгон бүх цэрэг унасан жанжиндаа гашуудал хойлго хийж, бал унд чанаж, баатраа дурсан ууцгаажээ. Прагын шилтгээнээс Неклан сэнгүн ирж, Честмийрийн булш дээр

уйлан хайлаад нөгчсөнийг тахиж, хойлго гэдэг ёслол будаалга хийж гүйцээд бүх цэрэг хойлгын хуримаас мордон Лүкүүд нутаг зорьжээ.

V

Страба тэр цус асгаруулсан байлдааны газраас муучхан байдалтай хурдан хүлэг мориороо дутааж жадыг нь үзүүр, анхлан дайрсан нэг чех хүний цус болсон хэвээр буруулан зугтаахдаа, унасан тэр дайсны хоёр чихийг нь огтолж авангуут, хашхиралдах, бүрээ татах, тулалдах чимээ үл анзааран, чөтгөрт хөөгдсөн адил зугтаасаар үдэш болтол давхиж, шөнө морио баахан амраагаад Хлумчан нутагтаа хөндий талаар зорин давхиж, айл гацаа харвал, дайснаас оргосон гэх болов уу гэж тойрон гарч хоёр хоног дээрээ шөнө зэлүүд нутгийнхаа орон гэртээ эцсэн мориороо бие амьд хүрч ирэв.

Гацааныхан харанхуй шөнө хэдийн унтжээ. Хөгшин эм дом мод харлан харагдаж, тэр модны цаана зүүн зүг цайрсхийн үзэгдэж: хашаандаа ортол нь гэрийн нэг хэдэн эмэгтэйчүүд гарч явсантай дайралдлаа. Тэд нь Страбыг хараад сочиж, гашуудан

— Уй гашуутай цагаар ирж дээ гэхэд нь мориноосоо бууж, яаран гэртээ ороход нь орны дээр цонхны тэнд цагаан даавуугаар бүтээлгээтэй нэг юм хэвтэж байв. Байдлыг нь ажвал үхсэн хүн бололтой. Сүнс гараг гэж цонх онгойлгожээ. Тэр хүүрийн дэргэд хүрч очоод бүтээлгийг хуу татан үзэхэд нь үүр манхайтал цайж байгаа гэрэл цонхоор тусч байгаад үзэхэд залуу эхнэрийн нь хөхөрчихсөн царай үзэгдэн, нүдээ аньж үсээ задлан элгэндээ нөж болсон гүнзгий шархтай байжээ.

Нүдэндээ итгэлгүй гайхан зогсол, ард нь хойд эх цагаан алчууртай сүүдэр шиг зогсон, бор нүдээр тэр хүүр ширтэн — Үсийг нь сөхөөд үз! гэж муухай дуугаар хэлжээ.

Муу юм санагдаж, залуу эхнэрийнхээ өтгөн сайхан үсийг нь сөхөөд үзтэл, цус бялхсан шарх байв. Яаран нөгөө талын үс сөхтөл бас цустай шарх байжээ.

Айж сочсондоо үг хэлж чадахгүй болж, яаран хэтэвчээ нээж, цус болсон ээмэгтэй хоёр чих гаргаад үзвэл, эхнэрийн нь чих мөн байна гэж таниад байлдаанд намайг дайран орж алах гэснээ надад алуулсан юм байна гэж ухаарч, дайнд мордохын өмнөх орой яаж байсан, ямар хачин дуу дуулж, байсныг нь таниад хойд эхдээ

— Та мэдэж байсан юм байна шүү дээ! гэхэд нь

— Чи надад хаанаас тэгэхэд итгэх вэ дээ? Үүний муу увдист автагдаад байсан шүү дээ. Энэ чинь чех хүн болоод бидэнд дургүй байсан. За явъя, хавцал аманд очиж онгодоо тахья гэхэд нь энэ хүүрийг гацааны гадаа тавь гэж захиад хойд эхийн хойноос харанхуй хавцал амын зүг, зовлонд дарагдан муухай зүүд зүүдлэн яваа юм шиг даган одов.



ДҮРИНК НЕКЛАН Х ОЁРЫН ДОМОГ

I

Лүкүүд нутагт гамшиг тохиож хүнд хар сүүдэр даран туссан адил боллоо. Хэд хэдэн хүнээ үхүүллээ гэж айл гацаа бүрд уй гашуу болж, Лүкүүд эрчүүлийн аль бяртай эрэлхэг хүн үхсэн Турско талыг газар сайгүй уйлан гашуудан дурддаг болжээ. Үхсэн эрчүүлээ гашуудахдаа үхсэнийг нь гомдон, биеийг нь хээр хайлуулан нясгалгүй хаяж махчин нохой шувууны идэш болгосонд гомдоцгоожээ.

Чингэж гашуудахын хажуугаар бас айх эмээх зовлон тусч, Чехчүүд Турско талаас нашилж, хил дээр хүрч ирлээ гэдэг чимээ тархаж отог бүр сандарч, хил хавийн улс сандран мэгдэн дотогшоо дүрвэж, шилтгээн бараадан ой мод руу шургаж, Чехчүүд явсан гацаа бүхэнд өшөө хорсол нэхэж байна гэж эмээн хэлэлцжээ.

Тэр үг дэмий хоосон үг биш, айж сүрдсэний улмаас түгжээ. Өдөр гал түймрийн суунагласан хар утаа тэр мэдээг батлан гэрчилж, шөнө огторгуй улайтал туяарсан их гал дөлийн туяа гэрчилж, гацаа суурин түймэрт идэгдэн, тарианы газар ургасан тариа галт нуур мэт дүрэлзэн, салхинд хэншүү утаа нь тун хол ханхалдаг байлаа.

Аргалах аргагүй хамаг бяр чадалтай хүн Турскод унасан тул, дайсан хурдан давшиж, отог омгийн нутгийг эзэлж явахад газар бүр амь гуйж, Прагын сэнгүн ноёнд гаслан бууж өгч байв. Тэр сэнгүн, шилтгээнийг байлдан шатааж, юуны өмнө Властислав шилтгээнийг

үгүй хийгээд, бусад шилтгээнийг идэж, Лүкүүд нутагт Охарка голын зах дээрх Властислав овоо гэдэг баталсан суурин газрыг үгүй хийжээ. Гэвч Властиславын хүүг олж чадсангүй. Тэгж байтал, хүн ирж нуусан газрыг нь зааж, голын тэртээ хад дунд нэг эмгэний гэрт нуугдан байгааг нь хэлж өгчээ. Неклан тэр зүг зэвсэгтэй улс явуулж, хоёр хоногийн дотор Властиславын ганц өнчин хүүг олоод авчээ.

Тэр жаал даахиа¹² авхуулах найр хийлгэх цаг ойртсон алтан хонгор шар мяндас шиг зөөлөн бужгар үстэй тавтай хөөрхөн хүү байжээ. Өнчрөх зовлон тохиосныг ч мэдэхгүй, аюул учирснаа ч мэдэхгүй эцгийн дайсны өмнө хүргэгдэж ирээд, хөөрхөн сайхан нүдээр өөдөөс нь хараад хар багаас заалгасан ёсоор мэхийн ёсолжээ.

Неклан тэр хөөрхөн жаалыг тэгж байхад нь нас бага, өнчирсөн зовлонтойг нь өрөвдөж, огт гэм хүргэсэнгүй, олзны хүний адил аваад ч явсангүй, нутагт нь үлдээж, Лүкүүд отогт нь сэнгүний хүүг суух газартай болог гэж шилтгээн бариулжээ. Лүкүүд хуйвалдан бослого гаргавал, түшиг газар болуузай гэж болгоомжлон, халдахад хялбар газар¹³ асар бат болголгүй босгуулсан билээ.

Неклан чингээд нутагтаа буцаж, Прагын шилтгээнд олз, их омогтой хүрч ирээд, орой орондоо орох өглөө босохоос аваад өдөр ч гэсэн санахдаа дотор эмээж, амар заяаг нь үзүүлдэггүй бэрх дайсныг дарж онгон тэнгэрийн ачаар ялсны хариу тахилга тайлга хийж өргөл барьц барьжээ.

Лүкүүдийн бардам дээрэнгүй аймаг дарагдан, нэгэн цагт тэднийг ноёлох Збислав гэдэг жаал, тэдний сэнгүн ноён Властислав гэдэг Нутаг алдрын хүү, Драгүшийн шилтгээнд хүн амьтнаас хөндий номхон суух болжээ. Дэргэд нь харь омгийн серб хүн, Дүринк гэдэг багш байдаг байжээ. Тэр Дүринк урьд Властиславын маш итгэдэг хүн байсан юм санж.

Неклан бас түүнээ итгэж, Збислав, хүү, Драгүшийн шилтгээн хоёрыг түүнд мэдүүлсэн байжээ. Чингээд зун өнгөрч, намар болсны сүүлээр өвөл болж, тэр Турско талын байлдаан болж, Властиславын үхсэнээс хойш тэгээд өдөр богино, бүрэг болох тусам Дүринкийн дотор ч улам муу болж, орох газраа олж ядсан юм шиг шилтгээн дотроо сэтгэл амаргүй холхиж явдаг болжээ.

Муухай санаа төрж, сүүдэр мэт салалгүй бие сэтгэлийг нь зовоон, нэр гавьяа олз ашигт шунагаас тэр санаа үүсжээ.

— Тэр жаал хүүг үгүй хий. Властиславын хүү байгаа цагт Некланы сэтгэл амаргүй байх бий. Тэр жаалыг цааш нь харуулж орхи. Тэгвэл сэнгүн ноёны сэтгэлд нийлүүлж, ноён чамайг хүндэд шагнах бий. Тэр жаалын төлөө сахин эрхэлж байдаг шилтгээн даруй чиний шилтгээн болж, орчин тойрны газар ус цөм чиний мэдлийн газар болно. Бусдын төлөөний зарц хүн байгаагаа тэр цагт байж газар усны эзэн ноён болно. Тэр жаалыг далд оруулан салгаж өгвөл, Прагын ноёнд их л ачтай болно чи гэж дотор нь нэг юм хэлээд байх шиг боллоо.

Чөтгөр чингэж дотроос нь хатгаж цустай муухай тэр санаа ер салж өгөхгүй дахин дахин сэтгэл дотор нь орж ялангуяа ганцаараа байхад нь бодлоос нь гарахгүй болжээ. Өвлийн үдшийн харанхуй бүрэнхийгээр задгай галын өмнө сууж байхад нь тэр муухай санаа сэтгэл бодлыг нь эзлэх болсон үүнд Збислав юу болж, Дүринк юм санаашран ингэж суудаг юм бэ гэж гайхан, өтгөн хар хөмсөг дороос ногоон нүд нь яагаад хачин муухай хардаг болов оо гэж аягүйрхэвч багшийгаа биеэ барьж, ухаан ороод, жаал хүүгийн алтан шаргал үсийг илж, зөөлөн үг хэлэхэд нь сэтгэл тайвширдаг байв.

Нэгэн өдөр Дүринк Збиславыг доошоо голын зүг бууж, хамт загас барья гэхэд тэр хөөрхөн жаал хүү малгай, үстэй дээлээ өмсөж, их баяртай гүйж гарчээ. Дүринк дотроо муухай санаа өвөрлөсөн тул, алман сүх, мөс цоолж загас барина гэж авч гараад, Збислав баяр хөөр болж багшийн дэргэд дэвхцэн гүйжээ. Хоёулаа цас дундуур нарийн тоомоор явж, үд хэдийн өнгөрсөн боловч, нартай, хүйтэн байжээ.

Орчин тойронд хүн амьтан үгүй, голын тэнд бас чимээгүй нам гүм авай. Эрэг дагуу хөгшин бургас, агч мод, харлан харагдах борлож нигүрс огт хөдлөхгүй жижигхэн жижигхэн гөлөг нахиа нь салаа найлзуурт нь харлаж, зарим нь болор жижиг талстаар бүрхсэн юм шиг гялалзах цас дээр нь цоохорлон үзэгднэм бөгөөд өндөр цагаалж өвсний цан хүүрэг цайлзан гялалзаж, голын ус чив чимээгүй ногоовтор өнгөтэй мөс дээр нь энд тэнд овгор цас усны цагаан цэцэг шиг үзэгдэх ажээ. Збислав мөс дээр гүйн гарч, нөгөө эрэгт хүрэх гэтэл, багш нь

— Хүлээж бай, би мөс цоолно гээд, сүхдэн цоолоход жаал хүү цавчихыг нь сонирхон харж, мөс хагарч, тас няс хийж, ус цоолгоор хаагдах болсныг харж зогстол Дүринк аятайхан зөөлөн дуугаар

— Агь хонгор минь. Энэ усанд загас жараахай бужигнан үймж байхыг хараач! гэхэд нь жаал хүү огт ажиг сэжиггүй мөс дээр сөхөрч

загас харах гэж бужгар үстэй толгойгоо усны зүг хүзүү сунган
бөхийтөл нарийхан хүзүү дээр нь сүхээ буулгажээ.



Цэвэр мөс, цагаан цас дээр цус олгойдон, харвамагц, Дүринк сүхээ хойш тавьж, бүснээс зүүсэн хурц хутга гаргаж, тэр бузар хэргээ гүйцээж яаран зайлж одов.

Борлож, нигүрс шугуй харанхуй болж, үдшийн нарны туяа модны цаагуур тэнгэрийн хаяанд улайж байх үес хүн, толгойгүй жаалын хүүр олоод, хажууд нь ойчоод хэвтсэн малгай дээл хувцсаар нь ноёны хүү гэж таньжээ. Тэгээд, сочин өрөвдөж тэр хөөрхөн жаалыг гашуудан хайрлаж, биеийг нь шилтгээнд аваачсан билээ.

Дүринкийг шилтгээнд эрээд олсонгүй. Сураглавал саяхан морио эмээллүүлээд шилтгээнээс мордсон. Чухам хаа очсоныг хэлээгүй тул, хэн ч мэдсэнгүй байжээ.

II

Чингэтэл, Прагын шилтгээн чиглэн мордсон ажээ. Тэнд хүрч ирэхэд нь Неклан лех ахмадтай хэрэг зөвлөн сууж байсан үес тохиолдоод Дүринк тэдний өмнө гайхуулах гэж бодоод, тарахыг хүлээлгүй оржээ. Амрыг эрж ёслоход нь ноён сэнгүн түүний ороод ирсэнд гайхасхийж, толгойгоо дохисонд олны өмнө өгүүлрүүн:

— Миний бие Лүкүүд сэнгүн ноёнд бат журам сахиж явсан билээ. Одоо ноён чамд бүр ч бат үнэнчээр зүтгэхийг хүснэ. Одоо би сүхээр ганц цавчаад, та бүгдийг санаа амар нойрсох болголоо гэдгийг сонсон итгэцгээ. Гэр оронд аюулгүй болохыг хүсэх хүн очийг гал болохыг хүлээдэггүй гэдгийг бодож, та бүгдийг ирээдүйн галын аюулаас хамгаалах гэж аюулт очийг даран сөнөөлөө гээд ваадантай юм авч орсноо тайлж, цагаан вааданд ороосон өнөөх жаалын алтан шар үстэй толгой гаргахад үг хэлэхгүй болохоос биш амьд шиг үзэгджээ. Тэр толгойг ноён ахмад нарын өмнө ширээ дээр тавиад хуруугаар заан өгүүлрүүн:

— Үзэгтүн! Эцгийн өшөө нэхэн, та нарт хожим хойно нэгэн цагт хорлох хүн, та нарын цус асгаруулалгүй дарагдаад, энэ хэвтэж байна. Эрийн насанд хүрвэл, яасан ч та нарын олонхын толгой цустах хүн байсан шүү! гэхэд нь ноён сэнгүн хирдхийн сочиж цаашаа харав. Олон лех ахмад мөн сочин сандарч танхим дүүрэн хилэгнэн хорсох, жигшин буруушаах дуу чимээ гарав. Сэнгүн ноён, нүд гялалзан, царай хүрэн улаан болж, хилэгнэн зандарч:

— Ёсон бус бузар эр, энэ авчирсан юмаа цааш нь хий! Чи үүгээр хэнд гавьяа байгуулж нүүр олох гэсэн хүн бэ? Надад уу? Чиний ингэдгийг намайг чадахгүй байв гэж бодов уу? Би дайснаа дарья гэвэл дарах асан. Чи харин эзэн ноёноо хорлож орхилоо. Чамд ачтай хүнийхээ хүүг хороолоо, ач хариулахыг мэдэхгүй харгис чиний бие! Би чамайг энэ жаалыг хүндэтгэн асар гэхээс биш, алан хорло гэсэнгүй шүү. Чи гавьяа шагнал хүссэн биз. Тэгвэл яах вэ. Гурван зүйлийн үхлээс аль дуртай нэгийгээ өөрөө сонгож ав. Өндөр хадан хясаанаас харайж үхнэ үү, нэг модноос дүүжилж үхнэ үү, юлдээрээ биеэ чичиж үхнэ үү, өөрөө л сонгож мэд гэжээ.

Дүринк хилэгнэсэн ноёны тэр үг сонсоод царай үнсэн хөх болж тэргүүнийг дарж, доошоо харан танхимаас гадагшаа гарахдаа чичрэн санаа алдаж:

— Ай халаг! Ингэнэ гэж би мэдсэнгүй ай халаг! гээд гарчээ.

Чингэж гаслахад нь хэн ч өрөвдсөнгүй. Шилтгээнээс гараад замын хажууд байсан нэг өндөр нигүрс модноос дүүжлэн үхэхэд нь тэр нигүрс модыг хожим цавчиж унагатал амьтан Дүринкийн нигүрс гэж нэрлэдэг байсан гэдэг.



III

Тэр үес Вышохрад гэдэг Өндөр шилтгээний тушаа «Хадан хясаанд» онгон хуучин ой мод байсан гэдэг. Хүнийг мөнх бусын босгоноо хөтлөгч үхлийн эзэн, Морена гэдэг Эрлэг эхийн догшин сүртэй дүр нь тэр ойн бүдүүн модны сүүдэрт том үхэр чулуу дээр босгоотой, эрлэгийн эрхшээлийн газар тэр хавьд сүүдэрт мод орчны талд байж, үхсэн хүний хүүр нясган хайлуулж, үнс чандрыг нь тэнд оршуулдаг тул, олон булш дээр нь өвс ургаж байдаг байлаа.

Бэлээр нь саглагар модны орой нийлэлдсэн Ботич горхиноос баахан зайс, арай бага шиг булшны газар байсан түүнээ нэн эрхэм хүний үнс чандар оршуулаатай байдаг байлаа.

Тэр газар шуугинах модны сүүдэрт, чулуугаар хашин дарсан шороон овоо дор газар орны сэнгүнийг оршуулдаг байсан үүнээ, нутаг усны олонд хууль цааз тогтоож өгсөн мэргэн Пшемислыг хамгийн түрүүнд оршуулсан байжээ. Дараагаар нь түүний ширээ залгамжлагсад Незамысл, Мната, Воён, Внислов, Кшесомислыг оршуулсан бөгөөд, Неклан ноёны зүрх нь цохилохоо байсан хойно бас тэр газар оршуулсан гэдэг.

Чингээд лех ахмад тэргүүд Нуурмаг усны тэндээс ойд хурж, Хостопит хэмээх, Зочид мэндлэх гэдгийг ноён болгон өргөмжлөөд, Өндөр шилтгээнээ баяр хөөр, дуу шуу болцгоон сэнгүн ноёны ширээнээ залж, Пшемислын малгай ёслон өмсгөсөн гэдэг.

Чингээд насны хэмжээ гүйцсэн үес тэр ноёныг өвгөд дээдсийн тэр алтан өлгийд авслан тавьсан гэдэг.

Ботич горхины эрэг дээр Өндөр шилтгээний дор нэг хуучин байшин нүүр талдаа бүдүүхэн хийцтэй бөө мөргөлтөн чех таван ноёд Вратислав богд Вацлав ноёны дүрстэй байсан нь хуучин домогт чех эртний бөө мөргөлт ноёдын хүүр оршуулсан газар босгосон юм гэдэг. Тэгээд түүнийг «Булш дээрх байшин» гэж нэрлэдэг байжээ. Их булш гэж ерийн хүн булдаг газар нь «Хадан Хясаа дээрх гэдэг байж, тэнд нь «Насловенех» гэдэг хийд босгожээ. Тэнд, Эрлэг эхийн шүтээн байсан газар богд Вацлав ван, богд Когма Дамнаг хоёрын бага дуган босгосон нь одоо хүртэл «Насловенех» гэдгийн дор нь бий. Одоогийн тэр барилга нь 17 дугаар зууны үед босгосон барилга.



ХРИСТ ОСЫН НОМТ ОЙ Б ОЛСОН ЦАГИЙН ДОМОГ

Өгөрсөн олон зуун жилийн сүүдэр үзлээ би...
Врхлицки Врхлицки

Анх дээр үеийн домог шувтарч бөө мөргөлт эрт үеийн үлгэр мэт домгийн үүсгэл эх нь үгүй боллоо.

Шинэ цаг болж, дурсгалтай сонин шинэ явдал гарч ирлээ. Тэр явдал, гэрэлтэй өдөр болохын өмнөх үүрийн туяа мэт, хамаг юм тод домруун үзэгдэх цаг болж шүтэх нэгэн Тэнгэр бий гэдгийн мэдлэгтэй болж ирлээ.

Балар хар шугуй мод дотроос эгшиг дуулал хангинаж, Морав нутгийн зүгээс дуулдаад, харанхуй ой дотор слов хэлтний үгээр цуурайтсан нь:

Манай аврагч Тэнгэрийг дуудан эгшиглэж, номлолд нь түүний дүрийг үзэн толилъя.

Эзэн түүнээ шинэ дуулал дуулмуу, эзэн түүнээ дуулж, түмэн улсад алдрыг нь дуурьсгамуу гэжээ.

Үзтэл Литомышлийн шилтгээнээр, мөн Хрутоваа шилтгээнээр. Трстеницийн замаар Морав ордог нутгийн хаалганы тэндэх зах заагийн ой модноос нэгэн тэнгэрийг тахигсад Методейт бискуп нөхөд

шавь нар сэлт гарч, тэр Методей бискуп гэдэг хамба Кирилл богд гэдэг лүгээ ах дүү хоёр, үгсийн анжсаар Морав Славян газрын бөө мөргөлтний сэтгэлийн тариаланг хагалж, ариун ном, сайн явдлын буудай цацан тарьжээ.

Чингээд Морав нутгийн нэрээр биеэ Моравууд гэдэг улсаас Чехчүүдэд хүрч ирсэн үүнээ Моравчуудын үг хэл нь Словакуудтай нэг бөгөөд Чех нутгийнхан ч мөн нэгэн угсаатай тул, хэл үг нэгтэй байжээ.

Методей арцибискуп гэдэг ханчен алдарт Велехрад гэдэг Их шилтгээнээс ирж, чех нутгийн зах зааг дээр нь ерөөж, ном судрыг нутгийн сав зааг газар, Литомышл шилтгээн түүний хормойн гацаанд номлон тэндээс номч нартай цаашлан явж, газар бүхнээ номлон зааж, номын үг утгыг дэлгэрүүлэв.

Чехчүүд өөрийн үгээр номын утга сонсож баясаад Методей сэлт номлогч нарыг даган хуран, өршөөл энэрэл төгөлдөр түүний номлох үг:

Цэвэр усаар та бүгдийг цавдъя. Хир хилэнц тань онгодын дүрс хөрөг тань үгүй болж, нэгэн Тэнгэр та бүхнийг өршөөж хир уналыг тань үгүй болготугай гэж номлохыг нь сонсоцгоодог байлаа.

Методейн үг нь чехчүүдийн сэтгэлд таатай санагдаж, түүний номын садан нөхдийн номлох эгшиглэн унших нь сайхан үзэгдэж, Боживой ноён, Пшовын сэнгүн Славпбарци охин Лүдмила хатагтайгаа номд нь орсонтой нэгэн адил, номд нь орж, слован үгээр ном уншихад нь буюу евангели псалтирын зэрэг ном судрыг слован хэлээр буулгасан ном авч явахад нь шохоорхон цугладаг байжээ.

Тэр улс хичээн залбирч, үнэн бишрэлээр «Эзэн биднээ өршөө» гэх зэрэг дуулал сурснаа эгшиглэн хөгжөөдөг байжээ.

Тэр батад агч ном номлож удсан газраа богд Климентын дурсгал болгон Тэнгэрийн алдар мандуулж сүм байгуулдаг байлаа. Түүнээс анхных ноёны шилтгээнд Литомышлид Климент богдыг хүндэтгэн босгож, бас нэгийг мөн Климентын сүм гэж Лаба мөрний дэргэдэх Шлитгэнцэр Храдецэд босгож, гуравдахыг Садскад дөрөвдөхийг Өндөр Шилтгээнээ тав дахийг Солгойн Шилтгээнээ босгожээ.

Номын туяа хил заагийн өтгөн ой хөвчөөр нэвтрэн, бүх орон даяар гийгүүлж, бөө мөргөлт нууц төгөлдөр ой модны балар харанхуйд ороход нь харанхуй арилж, шинэ номд орогсод тэр ой хөвчийн мод огтолж онгодын хөрөг устгаж, онгон тал хавцалд бас мод цавчин унагааж, галдан түлдэг боллоо.



Онгодыг үгүй хийж, улс олныг нялх хүүхдээ гал дээр ариутгана гэж утаж барьж болохгүй, галын сахиус гэж битгий тахь, нялх хүүхдийн насан эцэс болтол нь сахиус бол гэж галд мөргөж, болохгүй гэж захидаг байлаа. Бас чөтгөр бугийг аргадан тахина гэж тахил тайлга битгий хий. Үхсэн хүнийг ой талд оршуулж, хойлго гэдэг үхэгсдийн тахилга бүү хий. Замын салаа, гурван замын бэлчирт үхсэн хүний сүнс амраг гэж тайлга хийхээ байтугай. Үхсэн хүний дээр баг авгалдай зүүж наадам битгий хий, хий сүнс битгий дууд гэдэг боллоо. Өндөр шилтгээнд Перүн тэнгэрийн хөрөг үгүй хийж, аймшигт догшин Эрлэг эх Мореныг тахихаа байлаа. «Хадан хясаа» дахь түүний сүртэй догшин хөргийг үгүй хийгээд, бас олон онгодын хөрөг устган үгүй хийжээ.

Ойн эзэн, усны эзэн, салхи харанхуйн эзэн гэж тахиж шүтдэг юм нь үгүй болцгоож, загалмайн усанд тэндээс хагацах дургүй нэг хэсэг хүн их л харамсдаг байлаа. Үүнд ялангуяа бөө удган илбэчин жатгачин нэн хорсож, ой мод, бөглүү хавцал аманд зугтаан оргож, онгодынхоо дүрс хөргийг тэнд аваачин босгож, тахил тайлга хийгээд: шинэ номын ёсыг харааж зүхдэг байлаа.

Гэтэл тэр шинэ ном хүч ихтэй

Өргөн нутаг даяар хонхны өтгөн дуу хангинаж, модон сүмийн сэтгэл татам бүрийд өндөр дугуй чулуун сүмийн сайхан үнэрт сангийн

утаа дунд зулын гэрэлд алтан дэвсгэрт гоё зурагтай сайхан сийлбэртэй тахилын өмнө номын эгшиг улам дуутай дуулддаг боллоо.

Шинэ ёс бий болж, түүний хамт бас дурдалтай шинэ шинэ сонин явдал гараад, бас л өнгөрсөн боловч түүний тухай мөн эртний мэдээ бий.

Аяа, чех нутгийн минь хөвүүд охид дүү нар минь, тэр мэдээ домог сонсмуу. Эртний тэр үеэс уламжилж ирснийг бүх чех аймаг даяар, Слов хүн бүхний хүндэтгэдэг тэр Кирил¹⁴ Метод номын хоёр ах дүүгийн үйлс манайд үүссэний домог сонсмуу.

Морав, Чех нутгийн ноёд вангууд, манай омгийн баатар эрс, хүн ардын тухай сонсмуу. Эх суурин хот болсон Алтан Прага эхийн домог сонсмуу. Он дараалсан судрын хүн та нарын болон хойч үеийн хүний дурсгал болгон тэмдэглэсэн зүйл, амьд дэвтэр болсон ардын амаар дамжин үеийн үед улирч ирсэн домгийг сонсмуу.

Аяа эрт дээр цагийн тэр домгийг үүсгэн хэлсүгэй.



СВАТОПЛУК В АНГИЙН ДОМОГ

Их шилтгээн гэдэг Велехрадын сүмд цугласан олон хүн ном номлосны сүүлээр дуулал дуулж, гүйцээд, тэр залбирал дууны сүүлчийн эгшиг нь дуурьсаж гүйцээд, хүн бүхэн тахилын орны зүг харжээ. Мше гэдэг хурал уншлагын цаг болж, тэр уншлагыг арцибискуп ханчен гэдэг Методей өөрөө унших болжээ. Батад агч Петр Павел хоёрын дүйцэн өдөр байсан тул, их ёслолоор унших болжээ.

Тахилын газар олон зул барьж бадраавч, Методей гарч ирээгүй тул, сүмд цуглагсад хүлээж, чимээгүйхэн залбирч байтал, цаг мөч өнгөрсөөр нар дээр гарч, цонхоор доошоо алтан урсгал буусан мэт сүмийн хөлгөнд тусч, туурга, алтан дэвсгэрт богдуудын зураг, сүсэгтэн олон эмэгтэй, сахалтай эрс, өвгөд охид хүүхдийн хонгор шар үс цөм гэрэл тусжээ.

Тэр гэрэлд аль хэдийн барьсан зулын улбар гал дарагдаж амьтан олон яагаад удчихав аа? юу болчхов оо гэж шивнэлдэн ийш тийшээ эргэж харж, бие биеэсээ асуулцан, мөн хариу мэдээ шивнэлцэн арцибискуп маань ванг хүлээж байна гэнэ. Ван, Мше уншлагыг миний эзгүйгээр битгий унш, би заавал ирнэ. Хүлээж бай гэж захисан юм гэнэ шүү гэж шивэр авир шивнэлдлээ.

— Хаа байна, ван хаа байна?

— Яагаад ирдэггүй саатав? гэж энд тэндгүй асууцгааж байтал, нэг хүн, ван аль хэдийн, өглөө эрт ан гөрөөнд үүрээр олон бараа бологчоо нохойтой дагуулан мордлоо. Ийм дүйцэн өдөр ан гөрөөнд мордох гэж даанч яав даа! гэж гайхан хэлэлцэв.

Тэгж шивэр авир хийж байтлаа, жавхлант Методейн гарч ирэхэд цөмөөрөө дуу чимээгүй боллоо. Цаг өнгөрч уншлага хойшлуулж, хүлээх аргагүй болсон байжээ. Арцибискуп гэдэг ханчен буюу их хамбын хамт тахилын газар олон санваартан, номын хувцас өмсөцгөөн гарч ирээд, арцибискуп уншлагаа эхэлж унзад олон санваартан сан тавьж, уншлагаа уншиж эхэлжээ.

Улс амьтан сөгдөх нь сөгдөж, зогсох нь зогсож гараа өргөцгөөн, санваартны хувцас, сийлбэр хөрөг зураг гялалзуулсан олон зулын гэрэл туссан тахилын орныг харж, ном залбирал уншигсад бүгдээрээ, мөн нэг нэгээр уншихыг сонсож, цөмөөрөө ном унших, залбирах эгшиглэх мэтийг цөмийг үгийг нь ойлгож сэтгэл санаагаа Тэнгэрийн зүг хандуулан, ванг огт мартжээ.

Тэгж байтал, нэг их хүрхрэх чимээ гарч, үймээн шуугиан хашхиралдах нижигнэх юм, хуй салхи ирж яваа юм шиг ойртсоор архирах хүрхрэх, муухай дуу гарах, бүрээ татах, нохой хуцах, агт морь унгалдах сүртэй чимээ яг сүмийн тушаа дуулдлаа. Тэгээд сүмийн босгонд, сүм дотор тэр дуу чимээ гарч, тахилын орны зүг шуугилдсан олон хүн түрэн орлоо. Тэр олны магнайд Сватоплук ван, толгойдоо малгай өмсөөтэй, гартаа юлд бариатай хойноос нь олон анчин бараа болоочин нохойгоо дагуулсаар түрэн оржээ.

Хурал хураачин чимээгүй болж, амьтан тэр орж ирсэн олонд зай тавьж багана туурганд шахалдан зайлж, сандартал ван хэн юунаас ч зовохгүй, юлдээрээ ширвэсээр тахил шүтээний зүг дайран орохдоо арцибискупыг яагаад эс хүлээв яагаад тахил шүтээний тэнд хүлээлгүй оров гэж зандран хашхирсаар, тахилын тавцангийн гишгүүрийн тэнд ширүүлэн алхахыг баахан тогтуун болгож, арцибискуп ханчены урд нь тулж очингуут өөдөөс нь ширтжээ. Арцибискуп баруун гараа өргөөд урдаас нь зогсож,



— Наашаа нэг ч битгий алх! Тэнгэрт дороо ниргүүлэх гээгүй л юм бол зогс. Шуламсын омог чамайг эзэлжээ. Чиний дур зориг дагаж би номын ёс дагасангүй. Тэгэхэд чи эзний сүм хүндэтгэхгүй байна! Түүнээс болж чамд хараал тусч, буянаа барна! гэж хилэгнэн хэлэхэд нь ван царай хүзүү хоолой нь час улаан болж, уурласандаа нүүр нүдгүй явж байсан хүн, тэр үгэнд цохигдож, сүр жавхланд нь дарагдаж, юлдээ доош болгоод алмайрснаа эргээд сүмээс гарахад нь хойноос нь шуугилдсан олон анчин нохойтойгоо гарцгаажээ.

Тэгээд шилтгээндээ буцмагц, дахин омог дээрэнгүй өст санаа нь хөдөлж, гэмээ хүлээхгүй, тэр арцибискупын үгэнд автагдаж, сүрт нь дарагдсандаа ичиж, уурлаад, хүн явуулж, миний нүдэнд бүү үзэгд гэж тушаажээ. Методей ханчен тэр ёсоор нь болгож, Их шилтгээн Велехрадаас тэр дороо гарч, багш удирдагч гэж шүтэгдэж байсан орон нутгаар ном номлоор одлоо. Чингээд газар бүр христосын шашин дэлгэрүүлж, ном номлон сургасаар насан эцэс хүртэл явжээ.

Ван тэр Методейд үргэлж өширхөж, Морав газар түүний бүтээсэн тус, ном дэлгэрүүлэн гийгүүлсэн зүтгэл ард олонд нь хамаг нас явдлаа зориулсныг нь бүрмөсөн мартаж, хавчин мөрдөж Методейн тогтоосон слован ёсыг эвдэж, түүний дайсан германы ёс дагуулж байв.

Гэвч Сватонлук буруу үйлсийн үрийг амсаж Методейн хэлсэн үг ёсоор болсон нь тэр хүчирхэг вангийн аз бууруулж, хараал хүрчээ. Улс оронд нь зүг зүгээс дайсан цэрэг халдаж, Унгар, Польш, Герман довтолж бас чехчүүд үймэн босоцгоож, ванг дагахгүй гэлээ. Тэгээд вангийн харьяат Морав бүх газар орныг дарлан сүйтгэх зовлон тохиожээ.

Ван олон дайснаас улсаа хамгаалах гэж байдаг хүчээ гаргаж, тэр гамшиг зовлонг улсаасаа холдуулах гэж ядлаа. Гай дээр гай гарч хорлол дээр хорлол, хөнөөл дээр хөнөөл үргэлжилжээ.

Тэгээд ирэхэд нь ван эргэцүүлэн бодсоор тэр гамшиг зовлон цөм өөрөөс нь шалтгаалжээ. Өөрийн омог дээрэнгүйгээс болжээ гэж ухаараад Методейн өмнө их буруутай байснаа бодон, тэр хүнийг ахин ахин санадаг болж, санах бүр гэмшдэг болжээ.

Дайсны цэрэг улам ихээр халдан ирж, газар орон сөнөх зовлонд улам улам нэрвэгдэж, албат олны гашуудал гомдол сэтгэл шимшрэм болсныг сонсох бүр нэн зовниж, лех Земаа гэдэг ахмад, тайж зөвлөх

түшмэдийг ирүүлэн, явал зохих вэ гэж асууваас, хэн ч Тэнгэрийн тааллыг зөрчих санал гаргаж чадсангүй.

Цэргийн хүрээнд цуглуулсан тэр зөвлөл үдэш орой тархахад ван, өргөөндөө сэтгэл зовнин ганцаараа буцаад, түүнээс хойш тайж нар ч бусад хүн ч түүний барааг харсангүй, Шөнө дөл гарсныг нь харуулын цэрэг үзсэн байж, гадаа уяатай морио унаад, унтсан цэргийн хүрээ дундуур явсан ажээ. Замд нь хэн ч хориг хийсэнгүй. Хүрээний захад байсан манаа харуул ванг таниад дуудаж хашхирсангүй гагцхүү ийм орой явсныг нь гайхжээ.

Ван алдар хүчин төгөлдөр авч, санаа амар төвшингүй Морав газарт их ачтай алдарт хүнийг эсэргүүцэж, түүний ёс зан үйлийг эвдсэндээ вангийн сэтгэл чилснийг хэн ч мэдсэнгүй. Нойргүй шөнө тэр гэм уналаа яаж наманчлах вэ гэж боддог байжээ. Тэгээд, омог дээрэнгүйн сэтгэл төрүүлсэн вангийн сүр хүчнээ тэвчинэ. Цэрэг, олон бараа бологсод зарц зардас, эрдэнийн сан, сайхан зэмсэг бүгдийг гээж, гэм уналд оруулсан өрх мэдлээ хаяж, Морав орныг түүнээс болсон гай зовлонгоос салгана гэж шийдсэн байжээ.

Чингээд хүрээнээс гарч, хүнгүй шөнө явсаар, урьд аглагч нар сүм босгосон хөвч их модтой Заабор уулын зүгт нэгэн газар очжээ.

Тэнд нэг буйд газар, харлах их модны дунд унаж явсан морины хэнхдэгийг юлдээрээ хатган сайн нөхөр хүлгийнхээ нус болсон тэр юлдийг хаяад, зэр зэмсэггүй гон биеэр харанхуй мод дундуур залбиран явсаар үүрээр тэр аглагч нар дээр хүрч очжээ.

Тэд нь хэн ирснийг таньсангүй урьд үзээгүй тул мэдсэн ч үгүй, ван өөрөө биеэ мэдэгдсэнгүй. Нэгэнт гэмээ наманчилж, бацаг сахин, урьд Морав улсын эзэн ван байсан Сватоплук байжээ. Урьд булган үстэй, үнэтэй хувцас өмсөж вангийн Их шилтгээний уудам сайхан танхимд сууж байсан ноён хүн, муу модон байшинд сууж, шавь хүний ширүүн хувцас өмсдөг байжээ.

Амьд байгаа цагт нь хүн огт таньсангүй. Чингээд насан эцэс болох цаг ойртсоноо мэдээд, тэр аглагч нарт биеэ ямар хүн байгаад юуны учир ирж сууснаа хэлж өгөөд, удалгүй нас барсан гэдэг.



АРВАЙХҮҮ НОЁН

I

Сватоплук гэдэг Хутагт цэрэг ноён сураг үгүй болсон хойно Морав газрын олон цөм шинэ засаг ноён өргөмжлөн залгамжлуулах гэж шийдээд вангийн ширээнд залах сайн хүн хэн байна гэж хэлэлцжээ.

Тэр цагт Пшеровскод Хропин гэдэг шилтгээнээ нэгэн тайж байжээ. Тэр тайж, нутаг газар ихтэй айл ах дүүдээ хүндтэй албат олондоо хайртай, тэднээ өршөөл журмаар захирч уулаас цэцэн ухаантай тул, аливаа хэрэг шударга үнэнээр шийтгэдэг байсан тул, олон ноёд тайж нар хэлэлцээд

— Бидний дунд ийм сайн хүн байхад бус газраас бид эрэл хийгээд яах вэ? гэж нэгэн сэтгэлээр эв эс нийлж, Хропин шилтгээний тэр тайжийг ван өргөмжилжээ. Орон даяар тэгж өргөмжилсөн мэдээ сонсмогц их л онож залгамжиллаа гэж хөхилдөн баярлалдаж, шинэ ванг машид талархжээ.

Ван харьяат Морав улсын зах хязгаартай танилцах гэж аялан явдаг болж, хүрсэн газар бүхнээ ванг ихэд хүндэтгэн, усан үзэм боловсордог өмнө хязгаарт ч гэсэн, өгөөмөр сайхан Хана мужид ч гэсэн, умар дорно өрнө аль ч зүгт, ой модтой уул гүвээний хоорондох өргөн сайхан

хөндийн улс амьтан цөм шинэ ванг нэн хүндэтгэж, ноёд тайж нар ванд нүүртэй болох гэж тэмцэлдэн ирж, зусардан бялдуучлах нь бялдуучилж, бэлэг барих нь барьж, хөлтэй их найр наадам хийх нь хийж өнгөрүүлдэг байжээ. Ван Хропин шилтгээндээ эргэж ирээд, тэсгэлгүй уйдаж, шилтгээн нь найр наргиангүй хөндий хоосон мэт үзэгдэн сайхан зантай үнэн журамт хатны халуун сэтгэл ч уйтгарыг нь сэргээж чадсангүй. Зугаа шуугиан ихтэй наадам санагдах болжээ. Чингээд, бараа бологсдоо дуудан ирүүлж, олон эрхэм язгуурт зочид урьж, их хурим хий гэж тушаажээ.

Олон ноёд тайж нар, хатгамал гоё хижимтэй сайхан эмээл тохсон мориныхоо сайныг унаж, үстэн ангаар эмжсэн гоё дээлээ өмсөцгөөж, гоё бүснээсээ гялалзсан сэлэм зүүцгээж, дэглийн өдөн отготой гоёлын малгай өмсөцгөөн мордож, Хропин шилтгээнд уван цуван ирцгээжээ. Морав газрын зүг зовхис бүхнээс хуран чуулсан тул, олон зочид шилтгээнд чүү чамай багтаж, дагаж бараа бологсод хиа нар нь шилтгээний ул дахь бяцхан сууринаар дүүрч, шилтгээнээ найр дээр найр, наадам дээр наадам залган хийжээ. Чингээд вангийн тушаалаар байн байн шилтгээнд нь зочид ирж, нуураар хэмжим архи ууж, зугаатай наргиантай үг хэлэлцэн, наадам хийж, морьтон баатар сүртэй сайхан эрүүд гарч эр чадлаа үзүүлэн нааддаг болжээ.

Шилтгээний харьяат тариачдыг орой тариалангаас гэртээ харих үес Хропин шилтгээнд хөл ихтэй найр болж, хундага цом хангинан, бамбар лааны гэрэлд найрын дууны түрлэг нижигнэдэг байжээ. Хүнд их ажил хийдэг тариачин олон, шөнө унтаж, биеийн чилээ гаргаад, үүрээр дахин ажилдаа очиход, шилтгээнд найр зугаа тасраагүй наргисаар байдаг тул, ардууд, вангийн өндөр шилтгээнийг зэвүүрхэн харж, ийм засаг ноён даанч урагшгүйеэ гэж хэлэлцэн вангийн хатны зовж суудгийг үл андах тул, согтууран наргидаг хурим найрт дургүй тэр хатан юутай зовлонтой байгаа бол гэж өрөвдөн хайрладаг байжээ.

Ард олны чингэж зэвүүрхэн дургүйцэх нь бас учиртай байжээ. Наргиж найрлахад вангийн сан хөрөнгө хүрэлцэхгүй болоод, сангийн мөнгө ч бас дутах хомсдох болсон тул, албат олондоо байн байн хүнд алба татвар оноож, алба татаж гувчих хүмүүсийг ер хөнгөлөлт үзүүлж үл болно. Татвар хураалгаж үл чадах хүнийг чандлан шийтгэгтүн гэж тушаасан тул ардууд, урьд Хропин шилтгээнийг зэвүүцэн гайхаж хардаг агсан бол түүнээс хойш шилтгээнийг харахад нүд нь хорсох болж цөм ванг буруушаан муу хэлэх болжээ. Гэвч хатныг нь урьд адил

өрөвдөн хайрлаж, шагшин хэлэлцэх нь хатан ноёныг ард түмнээ битгий зовоо гэж хэчнээн гуйж, ядуу хоосон хүнийг битгий хяхан зовоож эрүүдэн шийтгэ гэж аргадан гуйдгийг нь сэтгэл хөдлөн хэлэлцдэг байжээ.

Тэр цөм түмэн үнэн байсан боловч, ганцаараа хатан уйлан хайлдгийг нэг ч хүн үзэж чадаагүй, ванд хайртай сэтгэлийн үүднээс төлөөнөө санаа зовж, хатуу сэтгэлээ зөөлөн, өршөөл төгөлдөр болго гэж гуйдгийг нь хүн сонсож чадаагүй, ван хатандаа уурлаж, харааж түлхэн хөөдгийг нь ч хүн үзсэнгүй, хөөрхий хатан толгой бөхийн гашуудаж чичрэн дагжин арай хэмээн хөл дээрээ хөөгдөн гарахдаа ичиж зовсондоо нулимс мэлтгэнүүлэн, нүд бүрэлзэж байдгийг нь хүн мэдэхгүй байжээ. Чингээд нэгэн өдөр ванг дахин олон албат иргэндээ хүнд албан татвар оноосонд хатан бас л олноо өршөөн үз гэж гуйхад ван уурлаж, юлдээ суга татан хатны зүг дайран орсонд арай гэж хаалгаар шурган амь гарч билээ.

Ван догшин хилэнд автагдаад, хатныг шилтгээнээс чирч гарга. Нүдэнд минь битгий үзүүл гэж тушаагаад цонхоор хаалганы зүг шагайж тушаасныг хэрхэн гүйцэтгэв гэж үзэх үес хөөрхий хатан нүдэнд нь тусч галзуу их хилэн дахин хөдлөөд, юлдээ суга татан хатны хойноос гүйн гарчээ. Аз дайрч хатан нь түүнийг холоос хараад, тэнхрүүлэн тусалж амь аврах хүн огт байхгүйд ийш тийш харваас, замын хажууд үст арвайн тариалан наранд шаргалтан хялалзаж байхыг үзээд яаран арвайн тариалан дунд шургалан ортол арвайн түрүүг анхан ярж хатны хонгор шар үс нь арвайн тариалан дунд гялалзаж явснаа гэнэт үзэгдэхгүй болов. Усны долгио мэт намиран хөдлөх арвайн тариалан цэлмэг өдрийн далайн мандал адил тогтуун намуун болоод, вангийн гүйж ирэхэд хатан хаа зайлсан нь огт олдож өгөхгүй ийш тийш харавч харагдахгүй боллоо.

Хөдөөгийн эмэгтэйчүүд хожим хатныг арвайн тариалан дотроос олбоос нялх хүүтэй болоод байсан байжээ. Даруй хатныг гацаандаа аваачиж асран сувилаад, хүүд нь арвайн тариалан дундаас олсон тул Арвайхүү гэж нэр өгсөн гэдэг.

Ван хожим тэр сураг олж сонсоод, төрсөн хүүгээ ч хайрлахыг үл мэдэн, хатан хүү хоёрыг Хропин хавиас хөөн цөлөх тушаал гаргаж, цэргийн хүн хүрч ирээд хатныг алс хязгаар бөглүү газар аваад явсан гэдэг. Чухам хааш аваачсаныг хэн ч олж мэдсэнгүй.

Ван хожим санаа орж, хайртай хатны зовж зүдэрсэн царай нь нүдэнд үзэгдэх болж, ганц хүүгээ санах болжээ. Чингэ чингэсээр, найр хурим хоосон зугаа цэнгэлд уйдаад ирэхийн үес, хатан хүү хоёроо санах нь бүр ч их болоод, тэсгэлгүй уйдагдаа хатан хүү хоёрын хойноос элч зарж, Хропины шилтгээнд буцааж ир гэж мордуулавч, элч сураг гаргаж чадалгүй буцан ирсэнд ван, хатан хүү хоёроо чухам хаа очсоныг хүн мэдээгүй, сураг чимээгүй болсонд сэтгэл нэн чилжээ.

Чингээд зүг зүг эрэлчнийг явуулж, сураглуулбаас сайхан санаат хатанд хүн бүхэн дуртай тул Хропин хавийн хүн дуртайяа эрэлд мордож тэдний сүүлээр бүх Пшеровскийн хүн эрэлд гарчээ. Эцэс сүүлд нь ван, шадар цэрэг дагуулан мордоод, харьяат газар орноо эргэн тойрон сураглавч ер сураг чимээ үл гарах тул газар бүхэн эрэл хийж уул тал, хот балгас гацаа тосгон, ой хөвч, хад агуйгаар эр эрсээр Заабор уулын их зузаан ойн тэнд хүрч, харанхуй агуйд урт буурал сахалтай нэг аглагч хүнийг олж, тэр буянтан өвгөнөөс миний хатан Арвайхүү хоёр хаа байдаг бол? гэж асуужээ.

Өвгөн даяанч босоод Хропин ноёныг буруушаан харж, ирээдүйн байдлыг бошиглон өгүүлрүүн:

— Чи их ял нүгэл хийсэн тул, ариун явдалт хатантай нүүр золгох хувьгүй болсон. Хүү чинь бурангуй бузар явдлын чинь уршгийг үгүй болгон чиний гажууг хожим залруулан засах болно. Чи Морав газрын гайтай хүн. Хүү чинь Морав газрын авралтан ачтан хүн болох заяатай. Чамайг хүн бүр хараадаг бол, хүүг чинь хүн бүр ерөөдөг болно. Тэр буянтай хүүг чи олж үзэх хувьгүй амьтан. Хүү чинь манай эх нутагт нэн их гашуун зовлон тохиоход үзэгдэнэ. Харь дайсан манай газар шороо эзэлж хүн ард маань сөнөхийн цаг болов уу гэж айн эмээх тэр цагт Арвайхүү их цэргийн хамт ирээд, дайсныг дарж, нутаг усаа ариутган Морав улсыг харийн талхин дороос ангижруулна. Чи буцаж, гэмээ наманчлан гэмш! гэхэд нь, ван тэр үг сонсож тэсгэлгүй гайхан эмээж, буруугаа мэдээд сэтгэл эмгэнэн зовж хатан хүү хоёроо санан гашууджээ. Шилтгээн дотроо ганцаараа хүнээс хөндийрч, царайгаа барайлган явдаг болоод, нэгэн өдөр бас олон ноёд зочдын урин ирүүлж урьдын адил найр хурим хийх гэсэн ч, бусдын наргихыг харахдаа сэтгэл сэргэхгүй ширээнээс босоод, зочдоос холдон шөнө шилтгээн дотроо орох гарах газраа олж ядан, ийш тийш явдаг болжээ. Чингээд нэгэн цагт, сэтгэл гансран цөхрөөд, шилтгээний хүрээ доторх мань гүнзгий худагт үсрэн орж амиа хорлосон гэдэг.

II

Хропин ноёны хүүгийн тухай даяанчийн хэлсэн үг нь Морав газар тархаж, хүн амьтан Арвайхүү ванг хүлээн суух боллоо Хронины шилтгээнд ван морилж ирэх бий гэж хэзээд ширээ засаж, нойрсох лавран бэлдээтэй байжээ.

Арвайхүү ван ирнэ гэж Хропиныхон, Пшеров хотынхон, Жалковскийнхан бүх Пшеров нутгийнхан хүлээцгээж жил бүр хот тосгонд олноор цуглацгааж, ирээдүйд олныг жаргуулна гэж горьдон хүсдэг хүлээдэг Арвайхүү ванг угтан тосох гэж, зэр зэвсэг барьцгаан, хөдөө тал, айл гацаа ой модоор явдаг байлаа.

Аж төрөх нь улам гашуун бэрх болж, албат харц ард амьтан сүүлдээ ноёдын албан ажилд махаа идэж байх цаг. Арвайхүү ван ирэх цаг бий, тэгэхэд ард олны жаргах цаг ирнэ гэж сэтгэлээ засдаг байжээ. Чингээд Иосеф хуандийн үес хамжлага албатын байдлыг нэлээд хөнгөн болгосонд, хөдөө нутгаар өнөөх хүсэлт Арвайхүү ван ноёнтон ирсэн байх. Одоо л хэдийн хүссэн сайхан цагийн эх нь үзэгдэж, ноёдын санд албаар ажил хийх зовлон устаж, харц албат бүхэн бүрэн эрх чөлөөтэй болох нь гэж горьдоод, йосеф хуанди насан эцэс болов гэсэн чинээ сонсоод огт итгэхгүй байсан гэдэг.

Амьд бий, гагцхүү хөдөөгийн ард олны аж амьдралыг өөдлүүлэхэд дургүй ноёдоос биеэ нууж, зүс буруулаад энгийн олны дунд хэсэж хөдөө айлаар явж байгаа гэж амьтан цуу дамнан хэлэлцэж, Арвайхүү ван маань тэр дээ гэж хэлэлцдэг болж, тийнхүү шинэ Арвайхүү ван тодорчээ.

Гэтэл дээгүүр түүнийг дургүйцэх ноёд эмээж, тэр вангийн нэрээр хөдөө тосгонд үймүүлэгч улс явж, амьтныг хатган үймүүлж байна гэж боддог болжээ. Тэгээд мөрдөж хөөж, бүх орны олон мужид эртнээс нааш тэр битүүлэг нууц ванг шөнө ч гэсэн хааяагүй тогтсон цагт агнан эрэх болсон билээ.

Ноёдын албаны хүн, анчин, ойн цагдаа, ангийн хайгуул, тамгын бичээч, хаалгач бууч нар цөм гацаа суурин газар айл алгассангүй явж ахлагч дарга зөвлөх нар тэдний эрэлд туслах үүрэгтэй байжээ. Байшин бүрд орж нэгжээд, пүнз өрөө, тасалгаа, зоорь дээвэр доорх хөндий бүхэнд шагайж үзээд, гацаа тосгон доторхыг цөм байцааж, буудалд бууж, ноёны зардлаар идэж ууж ядраагаа гаргадаг байсан гэдэг.

Чингээд хэчнээн эрэвч, Арвайхүүг хаа ч олдсонгүй. Улс амьтан түүнийг олны дунд яваад, ноёны баалан хийлгэдэг хатуу ажил мөд эцэс болж, амар жаргалаа эдэлнэ гэж зовсон олны сэтгэл сэргээж явдаг юм гэж итгэдэг байсан бөгөөд, айл гацаа бүрд Арвайхүүг таньдаг нэг хоёр хүн бий. Тэднийдээ хүн амьтан унтсан хойно очиж ярьдаг. Орж ирэхдээ цочмогхон орж ирдэг бөгөөд (насны дунд байдалтай, өндөрхөн нуруутай) хөх цэмбэн цувтай, малгайтай, урт дээлтэй хөх өмдтэй, Гутал нь ямар ч их үер бороотойд толь мэт гялалзаж байдаг юм. Өөрт нь ч борооны ус халддаггүй, цув малгай нь хув хуурай байдаг. Тэр цув нь эзэндээ ус халдаадаггүй, бас нойр хүргэдэггүй, өлсгөж умдаасгадаггүй бөгөөд эзнээ далдлах чадалтай тул, уулзья гэж эзний нь хүссэн хүн л харахаас биш, хамаагүй хүнд эзнээ үзүүлэхгүй цув байж гэж амьтан хэлэлцдэг байлаа..

Орж ирэхдээ, харанхуйгаар, хаалга нээлгүй орж ирээд, сандал дээр сууж яриад таньдаг хүнээсээ элдэв юм асуугаад, ялангуяа, эзэн ноёны баалах ажилд хүн ардыг яаж байна гэж асуудаг байж гэнэ. Тэгээд алба гувчуур улам бэрх болох нь, юм бүрээс татвар татаж, хогийн шүүр ч бас эцэстээ татвартай болно. Тэгээд түүгээр шувтарч, тэр ёсон бус татвар устаад, эзний баалах ажил ч үгүй болно гэх зэргийг ярьж суугаад тавьсан талх иддэггүй, ирсэн лүгээ нэгэн адил, хаалттай хаалга нээлгүй нэвт гараад, хаа очихоо хэнд ч хэлэлгүй яваад өгдөг. Айлд ер хонодоггүй. Шидэт цув биеийг нь халхлан хамгаалж харанхуй шөнө ганцаараа явахдаа ард олны сэтгэл зоригжуулагч тэр хүн, ус шалбааг шавар шавхай замтай замгүй газар гэж үл ялган хөөж, тагнах хүнээс айлтгүй, санаа амар явдаг юм гэж хэлэлцдэг асан. Тагнуулчин ч замд нь зэвсэг барин, агталж хүлэн баривчлах гэж яваад дайралддаг байжээ. Тэгэхэд аливаа дарлагдсан хүний санах сарвайх юм нь болж, үеийн үед бэрхийг туулж, хэзээ ч дарагдашгүй бөгөөд итгэсэн горьдлыг нь лав л гоомойдуулахгүй. Морав нутаг хэтийн сайхан ирээдүйтэй юм гэдгийн биелсэн итгэл горь нь болсон Арвайхүү ван тэгж ажран явдаг гэнэ.



БОГД ВАЦЛАВЫН ХИЙР

I

Зун хүйтэн байжээ.

Тэр бол, Тэнгэрийн хөвүүн мэндэлсний нэгэн мянга нэгэн зуун хорин таван он улаан сар гэдэг зургаан сард, Сүлд тэнгэрийн өдөр чех газар их хүйтэн болж, цас их орж, олон газар мод үхээд, ууланд гол горхи нимгэн бус, маш зузаан мөс хөлдсөн цаг байлаа. Чингэхэд тэр жил бас нэг сонин жил болсон нь ёстой өвөл цаг болоод хамаг юм цасанд дарагдсан хойно зуны их салхи хүн амьтныг сочоож билээ. Тэр жилийн эцэс, Христос мэндэлсэн зул сарын хорин тавны урьд Хишигт үдэш, мөн хорин тавны шөнө, Тэнгэрийн хөвүүн мэндэлсэн цаг тэнгэр дуугарч, цахилгаан гилбэлэн цахилсныг улс амьтан үзсэн билээ. Бас анхны тамлуулагч¹⁵ богд Штепааны тэмдэглэлт өдрийн шөнө цахилгаан ихэд гилбэлэн цахилсан гэдэг.

Чингээд өвлийн улиралт газар оронд цаст их үүл тун доогуур нүүж, гялалзсан гялбаа гарсан гэдэг. Тэр бол, Шинэ жилийн шинийн хоёрын үүр цайх үес байжээ. Тэнгэр нээгдэж, хөхөмдөг улаан гялбаа нүд нь эрээлжлэм гялс гялс гялалзаж байлаа. Амьтан наманчлан залбирч, муу ёр боллоо, дайн хөл болж байна уу болох ч юм уу гэж хэлэлцжээ. Ноёны омог дотор сүрхий тэмцэл гарч байхад дайн

бололгүй яах вэ? Оломоуцын ноён Хар гэдэг Отик, үеэл Собеславыг олны сэтгэлээр ширээнд суусныг дургүйцэж, Бавар гэдэг германы Резно хот, герман хааныд одсон гэж, нутаг даяар, шилтгээн, шилтгээнцэр, шилтгээний хормойн суурин, гацаа айл хийдээр чимээ гарах болжээ.

Ота буюу Отик, өөрөө чех хүн мөртөө, хэлээ буруулж, герман хааныг бараадан түүнээс, мөн герман ноёдоос тусламж гуйж. Собеслав ноён болон Чехчүүдийг довтолбоос, аль хүссэнийг нь даган амлана гэж байгааг газар сайгүй хэлэлцэх боллоо. Амьтан, тэгж л гайтах байх даа гэж суух болсон нь, германыг андахгүй, тэд олон гуйлгахгүй ашиг олз олох гэж, бас Отикийн амлаж хэлэлцсэнийг хүлээж, мөнгөний хойноос Чехчүүд нутаг орж ирэх байх гэж хүлээж суутал, удалгүй нэг мэдээ хорсон сонсвол, герман хаан Лотар, омогтой үгээр Собеслав гэдэг Өөртөөбаяр ноёныг яагаад, ямар эрхээр чехчүүд газар ноён суух болсон гэдгээ шүүхийн өмнө хариул, тэр суурин залгамжлуулах эрхийг гагцхүү хааны бие мэдэх тул, германы шүүхийн өмнө өчгөө өг, эс чингэвэл, Хутагт Ром улсын хааны сүр хүчин юлд мэсийн чадлыг үзүүлнэ гэсэн чимээ гарчээ.

Чингэтэл бүгдийн нүд гялалзан, баярлан хашхиралдсан нь, тэдний ноён Собеслав германд хариу хэлэхдээ, Тэнгэр өршөөн, богд Уламбаяр Вацлав, Дайны цэнгэл Войтех тэтгэж, чех газар харийн эрхшээлд орохгүй байх гэж горьдоно гэсэнд нь баяр хөөр болжээ.

— Орохгүй Тэнгэр өршөөж, оруулахгүй! гэж хааяагүй хашхиралдан, дайнд зэхэцгээжээ. Хавар тийшээ цас хайлж, замын шавар шавхай хатахад дайн хөдлөх байх гэж амьтан боддог боллоо.

Цахилгаан гялбаа гарсан нь огт дэмий бус. Бас цэлмэг хүйтэн шөнө тэнгэрт муу ёрт сагсайсан сүүлт од үзэгдэн, олон одны жирэв жарав хийх гэрэлд сүртэй гийж харагдахад нь хүн бүхэн түүнийг харж, юу болохын шинж, яахын тэмдэг вэ? гэж зовнин хэлэлцэв. Тэгтэл маргааш нь Бэрх уулын зүгээс чимээ ирсэн нь цэлмэг өдөр аянга ниргэсэн адил олныг хэлмэгдүүллээ. Герман дайнд мордохыг зэхэж, хаан хавар болохыг хүлээлгүй Чех нутагт дайлаар мордох болов гэсэн чимээ тархжээ

Бэрх уулаас Шуугиант гэдэг Шумовын зүг, нутгийн өмнө зүгээр, доошоо Виторав, зүүнш полын хязгаарын тэнд Кладын шилтгээний зүг, умар тийш хөвчит хянган Крконошийн уул, цаашаа Житовск хүртэл, Лабын гол дээрх Коман гэдэг Их чулуугаар гардаг тэр үеийн

чех хилээр, бүх чех нутгаар Морав газраар их хөл бужигнаан болж, байлдах гэж яаран сандан зэхэцгээв. Цагийн хүйтэн их шуурганаас ч амьтан зовохоо байж, дайсан халдах гэж байхад газар усаа хамгаалах нь чухал болов. Чингэхэд бас хайртай Ноён, Собеслав ноён дайтна гэж уриалжээ! Мораваас Отикийн харьяат нутгийг эзэлж аваад, тэндээс хөдлөн, зэр зэмсгээ барьцгаа гэж газар сайгүй зарлан явжээ.

Амьтан сонсвол Литомышлийн газрын хэрмийн тэнд модонд, Хрудим Садек зэрэг газар, замаараа, мөн замаас гадуур ч, сүмд залбирч явсан бөгөөд мөн хүн олны хамт залбирал хийгээд, олны зүг үг хэлэхдээ, битгий ай, эр зориг гарга, сайн ёсыг даран дарлахад Тэнгэр арай хүрүүлэхгүй, ноён миний бие өөрийн нэр, газар орны нэр алдрыг бодоод, герман хааны дураар болсонгүй гэж хэлж явсан байв. Бас Прагын шилтгээнд отгийн дарга тайж нарт

— Өөрийнхөө чех хэлийг муучлуулахыг үзсэнээс өөрийнхөө төрөл төрөгсдийн сөнөхийг үзсэн минь дээр гэж хэлснийг нь газар бүр улс амьтан баярлан ярилцдаг боллоо.

Чингээд газар сайгүй дуртайяа хана туургандаа өлгөөтэй хуяг, зэвсгээ, юлд жад, балт, нум саадаг, бамбай, битүү саравчит дуулга, хөө хуяг, гялалзсан ялтсан хуягаа авцгааж, хүн бүр өөрийн отгийн шилтгээнд очиж, отгийн хошуу цэрэгт элсэцгээлээ. Отог бүрээс, хол ойроос баг цэрэг Прагад мориор, явгаар хуяг дуулгатай сармай хуягтай, үстэй дээлтэй, хонин, чонон, шилүүсэн зэрэг малгайтай янз янз хувцастай боловч, дайтах эрэлхэг зүрх цөм нэг адил улс ирцгээжээ. Чех түмний цэрэг тийнхүү хуран цугласанд Собеслав ноён, санваартныг Сватовит гэдэг богд Вийтийн сүмд хадгалаастай богд Вацлав вангийн жад зэхэж бай. Дайсны өөдөөс өмөг сахиус болгон маргааш их цэрэг хөдлөхөд авч явна гэж захиад өглөө үүрээр лам нар отгийн дарга, тайж нар, ард олон шилтгээн дэх сүмд цэрэг мордохын өмнө Мше хурал хурахад очтол, ноён ганцаараа саатжээ.

Тэр үес Вийт гэдэг багш ламыгаа дуудуулан ирүүлээд тасалгаандаа багштайгаа саатсан юм байжээ. Төр Вийт лам сүрхий хүн, эх хэлэндээ, хайртай, сүсэгтэй, эрэлхэг зоригтой бөгөөд ноёны сэтгэлд таатай хүн байжээ. Ноён өглөө эрт тэр багшдаа сэтгэл зовсон байдалтай, нэг жигтэй, юм ярьсан нь.

— Сонсооч, гэж гэнэ, би тун жигтэй зүүд зүүдэллээ. Миний орны хажууд богд Войтех хүрч ирээд, дайнд миний аавын хийр авч яв. Врбчаны сүмд хадгалаатай байгаа. Тэр сонин зүүд зүүдлээд, зүүдний

ёсоор хийрийг авч явах асан гэж бодож байна. Одоо цэрэг мордох болоод, цөм хүлээж байдаг. Явах цаг болоод байдаг. Мше хурлын сүүлээр мордох шүү дээ. Багш минь хичээж үз, би гуйя. Мориндоо шалавхан мордоод, тэр Врбчанд хүрч үзээч. Ганцаараа битгий яв. Зэвсэгтэй дагуулаас аваад яв. Тэгээд тэр Словникийн хийрийг олбол, миний өмнөөс аваад, бушуухан бидний хойноос цаг мөч алдалгүй мордоорой гэж гуйн энсэхэд нь эрэлхэг тэр багш лам нь сонин зүүд, их л учиртай хэрэг гэж, ноёныхоо хүссэн ёсоор яаран мордож, Мше хурал тархаж, ноён олон цэргийн эгшиглэж дайнд мордоор хөдлөхөөс өмнө Прагын шилтгээнээс гарч, хоёр шадар тайж хэдэн зэвсэгтэн цэрэг дагуулан хурдан мориор Чех олмын зүг давхиж, тэндээс богд Прокондын төрсөн гацаа Хотоуны хажуугаар Врбчан тосгоноо зорьжээ. Давхи давхисаар өвлийн богино өдөр шувтрах үес цасанд дарагдсан хөл үймээнгүй тэр тосгонд оржээ.

Энх сайхан өдөр газар шороон далан хэрэм босгосон дугуй дуган сүм, үдшийн шингэх нарны улаан туяа татсан тэнгэрийн зүг сүндэрлэж, асарт цамхаг хамгаалах хэрмийн ганц хаалгыг батлан наана нь үзэгджээ. Дуганы лам нь ноёны элчийг тэр цамхагт богд Войтех бодон Түүний омог төрлийн хийр хадгалсан газрыг үзүүлэхээр оруулах үес үдэш болж, тэр тахилын чимээгүй оронд бүрэнхий болж байлаа.

Вийт лам, дагасан хүн, сүмийн ламын хамт сөгдөн мөргөж, зорьж ирсэн хэрэг бүтэхийг залбираад, лаа зул барьж, тахил шүтээний цаана нь хэрмийн хөндийд тусгайлан юм хадгалах далд газар хуучин ваадан торгон асар өргөнгүй зурвасыг хоёр нарийн шиг хэсэг болгон хийсэн хийр, таван хошуу хатгасан тийм юм байв.

Бүгд тэсгэлгүй баярлаж Вийт лам сөгдөн тэр хийр олдож, бэрх дайнд ялахын горь заяасан тэнгэрийг магтан залбирсанд дагалдан сөгдөцгөөлөө.



Чингээд морь биеэ түр амраасхийгээд, дахин мордож, шөнө харанхуй болсонд ч айж сааталгүй тэр эрдэнэ олсондоо бушуухан эр цэргийг гүйцэх гэж цасан дундуур нам гүм хүйтэн шөнө, түг түмэн түгсэн одны дунд өнөөх сүртэй одон цэлмэг тэнгэрт үзэгдэж байгаа үеэр хий үзэгдэл мэт чимээгүй давхицгаажээ.

II

Чех цэргийн мөрөөр нь өдөр шөнөгүй ингэж довтолсоор явахад, их цэргийн өнгөрсөн газар зам нь андашгүй тоо томшгүй морины тах, хүнд юм ачсан чарганы мөр гарсан байв.

Тэр замаар нь саадгүй хойд зүг чиглэн явахад нь морины амнаас цагаан уур савсаж, хүйтэн тул, хүний нүүр улаан болж, зэвсэгт тэр эрсийн сахал үс нь мөнгөн цагаан цан болж, тэсвэр сайтай морины үс дэл, чих нь цантжээ.

Аялж явсан тэр хэдэн хүний өмнө цагаан жанч нөмөрсөн Бэрх уулс сүндэрлэж, Теплицийг өнгөрөөд, их цэргээ гүйцээд авчээ. Вийт лам мориноосоо бууж, шууд ноёны өргөөнд орсонд, Собеслав ноён

ихэд баярлаж, хэрэг бүтсэнд Тэнгэрийн ивээлд залбираад, бүх цэрэгтээ учрыг зарлавай.

Тэр сонин сайхан чимээ цэргийн хүрээнээ салхин мэт хурдан түгж, хүн бүр ноёны өргөөний зүг тэр сонин хийр үзэх гэж очсонд, ноён өөрөө, сайхан үсээр эмжсэн дээлтэй, эрэлхэг эр, олонд хийрийг үзүүлэх гэж том чарга дээр Вийт ламын хамт гарч зогсжээ. Багш ламын адил, малгай дуулгагүй, толгой нүцгэн зогсоод, хийрийг дээш нь өргөн, хол сонстох өндөр дуугаар сэтгэл хөгжин өгүүлрүүн:

— Энэ бол Тэнгэр тэтгэсэн тэмдэг! Энэ жад бол богд Вацловын жад. Жаданд байгаа энэ хийр бол, богд Войтехийн бидэнд хайрласан хийр хөгшин залуугүй, тайж харц олон цөм малгай авцгаан сөгдөж, наманчлан залбирч, ноёны өргөө чарга тойрон гайхан баярлах, ерөөх үг дуу шуугьжээ.

Баяртай чимээ хүрээгээр дүүрэн, цаашаа боомтын газар, цасан зам, уулын хавцал сахисан манаа, манлайн харуул хүртэл тархав. Тэр харуул, маргааш ид герман айсуйн мэдээ ирүүлэв.

Герман маш их хүчин айсаж, дотор нь Саксууд нэн олон. Бас Дүринкүүд, Фландрууд, Фрисүүд, Брабантууд, бас Рейнийхэн, мөн Швабууд, бас Бавар газрынхан явалцжээ. Тэр их цэрэг, цаст уулын хоорондуур тасралтгүй цувж, аварга могой явж яваа юм шиг нам газраас даваа өөд, даваанаас доошоо нугачин цувж, зам их бэрх, хүн морь их л ядран явах ажээ. Цасан хунгар дундуур туулж, гулгах нь гулгаж, шигдэн ойчих нь ойчиж, хүйтэн боловч, хөлөрцгөөж, морь нь уур савсаж, хүнд хуяг нь ялангуяа уулын нарийн замаар явахад бүр ч хүнд байжээ.

Морьтон баатруудын зарим нь өмсгөл хуягаа тайчаад, мориныхоо дэргэд явган явж, нэг хэсэг яваад ядарч зогсдог байв. Урд нь хошуучилж явсан хөө хуягтай эрэлхэг засаг гүн Баавгай хочтой Албрехт түүнтэй зэрэгцэж явсан хүрэн царайтай хар үстэй, өвч хуягласан нэгэн ноён, өнөөх Хар Отик гэдэг тэр хоёр гагцхүү урагш яаран давшиж шамдан довтлов.

Чингэж явсаар даваа давж, доошоо нугачаа бэрх замаар бууж, урагшлуур анги, бөөн их цэрэг цөм доошоо намд ортол, хлумын аманд бүх чех цэрэг жагсан тосжээ. Цэргийн баг дээгүүр туг нь гялалзсан хүйтэн агаарт хийсэж, хамгийн дээр нь бүх цэргийн хийр болсон богд Вацлавын хийр намиран хийсэж байлаа. Вийт лам хуяг дуулга өмсөөд,

тэр хийр барьж, дэргэд нь түүнийг хамгаалах зуугаад чех ноёд, зэвсэг барин зогсоод, сүмчин, мяндагтан бас байлцжээ.

Бүх чехчүүд өмнө нь хүрч ирсэн тоо томшгүй олон хүнтэй дайсны жагсаалыг ширтэж, тэр дайсны цэргийн сүүлч нь харагдахгүй хол явж хөндий дүүрсэн бөгөөд, харлан харагдах тэр их цэргийн зэр зэмсэг, хуяг дуулга нь мяралзан гялалзаж байв. Эрэгчин эмэгчнээ үзэх цаг тулж, харин тэгшгүй тулалдааны өмнө хүн бүхний зүрх түгшин цохилоо.

Чингэтэл, нэг хүн хашхирч, дээшээ заасныг үзвэл, огторгуйн гялбаганах өөд их бүргэд халин нисэж, бяр ихтэй далавчаа дэлгээд чех цэргийн дээгүүр герман цэргийн зүг нисэн явав.

Цөм машид гайхаж, дуу чимээ нэгмөсөн намдаад, гагцхүү их бүргэдийн хахир дуу тов тодхон дуулдаж, германы өөдөөс хашхиран нисэж яваа нь тэнд улай гарахыг зөгнөж яваа юм шиг.

Тэр сайхан бэлэгтэй үзэгдэл далд орохын өмнө чех цэргийн дээгүүр бас нэг сүрхий дуу чимээ гарч, хонхны дуу дүнгэнэн дуурьсаж, олны дээгүүр жавхлантай дүнгэнэсэнд, хүн бүгд гайхан баярлав. Тэр битүүлэг сонин дуунд сэтгэл баясаж зориг ороод, хүн бүхний царайд баярын тэмдэг тодорч, нүд гялалзан зарим хүн сэтгэл хөдөлсөндөө чичрэв. Вийт лам санаа зориг бадарсандаа царай нь цайвгар болж, нүдний нулимс унаган уярч тэнгэр өөд хараад, сүр төгөлдөр чимээгүйн дунд өндөр дуугаар дуудруун:

— Ах дүү олон минь! Тэнгэр бидний хамт байнам.

Хатан зоригтой бай. Зоригтой бай! Харав уу богд Тэнгэрийн гэгээн агаарын цагаан морь унаад, цагаан өмсгөл өмсөж тэр хийртэй жадаа бариад, манай талд дайнд ялгуун мордлоо. Харж байна уу, бидний дээгүүр гэв гэгээн богд Вацлав, чех нутгийн өвгөд морилж явна! гэхэд нь олон цөм гайхан баясаж, гараа тэнгэрийн зүг өргөцгөөн, уярсан нэг нь нулимс унаган, үнэн голоосоо сэтгэл хөгжин, нэгэн санаагаар «Эзэн биднийг өршөө!» гэж дуулал, эгшиглэлээ. Өвгөд дээдсээс уламжилж ирсэн тэр дуулал, хөндий дүүрэн хангинаж ноён Собеслав юлдээр урагш чичин заамагц, бүх цэрэг тэр дууллаа дуулсаар, байлдах зориг бадран, дайсны урдаас дайран орлоо.

Байлдааны их хөлд дуулал чимээгүй болж, хоёр цэрэг хөндийд дайтаж герман хэдий зоригтой тулавч тэссэнгүй. Яаж ч чадсангүй. Чехчүүд далайн давлагаа мэт дайран, их цэргийн гол нь шууд түрээд, хоёр жигүүрээс бүгсэн цэрэг орж, дайсныг улаа асгартал хядан, нарийн

хавцал зам хүртэл шахан түрэхэд, герман хавцалд тас шахагдан цаашаа ч үгүй, наашаа ч үгүй, чигжигдээд, догшин тулалдаанд унан үхэцгээж гээж, орчин тойрны цас час улаан болжээ. Их хүйтэн байсан тул, цус дорхноо хөлдөж, хувцас, цас, хуяг зэвсэг, шарханд хүртэл бялтан хөлдөв.

Сандрахдаа германчууд оргож зугтах нь оргож, бамбайгаа хаях нь хаяж, юлдээ цасанд шаагаад, амь гуйж, бууж өгцгөөв. Үүнд Мезибарын бискуп хамба, халберштатын хамба, Ларын гүн, бас Баавгай Албрехт гэдэг засаг гүн бууж өглөө. Гагцхүү тэр дайн өдүүлсэн Хар Ота, алуулсан хүний дунд үхээд хэвтэж, унасан дайсны тоо маш их. Жир хүнийг эс тоолбол чехэд алуулсан дан ганц нэртэй хүн таван зуу хүрчээ.

Даваа дээрээс Лотар хаан, өөрийн цэрэг хиар дарагдахыг айн эмээн харавч, туслан тэнхрүүлэх аргагүй, өөрт нь аюул учрах шахжээ. Дэргэдээ үлдсэн цэргийн хамт ухран зайлъя гэтэл, Чехчүүд бүх зам хаасан тул, довтлон байлдаж гарсугай гэтэл хүчин мөхөстжээ. Чехчүүд эс тавивал, яаж ч мултарч гарахын ухаангүй болсон тул хаан цэргийн хамт бүслэн хоригджээ.

Найрамдахыг гуйхаас өөр аргагүй болсон тул, Гротски Йидрик гэдгийг чех ноёнд явуулж, хаантай уулзахыг ирээч гэж гуйхад хүрээнд, Собеслав очиж, уудам сэтгэлээр хэлэлцээ хийсэн гэдэг. Чингээд Лотар хаан, Собеславыг даруй чехийн ноён мөн гэж хүлээн зөвшөөрч чехчүүдийг ноёноо сонгон өргөмжлөх эрхтэй гэж зөвшөөрсөн хойно сая ухран буцах зам гаргаж өгчээ. Чингээд үлдсэн цэргийн хамт Герман нутагтаа гуныхран эгвээс, Герман газар бас хааны хамт гашуудал эмгэнэл хүрч ирлээ. Ялангуяа Саксон газар их бэлэвсрэл болсон нь Саксууд, Чех газар дайнд бусдаас илүү хүн хохироод, тэр унагедын дотор аль эрхэм омгийн хүн тун олон байжээ.

Хлумце гэдэг Толгод нэртэй тэр газраас харин Чех нутагтаа буцах цэрэг, дайнаа дарж, даашгүй их олзтой буцаж билээ. Ялсан мэдээ цэргээс түрүүлж газар сайгүй олон амьтан, Тэнгэр өршөөж тэтгэсэн гайхалтай явдлыг зон олон гайхаж, ёр бэлэг үзэгдсэн зүйл, богд Вацлав үзэгдэж, түүний хийр цэрэгт байсныг хэлэлцэхдээ, тэр Хлумцийн дайнд олсон их алдар хүндийг өвгөд дээдэс маань ч үзээгүй билээ гэж газар орон даяар хэлж баршгүй их баяр болон, эрэлхэг Собеслав ноёныг цэрэг сэлтийн хамт Прагад нэн хүндэтгэж, алдар цууг нь гайхан тосож билээ.

Хлумцийн тэр их байлдаан, эзэн мэндэлсний нэгэн мянган нэгэн зуун хорин зургаан оны хоёрдугаар сарын арван наймны өдөр болсон билээ. Тэр жил гэгээн ноён Собеслав Жийп ууланд богд Ийжийн дуган өндөрлөсөн бөгөөд дуган түүнийг манай эрхэм судрын хүн Космаагийн хүү, Оломоуцын бискуп хамба Здик амласан билээ.

III

Манай дээдсийн бас сайхан ялалтыг өгүүлж, дээрх байлдаанд далдын тусламж үзүүлсэн явдал, Свойсловын хүү Яны үзсэн сонин үзэгдлийг дурдсугай.

Тэр бол 1260 оны нэгдүгээр сард чех ван 11 Пшемислыг Унгартай, тэдний Бела ван, бага Штепаантай байлдаж байсан үед болсон хэрэг Хоёр улсын цэрэг Морав талд, австри нутагт Морав голын хоёр эрэг дээр урд урдаасаа хараад их удсан билээ. Баруун гар талын эрэг дээр Чехчүүд, зүүн гар талд Унгар холбоотон Польш Орос, Хорват Серб Босни нутгийн сербүүд Волах Итали нар, секелийн Мажаар, татаар догшин Куман гэдэг хивчагүүд хорезмийн түркчүүдтэй байжээ. Бүгд нэг бум дөрвөн түм, бас илүү ч их төлөв морин цэргийн их хүчин байжээ.

Чех ван гагцхүү нэг буман цэрэгтэй. Түүний долоон мянга нь хөө хуяг, ялтсан өвч хуягтай морин цэрэг, морь нь бас төмөр хуягтай, Пшемислын цэрэгт Чех Морав Силезүүд бас австри Браниборын туслах Герман цэрэг, Корутан-газрын герман, Словенчууд байжээ. Вангийн дэргэд бас чех Морав нэртэй ноёд чех вант улсын их жанжин Рожмберкийн Вок ноён, Подехүсийн Ярош, Прагын туркраб хэмээх шилтгээний гүн ноён бөгөөд богд Вацлавын жад дахь газар, орны туг эрхлэгч нь, подкоморжи гэдэг вангийн шадар сайд, Баварын дээд Коморнак гэдэг шадар сайд Страконицын ноён, Подебрадын Вилеем. Одон уул гэдэг Штернберкийн Хэрэм-алдар гэдэг Здислов, Фалкенштейн гэдэг Шонхор чулууны шилтгээний Заавиш ноёны эцэг, Крумловын Будивойн зэрэг Вийткийнхэн, бас чех Морав омгийн ноёд байжээ. Тэдний хамт бас Прагын бискуп хамба, Оломоуцын хамт мөн герман морьтон баатар, Герман улсын ноёд байлцжээ.

Хоёр их цэрэг тэгж урд урдаасаа харалцаад, хооронд нь их гол урсаж байлаа.

Аль аль талын ч цэрэг, нэгийнхээ өөдөөс гол гатлан хохирохыг үл зүрхлэн, өдөр хоног өнгөрсөөр нэг долоо хонолоо. Тэгээд, хоёр ван харилцан хэлэлцэж, тангараглан баталж, тогтоосон нь Чехчүүд тухайлан тогтсон долоодугаар сарын арван нэгэнд голоос ухран зайлж өгөөд маргааш нь арван хоёрт Унгарчууд гол саадгүй гатлаад, нөгөөдөр нь арван гурванд хутагт Маркетийн өдөр байлдан тулахаар тохирчээ.

Чингэж хэлэлцэн нийлээд, унгар ван, амбас сайд нь тангараг өргөсөн боловч түүнээ юманд бодохгүй, хэлэлцлийг зөрчиж, голд сайхан олом олмогц, шөнө гатлаад арван хоёр, арван гуравны өдөр тоо томшгүй олон цэрэг чехчүүдийг дайрчээ.

Чехчүүд, хэлэлцэл хийлээ гэж итгээд, сэргийлсэнгүй. Байлдаанд ч зэхсэнгүй. Зарим баг цэрэг нь хүнс хоол эрэх гээд мордсон байжээ. Чингээд Унгарын довтлоход Чехчүүд тун зэхээгүй байсан цаг таарч, Унгар цэрэг нуман жагсаалаар дайран орлоо.

Куман цэрэг догшин сүртэй хашхиран довтолж, түмэн царцаа дэвхрэг адил дэлхийг бүрхэн, морины төвөргөөнд газар донсолсонд чехчүүд анх айн сочиж билээ. Чингээд, «Эзэн Тэнгэр биднээ өршөө» гэдэг дууллаа эгшиглээд дээд пуркроб гэдэг шилтгээний гүн төмөр хуягтны дунд газрын туг өргөмөгц, бүх цэрэг айхаа байж, баатарлан тулалдаж эхэлсэн билээ. Подехусын Ярош ноён хийрээ барьж дайран орсон зүг бүхэн дайсан ухран шантарч, дутаан сарницгаагаад, төмөр хуягт эрс нэг ч гэмтэл шарх олсонгүй хуягт морь нь осолдсонгүй.

Тэр сүрхий догшин тулаан болоход үд өнгөрч, тэсгэлгүй, бүгчим халуун байсан бөгөөд, их цэргийн ард бүгсэн цэрэг сонин юм үзсэн нь:

Морьтой явган чех цэргийн дээгүүр, түг түмэн дуулга, баг цэргийн хийр тугийн дээгүүр гэнэт нэг том шувуу далавчаа дэлгэн халих нь үзэгдлээ. Ажиглаваас, цаснаас цагаан бүргэд, толгой хоолой нь алтан шаргал туяа татаж, биеэс нь гэрэл туяарч байв.

Чех цэрэг дээгүүр нисэж, яг богд Вацлавын туг дээр очиж, дээд шилтгээний гүн пуркробийн залж, бэрх тулалдаан алалдаан дундуур намиран хийсэж явсан түүний дээгүүр халин нисжээ.

Чингэсээр тэр гэрэл татсан цагаан бүргэд юм бол болсоор, өд нь өргөн их бол болсоор дэлгэр их жагсаалыг далавчаараа бүтээж, үлэмж их жигүүрээс нь үүлнээс тусах мэт сүүдэр тусч морь хүнийг хамгаалах атал, богд Вацлавын хийр ганцаараа нарны гэрэлтэй гэгээн гялгар бөгөөд алтан гилбэр нь түмэн цэргийн дунд ганцаараа нигууцсын

гэгээн гэрэл туяа сацруулж, бүрэг сүүдэр дунд гялалзанхан харагдаж байв. гэнэ

Чингээд гэнэт гэрэл туяа нь үгүй болж, цагаан бүргэд агаарт замхран үгүй болж халуун нар дахин бүх цэрэгт илч гэрлээ тусгав. Тэр бол, Морав тал дүүрэн чех цэргийн баярлан хөгжимдөх дуу нижигнэнхэн дуурьсаж, Унгарчууд сандан мэндэн тоос бужигнуулан дутааж, голын зүг тэмцэн Куман-Хивчаг Татаар Мажаар, тэдний бүх цэрэг ухаан амьгүй Морав голын нөгөө талд гарах гэж давхиж усанд ороод, хөл алдаж, морь хүн сацаж үхсэн, голын ус хааж, чехчүүд тэр олон хүүр дээгүүр дамжин гарч, Унгарын маш баян цэргийн хүрээг эзэлж, өдий төдий их олз олжээ.

Тэр унгарын дайнд хавар цаг мордох гэж Свойсловын хүү Ян гэдэг эрэлхэг нэг тайж, зэхэж, морь зэр зэмсэг өвч хуяг бэлэн зэлэн болгоод байтлаа хүнд өвчинд нэрвэгдсэн байжээ.

Моринд мордож чадахгүй, хэвтрийн хүн болоод, олон долоон хоног орноос салахгүй хэвтэхдээ, ван лугаа дайнд мордож эс чадсандаа гашуудаж, дайны газраас мэдээ чимээгүй тул, мөн ч бухимдан хэвтдэг байлаа.

Нэгэн өглөө үүрээр гэр орны хүнийг унтаж байх үес гэнэт өвчин нь хүндэрч, мэдээ алдсанд, нөхөд найз нь, орны дэргэд цуглан, одоо амьсгал хураах цаг нь болж дээ гэж бодоцгоолоо. Царай нь хөв хөх болоод, аньсхийсэн нүдний гал нь муудаж, хэнхдэг нь оволзон амь бүтэн байлаа.

Тэгсээр намдаад, хэвтэсхийж байтал, гэнэт царайн өнгө ондоо болж сэргээд, уруул ам нь мишээж, нүд нээвээс, маш тунгалаг болоод, ор дээрээ овоо дориун өндийж, тун баяртай дуугаар өгүүлрүүн:

— Тэнгэрийн хишигт баярлагтун! Миний адил магтан ерөөгтүн. Миний саяхан үзсэнийг баярлан сонсогтун. Би энд эзгүй, дайны газар очоод, манай чех түмэн цэрэг, Унгарын өөдөөс олигтой жагсаж чадаагүйг үзлээ. Тэгтэл дайсан тэр үес цочмог дайрч, их муухай юм болон алдлаа... Түүнийг хараад, миний зүрх шимширч, нэг харах нь аа, та нар сонсоорой, ихэс өвгөд, юуны өмнө богд Вацлав гялалзсан хуяг дуулгатай, сувд шигтгээтэй алтан хуйтай юлдээ бүснээс агсаж, баруун гартаа хийрээ бариад явахыг харлаа. Хойноос нь богд Войтех бискуп хамбан¹⁶ жанчтай, тэгээд богд Прокон ширээт гартаа дулдуй бариад, хойноос нь таван тамлуулагсад номт хувцастай явахыг үзлээ.

Богд Вацлав, богд Войтех, Прокон хоёрын зүг, мөн бусдын зүг хараад,

— Миний цэрэг хүчин мөхөстөж байна. Тэнхрүүлэн туслаар одьюу гэж айлдахыг нь би ив илт сонслоо. Чингээд, хийрийг дайсны эсрэг хандуулан дайрахад нь манай цэрэг «эзэн тэнгэр» гэдэг сайхан дууллаа эгшиглэн байлдаж эхлээд, дайсны сүр омог дарагдан дутаалаа гээд гараа сунгахад нь дэргэд байсан улс машид гайхаж,

— Тэнгэр манай ванд дайснаа дарах хутаг хайрлажээ! гэж өгүүлэлдэв.

Чингээд дайны газраас мэдээ ирж, цэрэг нутагтаа эгэх цаг сонсвоос, Чехчүүд, Морав талд Мажаарыг дарж дархан цолоо мандуулсан тэр өдрийн үүрээр, Собеславын хүү Яны үзсэн тэр үзэгдэл яг үнэн болсон гэдэг. Тэр явдал дээр өгүүлсэнчлэн Тэнгэр Мэндэлсний 1260 оны долоодугаар сарын арван хоёрын өдөр болсон хэрэг билээ.

IV

Богд Вацлавын хийр нь манай эх нутагт тохиолдсон бэрх цагийн үймээнээр үгүй болоод чухам хэдийд яасныг мэдэхгүй домог үгэнд сэтгэл засаж өгүүлэх нь, бузар гараар устаагүй, харийн олз болоогүй, эх нутагтаа л бий байх, байх байхдаа бас урьд байгаад, бэрх аюул тохиолдох дээр эрт цагт чех цэргийн зориг бадруулах өмөг болгох гэж анх авсан газар, Врбчаны хэрэмт бяцхан дуганд л байж байгаа байх гэж хэлэлцдэг.



Тэнд хэдийгээр урд байсан хөндийд байгаагүй боловч, бүр ч бат далд газар, дуганы доорх толгойн дотор ухсан бэх зооринд, гантиг ширээ дээр байдаг юм гэлцдэг. Тэр зооринд чив чимээгүй бөгөөд, зэмсэг хангинах, баатар эр хашхирах нь дуулдахгүй боловч, тэр бяцхан тасалгааны харанхуйд хутагт жадны алтан гилбэр нь харш тотгорын харанхуйд горьдол тодорч байдаг лугаа адил гэрэлтэн гийж. «Эзэн тэнгэр өршөө», «Чех нутгийн сэнгүн ноён богд Вацлав аа» гэдэг дайчин эрсийн байлдан орохдоо дуулдаг дууллын эгшиг дээрээс нь анирлаж, хойчийн ач үр нь зориг төгөлдөр бөгөөд тэр газар орныхоо төлөө эцэг өвгөдийнхөө хэлний төлөө тэмцэхэд цуцахгүйг гэрчлэн буй ажам.



БР УНЦВИГИЙН ДОМОГ

I

Живжид ноёны тэнгэр болсон хойно чехийн төрийг хүү Брунцвиг нь барив. Залуу тэр ноён сайн санаатай шударга хүн байжээ. Эцгийн их гавьяа зүтгэлийг бодоод, алтан дэлхийгээр бядан явж, чех түмнийхээ алдар нэрийг эцгийн адил дуурьсгах юм сан гэж бодох болсоор нэгэнт санаа тогтож, төр барьсан гуравдугаар ондоо хатандаа

— Миний эцэг бүргэдийн тэмдэг олсон билээ. Би арслангийн тэмдэг олох хүсэлтэй гэхэд нь залуу хатан сэтгэл машид чилж, тийм аюултай юм хийгээд яах юм гэж энсэн гуйвч, ноён хатны үгийг огт дагасангүй.

Чингэхэд, хатан гашуудан хайлж ганцаарыг минь битгий орхиоч, уйтгар зовлонд нэрвэгдэн суух нь тэсэхүйеэ бэрх хэмээн гуйваас Брунцвиг ноён, хатны сэтгэл засаж, чамайг ганцаарыг орхихгүй, эцэг чинь үлдэж, миний эзгүйд төрийн хэрэг шийтгэнэ гээд, хуруунаас бэлзэг авч өгүүлрүүн:

— Би чамд энэ бэлзэг тэмдэг болгон үлдээв. Чингээд чиний зүүж яваа бэлзгийг би авч явья. Тэр бэлзэг чинь чиний гарт буцаж ирээгүй цагт хүн миний тухай юу ч гэж хэлэлцсэн битгий итгээрэй. Тэгээд

хэрэв долоон жил өнгөртөл, энэ бэлзэг чинь эргэж эс ирвэл намайг нас барсан гэж мэдээрэй гэж захиад, өвгөн худыг залан ирүүлж, төрийн хэрэг тушаагаад, дайнд унадаг гучин хүлэг морь эмээллүүлж, дагах баатраа цуглуулаад, Ноймин хатан, өвгөн худ хоёртойгоо салах ёс хийж, баатар морьтон эрийн ёсоор алтан дэлхийгээр бядан явж, хав чадлаа үзэлцэн тулах сайн эр хайн морджээ.

Дагах морьтон баатар, зэвсэг барих хүнтэйгээ олон улсын газар нутгаар өнгөрөн гарч яв явсаар их далайн эрэг хүрч, онгоц олж аваад нөхөд цэрэг, хүлэг морьтойгоо сууж, өргөн их далайгаар үзэж сонсоогүй газар оронд хүрэх гэж зорин одлоо. Далайн аянд эхлэн мордоход найртай салхи онгоцны далбаа түрж, удтал явсаар гурван сар аян хийсний эцэс нэгэн шөнө салхи өөр болж, далайн догшин долгио давлагаа хөдөлгөжээ. Ноёны онгоц их салхинд дайвалзан оволзож сүртэй их давлагаа нэг их өргөж, өндөр уулын орой дээр гаргах мэт болгоод доош нь нэг хаяж, онгоцонд суусан хүн цөм тэсгэлгүй айжээ. Тэгтэл гэнэт, харанхуйд шаравтар гэрэл гарч, сайхан үнэр ханхалсанд нэн ч эмээж, уйлан хайлав.



Тэр гэрэл үнэр хоёр Хув уулын гэрэл үнэр мөн байна гэж танимагц амь гарах арга барагдсанаа мэдэж айсан нь — Орчин тойрон тавин бээрийн газраас тэр Хув уул, хүн амьтан, хүлэг онгоц мэтийг сорон татдаг тул, салах арга байдаггүй гэж хэлэлцдэг учир салхинд тэр аюулт уулнаа ойртсоныг үзээд, салхи өөр зүг салхилахыг тэнгэрт залбирвал тус болсонгүй. Хув уулын зүг салхилсаар тавин бээрийн газар ойртмогц онгоц, харвасан сум мэт хурдлан бүрхэг бараан тэнгэр, давлагаа их долгиог шар гэгээ туяа татуулсан тэр Хув уулын зүг довтлон эргийн өмнө гэнэт зогсоос Хув уул өндөрлөн үзэгджээ. Далайн долгио давлагаа ч гэнэт намдан зогсож, орхисонд Брунцвиг нөхөд сэлтээр бууж, онгоцонд байсан дайнд унадаг хүлэг морийг цөмийг эрэг дээр гаргаад үүр цайж, нар гарахад үзвэл тэр газар нэг арал байжээ. Хүн амьтангүй зэлүүд буйд газар бөгөөд амь зуух юм алга ажээ.

Тэр арлыг тойрон явж үзвээс, ээм халуун нарны гэрэлд хөсөр цайж хэвтэх хүний хувхай яс ялзарч бутарсан онгоцны яс мод өдий төдий байжээ. Брунцвиг нөхөд сэлт, түүнийг үзээд, зориг шантарч, тэр эвдэрхий хөлөг онгоц хүний хувхай яс даруй Хув ууланд татуулсан далайн аянчны үлдэгдэл мод яс гэж мэдээд, өөрсдийг ч мөн түүний нэгэн адил болно гэж гуньхарч, орчин тойрныг ширтэн үзвээс, ногоон долгио. тэнгэрийн хормой лугаа оволзон нийлэх нь их уснаас өөр юухан ч үл үзэгдэх ажээ.

Баахан амсхийж, их салхинд ядарч зүдэрсэн биеийн чилээ, гармагц, тэр арлаас холдон үзье гэж онгоцондоо суугаад, эргээс хөндийрч далбаагаа дэлгээд чадал мэдэн сэлэхэд нь онгоц, Хув уулаас холдон эхлэв. Одоо л тэр Хув уулын сордог чадлыг давлаа гэж бодоод тэсгэлгүй баярлан, хөлс гоожуулан чармайн сэлтэл гэнэт онгоц нь аргамжаастай байсан юм шиг зогтусаж, нэг мэдэх нь ээ Хув уулын эрэгт хүрсэн байжээ.

Үүнд Брунцвиг сэтгэл зовж, нөхөд нь зориг буурч, тэр гайтай арлаас салахын аргагүй боллоо гэж урам тасарчээ. Онгоцонд ачсан идээ ундаа байгаа цагт зовлонгүй байсан агаад, бас хоёр удаа арлаас зайлах гэж оролдоод үзсэн нь, анхны адил онгоц Хув ууланд эргэн татагдаад буцдаг байжээ.

Чингэсээр идэх хүнс барагдаад, хүлэг морио алж идэх цаг иржээ. Ид идсээр Брунцвигийн унадаг морийг хамгийн сүүлд алж идээд идэх

юмгүй болж өлбөрөн үхэх цаг ойртжээ. Арга барагдахдаа арал дээр идэх юм эрэвч, будаа байтугай юу ч олдсонгүй.

Горь тасрахад бүгдээрээ үхэх цагаа хүлээн онгоцны дэргэд суух нь сууж, хэвтэх нь хэвтэж, хэзээ амь хагацдаг бол гэж цөхрөн хүлээтэл, удалгүй уван цуван үхэж эхэллээ. Үх үхсээр Хув уулын ёроолд ганц Брунцвиг, Балад гэдэг өвгөн морьтон баатартай үлджээ. Тэр өвгөн морьтон нэгэн өдөр, Брунцвигийн хажууд сууж, далайн зүг харж байснаа залуу ноёндoo ийн өгүүлрүүн:

— Аяа сайн ноён минь? Чиний хатан, олон тайж эрс, чиний энэ зовлонг мэддэг ч болоосой гэхэд Брунцвиг тэр үг сонсоод тэргүүнийг даран гунив. Балад, тэр байдлыг үзээд,

— Эзэн ноён минь сэтгэл бүү гуньхар! Миний үг дагаваас эндээс гарах нэг арга бий. Гагцхүү гараад хаа хүрэхийг би мэдэхгүй гэхэд нь Брунцвиг.

— Би ч яах вэ. Та юу болох вэ? гэхэд

— Миний хойноос санаа бүү зов. Би насан зүг болоод, үхэхээс үл эмээнэ. Бодвол, миний ясаа тавих газар энэ бий. Харин чи амь гарч, нутаг усандаа нэр төртэй буцваас, чамд үнэн шударгаар миний хүчин өгснийг дурдан санаарай гэхэд нь Брунцвиг

— Та ямар арга хэлэн өгөх гэсэн бэ? хэмээвээс,

— Эзэн ноён минь, бидний анх ирсэн жил хан гарди энд ирснийг та үзсэн шүү дээ. Хойтон жил нь бас ирсэн дэг. Энэ жил ирэх ёстой. Би санавал, энэ аралд жилд нэгэн удаа ирдэг бололтой. Хэрэв чи хүсвэл, Хан гарди чамайг эндээс аваад явах арга бий гэхэд Брунцвиг гайхаж,

— Яаж намайг аваад явах вэ? гэхэд нь өвгөн морьтон, онгоцны дэргэд хэвтэж байсан морины шир заагаад юлдээ авч, тэр шир дээр хэвт гэжээ. Тэгээд Брунцвигийг ширлээд, Хув ууланд аваачиж тавьсан хойно удалгүй их салхи хөдөлж «Брунцвиг ширийн завсраар харвал хан гардийн дэвлэгд тэр их салхи хөдөлж, уулын ойр нисэж ирэхэд нь тэнгэр халхлагдан үүлэнд бүрхэгдэх адил болоод, хан гарди, далавчаа дэлгэн хальж байснаа гэнэт доош шурган Брунцвигийг өөд шүүрэх адил шүр хийтэл савардаад дээшээ нисэн дэгджээ.

Чингээд салхи намдаж, Хув уулын хормойн аралд урьд адил нам гүм, чимээ имээгүй болж, элсэн эрэг дээр сүүдрээ тусган, эвдэрхий сандархай хөлөг онгоц гунигтайяа харлаж, далайн аянчны хувхай яс наранд цайн хэвтэх бөгөөд, амьд амьтан гэхэд ганц шударга журамт өвгөн Балад морьтон, аль хэдийн баларсан эвдэрхий онгоцны

хэмхэрхий мод түшин өл алдаж турангилан, тэнхээ тасраад, залуу ноёны үл мэдэх газар аваад явсан Хан гардийн барааг балайран буй нүдээр гунигтайяа ширтэн суужээ.

II

Хан гарди, Брунцзигийг далай дээгүүр гурван хоног авч яваад, Хув уулнаас хэдэн зуун бээрийн газар алсалж, элчилгүй уулнаа хүрээд Брунцзигийг үүртээ өлөн ангаахайдаа хаямагц, бас идэш эрэн одлоо. Өлөн ангаахай нь адууны шириг шуугилдан ноцож, хага татмагц Брунцзиг юлдээ барин босож ирээд, бүгдийг нь цавчин алжээ. Тэгээд яаран тэр хан гардийн үүрээс холдож, уул өгсөн уруудан түйсээр нэг хавцал аманд хүрвээс архиран урхирах сүртэй дуун гарчээ. Брунцзиг ихэд гайхаж, хэрхнэм билээ? хэмээн нэгэн хэсэг азнаж, гэдрэгээ хан гардийн зүг буцахыг үл зүрхлэн, урагшилтал нэг өндөр хаданд тулаад, ёроолд нь арслан луу хоёр тулалдан ноцолдож байхыг үзэн гайхжээ. Үхэн тэмцэлдэх тэр хоёр аварга хүчтэний дуунд хад донсолж, мод доргиж байсан үүнд Брунцзиг:

— Алинд нь тусалдаг билээ? Арсланг эрж, арслангийн тэмдгийн хойноос явсаар өчнөөн бэрхийг туулснаа бодвол, арсланд нь туслах ёстой боллоо. За аз минь мэдтүгэй гэж санаа шийдээд юлдээ хуйнаас суга татан, гялалзсан ногоон хайрстай ясан толгойтой лууг дайран цавчиж, толгойг нь хяргаж эхэлсэнд арслан үхэн байлдсаар цус нөж болж, амьсгаа давхцан, машид ядарсан тул, луунаас холдож, бие амсхийн хэвтэв.

Брунцзиг ганцаараа луутай зориглон тулалдаж, юлдээр тас няс цавчивч тэр аюулт амьтан давшгүй их чадалтай тул, Брунцзигийн хүч буурч дайрахыг хэдийн байгаад, гагцхүү лууны давшихад хориглох төдий цавчиж байлаа. Тэгтэл сэгхийж амарсан арслан гэнэт ухасхийн лууны зүг цахилгаан мэт хурдан дайраад, бөгс цээжээр нь тас татаж алсанд луунд залгиулах аюулаас ангижравч, арслан одоо яадаг билээ! гэж Брунцзигийн эмээвээс огт дайрсангүй даруй хөлийн дэргэд хэвтжээ. Зайлья гэтэл босоод хойноос нь дагах тул, энэ яах гэсэн амьтан бэ? гэж хардаж, болдог асан бол, энэ арслангаас салах юм сан гэж бодож, царс мод, бүг модны үр түүгээд, өндөр царс дээр гарч бүдүүн гишүү дээр суугаад навч намааны нөмөрт биеэ халхлан, арслан хэзээ зайлах бол гэж хүлээн сууваас, ер зайлахгүй, мод өөд хараад суух

ажээ. Тэгсээр шөнө болж, Брунцвиг үүргэлэн нэг мэдэх нь ээ үүрийн сэрүүнд баахан жихүүцэж сэрээд дорогш харваас, арслан өнөөх л суусан хэвээрээ, эзнээ дагасан нохой адил сахих ажээ. Хойд өдөр бас л суусаар шөнө болоход мөн сахисан хэвээр байжээ. Нэгэнт гурав хоног эс буусанд, арслан гомдож, маш их дуугаар урхирсанд царс мод доргин донсолж Брунцвиг цочсондоо суусан найлзуураа алдаад, доошоо пид хийтэл ойчжээ. Хоол ундгүй өлсөж тамирдаад газар цохин ойчсондоо босож чадсангүй хэвтэж байтал, арслан нэгэн зээр барьж ирээд Брунцвигийн өлмийн өмнө тавьжээ.

Түүнийг үзээд Брунцвик арслангийн сайн санааг сая таньж дэмий айснаа мэдээд, дэргэд нь хэвтээд өвдөг дээр нь толгойгоо тавихад, арслангийн өтгөн зогдрыг илж, эзэнд хайртай нохой эрхлүүлэх адил илэн, арсланд түүнээс хойш их хайртай болжээ. Арслан ч Брунцвигийг нохой мэт дагаж, гурван жил элчилгүй газар уул модоор явахад нь ан гөрөөс барьж эзэндээ авчирдаг байжээ.



Нэгэн өдөр Брунцвиг тэнэж явсаар нэг өндөр уулын орой дээр гараад алсыг хартал өргөн далай үзэгдэж, арал дунд нэг шилтгээн харагджээ. Хүний орон сууц үзсэндээ тэсгэлгүй баярлаж, яаран тэр далайн зүг зорин Бэрх уул давсаар далайн зах хүрвээс элс чулуу ихтэй эрэг хөвөөнд ер хүн амьтан үл үзэгдэх тул, шилтгээнд очиж орох хүсэл бадарч зориг орсон Брунцвиг, юлдээ суга татан, мод гишүү цавчсаар том сал хийгээд, арсланг анд явах хойгуур салаа усанд тавьж, саад хийх болуужин гэж мэдэгдэлгүй явах гэтэл, арслан нэг гур зуугаад ирж, эзлээ салд суусныг үзэнгүүт, зууснаа хаяж, далайд урхиран үсэрч ороод, нэг ухасхийтэл салыг нь гүйцээд урд хоёр хөлөөрөө сал түшин Брунцвигийг дагасанд, баатар эр, арслангийн шударга сайн санааг өрөвдөн, сал өөд татан гаргаж, хоёулаа нэг үзүүрт нь тэнцүүлэн суугаад есөн хоног явж, далайн давлагаа заримдаа Брунцвигийн бүслэхээр заримдаа хоолойгоор нь татан, тэнгэр улам бүрхэг бол болсоор улам харанхуй болж, чухам хаашаа ч явж байгааг мэдэхийн аргагүй болжээ. Брунцвигийн зориг шантарсхийвч, ажиж үзвээс их далайгаас холдож, харанхуйд хоёр хажуугаас уул завсарлан харагдах ажээ.

Чингэсээр, Нал эрдэнийн ууланд ойртож, тэнгэр гэрэл гэгээтэй боллоо. Нал эрдэнийн уулнаас бадмарааг улаан гэрэл туяарч урьд харанхуйд явснаас улам ч улаан гэрлийн өнгө хурц мэт үзэгдэж билээ. Тэгж явтал наран гэрэл гийсэн өндөр шилтгээн үзэгдсэн нь Брунцвигийн тэр өндөр уулнаас урьд барааг нь харсан шилтгээн байжээ. Салаас бууж, арсланг дагуулан тэр шилтгээнд орвоос эзэн нь Олибриус ван гэдэг сонин жигтэй нэгэн ван байжээ. Түүний хоёр нүд нь урдаа, хоёр нүд нь ардаа тийм сонин ван бөгөөд шадар сайд түшмэд нь бүр ч жигтэй. Зарим нь ганц хөлтэй, магнай дундаа ганц нүдтэн лалар, зарим нь эвэртэй зарим нэг нь хоёр толгойтой, зарим нэг нь нохой толгойтой зарим нь үнэг шиг улаан зарим нь бор алаг зарим нь үлэмж биетэн зарим нь тарваган хүн байжээ.

Тэр олон муухай амьтныг үзээд, Брунцвигийн дотор, аягүй болж, бушуухан салахыг бодовч, Олибриус ван явуулж өгсөнгүй. Яагаад чи энд хүрч ирэв? Сайн дураар ирэв үү? Баагаар ирэв үү? гэж шалгааж асуусанд,

— Нутгаасаа гарахдаа сайн дураар гараад энэхүү газар аргагүйн баагаар ирлээ. Намайг нутаг усанд минь буцааж өгнө үү? гэж хариулахад,

— Энэ шилтгээнээс гаръя гэвэл, гагцхүү төмөр андамин хаалгаар л гарч болно. Би охиноо Басилиск луунд алдсан хүн. Чи миний тэр хүүхнийг олж өгвөл, чамайг хаалгаа нээж явуулна гэхэд Брунцвикийн бодож үзэхэд нэг болбол тэр олон муухай мангас дунд суух болдог, нэг бол, мангасан хаан Олибриус вангийн охиныг луунаас салгаж, нутгийн зүг хандах арга сүвэгчлэх энэ хоёроос өөр аргагүй тул, бодон бодож, тэр Басилиск гэдэг луутай тулж үзсэн нь дээр бололтой. Тэгээд азаа үзье гэхэд нь Олибриус ван, онгоц бэлдүүлж, Брунцвикийг арслантай нь догшин лууныхаа Басилискийн шилтгээнт арлын зүг явуулжээ.

III

Арал хүртэл зам саадгүй боловч, шилтгээнд ороод бэрх хэрэмд нь гурван давхар хаалгатай, хаалга тутамд их мангас сахиултай тул Брунцвиг тэдэнтэй байлдаж дотогшлох тусам улам хэцүү бэрх догшин сахиултай байжээ.

Арслан эс дагаваас Брунцвиг хэрхэвч тэр шилтгээнд орж үл чадах ажээ. Байлдаад хүч мөхөстөхөд нь арслан гүйж ирээд, тосон байлдаж, эзнээ түр сэгхийж, зориг ортол тул тулсаар хоёулаа шилтгээн дотор орвоос, маш гоё их танхимд Олибриус вангийн үзэсгэлэн гоо охин бүсэндээ хүртэл могойгоор ороолгоотой байхыг үзжээ.

Тэр сайхан авхай бас Брунцвикийг үзээд, эр чадлаараа тулан орж ирснийг мэдсэнгүй, догшин сахиулын унтах чөлөөгөөр сэм орж ирсэн хүн болов уу гэж бодоод, бушуухан буц гэж гуйжээ. Тэгээд байлдан орж ирснийг олж мэдээд бүр ч ихэд гуйж, хаалганы мангас манааг дийлэвч лусын хааны их цэргийг хаанаа дагаж ирэхэд яасан ч хүн дийлэхийн аргагүй. Василицкийн ирдэг цаг боллоо. Бушуухан гарч амь бүтэн зайл гэж гуйваас Брунцвиг үг дагасангүй. Баслиск вангийн бараа бологсдын түрүүч нь их танхимд орж ирэхэд ч айсангүй, хараад байтал нь, гялалзсан аварга могой үлэмж гүрвэл, могойн сүүлт охидын зэрэг сонин хачин амьтан ганц нэгээрээ, хоёр хоёроороо орооцолдон, шуугилдан орж ирээд, төдхөн танхим дүүрсэнд Брунцвиг тэднийг дайран байлдав. Олибриус вангийн гүнж Брунцвигт бас хорин эрийн чадал оруулдаг нэг бэлзэг өгсөнд бүр ч зориг хүчин нэмэгдэн, бас тэр хөөрхий гүнжийг лусын эрхшээлээс салгах гэж бодохдоо улам ч хүч орж байлдваас арслан бас эзэндээ туслалцан, сүүлээр лут могойг тас ширвэж, хөлөөрөө тас гишгэж шүдээрээ зууж тастан удалгүй арслан

Брунцвиг хоёр лус Басилискийн бараа болсон олон могой гүрвэл зэргийн муухай амьтныг цөмийг үгүй хийж дайснаа даржээ.

Гэнэт тэнгэр дуугарах мэт чимээ гарч, танхим доргиод гялалзсан ган хайрст арван найман сүүлт Басилиск ван, амнаасаа галаар бөөлжин, Брунцвиг арслан хоёрын зүг дайран орлоо. Залуу морьтон эр урьд үзээгүй бэрх дайсантай тулж, дайрахад нь биеэ хамгаалж ухрахад нь давшиж цавчсаар өөрийн бие бас олон шарх олж цус савиран урсаж хэдэн удаа хөл суларч торж унатал арслан дайран орж эзнээ хамгаалахаар Брунцвигт амьсгал авах зав гаргадаг байжээ. Тэгээд, арсланг ядрахад Брунцвиг байлдаж, арслангаа амраасаар үдэш болтол тулалдаад, үдшийн шөнөөс үүрийн шөнө хүртэл, үүрийн шөнөөс их үд хүртэл тулалдтал Басилискийн амьсгал бүтэж, пид хийж ойчоод сур мэт сунаж, сухай мэт улайн үхжээ. Арслан машид баярлаж, сүртэйеэ урхиравч олон шарх олсон Брунцвиг хэдийн ойчоод, арслангийн урхирах дууг ч дуулсангүй, ухаан мэдээгүй хэвтжээ.

Олибриус вангийн гүнж, шархтай морьтныг сайхан сувилж, шархыг нь угааж боогоод аргалан эмнэсээр ес хоног дээрээ босгожээ. Тэгээд Брунцвиг тэр гүнжийг лусын хатны эрхшээлээс салгаж, онгоцондоо суулгаад, арслангийн хамт Олибриусын шилтгээнийг зүглэн одохдоо, төмөр хаалга одоо нээгдэж, нутгийн зах үзэх цаг ойртлоо хэмээн дотор баяртай хүрч очвоос Олибриус ван баярлан угтавч, Брунцвигийг буцаана гэж нэг ч үг дурдсангүй. Тэр ч байтугай, буцна гэдэг үг огт сонсохгүй. Африк гэдэг нэртэй гүнж, лусын хаанаас аварч аван шилтгээнд хүргэж ирсэн баатар эрд хайртай болж нөхөр хийх гэж байна гэдэг санааг Олибриус ван Брунцвигт нэвтрүүлэх болжээ.

Брунцвиг тэр үг сонсоод, ван гүнж хоёрыг ёсон бус гэж хилэгнэвч, аргалах арга үл олдох тул, гүнжээр хатан хийгээд сэтгэл санаа нь гагц алс холын нутаг ус, хайрт амраг гэргий Нойминд байжээ. Чингээд хоног өнгөрөх тусам нутаг гэргий хоёроо санаж уйдах нь улам их болж, далайн захад очоод алсаас онгоцны далбаа үзэгдэх болов уу? Тэр онгоцонд суугаад эндээс хагацах аз байдаг болов уу гэж горьдон хүлээж хэчнээн суувч, хязгааргүй өргөн далайн уудамд далбааны бараа үл үзэгдэн наран гэрэл туссан долгио нэг ч онгоц хагалан зурайлгах нь үзэгдэлгүй, гагцхүү усны долгио шуугинан залуу морьтны гашуудан сүүрс алдах чимээг дарах ажээ.

Ганцаараа шилтгээнд явж байхдаа Брунцвиг сэтгэл гонсорч ван гүнж хоёрыг тэдний бараа бологч хортон муухай мангасыг дотроо дэмий л зүхнэм бөгөөд нэгэн өдөр шилтгээнээ дэмий хэсэж яваад урьд ер ороогүй нэгэн зооринд орж үзвээс нэг чулуун ширээ дээр бариул үгүй нэгэн хуучин юлд байх ажгуу.

Хуйгаас нь тоомсоргүйхэн суга татаад үзвээс, маш хатан болд бөгөөд хурц нь гайхалтай. Түүнийг үзээд, ийм сайхан юлд байх ажээ гэж ихэд дурлаж өөрийн юлдийн бариул салгаж, тэр сонин юлдэд тааруулж хийгээд хуйлан зүүж, бариул үгүй болсон өөрийн юлдийг нөгөө юлдийн хуучин хуйд хийгээд өнөөх чулуун ширээ дээр тавиад гарчээ.

Чингээд Африк гүнжтэй дайралдаад, тэр юлд сольж авснаа хэлэлгүй зооринд хэвтдэг тэр ямар юлд вэ гэж асуувал, гүнж ихэд сандарч, үг дуугүй есөн цоожоор тэр зоорийг цоожилсонд Брунцвиг нэн гайхаж ямар юлдийг тэгж нандигнадаг юм бэ? гэж салалгүй шалгаан асуух болсонд чи тэр юлдийн чадлыг мэдвэл гайхах асан аа! гээд гүнж ер юм хэлж өгсөнгүй.

Чингээд чи нэгэнт цоожилж аваад түлхүүрийг хадгалж байгаа тул айлтгүй тэр юлдийн учир одоо надад хэлж өгвөл ямар гэм алдал болох вэ? гэж гуйж гувшсаар үг алдуулахад гүнж,

— За мэдэх гэвэл сонсож бай! Тэр юлдийн чадлыг чамд хэлбэл, хуйнаас суга татаад нэг хотын гучин буман толгой тас цавч гэвэл, тэр ёсоор тоотой толгой тас үсэрдэг ийм хувилгаан чадалтай юлд юм шүү гэхэд нь Брунцвиг инээгээд үл итгэх дүрэм үзүүлэвч гүнжийн хэлсэн үг цээжинд хатангадаж, яаж юлдээ шалгаад үздэг билээ гэж бодох боллоо. Тэгж байтал, нэгэн өдөр нохой толгойтой, хоёр толгойтой шар хар бөгтөр хэдэн мангас өрөөнд ороод ирэхэд юлдээ суга татан,

— За энэ хэдэн мангасын толгойг хярга! гэхэд нь тэр орж ирсэн мангасын толгой түг түг хийтэл газар ойчсонд түүж аваад чимээгүй далайд хаяж билээ.

Тэгээд нэгэн өдөр Олибриус ван, гүнж олон бараа бологч мангасын хамт их танхимд хоол идэж суутал Брунцвиг юлдээ гэнэт суга татаад,

— Сайхан юлд минь, энэ мангас ван гүнж цөмийн толгойг хярга гэхэд цөм толгойгүй боллоо.

Шударгагүй ван гүнжийг тэгж гэсгээгээд толгойгүй олон хүүрийг тэнд нь орхиж, алсын замд зорин, төмөр хаалгыг нь нээж, идэх уух юм

базааж аваад, алт эрдэнийн зүйл авч, онгоцонд ачаад хайртай арслантайгаа хоёулаа маш баяртай аялан мордож, нутгийн зүг зорив.

IV

Найртай салхи нутгийн зүг онгоц залж, төвшин далайгаар саадгүй явсаар зам зуур нэг ч онгоц нэг ч арал дайралдсангүй явтал, долоо хоноход сая газар үзэгдэж зүлэг сайхан ногоотой хөх тэнгэрийн зүг сүндэрлэсэн саглагар сайхан модтой их л үзэмжтэй бөгөөд модны завсар гоё байшин үзэгджээ.

Салхи татахад хөгжмийн яруу эгшиг дуулдаж, бүрээ татах, хэнгэрэг дэлдэх чимээ сонстлоо. Эр эм хүний эгшиг нийлсэн сайхан хоолой, тунгалаг агаарт дуурьсаж, Брунцвиг түүнийг сонсоод хүний царай үзэх асан гэж арлын зүг зорьж эрэгт хүрээд бууваас их найр болж байхыг үзлээ. Морьтой хүн давхилдан, танан өнгийн торгон хилэн хувцастай эрэгтэйчүүд чилгэр сайхан нуруутай сайхан нүдтэй урт гээгтэй эмс охид цөм найр наадам хийж цэнгэх ажээ. Зарим эрс ирүүлд гарч морьтон эрсийн наадам хийж, зарим нэг нь бүжиглэн наадаж зарим нэг нь дуу дуулан тоглоом тоглох ажээ.

Брунцвигийг онгоцноос бууж, тэр олныг сонирхон үзэхэд, эр эм олон залуу наадамчин урдаас гүйн очиж,

— Чи хаанаас яаж ирэв? Бидэнтэй наадам хий!

— Энд бидэнтэй бай!

— Чамайг явуулахгүй!

— Энд насаараа л бай гэцгээж сайхан эмс охид гараа сарвайн тэврэх гэж, эрчүүд тойрч бүслээд, явуулахгүй гэсэнд Брунцвиг тэр цэнгэл наадам, найр хуримд аюул байна гэж ухаад, юлдээ суга татан,

— За миний ойр шахалдсан хүний толгой тас буу! гээд орхитол, толгой тус тус унавч, цаагуур байсан нэг нь,

— Чи тэгээд мултарч чадахгүй! Бидэнтэй морь унаж давхиж бүжиг хийхээс чи зайлахгүй. Бид асMODE гэдэг хүмүүн чөтгөрүүд билээ! Бидний чадал маш их! гэхэд нь Брунцвиг юлдээ суга татаад,

— Тэгвэл, энэ бүх чөтгөрийн толгой тасар! гэж хашхирмагц бүх асMODEн толгой тасран үгүй боллоо. Брунцвиг аюулаас мэнд гарч яаран онгоцондоо суугаад бушуухан холдов.

Олон долоо хоног онгоц нь тэнгисийн долгион дундуур явж нэгэн: орон гал дөл гялалзсан сайхан хот үзээд, түүнийг чиглэн, захад нь

хүрээд онгоцноос арслантайгаа бууж, хотын зүг одвоос огт хүн амьтан үзэгдэхгүй. Хотын хаалга нээлттэй гоё сайхан хэрэглэлтэй байшингийн хаалга бас цэлийтэл нээлттэй, байшин бүхэнд сайхан ширээ засаатай зүйл бүр идээ унд тавиастай авч, хүн үгүй тул, байшин дамжсаар явтал нь бүрээ татах, хэнгэрэг дэлдэх чимээ гарч, айсуй болсоор хотын хаалгаар их цэрэг орж ирэв. Тэр бол астриолын цэрэг, Астриолус ван хар морь унаж хошуучлан удирджээ.

Тэр вантай дайралдвал түмэн түвэг татах бий гэж бодоод, хотоос зайлах гэтэл, астриолууд хэрээд, зам хааж, юун хүн хаанаас ирэв гэж асуусанд

— Хаанаас миний ирсэн танд хамаагүй. Би та нараас айхгүй гэхэд нь барьж вандаа хүргэжээ. Астриолус ван түүнийг үзээд,

— Манай энд үлдэнэ гэж шахаан өг. Эсвэл чамайг галт моринд мордуулан залхаана гэсэнд

Чиний сүрдүүлэхээс би үл айна. Тэнгэр намайг тэтгэж, тэр байтугай аюулаас би мултарсаар ирсэн хүн. Танай эндээс ч бас л сугарч гарна гэхэд нь ван, галт морь ирүүлж, дөрвөн астриол, Брунцвигийг шүүрээд, моринд мордуулан хуйхлах гэтэл юлдээ сугалаад

— Энэ дөрвийн толгой пад хий! гэхэд нь агшин зуур толгой нь пад пад өнхрөн ойчоод, арслан тэр дөрвийн биеийг тас татан сэглэжээ. Астриолус ван ихэд хилэгнэж, бүх цэргээ дуудан дайруулсанд бүрээ татаж, үй түмэн цэрэг нижигнэн дайрваас, Брунцвиг айван тайван огт айх эмээх байдал үл үзүүлэн, шидэт юлдээ сугалаад

— За хорин хүний толгой пад гучин хүний толгой пад, зуун хүний толгой пад мянган хүний толгой пад хий! гэхэд нь олон толгой пад пад ойчиж, толгойгүй бие нь газар доргитол унацгаасанд олон астриол тэсгэлгүй айж, ван бас эмээн гуйж,

— Брунцвиг өршөөж хайрла! Юлдээ хуйлж айлд! Нутаг усанд чинь аятай сайхнаар хүргэж өгөхийг ам алдъя! Алахаа зогс, Алахаа зогс, гэж чичрэн дагжин гуйхад нь Брунцвиг чех нутаг хүртэл намайг арслангийн хамт эд агуурсны хамт бүрэн бүтнээр хүргэж өгнө гэж шахаа тангаргаа өг гэж тангараглуулж байгаад сая юлдээ хуйлжээ.

— Чингээд Астриолус ван, ам тангараг өгсөн ёсоор Брунцвигийг Бархасбадь гарагийн өглөө эрт нутгийн захад хүргээд тэндээс цаашаа огт саад тотгоргүй явсаар Брунцвиг морьтон баатар эр Чех нутагтаа хүрчээ.

V

Прага хотноо дөхөөд ууланд суудаг аглагч хүний хувцас өмсөж, зүсээ буруулаад арслангаа дагуулан шилтгээндээ хүрвээс Ноймин хатныг нь ондоо хүнд өгнө гэж найр хурим хийж, их хөлтэй байж. Брунцвик бядан хэснэ гэж Прагаас гарсаар долоон жил чив чимээгүй болоод, Ноймин хатан, нөхрийн бэлзгийн бараа хараагүй тул, эцгийн үгэнд орж, нэгэн баян ноёны хатан болох зөвшөөл өгсөн байжээ.

Аглагч хүний дүрээр шилтгээндээ хүрээд тэр учрыг сонсож сэтгэл ихэд чилээд Брунцвиг нэг ч хүнд үг хэлэлгүй, биеэ нууж, сөнгийн дэргэд хүрээд, Ноймин хатны хундаганд хуруунаасаа салгалгүй зүүж явсан бэлзгээ хийгээд шилтгээнээс гарч, хаалга дээр нь «явсаар долоон жил болсон хүн буцаж ирлээ!» гэж бичээд оджээ.

Улс амьтан сандран шуугилдаж үймэлдээд, Ноймин хатан хундагаа шавхтал ёроолд нь бэлзэг байхыг таньж, Брунцвигийн бэлзэг үзэгдлээ. Эзэн нь буцаж ирлээ гэж сэтгэл хөдлөн зарлаваас хатантай суух гэсэн ноён сандарч, ухасхийн гараад, морь эмээллүүлж, Брунцвигийн хойноос очоод ална гэж гучин эр дагуулан давхиж барьж автал Брунцвиг юлдээ суга татаад,

— Миний хатантай суух гэсэн хүнийг дагасан дагалтын хамт толгойг нь ав! гэж хашхирмагц толгой нь пид пад ойцгоож, толгойгүй хүүр нь мориноос унацгаагаад эзэн хүн үгүй болсон морь нь эргээд давхицгаажээ.

Брунцвиг тэндээс нэг шилтгээндээ очиж, ноёд тайж нарыг зарлан ирүүлээд баярласан тэдний хамт Прага орвоос, Ноймин хатан эцэг бараа бологсдын хамт угтан гарч, бүгд их баяр хөөр болж, Ноймин хатан жаргалын нулимс унаган бүгдээс илүү баярласан гэдэг.

Тэгээд Прагад ороход нь хотын хүн, хөгшин залуугүй ихэд баярлаж, маш их ёслолоор угтан тосож, залуу ноёноо арслан дагуулан, мэнд буцаж ирсэнд тэсгэлгүй баярлажээ. Чингээд Брунцвигийн нийтэд зарлаж, үүнээс хойш хотын хаалга, чех улсын далбаанд улаан ваадан дээр цагаан арслан зурж хэрэглэ гэж зарлиг буулгасанд улс даяараа баяр хөөр болсон гэдэг.

Тэгээд Брунцвиг ноён Ноймин хатантайгаа төвшин сайхан жаргаж байсан дөчин жил энх жолоо барьсан гэдэг. Арслан нь эзнээсээ салалгүй дагаж, Брунцвигийг өндөр сүүдэр зооглож, ганц хүү

Вацлавыг хаан ширээ залгуулан тэнгэр болсонд арслан нь эзнээ санан уйдсаар хойноос нь дагах гэж эцэж турсаар сүүлчийн удаа маш гашуудалтайгаар нэгэнт хүрхрээд Брунцвигийг оршуулсан газар нь үхсэн гэдэг.

Брунцвигийн шидэт юлд яасан бэ? гэвэл Карл вангийн чулуун гүүрэнд хөлдөө арслан хэвтүүлсэн Брунцвигийн хөшөө хөрөг байгаа газар гүүрний чулуу ухаж хийсэн гэдэг. Брунцвиг насан эцэс болох үес юлдээ өөрөө тэнд сэм оршуулаад тэр шидтэй юлд олон зуун жил болсон гэдэг. Чингээд чех улсад гамшиг их зовлон тохиолдох цагт тэр юлд гарч ирэх юм гэж хууччуул хэлэлцэн, манай эх орон, гашуун дарлал үзэж тэсгэлгүй зовохын цаг хан Блоник уулнаас богд Вацлав ноёны морьтон баатар чех түмнээ тэнхрүүлэх гэж, Чех нутгийн сахиус болсон тэр богд вангаар удирдуулан гарч ирэх юм гэдэг.

Тэгээд Карл вангийн гүүрээр өнгөрөн гарахад нь цагаан морь нь Брунцвигийн юлдийг чулуу дотроос туурайгаараа суга үсэртэл бүдэрч, богд Вацлав ноён, тэр юлд шүүрч аваад, догшин байлдаанаа далайн орж,

— Чех нутгийн хамаг дайсны толгойг пад хий! гэхэд нь муу дайсан цөм дарагдан сөнөж, манай эх нутаг амар сайхандаа жаргах юм гэдэг.



ОПАТОВИЦЫН ЭР ДЭНЭСИЙН С АН

I

Опатовице гэдэг Ширээтийн хийдийн богд Бенедиктийн ёс хийгээд номын нэг залуу хувраг, яг үдийн өмнө ширээт ламдаа нэгэн зочин санамсаргүй ирлээ, байдал сурвалжит гэрийн хүн бололтой. Хоёр морьтой хиатай, урд хүрээнд хаалганы тэнд буугаад, тэр ноён хүн, дуганд шууд орлоо гэж айлтгажээ.

Ихэмсэг байдалтай ширээт нь, хаанаас ирсэн бэ хэмээн асууваас,

— Шилтгээнцрээс иржээ гэж хувраг хариулжээ.

— Юу гэж явна? гэхэд нь

— Юм хэлсэнгүй. Дагасан хүн нь бас юм хэлэхгүй байна гэлээ.

— Ямар шуу хүн байна гэж асуувал,

— Дунд зэргийн нуруутай бөгөөд настай, хар сахалтай хүн л билээ. Ихэмсэг жавхлантай, бас хувцас сайтай, гэвч бараан өнгийн хувцас нь гоёл чимэггүй, хээ судалгүй юм билээ гэхэд нь ширээт нэг хэсэг бодлого болсноо босож, урт хонгилоор хурлын газар очиж, шатаар доош нам тайван «энхжиний хүрээ» тойрсон дугуй саравчаар одлоо. Тэр «энхжиний хүрээ» гэдэг тойрон байшингаар хүрээлсэн газар үдийн нарны гэрэл тусч ихэд саруул гэрэлтэй байжээ. Тэр гэрэл нь хүрээг дотуур нь тойрон саравчны дор ч нэвтрэн тусч, роман гэдэг

ромын маягийн уран барилгын хэлбэртэй баганын сүүдрийг шал, туурганд тусгаж, наймдугаар сарын өдрийн бүгчим нь, өглөөнөөс үд хүртэл саравчийн сэрүүн сүүдэртэй газар тул, төдий л мэдэгдэхгүй байжээ.

Хуучин байшингуудын хооронд хүнгүй, чимээгүй, гэлэнгүүд тэр үес цөм өөрийн өрөөнд сууцгааж байсан цаг. Ширээт лам гэрэлтэй сүүдэртэй газраар дамжиж, сэрүүн газраас өргөн уудам хүрээнд ороход бүгчим үүлгүй цэлмэг хөх тэнгэрийн зүгт роман барилгын их сүм, түүний хоёр цамхаг тун тодхон зурайж харагдах ажээ.

Ширээт сүмийн сийлмэл цэцэг навч сонин амьтны дүрстэй чулуун их хаалганы зүг одвоос үүднээс сүмийн доторх сэрүүн салхи сэнгэнэж тэр харь зочин, өөдөөс нь малгайгаа авсан хэвээр гарч ирэн, байдал царай хүрэн, үс хар, магнай халзан, нүүр өргөн, баахан бөхийсхийн явжээ. Ширээт лам, түүний торомгор хар нүдийг харж, өгүүлэх үгийг сонсмогц энгийн тайж хүн биш байна гэж танив. Ширээтийг тосон очиж, мэнд асуусанд найрсаг сайхнаар тал өгч, үдийн хоол зоогломуу гэсэнд дуртайяа хүлээжээ. Чингээд хоёулаа сүмийн үүднээс өнөөх тойрон явдаг саравчит дундуур «энхжиний хүрээ» тойрон хийдийн хоолны газар очих үес үдийн чимээгүй нам тайванд хийдийн хонхны дуу хангинаж, үдийн амрах цаг болсныг орчин тойрон гадаа айл, хүн амьтанд мэдэгдэв.

Нуман унь дээвэртэй урт танхимд голоороо бүдэг туяатай цагаан тугалган аяга таваг өрсөн царсан урт ширээ, олон сандал суудал өрөөтэй түүнээ хөгшин залуу гэлэнгүүд ширээт зочин хоёрыг хэдийн хүлээж байв. Чингээд хоолны өмнө уншлага уншаад бүгдээрээ суудлаа эзэлцгээхэд ширээт зочин хоёр, сийлбэртэй түшлэгт сандалд сууцгаажээ.

Тэр зочин, сайхан яриатай хүн бөгөөд, хийд их сүмийн барилга юутай сайхан бэ, байдлыг үзвэл, итали хийцтэй мэт ялангуяа сүмийн үүдэн тал нь гэж хэлэхэд, ширээт лам, гадаадын биш, дотоодын ур юм, дуганы ууган бага дуганыг өргөтгөж босгосон юм. Гэвч анхны гэлэнгүүд нь Монте Кассиний итали нар байсан гэдэг нь тэр зочин уутал дуганыг сайн мэддэг байж, түүний уг гарлыг итали, нарыг, Ром-хотыг ярьж эхэлсэнд ойр хавьд суусан шавь нар тэр зочны үгэнд тун сонирхож, идэхийг мартчихжээ.

Чингээд, зочин ярих тусам, ширээтийн сэтгэл тайвангүй болж ирэв. Учир нь гэвэл Шилтгээнцэрт өчигдөр хан олон бараа бологч

морьтон лугаа хүрч ирсэн мэдээ олж аваад, Шилтгээнцрээс нэг ноён ирлээ гэж сонсонгуут тэр хааны дэргэдийн хүний нэг нь билүү гэж бодсоноо, жаал хуврагийг ирсэн зочин шууд сүмд орлоо гэж хэлэхэд, Карл хаан ямар нэгэн газар хүрч ирвэл, юуны өмнө сүм дуганд очиж ордог гэж хэлэлцдэгийг санаж байсан юм санж.

Тэр зочны найрсаг сайхан үг, юм их үзсэн байдал, зан аашийг нь үзвэл, хүн болгон гайхан биширмээр. Чингээд хоол идэж цадаад хутгаа тавьж, гараа гялалзсан зэс гадурад угааж гүйцмэгц ширээт лам, зочныг цонхны тэнд уриад, та уучлаарай, нэр усаа бидэнд хэлж өгмүү гэж гуйжээ.

Зочин тэгье гээд, шавь нар дотроосоо хамгийн ахмад хоёр гэлэнг авч, урьдаар дуганд оръё гэлээ. Ширээт дуртайяа зөвшөөрч, зочны хамт хонгилоор явж, их дуганд орвоос, нуман уньтай, маш өндөр бөгөөд гурван хөлөгт, хөлөг тус бүр бөөрөнхий баганаар салгасан бөгөөд, тэр багана нь тал дугуй лут гулдан өргөн тулсан байдалтай ажээ. Нууц төгөлдөр харанхуйд туурганы зураг сайн харагдахгүй бөгөөд тэр их сүмийн уудамд тоолшгүй олон цонхтой ажээ.

Сүмд орогсод, тахил шүтээний өмнө очиж сөгдсөнд харь ноён босоод

— Ширээт лам, миний нэр мэдэхийг хүслээ. Чамд, энэ шавь нарт чинь нэрээ хэлж өгье. Би Карл гэдэг ромын хаан чехийн ван, та бүгдийн ноён доо гэхэд нь ширээт лам хүндэтгэн хүлээж авч эс чадсан алдал гаргаснаа хүлцэл өчөөд, манай сүм хийдийг гийгүүлэн морилж ирсэнд ихэд баярлан, хааныг ер морилон ирсэнд бараг итгэмгүй санагдана гэхэд хаан инээмсэглээд энгийн байдлаар ирвэл дээр гэж бодсоноо хэлж, хүнд мэдэгдэлгүй орж ирэх гэсэн юм. Тэр учраас тайж нараа Шилтгээнцэрт үлдээгээд, хаа очихыг ч хэлэлгүй хүрч ирснээ хэллээ.

— Та нартай тавтайхан ярих гэж зориуд энгийн байдлаар хүрч ирсэн билээ. Ширээт гуай, энэ шавь нар чинь, чиний хийдийн хамгийн итгэлтэй ахмад шавь нар мөн үү гэж асуухад нь

— Тийм ээ гэлээ.

Тэхэд нь хаан хэлж:

— Эрхэм гэлэнгүүдээ, би энэ сүмийн газар та нарт зорьж ирсэн хэргээ хэлье. Битанай энэ хийдийн газар нуусан эрдэнийн их сан бий гэж дуулсан, Тэр ортой болов уу гэж боддог: Та нар битгий нуу, Би түүнээс өөрийн биеэр ч авахгүй, хүнээр ч авхуулахгүй. Гагцхүү нэг

үзэх л юм сан гэж хүссэн юм гэхэд нь ширээт лам тэр гэлэнтэйгээ чив чимээгүй болж, нэг хэсэг болоод бид нэг үг зөвлөх санаатай. Та зөвшөөрнө үү гэхэд тэг тэг гэжээ. Тэгээд, гэлэнгүүд хоорондоо зөвлөлдсөн хойно лам хаанд айлтгаж:

— Эрхэм хаантан, тэр эрдэнийн сан манайд байна. Гэвч хийдийн тавин таван шавь тоотноос түүнийг мэдэх хүн нэг ч үгүй. Ганц миний бие, энэ хоёр шавийн хамт түүнийг мэднэ. Өөр хэн ч мэдэхгүй. Бидний элэгдэхэд дараачийн ширээт лам, бас хоёр ахмад гэлэн хүнд түүнийг хэлж, хэзээд гурван хүн мэдэж байх журам бий. Гагцхүү түүнийг үг дохиогоор ч бусдад мэдэгдэж болохгүй гэсэн андгайтай билээ. Тэр учраас хаан танд ч тэр санд орж үзэхэд маш дөхөмгүй, зохисгүй байна гэхэд хаан би заавал үзэх гэсэн билээ. Үзээд бас хүнд хэлж задруулахгүй гэхэд нь, лам нар дахин хэлэлцээд ширээт лам, хэлэх нь зохисгүй байна. Бас вангийн зарлиг үл дагах нь ч зохисгүй. Тэр учраас нэг бол, хаан танд газрыг хэлж өгөөд, санг чухам хаа байгааг заахгүй. Эсвэл, санг тэнд бий гээд, үзүүлэхгүй энэ хоёрын нэгээр болбол яана гэхэд хаан

— Би тэр санг үзэх л юм сан гэлээ.

Тэгэхэд манай хүсэх зүйлийг дагаж гүйцэтгэнэ үү? гэж гуйхад нь болно гэж хаан хүлээж, лам нар түүнийг дуганаас тахилын хэрэгсэл номын хувцас байдаг газар дагуулж, тэндээс нэгэн маш харанхуй бөгөөд тоосгоор өнгөлсөн зоорь мэт газар аваачиж, нэг гэлэн хэт хавирч хоёр лам дэн барив. Дэнгийн гэрэл харанхуйд сүүмэлзтэл, нөгөө гэлэн нь хааны дэргэд хүрч ирээд, толгойд нь малгай буруу харуулан өмсгөж, нүдийг нь халхлуулсан тул, юм эс хүрэвч, чимээг сонсвоос, тоосго хөдөлгөж зайлуулж байгаа юм шиг санагдана.

Чингээд нэг нүхэнд аваачаад, болгоомжтой яваарай гишгүүрээр уруудна шүү гээд, тэр ёсоор харанхуй дотор доошоо их л явж, ёроолд хүрмэгц, хааныг эргүүлж, замын хол ойрын баримжаа зүг чигийг алдуулах гэж, цааш нь хөтөлж, тэгээд ямар нэгэн харанхуй урт хонгилоор дагуулж явбаас их л чийгтэй хөгцөрсөн ялзарсан юмны үнэр ханхалж, гишгэх хөлийн чимээ дүнгэнэн гарч байв гэнэ. Хаан тэр хонгилыг зах хязгааргүй урт даа гэж бодож явлаа. Тэгтэл малгайг нь аваад орхисонд харваас, нэг бүгчим зооринд, сүүмэлзэх лав дэнгийн гэрэл туссан газар зогсох ажам. Тэр дэнгийн гэрэл нь төмөр авдар саванд тусч, ширээт лам нээлгийг нээтэл, цагаан мөнгө, эмбүү мөнгө цагариглан цутгасан бөөрөнхийлэн цутгасан мөнгө дүүрэн байв. Цааш

нь хааныг бас нэг зооринд дагуулж оруулбал, цул шижир алт цагариглан цутгасан, гулуузлан цутгасан, юм хийгээгүй цул алт байжээ. Хаан гайхаж яваад, бас нэг зооринд бүр ч их гайхаж, үг дуугаа хураалаа. Тэр зооринд хамаг шарийн эрдэнэ нь байж, эрдэнийн төмөрлөг маш их, алт мөнгө урчуудын чадамгай гараар боловсруулж, гайхалтай сайхан хийсэн сондор оосор, аяга хундага, загалмай, гуутай загалмай цөм шижир алт гялалзсан, нүд гялбам эрдэнийн чулуун шигтгээний гэрэл туяатай хааныг тэр их сайхан юм, тоо томшгүй баялгийн зүйлийг харж үзсэнд ширээт лам өгүүлрүүн:

— Эзэн минь энэ эрдэнийн санг бид чамд чиний ач үрд гэж хадгалж байгаа юм шүү. Тиймийн тул Сэтгэлдээ таалсан аль дуртай зүйлийг ав гэхэд, хаан авахгүй гэлээ. Ширээт лам, энд орж ирээд, дурсгал болгох юм аваагүй гарвал үл зохино гэж гайхалтай очир алмас гялалзсан шигтгээтэй эрдэнийн бэлзэг авч өгсөнд, хаан тал өгч авлаа.

Эргээд явтал, тэр гурван хөмрөг зоорь өнгөрмөгц өнөөх малгай дахин буруу харуулан өмсгөж, нүдийг нь бөглөөд, бас ийш тийш, цааш нааш төөрүүлэн хөтөлж хөтөлж, өнөөх гишгүүрээрээ дээшээ авиран үүдэн зооринд хүрч, орсон нүхээ бөглөж аялуулсан хойно малгайг нь авч дугандаа шүтээний газар аваачин оруулсанд хаан шүтээнд мөргөжээ. Чингээд гэлэнгүүдэд тал өгч өгүүлрүүн:

— Номын ах нараас нэг юм лавлая. Улс дотроо нууцгай газар доорх зооринд ийм гайхалтай эрдэнийн сан үзсэнээ би нөхөд, зарим хүнд, чухам хаа ямар газар байгааг эс хэлэвч, үзсэнээ ярьж болдог болов уу? хэмээвээс ширээт лам гэлэн сэлт нар цөм болно гэжээ.

Хаан мордохын өмнө тэдний бэлэглэсэн бэлзгийг хараад,

— Та нарын энэ бэлэг над маш эрхэм тул, хуруунаасаа үл салган, авсанд хамт авч орно гэж билээ.

Дуганаас гарч ирэхэд, үдшийн мөргөлийн цаг болж байсан бөгөөд, хаан төдий л саатсангүй, ширээт болон шавь нартай нь салах ёс хийгээд — Хоёр хаалгачаа дагуулан мордож Шилтгээнцэр Храдецийн зүг Лаб мөрөн өгсөн нуга газраар явжээ.

Бараа бологсод, хаалгачнаас хаагуур явсныг асууж, хаан, дуганд юу хийсэн бэ гэж асууж үзлээ.

— Хийдэд өдрийн хоол идээд, ширээт лам, хоёр өвгөн гэлэнтэй дөрвүүлээ дуганд орж, удтал тэдний хамт мөргөл хийсэн гэж хэлэхээс өөр юм тэр хаалгачин ч мэдсэнгүй, бусад хүнд ч хаан, тэр нууцаа үл хэлсэн тул, мэдсэнгүй. Гагцхүү амьсгал хураахын өмнө хэдэн зөвлөх

сайдад тэр бэлзгийг миний хамт бүү оршуул. Опатов гэдэг Ширээтийн хийдийн нууц эрдэнийн сангаас дурсгал болгож авсан юм. Олон жилийн өмнө би тэр санг үзсэн билээ гэж захижээ.

Тэр захиагаар нь болгож билээ.

II

Сайн дурсгалт IV Карлын наснаас нөгчсөнөөс хойш олон жил өнгөрч, түүний хүү IV Вацлавын төр барихын шувтаргаар 1415 онд Опатов гэдэг Ширээтийн хийдэд санамсаргүй нэгэн зочин ирж, хоёр хөтөл дагуулан, Опочнын Ян Меслецки гэдэг ноён иржээ. Тэр бол арван нэгдүгээр сард, олон хутагтын өлзийт өдөр, нар шингэх үед эзгүй нуга тал, Лабын тэндэх навчгүй мод бүрэнхийд харлан хүйтэн жавар татаж байсан цаг билээ.

Тэр морьтон ноён, хийдийн газар хоног гуйж ирсэн нь ч аргагүй гэмээр байж, шөнө харанхуй болох нь, салхи жавар сүрхий хүйтэн, дээл нэвт жигнэж байна. Шилтгээнцэр хүрэх гээд тэнгэрийн байдал горьгүй боллоо гэж орж ирсэн байжээ.

Петр Лачур гэдэг ширээт лам, нас өндөр, жавхлантай өвгөн гэлэн, тэр зочныг аятай сайхнаар хүлээн авч, хоёр хөтчид нь оройн хоол өг, бас гурван хүн хойноос нь ирэх юм байна. Тэдэнд бас идэх уухыг өг гэж захиж, Местецки ноён тэр гурван хүнийг замдаа саатаж, энэ хийдийн зүг айсаж яваа гэсэн нь, нээрэн ч үдэш оройн жавар жихүүнд улайж даарсан улс хүрч иржээ. Тэр үес ноён нь, ширээт лам, хийдийн шавь нарын хамт сайхан илчтэй туурган зуухын задгай галын ойр лаа дэн барьсан ширээнээ сууж, тэр айлчин морьтон, элдэв сонин юм ярьж, Кестницец бодсон хурал, Хүсинцийн Ян багшийг, ялангуяа Прага хотынхныг хүслийг дагагч Иесеницийн Ян багшийг зүхэж хараал хийсэнд дарагдаж, хурал ном ч Прагад хийхийг зогсчихсон гэдгийг ярьж, шинэ номын ёс, Прагынхныг муу хэлж лам нарын эсрэг үймэлдэж байна, ван, бас, тэр бүгдийг сул өнгөрүүлж байна гэж муу хэлж суув.

Чингэтэл, Берговын Отто ноён гэгч бас нэг гийчин орж ирээд, тэнгэр муухай, явж болшгүй болоод, таван дагалдах хүний хамт, хуучин хийдийн санд буух гэж ирлээ. Местецки ноён бас энд хонож байгаа юм бий. Маргааш Шилтгээнцэр хүртэл хамт явах замдаа ханьтай ашгүй боллоо гэж бахархав.

Ширээт лам, Берговын ноёныг бас аятай сайхнаар хүлээн авч олон шавь нарыг байр байрандаа тархан одсон хойно ч тэр зочинтой, ярилцан сууж байв. Ноёнд, дарс барин, чулуун туурганд дээш нь татах хоолойтой ил задгай галын ойр сууж, гадаа харанхуй шөнө цонх доргин донсолтол салхилж байх тэр цаг, галын дэргэд улам ч сайхан байжээ. Местецки ноён юм ярьж, Берговын ноён бас л сонин юмтай хоёул зоригтой ууж, хундаганд байн байн шаргал туяатай улаан дарс хийж, нүд нь гялалзан царай нь улаан зээрд болжээ.

Чингэтэл гадаа харанхуйд гэнэт цэргийн бүрээ татсанд хоёул дуугүй болоод босож, бүрээний дуу улам чангарч, салхины чимээ дарсанд хоёр морьтон эр, ширээт ламын гараас шүүрэн, Местецки ноён хүйтнээр өгүүллрүүн:

— Ширээт лам, тэр бүрээ сонсов уу? Манай цэргийн хүмүүс, хаалгыг эзлээд, гадаа харанхуйд хэрмийн гадна бүслэн гучин хүнийг дотогш оруулсан мэдээ бидэнд өгч байна аа одоо цөмөөрөө дуганд оржээ. Чи, шавь нарын хамт манай эрхэнд орлоо гэхэд нь ширээт хирдхийн цочиж асууруун:

— Юу болоод байна гэхэд,

— Танай нууц эрдэнийн сан хэрэгтэй болоод байна. Түүнийг заагаад өгвөл, чамд гэм хор хийхгүй газар дор зооринд бий гэдгийг бид мэднэ. Чухам хаа байгааг хэлээд өг! гэж Берговын ноён тулгажээ.

— Мэдэхгүй! Гэтэл хонгилоор хүн үймэх шуугилдах, зэвсэг хангинах чимээ гарлаа.

— Хүн чамайг тэнхрүүлнэ гэж битгий бод. Тэр цөм манайхан. За одоо сангаа хаа байгааг хэл гэхэд нь өвгөн ширээт айвч, санаа шулуудан

— Хэлэхгүй! гэлээ.

— Чамайг тамлана шүү! гэхэд,

— Үйлээрээ л болохоос доо. Хэлж болохгүй юм, би хэлэх ч ёсгүй юм гэлээ.

Берговын ноён, гадагшаа ухасхийж гараад, удалгүй хойноос нь өвч зэвсэгтэй дөрвөн эр орж ирлээ, Местецки ноён, тэдэнд өвгөн ширээтийг тушааж өгвөл тэр арван нэгдүгээр сарын харанхуй шөнө түгшүүр зарласан их хонхны чимээ гарч, хийдийн гэлэнгийн нэг нь хонхоо сандран цохиж ойр байгаа гацааныханд мэдээ өгсөн байжээ. Тэгтэл, цэрэг тэр хонхон зүг гүйж очоод, зүрхтэй гэлэнг хүнд шархтуулжээ.



Хийд дотор галын улаан туяа татаж, дуганы цонх нь гялалзав,
Гэлэнгийн суудаг бяцхан бяцхан тасалгаа, харанхуй хонгил, хүрээгээр
гүйж яваа гэлэн, тэдний хойноос хөөж яваа тонуулчин цэрэг, юм
олзлон талж яваа нь сүүмэлзэж, хийдэд ганц ширээт лам хоцорч,
хүрээний зоорин байшинд хүлээтэй хэвтэж, Местецки ноёны хүн,
бамбарын гэрэлд зодож, шатнаас хүлээд, Местецки ноён, Берговын
ноён зандран асууж

— Эрдэнийн сан хаа байна? Хэл, эс хэлбэл, амь алдана шүү! гэж
байцааж, тэр ширээт, эрүү шүүлтийг баатарлан хатуужиж, нэг ч үг
хэлэлгүй, лаагаар өрөөсөн бөөрний нь тушаа түлж зовоосон ч үг
алдсангүй

— Хойд өглөө нь тэнгэр муухай бүрхэг үес, Опатовицын хийдэд
нэг ч хүнгүй, хоосон чимээгүй. Хамаг юмыг нь шөнөдөө талан тонож,
Местецки ноён, Берговын ноён мөнгө санга, сүм хийдийн эрдэнийн
зүйл, хамаг юмыг нь талан авч, гацааны улс хүрч ирэхэд, шархтай
хэдэн гэлэн, үхтлээ тамлуулсан ширээтийн төдийхөн хэдэн хүн хэвтэж
байлаа.

Хийдийг ихэд сүйтгэвч, ширээт ламын хатуужлын ачаар газар
доорх их эрдэнийн сан бүтэн үлдэж, ширээт лам удалгүй нас нөгчжээ.

Тэр үес хөл үймээн ихтэйн учир шийтгүүлбэл зохих ялаас хэлтэрч
зайлсан боловч Опочнын Местецки ноён таван жил болоод дахин тэр
Опатовицын хийдэд хүрч ирэхдээ, тонуулчны хувиар ирээгүй,
хамгаалагчийн хувиар ирж, нутгийнхаа хүний эсрэг Зикмунд хааны
албаны хүн болж, тэр хааны цэрэг дагуулан хүрч ирсэн билээ. Тэр
цэргийн улсыг Хусын талын шилтгээнийхний эсрэг, мөн Оребийн
шавь нарын эсрэг суулгаж, газар дор нуусан их эрдэнийг
хөөцөлдсөнгүй, удалгүй дайнд мордож, цэрэг нь үлдээд, хоёр дахин
Шилтгээнийхэнтэй ялан тулалдсан нь, 1420 оны арван хоёр сард яг тэр
хийдийн тэнд нэг тулаад, хойтон жилийн гуравдугаар сард мөн ойр
хавьд нь Подолшон гэдэг бяцхан хотын тэнд тулсанд, тэр тулаанд
Шилтгээнийхний цэргийн тэргүүн Лукаш унасан билээ. Тэгээд
дөрөвдүгээр сард хааны цэрэг, Прагынхан, Оребийнхан
Шилтгээнийхний цэрэгт Кутна Хора. гэдэг Хүдэрт уулынхан хүч
нэмсэн их цэргээс айж, Опатовын хийдээс зайлсан билээ.

Зикмундын цэрэг яваад өгсөн хойно Милетиний Дивиш Боржек
ноён Оребын шавь нар, Шилтгээнийхний хамт хүрч ирээд,

Опатовныхнаас хоёр удаа дарагдсаныхаа өшөө хорсол, бас олон удаа дийлдсэнийхээ хариу авч, хуучин хийдийг галдан шатаажээ.

Хийд бүх барилгын хамт хайлж шатаагаад, Лаб мөрний нуга талд, өвс ногоо цэцэг навчны дунд хийдийн цонхны алтан загалмай ганжир нь гялалзан, эвдэрсэн нурсан барилга «энхжиний хүрээ» өвс шарилж ургаад, орчин тойрны хонгил гудам нь харлаж уншлага эгшиглэдэг газар сөнөсөн шинжтэй, чив чимээгүй болсон билээ.

Хийд тэр баларсан хэвээрээ хоцорч, эвдэрхий нураа дор нь алт мөнгө, эрдэнийн чулуу, царийн хийцтэй эрдэнийн эдлэл, олон зуун жил далд хэвтсэн тэр газраа үлдэж, хаа байгаа нь ч битүүлэг нууц болжээ. Тийм юм байгаа юм гэж үе улиран амьтан хэлэлцэж хуучин хийдийн эвдэрхий нь нур нурсаар үгүй болоход ч тэр эрдэнийн далд буй зүйлийг ам дамжин хэлэлцнэм билээ.

III

Усанд автагдаад, эвдэрхий хэрэм байшин нь үгүй болж арилсан нь, Лаб мөрөн нэг их үерлэж, тэр хавь газар урсгал солигдож ирсэнд эвдэрхий хийдийн нэг хэсэг нь усан дор оржээ. Чингээд, хийдийн ойр урсаж байсан Лаб мөрөн, хийд дундуур урсдаг болоод, усан татарч тунгалаг болох үес улс ёроолд нь, мэлтэлзсэн усан дор байдаг эвдэрхий хийдийн үлдэгдлийг харах гэж очдог боллоо.

Нэг хэсэг эвдэрхий барилга усанд автагдаагүй газар хоцорч, тэнд нь тээрэм бариад, гол сахиусны байсан газар нь эм дом мод ургаж, олон зуун жил боллоо. Тээрмийн хүн, багачуул, зуны үдэш тээрмийнхээ тэнд сууж, Карл хаан, нууц эрдэнийн санг ярилцаж, тэр далд дарсан юм чухам хаа байдаг бол, усан дор байдаг газар нь орж чаддаг бол юутай чинээжих асан бол гэж ярьдаг байлаа.

Чингээд тэртээ хол, саглайж үдшийн бүрийд харагддаг хөгшин эм дом модны зүг харвал тэр модны тэндээс салхи цэцгийн үнэр ханхлуулан, навч нь шуугинахад шүтээний газрын уншлага уншин, сан тавьж байгаа юм шиг ажээ. Шөнө дөлийн үес тэр хөгшин эм дом мод, сар гарч гэрэл нь туссан юм шиг тодрон, модны орой нь гэрэл татаж, гишүү найлзуур нь гэрэлтэн, зулын гэрэл шөнийн тэнгэрийн зүг гийсэн мэт болсонд, тэр жигтэй юм үзсэн хүн бүхэн, гайхаж наманчлаад, гэрийн хүмүүс, шүтээний өмнө сөхрөн мөргөх адил сөгдөн залбирч, тийм үес зарим нь тэр модны зүгээс ном унших чимээ,

холоос дуулдах юм шиг, салхинд мөрний зүг тэр дуу очин дуулдаж замрахыг сонсдог байлаа.

Гэгээн цагаан өдөр ч гэсэн тэр нууц төгөлдөр газар олныг гайхуулж, ялангуяа тээрмийн «ноён аав» тээрэмчин, багачуулыг гайхуулдаг байлаа. Хоёрдугаар Рудольф вангийн аав Максимилиан вангийн үес жин үдийн үес опатовицын тээрмийн тэнд ус гэнэт доошоо цөмрөн оржээ.

Амьтан мөрний зүг гүйж очвоос, жигтэй юм болсон байв. Тээрмийн хүрд зогсоод, ус нь хүрдний тэнд урсахаа байж, тээрмийн дээд талд доошоо газар цөмөрч, мөрний ус нэг их дуу чимээ гаран, тэр цөмөрсөн нүхэнд эргүүлэг тогтон, сүртэй нижигнэн, бараг хагас цаг доошоо орж, тэр үес тээрмийн хүрд усгүй болоод эргэхээ байж, тээрэм ч ажилгүй байсан билээ. Чингээд хагас цагийн сүүлээр ус дахин хуучин хэвээрээ тээрмийн хүрдний доогуур орж урслаа. Ус доошоо цөмөрсөн газрын тушаа аав ноён, ажилчин тээрэмчин, гацааны улс цуглаж, ямар жигтэй юм болов оо? Лав, дуганы доорх зоорины дээвэр нь усанд идэгдэн цөмрөөд мөрөн тэр зооринд орж өнөөх эрдэнийн сан нуусан газрын хонгил худгийг дүүрсэн байх гэж таамаглан хэлэлцлээ. Чингээд одоо тэр эрдэнийн сангийн газар орж үзэхээс өнгөрчээ гэж хэлэлцсэн билээ.

Гэвч, нэг оролдоод үзжээ. Чингэхдээ нутгийн хүн оролдоогүй гаднын улс үзжээ.

Түүнийг өгүүлбээс, Цагаан уулын дайны сүүлээр цөвүүн цагаар юм санж, Опзтовицед дөрвөн итали хүн хүрч ирээд биеэ Италийн Бенатын шумбагч нар гэж Фердинанд хаан өөрөө зарлиг буулгаж, усанд автагдсан тэр эрдэнийн санг ол гэж явуулсан хэмээсэн гэдэг.

Хүн тэднийг хориг ч хийсэнгүй. Чингээд хийдийн эвдэрхий нь усанд үзэгдэх газар шунгаж ороод, газрыг шинэчлэн байшин барилгын үлдсэн байдлыг үзнэ гээд, усанд асар их ч удсангүй. Хоёр нь уснаас гарч ирээд, нөгөө хоёр нь усны ёроолд үлдсэнийг хүлээтэл, ер гарч ирсэнгүй. Нэг бол, урсгалд нь автагдан алга болж, нэг бол усан дор тэр хуучин хийдийн эвдэрхий барилгын дунд төөрөөд амь үрэгдсэн болов уу, алин ч гэсэн, ер хүүр нь эс олджээ.

Үлдсэн нөхөд нь тэр эрдэнийн санг эрэх гэж дахин усанд орж зүрхэлсэнгүй. Мориндоо мордоод хоосон буцжээ.

Чингээд Опатовицийн хийдийн тэр эрдэнийн сан, одоо хүртэл газар дор хэвтэж, Лаба мөрөн дээгүүр нь сахин урсаж байнам.

ДОМОГ ТУУЖ



I. ХУУЧИН ПР АГЫН ДОМОГ

... Прага!

Прага гэдэг нэр, дуулал мэт тэр эгшиг нь
Чехийн сэггэ лийн хөгжмийн утсыг жингэнүүлж,
Зурх бахархан хөдлөх аж ам
Сватопл ук Чех

Дөрөвдүгээр Карл хаан Прагынхаа шилтгээнд нэгэн орой Пардубицийн Арношт гэдэг ахлах хамба, тэргүүн ченсиан сайд чех ванлагийн шилтгээний гүн сайдын зэрэг чех амбас сайд, язгууртан тайж, мөн зарим алдартай эрдэмтэн, тэдний тоонд бас зурхайчаа оролцуулан урьж, адрыг нь сийлбэр, будаг алтаар янзалж, туургыг нь франц хийцтэй хөшгөөр чимсэн сайхан танхимд олон зочдын хамт хуримлан суужээ. Ширээ дээр нь лаа дэнгийн гэрэлд алтан мөнгөн сав, хундага, цөм сайхан чимэг хийцтэй хэрэгсэл гялалзан авай.

Оройн зоог бариад, танхимд бүгчим халуун болоод ирсэн үес хаантан босож, гийчнийг хамт сэрүүн салхинд гадаалъя гэж ахмад хамбын хамт тэр оройн хоолны танхимаас ордны тагт дээр гарч, хойноос нь ноёд ихэс яриа хөөр болж гарцгаажээ.

Уудам тагт дээр гармагц хаан, зөвлөх сайд, бусад олон цөм үг дуугаа намдаж, ордны тагтнаас дор нь харагдаж байгаа вангийн хотын сайхныг гайхан харав.

Зуны тэр шөнө, тэргэл сарны гэрэлд Прага хот, энд тэнд сүүдэртэн нойрсож, өндөр байшин, дуган, цамхгийн хэрэм орой нь сарны гэрэлд өвөрмөц сүртэй бөгөөд, гулдангийн цонх, барилгын цонх нь гялалзан, сайхан цэцэрлэг, арлын шугуй модны навч намаа нь тэр саран гэрэлд бөмбөгөр бөмбөгөр юм харагдаж, орчин тойрноо маш айван тайван, гагцхүү усны боолт далангийн зүгээс шуугинах чимээ дуулдаж байв. Ван, олон ноёд, тэр үзэсгэлэнт байдлыг бахдан, гэрэл харанхуй хосолсныг харж, хөхрөн харагдагч Петшин, яг дор нь байгаа Бага хотыг хялайн харж, тэр хотын гэрэл татсан газар, мөрний захад хаалганы цамхгийн алтан орой нь гялалзаж байгаа арцбискуп гэдэг их хамбын ордон, цаашлан, урсгасан мөнгө шиг гялавхийж байгаа мөрний дээрх хуучирсан гүүр¹⁷ дээгүүр бүх Прагыг харцгаан, Жүүд хот, хуучин хотын байдлыг харвал, цонж, хүрээ хэрэмтэй бөгөөд түүний нь цаанаас цамхаг, дуган шөнийн огторгуйд арзайн сүндэрлэж, гудамж, айлын үүдний саравч харлан үзэгдэж, тэр зүгийн юм бүхэн, зарим нь гэрэлтэй, зарим нь сүүдэртэй зарим нь хав харанхуй ажээ.

Хуучин хотын цаана, цааш нь өндөр өөд их уудам газар¹⁸ богд Лазарын дуган цайвалзан харагдаж, Здеразын өндөрт богд Петрын сүм зэлүүдхэн сүндэрлэж, Опатовицийн тосгон унтаатай, цайвар гэрэл татсан газар цаана нь Цөөрөмт гэдэг Рыбникий тосгонд богд Штепааны сүм сүндэрлэхийж тэртээ нь Тулалдаант гэдэг Боиштийн тэндэх богд Яны сүм харагдаж, цэцэг жимсний хүрээлэн, боловсорсон тарианы газар сарны гэрэл цацран тусч, цаашаа нүд гүйцэх газар, усан үзэм урсгасан өндөрлөг газар, цайвар манан татан харагдаж байлаа.

Цөмөөрөө тэр дур булаам сайхан үзэсгэлэнт байдлыг дуу чимээгүй харж, ван, түүний үзэмжтэй сайханд нь сэтгэл хөдөлж,
— Энэ таатай сайхан газар аа. Миний дур булаасан үүнийг бусад газрын дундаас хамгийн сайхан цэцэрлэг шиг би маш таашаан бахаддаг. Энэ сайхан цэцэрлэг дунд нэн сайхан нь харцгаа та нар, Прага шүү! Энэ шиг сайхан юм ер байдаг гэж үү? гээд нүд нь гялалзваас, Пардүбицийн Арношт

— Сайхан хот оо, богд сэнгүн ноёны өндөрлүүлсэн бөгөөд, сударчийн үгээр хэлбэл, буянтай хот доо. Одоо бас чиний хайр хишгээр бүр ч мандах байх. Эрхэм вангийн хуланц дээд эмэг эхийн

ирээдүйг зөгнөсөн үг нь одоо биелж, Прага хот өргөн ч болж байна, алдартай ч болж байна. Ноёд олон энэ хотыг эрхэмлэн үзэж, алдар нэр нь дэлхийд түгэн түгсээр, улам ч алдар ихтэй болно доо гэхэд нь ван үнэн голоосоо өгүүллрүүн

Тэнгэрийн бошиг ивээлээр би улам ч эрхэм сайхан болгох санаатай, миний горилдог бол гээд, алсыг ихэмсгээр ширтэн зогсож байсан өвгөн зурхайчаа хараад, за зурхайч багш, хотын хэт ирээдүй нь сайн сайхан байгаа биз? Чи юунд царайгаа барайлгав? Юм дуугараач! гэхэд нь,

— Ван еэ, тэнгэрийн дохио тэмдгийг одоохон дээр танд хэлэх дургүй шиг байна даа, би тань хэмээвээс,

— Хэлээд бай. Од шинжлэхэд, ямар болоод байна? гэлээ.

— Өршөөлт ван, одны шинж муу байна гэхэд нь

— Хэлээд бай! гэсэнд арга буюу ван хийгээд, дэргэд нь чих тавьсан ноёд олонд тэр сэтгэлчилсэн багш, шинжилснээ хэлж,

— Одон шинжиж үзвээс, Бага хот их галд автагдан, үнсэн товрог болох шинж тодорлоо. Тэр хуучин хот үерт авхуулах гамшиг тохионо. Ор мөргүй балран сөнөх юм бололтой гэхэд нь олон цөм сандран мэгдэж, вангийн гайхан зовсныг харваас, ван байс гээд, хотын зүг эргэж, гараар занган

— Прага сөнөхгүй байсаар л байх болно. Бага хот, Хуучин хот үгүй боловч, өөр барилга босно. Тэнд, харж бай, тэнд шинэ хот босгож, дахин шинэ их Прага сүндэрлэнэ! гэхэд нь Хуучин хотын тэртээ өргөн дэнж зааж, тариалан цэцэрлэг Цөөрөмт гэдэг Рыбник Опатовицын зүг заахад нь олны дотор онгойж, магнай нь тэнийцгээн, мэргэн арцбискуп их хамба, чех олон ноёд тайж нарын бодож байсныг илэрхийлэн

— Тэнгэр, эрхэм ванг тэтгэтүгэй гэжээ.

Дөрөвдүгээр Карл ван санал ёсоороо болгож шинэ хот босгох: бэлтгэл ажил үүсгэлээ. Биеэр урт уудмын хэмжээ гаргаж зохиогоод, хэрэм хүрээний хэр байдлыг зааж өгөөд, суурийг нь биеэр тавилцаж¹⁹ гудамжны тиг татахад байлцаж, зах зээл, талбай хаа гаргахыг заан тогтоож өгөөд, барилгачинтай ярилцан, ингэ тэнгэ гэж хэлж өгч, барилгын ажил аль хэр урагштай байна гэж эргэн үзэж, чулуучин, хар ажилчинтай эргэх бүр ярьж, юм асуун, бэлэг зэлэг өгч, ажил урагштайд урамтай явдаг байжээ.

Нэг л удаа уурласан юм гэдэг. Герман улсаар явж ирээд, Шинэ Хотын барилга үзэх гэж очтол, газар хэмжээчин, эзгүй хойгуур нь нэг шинэ гудамж гаргаж, богд Индшихийн сүм өөд тэр гудамжны тиг татаж, байшин босгож байсныг харангуут сочин гайхаж, царайгаа барайлган, энд гудамж хэн гарга гэж хэмжиж өгсөн бэ? хэмээн асууваас, барилгач сандарсхийн,

— Ван еэ, бидэнд хэн ч гарга гэж хэмжсэнгүй, энүүгээр нэвтрэх газар байвал зүгээр гээд л гудамж гаргаж орхисон юм даа. Боль гэвэл болиулья даа гэхэд нь,

— Болиулаад ч яах вэ дээ. Зааж өгөөгүй газар гаргаснаар нь үүрдийн үүрд Заагаагүй гудамж гэж нэр өгч босго! гэсэн юм гэдэг.

Шинэ хот чингэж сүндэрлэн босож, байшин нэмэгдэн өндөрлөх нь борооны сүүлээр ургаж байгаа мөөг адил. Тэр олон орон байшинг дан ганц хотын ардуудаар барахгүй, чех орны эзэн хаан ч босголцов. Тэхдээ арай лут юм босгуулж хийд, цамхагтай сүм, өндөрлүүлжээ. Үүнд богд Йеронимын сүм, түүний дэргэд бенедикт ёсны гэлэнгийн хийд, Морена гэдэг Эрлэгийн хатны хөх ногоон мод шугуй урьд дээр цагаас байсан Хадатад босгож, тэр сүмийг их хөрөнгө гарган барьсан гэдэг. Тэр сүмийн үйлтгэлд тоосгоны хөх наанги шороогоор, Карлштейн шилтгээний тоосгоны нэгэн адил шатааж пааландаад сүмийн дээврийг сүрхий чадамгай уран сайхнаар босгосон үүнд хөвчийн лут мод оржээ.

Тэр сүм хийдийг хорь гаруй жил барьж, их хөрөнгө зарцуулсан нь, чулуун гүүрнээс ганц зоос л татуу болсон гэж хэлэлцдэг. Барьж гүйцэхэд нь²⁰ анх мөргөл хийж, шүтээний өмнө гэлэнгүүд слав хэлээрээ ном эгшиглэж, слав номоороо ариун мша хурлын уншлага эртний зан үйлдлээр, чех сүмд олон зуун жил болж слав хэлээрээ уншсанд, далмат нутгаас тэр слав гэлэнгүүдээ залж ирсэн бишрэлт чех ван баясаж, бүх олон даяар даган баясалцаж билээ.

Чингээд тэр хийд, их дуганыг «На Слованех», буюу «Славынх» гэж нэр өгсөн нь одоо хүртэл нэрлэсээр иржээ.²¹

Тэр слав сүм барьсаар гүйцэд гурван жил өнгөрөөгүй байх үес IV Карл ван бас нэг шинэ дуганы суурь тавьж Вышеград хэмээх Өндөр шилтгээний тушаа, Шинэ хотын хамгийн өндөр газар босгуулжээ.²² Тэр сүмийн зургийн төслийг Прагын нэгэн залуу барилгачин гаргасныг ван үзээд, ямар сайхан зураг гаргаж, юутай зүрхтэй зоригтойгоор хамаг юмыг нь санаачлан гаргав аа гэж их л гайхан

баярласан гэдэг. Ванг гайхахад хуучин хашир барилгачин ч бас үзээд гайхаж тийм сүрхий өндөр адар, зурсан ёсоор босгож, арай чадахгүй болов уу? гэж гайхан эргэлзсэнд ван зурсан зургийн ёсоор барьж үз гэж тэр залуу барилгачинд даалгасанд, зориг бадран, урьд өмнө Прагад байгаагүй барилга босгоно гэж их л урамшин оролджээ.

Барьсаар барьсаар байтал нь, найман зовхис тийш хандсан тэр сүм нь, нүдний өмнө сүндэрлэн босож, туурга нь босоод, сайхан угалзан сүлжээт хоёр гурван угсраа цонх гаргаж, гоё чимэгтэй хаалга нь босоод, янз бүрийн сийлбэр, тоонолжсон цэцэг, дүрс хөрөг чимэглэлтэй үзэмж төгөлдөр болоод, сүмийн тэр уудам барилгад нь бөмбөгөр, урьд үзэгдээгүй том бөгөөд зүрхтэй зорин зураг гаргасан ёсоор босох адар, өнөөх залуу уран багшийн санаачилсан дагуу барьж, доторх нуман нурууг нь цөм сүлжсэн шат наана нь босгосон тул, дотроос нь тийм гэж харагдахгүй, өдий төдий тулга мод шат дүүрэн байсанд, мэргэжилтэй хүн үзээд их л гайхаж, тэр залуу барилгачин урныг арай л барьж чадахгүй байх, тэр адрын нуман нуруу нь даахгүй, ер нь тийм уудам, сүмд тийм их өргөн бөмбөгөр адар босгож болохгүй, нурж сүйрэх байх, зүрхлээд зүрхлээд горьгүй дээ гэж хэлэлцдэг боллоо.



Тэгж хэлэлцэхэд, залуу уран барилгачны зүрх үхмээр болж, нээрэн ч яадаг бол, даахгүй нурдаг болов уу гэж сэтгэлд нь сэв орлоо. Урьдын адил барилгадаа баярлан гүйдэг нь байж, гэртээ хариад ч ганцаараа байхдаа санаа амар сууж чадахгүй, өдөр шөнөгүй тоо бодож, куман нуруутай бөмбөгөр адар нь тогтох уу, нурах уу гэж зурж боддог боллоо. Сэтгэл чилсээр нойр хулжиж, шөнө их л орой болтол, барилга шалган бодож суугаад, хэвтэхдээ хөгшин залуу бусад уран барилгачны горьгүй дээ гэсэн үгийг эргэцүүлэн бодож, тэдний айсан болгоомжилсон, хулчийн эмээснийг нь санаж, нуман нуруут адар бүтэхгүй гэснийг нь эргэцүүлэн сэтгэх бүр тэдний дооглон инээмсэглэсэн нь хүртэл нүдний өмнө үзэгдэх адил болж, нээрэн тэр адрьг гүйцээн босгож чадахгүй, нурж харлавал, нэр хүндээ алдаж, амьтны элэг доог болно гэж бодох бүр, халууртлаа бодлого бодсон, толгойгоо барьж эсвэл сүүрс алдаж, өрөө дотроо нааш нааш алхдаг байлаа. Нэг шөнө тэгж байгаад гадагшаа гүйж гарангуут, өнөөх Шинэ хотын өөд гүйж, харанхуйд харвал, босгож байсан барилга нь өнөөх сүм нь барьж гүйцээгүй, тойрон шат сүлжсэн юм харлан харагдаж, алх лантууны чимээ нижигнэн нижигнэх нь тасраад, эзгүй, хөндий хоосон, гагцхүү тэр сүм босгогч уран барилгачин түүний бие л сүмийн барилга үйлтгэлийг эргэн явах ажээ.



Чингэхдээ нуман нуруут адрын зүг харж явсаар, хүний залбирал хийж, номын дуу эгшиглэх хөндий их сүмийн дотор нь орж үзвэл шиллээгүй цонхоор нь одон түгсэн огторгуй харагдаж, саран гэрэл үүсэж байлаа. Тэр гэрэлд орчин тойрныг хараад, нуман нуруут адрын зүг ширтэсхийвээс дэмий л харлан харагдах авч, уран барилгач түүний нүднээ нуман нуруут дээвэр, бүтэн боссон адил санагдаж, доошоо найман хошуу болон буусан тэр нуман нуруут адар нь дотроо бас хоёр бага олон хошуут болон салаалж буугаад, нуман нуруу, уулзар нь будаг чимэг алтан шармал болж, их дуган нэгэнт бүтээд, наран гэрэлд гайхам сайхан гялалзаж байгаа мэт сэтгэгдэж, ван тэргүүтэй тайж нар, эгэл жирийн олон тэр сүмд оронгуут, өөдөө гайхам сүр жавхлан төгөлдөр нуман нуруут адрыг хүн бүр шагшин гайхаж байгаа юм шиг санагдсанаа сэтгэлд л тийм хоосон юм ургалаа гэж мэдэнгүүт, миний дотор баясган ургасан энэ үзэгдэл хэзээ ч үзэгдэн бүтэхгүй хоосон юм, тэр нуман нуруу нурж ойчно гэж сэтгэл дотор нь орж ирэнгүүт гадагшаа ухасхийн гүйж гараад ухаан сэтгэл нь үймж энэ сүмийн барилгыг яасан ч дуусгаж үзнэ, нуман нурууг яасан ч үзүүрийг нь нийлүүлэн барилдуулна. Өөрийн хүч чадлаар эс боллоо ч гэсэн, чөтгөр шулмын хүчээр ч гэсэн босгоно гэж ам алдаад, тэр амласнаараа болгож, чөтгөртэй нөхцөөд, сүнсээ чөтгөрт худалдаж гэрээ хийхэд нь, чөтгөр шуламс, тэр Карлын сүмийг дуусган барьж өгнө гэж амлаж тэр амласан ёсоор болгосон билээ. Барилгачин босоо нуман нуруу нь тогтохгүй, ханаран ойчно гэж бодон, хэзээ унадаг бол гэж өдөр ирэх тутам хүлээтэл, нурсангүй. Холбох татлагыг нь хийхэд, урьд үзэгдээгүй их том нуман нуруут адар нь тогтоод, сүм дотроос тулсан шатыг авч буулгавал, тэр гайхалтай сонин барилгын байдал бүрэн гүйцэд үзэгдэж байжээ.

Гэтэл, чулуучин, ажилчин олны хэн ч хэр тулгуур шат буулгаж, зүрхэлсэнгүй. Хүн бүр, тэр шат хөндвөл нуман нуруут бөмбөгөр адар нурах бий гэж айгаад, залуу уран барилгачин, ажилчнаа аргадаж, тогтоно гэвч, хүн хөдөлж өгсөнгүй. Тэгэхэд нь, өөрөө сугална гээд тэмүүлэхэд нь, ахмад нөхөд нь барьж хориглолоо. Тэгэхэд нь, чөтгөрт хатгуулж,

— Би шатанд гал тавина! гэжээ.

Тэр залуу уран барилгачийг очиж сүм дотор тулгуур шатанд гал тавимагц, нуман нуруут дээвэр нь тогтохгүй нурна даа гэж, олон

амьтан тэр шинэ барилга тойрон харж байтал сүмээс өнөөх уран барилгачин гараад ирж гэнэ. Гаруут нь сүм дотор юм нижигнэж, муухай их дуу гараад, салхи гадагшаа пүс хийтэл хөөргөдсөнд, нурлаа гэж хашхиралдаж, хамаг амьтан ийш тийшээ амь тэмцэн зугтаажээ.

Тэр их сандрах үед өнөөх уран барилгачныг бодох зав хэнд ч олдсонгүй. Тэгэхэд, тэр хүн, тэр дуу чимээнд чих дөжирсөн юм шиг,, ухаан санаа алмайран, цонхоор нь тоос бужигнан хөөрөгдөж байгаа сүмийн зүг харж, царай нь үнсэн хөх болоод зогсож байснаа,

Чөтгөрөөс болж гайтлаа! Тэнгэр шийтгэлээ дээ намайг гэж бодоод, босгосон барилгынхаа унахыг үзэхгүй юм сан гэж ухаангүй гүйжээ.



Бурхиран бужигнасан шороо тоос намдаад ирсэн хойно улс амьтан тэр сүмийн ойр очиж, дотогш нь шагайн үзэнгүүт машид гайхжээ. Доторх шат тулгуур нь ойчоод овооролдон хэвтэвч, сүмийн нуман баганат адар нь яагаа ч үгүй, бүв бүтэн, гайхалтай сайхан харагдав. Үдийн нарны гэрэлд жигтэй сонин, огт гэм суугаагүй, уран сайхан хийцтэй байдлыг нь харж, хүн бүхэн баярлалдан, өнөөх залуу уран

барилгачийг хаа байна гээд эрэл сурал хийвээс, гэртээ очоод, аминдаа хор хийж, хэдийн үхсэнийг олжээ.

Тэр нэгэн шөнө санаа зовж байгаад, сүмд орж, бүтлээ, боллоо гэж сэтгэлд ургасан тэр ёсоор нь болж, их сүмийн барилга нь гүйцээд, чимэг засал нь бүрэн төгс болоод,²³ тэр сүмд анх орсон ван, ноён, тайж, ер тэр сүмд анх орсон хүн бүхэн, юуны өмнө тэр сүртэй сайхан нуман сүлжээ нуруут адар өөд гайхан харж, түүнийг босгох гэж амиа өгсөн өнөөх залуу уран барилгачныг дурсан санадаг ажээ.

Тэр үес бас Шилтгээний хавьд Карл вангийн бас нэг шинэ барилга, богд Вийтийн шинэ сүм сүндэрлэн босож, Шинэ хотын байшин барилга нүдний өмнө өргөжин боссоор байв.²⁴

Карл ван, хайртай хотдоо халуун элэгтэйгээ илэрхийлж, сүсэг төгөлдөр бөгөөд урлагт халуун сэтгэлтэйнхээ тэмдэг болсон тэр хоёр алдарт дурсгал болсон барилгын хажуугаар бас гуравдугаар их үйл үүсгэсэн нь, чулуун шинэ гүүр бариулж эхэлсэн байлаа.²⁵

Тэр гүүр, өчнөөн төчнөөн зуун жил болж, манай ард түмний алдар мандах, бууран доройтох нь цөм тэр гүүр дээгүүр өнгөрсөөр ирж, тэр гүүр анх босгосноос хойш Чех улсад их ч өөрчлөлт гарсаар ирж, эвдрэл тэмцээн нэгэн улсаа, нэгэн хэлтэй ард түмнийг салган үймүүлж байвч, ганц тэр гүүр, үе улиран олны хайр сэтгэл татаж, самуун бэрх цагийн үес, бууран доройтохын улирал тохиоход, цөмийг нь туулан өнгөрүүлээд, бат чийрэг тэр гүүр, сайн цаг, сайхан алдарт үеийн дурсгал болсоор, тэр сайн цагийн юм гэж, буурай, хүчин доройтогсдын сэтгэл санааг нь сэргээн тэжээдэг байлаа.

Олон гүүр дундаас Карлын гүүр хамгийн бат бэх гэж хэлэлцдэг нь, босгох үес шохойг нь өндгөөр зуурсан гэлцдэг бөгөөд, арван зургаан лут гулдан, өдий төдий тулгуур багана, тийм их том юманд өндөгний тоог өгүүлээд барахгүй байх нь ээ.

Прагад тийм олон өндөг байгаагүй. Ойр орчимд нь ч бас тэр гүүрний барилгад өндөг нийлүүлэн барахгүй байсан тул, IV Карл ван, чех вант улсын бүх олон хотод Прагын гүүр барих өндөгний алба тогтоон оноож, тэрэг тэргээр зүг зүгээс өндөг ачуулан явуулж, хураан цуглуулаад, шохой зуурдаг байжээ.

Велваараас тэр өндөгний албанд барих өндөг явуулахдаа замдаа хагарч муудах бий гэж арга сүвэгчлэн, нэг том тэрэг өндөг аргацаан явуулсныг гүүр барих урчуул хүлээн авч, нэг өндгийг нь хага цохиод, бас нэгийг хагалаад, дахиад нэгийг хагалж шохойд хийх гээд, их

гайхал болж, бас нэг өндөг, дахин нэг өндөг авч хагалаад, тэгээд, овоолоотой өндгийг хага хага цохин үзээд, элгээ хөштөл инээцгээлээ. Шохойчин, чулуучин, гүүрний бүх урчуул тэр өндөгний жиг сонсон үзээд цөмөөрөө шуугин инээцгээж, тэднээс бүх прагын хүн мэдэж агдганан инээцгээж Велваарынхан шохой зуурах өндөгний алба нийлүүлэхдээ, нэг их тэрэг дүүрэн өндгөө аргатал нь чанаад явууллаа гэж элэг хөшин инээцгээж билээ гэж хэлэлцдэг.

Тэр чулуун гүүр барьж дуусахад²⁶ хүн чулуун хөшөө арай босгоогүй, одоо алталсан төмөр загалмай байдаг газар нь модон загалмай нэг суурь дээр босгосон байжээ. Тэр газар урьд эрт цагаас нааш цаазаар хүн аваачдаг газар байсан бөгөөд толгойн цаазад унах хүн, амь тасрахын өмнө тэр модон загалмайн өмнө эцсийн залбирал хийн мөргөдөг байжээ.



Загалмайтны хийд лүгээ гүүрний цамхгийг холбосон хэрэмд мөрний зүг харсан сахалтай чулуун толгой бий. Түүнийг сахалт гэдэг.²⁷ Тэр бол, гүүр анх босгосон хүн, үүрдийн дурсгал болгож, чулуугаар дүрсээ сийлүүлж, гүүрний чулуун тулгуур баганад суулгасан юм гэдэг.

Тэр чулуун гүүрээр манай вангуудын шилтгээний зүг явтал, зүүн гар тийш Петшинд арзгар урт хэрэм үзэгддэг. Уулын хяраар ногоон модны дунд цайлзан харагдаж, хуучин мужийн хаалга гэдэг байсны зүг уруудан буудаг бөгөөд IV Карлын «гэрийнхний» босгуулсан хэрэм гэдэг.

Юм их үнэд орж, 1360 онд ядуу улс аж төрөх ажил олдохгүй өлбөрөн үхэцгээж, Прагад хоёр мянгаад ядуус цуглаж, Карл ванг сүмээс гарах үес зам тосон уйлан мөргөж, өл залгах өчүүхэн хоол л өгвөл, өөр хөлс шагнал гэхгүй, ямар ч ажил хийе гэж гуйсанд, ван, тэднийг өрөвдөөд, маргааш яг л энэ цагт, энэ газар хүлээж бай гэж захиад, хойд өдөр нь дэргэдийн хүнд тушааж, тэднийг Петшин уулын орой дээр аваачуулаад, хойноос мордон очиж, тэр уулнаас чулуу авч, Влатаваас Петшинээр дамжин, страховын хийд хүртэл хэрэм босго гэж тушаасан гэдэг.

Тэр хэрмийн үйлтгэлд ажилласан хүнд мөнгө хөлс эс өгөвч, талх хоол цадтал нь олгож, гутал хувцас бас сангаас өгсөн тэр сураг бусад олон хоосон хүн сонсоод тэр хэрмийн үйлтгэлд бөөн бөөнөөр очицгоон оролцож, хичээнгүйлэн оролцсонд Карл ван тэр Петшинд байн байн ирж, тэр ажил хийж байгаа олныг миний гэрийн хүн, садан төрөл гэж түгээл хишиг хүртээдэг байсан үүнд, өчнөөн төчнөөн амьтан тэр ванг ерөөж, унтах босохдоо вангийн өлмийг бат орштугай гэж залбирдаг байлаа.

Уулнаас малтаж аваад, тэргэнд ачин буулгаж, тэгшлэн засаж хэрмийн үйлтгэлд хэрэглэсэн тэр чулуу, хоол тасарсан олон амьтны идэх тариа будаа өдөр бүр үржүүлдэг чулуу болж, тэр олон амьтан уулын чулуугаар босгосон тэр хэрмийг «Будааны хэрэм» гэж нэрлэн, зарим нь бас өлсөх зовохыг аргалсан хэрэм гэж, «Өлсгөлөнгийн хэрэм» гэж нэрлэсэн гэдэг. Тэр хэрэм дээгүүрээ арзгар байдалтай нь шүд шиг харагдах бөгөөд өлсгөлөнт олны шүдэнд зажлах юм бүү тасраг гэж тэр хэрмийн дээд талыг шүд мэт арзгар бариулсан гэдэг.

Тэр үес Прагад Ян Ротлев гэдэг нэг баян хүн байжээ. Тэр хүн, шавартад алт ухаад орхисон нэг хөндийн газар сайн ухвал алт бас гарах ёстой гэж худалдаж аваад, олон уурхайчин хөлслөөд, ямар ч хүнд сүйтгэл үл бодон цуцалтгүй, үргэлжлэн ухуулсанд зардал их гаравч, алт гаргаагүй. Ухсан худаг хонгил нь арвайн чинээ ч алт гарахгүй, шижир эрдэнийн судал огт үл үзэгдэх хайр чулуу, хоосон чулуун дундуур гарч, өдий төдий зоос сүйтгээд, мөнгө хөрөнгө нь барагдаж,

ажлаа зогсохгүй юм сан гэж өр ширэнд орж эхлэхэд нь, таньдаг садан нөхөд нь, алт гарахгүй боллоо. Байдаг юмаа газрын нүхэнд цутгаж барах нь гэж хориглон ятгавч, Ротлев, алт заавал гарах учиртай гэж зүтгэсээр тэр шавартай хөндийд зарах мөнгө олох гэж эд хогшлоо хэсэг хэсгээр зарж, эцэст нь, уурхайчны хөлс өгөх юмгүй болж ирлээ.

Тэгээд, ихэд гашуудаж, Хөрөнгө буянаа барсанд огт үл зовнин, гагцхүү, цааш нь ухах мөнгөгүй болсондоо гасалж, бас нэг баахан ухвал, лав алт гарах юм сан гэж гэгэж гиншихэд нь, амьтан инээмсрээд, итгэж өгөхгүй ганц эхнэр нь л, нөхрийнхөө үгэнд учир бий гэж, төлөөнөөс нь өрөвдөн зововч, тусалж чадахгүй, байдаг үнэтэй цайтай юмаа хуу нөхөртөө өгч дууссан хүн байжээ. Юмнаасаа ганц алтан утсаар сүлжсэн эрдэнийн бүтээлэг алчуураа, залуу насанд дурсгал гэж хадгалан үлдээсэн билээ. Тэр бол, нөхөр нь гэрлэн суухаар хэлэлцсэн үес бэлэг болгож өгсөн эд байсан тул түүндээ их хайртай байлаа. Чингэвч, тэр эрдэнийн алчуураас бас салах цаг ирж, нөхөр нь түүнийг авч, наймааны хүнд гүйж очоод худалдаж, тэндээс өнөөх Шавартынхаа хөндийд ажлаа хөдөлгөх гэж яаран сандан очжээ.

Уурхайчин, дахиж цааш нь ухаад эхэлсэн тэр, өдөртөө шижир сайхан алтан их судлаа олж тэр судлаас учиргүй их эрдэнэ алт гарсан тул, төдхөн урьд тэр хөндийн уурхайд зарсан бүх зардлаа эргүүлэн олж аваад бас ухсаар үлэмж их алт гаргажээ.

Буян хишиг хайрласан тэр Шавартын хөндийг бэлгэшээж, Алчуурын хөндий гэж нэрлээд, Прага хотноо хуучин хотод нь, богд Хавлын сүмийн тушаа их үнэтэй байшин босгосон нь, бүх Прагад хамгийн гоё сайхан байшингийн нэг нь болсон гэдэг. Байшингийн хүрээ нь гурван их хаалгатай, байшингийн доторх үүдний танхим нь, байшингийн уланд бөгөөд, дээр нь бяцхан цонж цамхагтай, засмал чулуун сайхан гулдан баганатай байжээ. Ротлев, сайхан зассан өрөө байшинд суугаад, хамаг том сайхан танхимыг нь Карлын сургуульд өгчээ.²⁸ Тэр сайхан байшин алтны уурхайт хөндийн эрдэнээр бүтээд, өөрөө бас гадаад дотоодын олон үеийн хүний эрдэм боловсролын их эрдэнийн уурхай нь болжээ.

Карлштейн гэдэг алдарт шилтгээнээ 1378 онд чиг чимээгүй уйтгартай байлаа. Урьдын адил, ван, олон сайчуултайгаа ан гөрөө хийх гэж тэр үеэр ирдэг байсан нь, огт ирсэнгүй. Буулгадаг гүүр ч буулгаагүй, вангийн суудаг өрөө ч цоожтой харанхуй бүрэнхий үес тэндэх ордны цонх нь гэрэл туяа гялалзах нь үзэгдэхгүй, шилтгээнээ

нам гүм, бөгөөд гагцхүү намрын хүйтэн салхинд их цонж цамхгийн тэнд дөрвөн газраас соргог харуудын цэргийн дуу авалцах нь, тав дахь нь шилтгээний худгийн тэндээс, зургаа дахь нь вангийн ордны тэндээс цагдаж байгаага мэдэгдэн, шөнө цаг тутам шилтгээнээс хол бай, хол бай, ? гэж дуудалцан, чийгтэй гунигтай жихүүн шөнө хангиналцан, үүр гийж өдөр болоход ч нарны гэрэл, орчин хавийн ой модны улаан шар навчинд туссан цаг тэр гунигт байдал арилан үгүй болдоггүй болжээ.

Авчин гөрөөчний эвэр бүрээний дуу ч тэр нам гүмд нь дуулдахаа байж, сүрэг сүрэг тайга нохой авчин олны чимээ ч гарахаа байж, хөтөл дөрөлж, эрээн өвс цэцэгт бэлээр ч дуулдахаа хэдийн байж, Карлштейн шилтгээнээс хадан хясааны дор Богд Яны тэнд очдог замын хөгшин царс модны тэнд ч хүн амьтан явахаа байж, жил бүр урьд дөрөвдүгээр Карл сайн ван, тэр царс модны хавьд ургасан түшлэг шиг үндсэн дээр нь очиж суух, саглагар гишүү мөчир дор нь залбирал үйлдэхээ ч байж, тосгоныхон, тэр хавиар явахдаа, урьд вангийн сууж амсхийдэг тэр «вангийн түшлэг» гэж нэрлэдэг царс модны үндсийг эзгүй боллоо гэж гуныхран харж явдаг боллоо. Вангийн ундаа гэж нэрлэдэг тэр хавийн нэг булаг шанд нь ч, урьд ван буун очиж ундалдаг байсан нь, бүг мод мэт том навчит модны шар навчинд дарагджээ.

Карлштейн шилтгээнд ч маш гуныхралтай болсон байжээ. Ванг Прагын шилтгээнээ халууран чилээрхэж, ёолон хэвтэж байгааг амьтан, ахин босохоосоо өнгөрсөн гэж хэлэлцдэг боллоо. Ван өөрөө ч түүнийг мэдээд, цагаа хүлээн хэвтэх ажээ. Дэргэд нь арцибискуп гэдэг их хамба, вангийн агь тайж нар, төрөл элгэн нь сахиж, ван, улсын суурин залгамжлах Вацлавыг шударга мэргэнээр төр барь гэж сануулаад, тэнхээ тамир тасарсан гараараа адислан хэвтэх ажгуу.

Тэгтэл, богд Нийтийн сүмийн цамхагт их хонх нэг дуугараад дахиад нэг дуугарч, гуравдугаар удаа дуугарахад нь, тэр хүнгэнэсэн дууны хариуд нөгчигсдийн хойноос дуугарах хонхны чимээ өрөвдөм гунигтай дуугарчээ.

Вангийн царайг нь харваас хэвтрийн дэргэд байсан улс амьтан сочин эмээж, маш арилсан тайван байдалтай болоод намуухан дуугаар: Сонс! Эзэн тэнгэр намайг дуудлаа. Үеийн үед та нарыг сахин хартугай гэхэд нь богд Витан сүмийн хонхчин нь, яаран сандран, сүмийн хонхны цамхагт гүйн очиж, цоожтой байсныг нь биедээ авч явсан түлхүүрээрээ түлхээд дээшээ шатаар мацан гарч ирээд, зогтусан эмээж

харваас, нөгчигсдийн хойноос цохидог хонх өөрөө хангинан дуугарч, бусад том хонх хөдлөн, дуугарч байхыг эмээн үзлээ.



Богд Вийгийн сүмийн цамхагт ийм байхад, бусад цамхгийн хонх мөн нэгэн адил дуугарч байлаа. Сандарсан Прага хотноо их хонхны дуу хангинан дуулдаж, тэр сүртэй дуугаар эх орны эцэг, алдарт сайн вангийн сүнс нь «Тэнгэрийн сайхан орны мөнхийн алдрын зүг халин одлоо.

II. ХӨХТ АРИАХҮҮ ИЛБЭЧИН

Карл вангийн хүү суурин залгамжилсан эхний хэдэн жилд цаг тайван байсан тул хожим улс амьтан хэлэлцэхдээ өдөр шөнийн зургаан цагт²⁹ толгой дээрээ шижир алт тавиад явсан ч, муу хүн халдахаас зовдоггүй байжээ.

Ван, баян чинээлэг нь ядуугаа хяхуузай гэж шударга ёсыг маш эрхэмлэж, ажилчин, ядуу гар үйлдвэрчин, дунд их сургуулийн оюутны, дүрээр явж, талх худалдагчдын дундуур хэсэн, талх ав, жинг нь шударгаар хэмжиж байвал, үнийг нь өгөөд, муу талх, дутуу жинтэй, байвал, байдаг талхыг нь хураалгаад, ядууст эсвэл сургуулийн

сурагчдад зүгээр өг гэж хэлээд талхчны нь хөрөнгөд торгууль оноож, эсвэл Влата мөрний усанд оруулан залхаадаг байжээ.

Яргачныг бас тэгж шалгаж, бусад гар үйлдвэрийн урчуулын ажлыг мөн хянаж, зарим нэгэн удаа ажилчны дүрээр усан үзмийн тариаланд очиж газар ухах ажил хийгээд, жирийн хүнийг яаж байдаг байна гэж ажиж, өдөржин газар ухаад, хэцүү хүнд ажил юм байна гэж мэдээд, үдийн амрах цагийг уртасгаж өг, орой нь эртхэн тарааж бай гэж тушаажээ.

Шөнө ч гэсэн зүсээ буруулаад Прагаар хэсэн явж, дэн гуанзаар орж, шударгаар үйлчилж байна уу гэж биеэр шалган, улс амьтан, юу гэж хэлэлцэж, юу гэж боддог юм байна гэж заншлан явахдаа, ялангуяа хуучин хотын «Хөх цурхайт» гэдэг газар олон явж, зугаач наргиач нөхдийнхөө хамт хөгийн наргиан үүсгэж байдаг асан гэлцдэг.

Заримдаа их хөгийн хачин юманд дуртай нь, ялангуяа түүний илбэчин Хөх тариа хүү гэдэг хүн, элдэв жигтэй наргианы юм үүсгэдэг байжээ. Тэр хүн бол, сүрхий овтой живтэй хүн, зүсээ буруулж, царайгаа ч ондоо болгож чаддаг бас хэнтэй ч гэсэн гайхуулан сүрдүүлж чаддаг эр байжээ. Ванд бараалхан очихдоо, бүдүүхэн оёсон цэмбэн, хувцастай бариу гуталтай очоод, вангийн өмнө хүрч зогсохдоо торгон хувцастай, эрээн гуталтай болж хувилгаад, гутлын гуулин хошуу нь, ямар ингэн хээнцэр гангачуулынх шиг гялалзаж байдаг асан гэдэг. Вангийн дэргэд нь тийм байж байтлаа, холдмогц, олны нүдний өмнө хувцас байдал нь, шал өмнөө болж, хувцсаа эс соливч, аянчин хүний хуниаст нөмрөгтэй болчихдог байжээ.

Вангийн зоогийн ширээнд үзүүлдэг жигтэй юмыг нь тоочоод барах уу? Ялангуяа вангийн алиа салбадайг сандраадаг нь бэрх. Тэр хүн нэг удаа, цартай загас авах гэж гараа сарвайгаад, атгамагц, алдчихаад, уулга алдан гараа харахад нь, бадайр бадайрсаар нэг харан гэхэд эвэр болчихсон, адууны туурайтай болчхож, нөгөө гараа харсан, бас тийм болчихжээ.

Салбадай хулчийгаад, туурайтай болчихсон гараас айн сүрдэж их сандруу байхад нь ван, олон ноёд элгээ хөштөл нижигнэн инээлцээд, аан, за одоо тэр хөөрхий салбадайг туурайнаас нь салгаж өг дөө гэхэд нь, Хөхтариахүү гараараа хүрээ татан зангаж, ам дотроо сонин хачин үг гүнгэнэн шившмэгц, адуун туурай үгүй болоод, үхрийн ац туурай болчхож, салбадай бүр ч сандарч, уйлан гашуудаж, арайхийж Хөх

тариа хүүг аргадсаар, үхрийн туурай болсон хоёр мөчөө гар болгуулсан гэдэг.

Нэгэн өдөр ван, шилтгээнээсээ гадагш морилох гэж дөрвөн бяцхан баганатай бүхээгтэй гоё хээтэй сүйх тэрэг нь гадаа бэлэн хүлээж, дөрвөн сайхан цагаан морь, гоё сайхан тоног хэрэгсэлтэй тэр тэргэнд хөллөөтэй байжээ. Тэрэгний хажууд вангийн бараа бологсод мориндоо мордоод, салбадай нь алагч гүү унаад ганц Хөхтарирахүү бэлэн бай гэж захиастай боловч үзэгдсэнгүй. Ванг гарч ирэхэд, тэр хүн байхгүй. Сүйхэндээ суугаад, цаадах чинь яасан бэ? гэж асуугаад, үзэгдээгүй гэхэд, вангийн царай баргар болжээ.

Тэгж байтал зэргэлдээ хашаа дотор хэдэн эр тахиа сүрхий сүрхий дуугарцгааж, тэр хашаанаас гурван хос тас хар эр тахиа хөллөсөн, хоёр дугуйтай бяцхан тэрэг гарч ирлээ. Анхны хоёр тахиа бага шиг, дараачийнх арай том, гуравдугаар нь их том хар тахиатай хар өд нь гялалзаж, толгой дээрх улаан сэчиг нь гал мэт улалзан, тахиа бүр хошуундаа сур шижимтэй, үзүүрийг нь Хөхтарирахүү бариад, тэр гайхамшигт дэлбэг жолоогоо залан явжээ.



Ван ихэд инээж, надаас давуу хөлгөнд суужээ. Одоо миний хойноос яв гээд, цагаан морьт сүйх тэргээрээ явахад нь хар тахиа

хөлөглөсөн Хөхтариахүү дагаж, тэр сонин хөлөгтийг явсан газар бүхэн амьтан гайхан цуглаж, хожим ч тэгж явахад нь амьтан шохоорхон дагаж, заримдаа Хөхтариа хүү явалцах нь гэж сонсвол, шилтгээний өмнө цугладаг байжээ. Бас нэг удаа их сонин юм үзүүлснийг Прага даяар, хол ойрын газар цөм гайхан хэлэлцэж билээ.

Тэр Хөхтариахүү сүрэл боож гучин баглаа хийгээд, шахмал юм шиг тарган гучин гахай болгож, Михал гэдэг нэг баян, ховдог нарийн талхчны бүдүүн эр гахай бэлчдэг голын захад тууж бэлчээж гэнэ. Тэр баян хүү, Хөхтариа хүүгийн сүрэг гахайг шохоорхон хараад, худалдана гэхийг нь дуулмагц, үнэ тохиролцон худалдаж аваад, гэр гэртээ харих үес Хөхтариахүү-Миний гахай ч яриагүй сайхан тарган, бордмол гахай. Ганц усанд л горьгүй гэж мэдээрэй? гээд яваад өгчээ.,

Тэр талхчин хүн, захисан үгийг нь мартаад олон гахайгаа голын гарамд аваачаад усанд шахаж оруулсан нь, далд ороод, усан дороос гучин боодол сүрэл хөвж, урсаад яваад өгчээ, Талхчин, өнөөх гахайгаа гараад ирэх болов уу? гэж хүлээгээд, ховдог нарийн сэтгэл нь хөдөлж, усны захаар гахайгаа дуудан гүйгээд тэр боодолтой сүрэл бариад өгөөч ээ! гэж дэмий л сандран тэвдтэл, тэр сүрэл нь хэдий урсаад алга болжээ. Өнөөх талхчин, хайран их мөнгө алдлаа, хайрт гахайгаа алдлаа гэж Хөхтариа хүүгийн хойноос шилтгээнд яаран гүйж очвол, өнөөх илбэчин эзгүй байж, эрж сурагласаар нэг гуанзанд байхыг нь олоод үзвэл, гуанзны зузаан хэрмийн хонхорт цонхны тушаа суугаад, хөлөө жийж, араараа өрөө түшин, урд нь хоосон аяга тавиастай үүргэлж суув гэнэ.

Өнөөх талхчин түүнийг хармагц ногоортлоо уурлаж, үүднээс эхлэн хараал тавьсаар дэргэд нь гүйж очтол, цаадах нь огт ажиггүй, харааж зүхэхийг нь батгана гүнгэнэн дуугарсны төдий ч бодохгүй унтаач болж суув гэнэ. Талхчин бүр ч уурлаж хөлөөс нь шүүрээд, сэрээх гэж дугтраад, угз таттал, хөл нь тасраад өгч гэнэ. Өнөөх талхчин айж ухаа алдчихжээ. Тэгтэл, Хөхтариа хүү сэрээд, чи намайг яав? гээд багалзуурдан шүүрээд, шүүхэд очно гэжээ. Яах яахын ч аргагүй, гуанзны эзэн, бас тэнд байсан олон хүн, цөм тэр талхчны хэрэг өдүүлснийг бэлхэн үзсэн тул, ялаас зайлах аргагүй. Сандрахдаа дэмий л гуйн аргадаж, хүнийг зэрэмдэг болгосондоо өдий төдий мөнгө өгч салжээ.

Хөхтариа хүү мөнгө өгнө гэхэд, тайтгаран зөөлөрч, мөнгийг нь аваад, тасархай хөлөө чихэж хэв янзад нь оруулаад, шүүхийн танхимд

заргаа авсан хүн шиг, огт ажиггүй сүрхий сүрхий алхаад гарч өгч гэнэ. Тэгэхэд өнөө их нарийн хэриг талхчин, улс амьтны элэг, доог болж, газар сайгүй түүнийг хэлэлцэн, Михалын гахайдаа баарсан шиг болуузай гэдэг үг гарч гэнэ.

Түүний дараахан Хөхтариа хүүд бас нэг хэдэн хэцүүхэн өдөр тохиолдож гэнэ. Вацлав вангийн баварын сэнгүн ноён айлчилж ирж гэнэ. Сэнгүнийг дагаж, хэдэн герман илбэчин, элдэв хачин юм ачсан хэдэн тэргээр ирж, сэнгүн ноён, тэднийг вангийн уйтгар сэргээх гэж авчирсан юм байжээ..

Тэр хэдэн илбэчин бол сүрхий наргиач улс, илбэ жилбэд айхавтар чадамгай юм байж, ван ч тэднийг их гайхаж, Хөхтариа хүүгээсээ илүү сонирхжээ. Чингээд Хөхтариа хүү ч сэнгүн ноёнд чадлаа үзүүлэх болж гэнэ. Гэтэл, үзүүлсэн бүгдийг нь, сэнгүний илбэчин чадаад байж гэнэ. Тэгээд тэр германчуудыг давж ядаад гутарч нэг юм үзүүлээд орхисон нь цаадуул тийм юм үзүүлэх гээд чадсангүй гэнэ.

Тэр бол, үдийн хоолноос хойхно нь болжээ. Өнөөх Германчууд. Шилтгээний хүрээ дотор индэр дээр, ван түүний зочин болон вангийн шадар олон, мөн Прагынхны өмнө илбэ чадлаа үзүүлэх юм болж гэнэ. Тэр хоол идэх үес вангийн танхимд ван сэнгүн хоёр, нэртэй тайж нарын хамт тавцан дээр сууж, тэдний доод талд алиа салбадай нар, Хөхтариа хүү, бас сэнгүний хоёр илбэчин хүн суулцсан юм гэнэ. Тэгээд цонх дор нь амьтан шуугилдах германаар юм хэлэх дуудах чимээ гарсанд өнөө хоёр герман, илбэчин, цонхон тушаа сууж байснаа, босоод юу болж байна гэж доошоо бөхийж хартал аргад автагджээ.

Дор юу ч болсонгүй, дэмий хоосон хашхиралдсан ажээ. Чингээд, тэр хоёр герман эргэж суух гээд чадсангүй. Толгой нь цонхонд тээглээд, болохоо байж, гадагш цонхоор цухуйх завсар толгойноос нь олон салаа бугын эвэр ургаад, тэр хоёр яаж ч чадахгүй, дэмий л толгойгоо ийш тийш нь эргүүлэн оролдоод, эвэр нь тас няс хийж байлаа.

Амьтан үүнийг үзээд, хүс хийтэл инээж, Вацлав ван бүр ч их таваа ханатал инээж, тэр илбэчин тохуурхахдаа Хөхтариа хүүг чингэж чадсанд нь улам ч бахаджээ.

Тэр германчууд, үдээс хойш, вангийн тушаалаар сая эврээсээ салж, шилтгээний хүрээ дахь индэр дээр ван болон, өчнөөн төчнөөн олон хүний өмнө сонин жигтэй юм үзүүлж, ийм овтой живтэй улс байдаг юм байж гэж амьтан гайхахын ихээр гайхваас, ганц Хөхтариа

хүү огт эс үзэгдэв. Бараа нь ч харагдсангүй, Олны дунд түүнийг хэлэлцэхдээ, энэ хавиар байснаа цаадуулын үзүүлдэг юмыг чадахгүйгээ мэдээд ичиж, алга болсон биз ээ. Олны гайхалцан шуугихыг дуулахгүй гэж нэг газар зайлан нуугдсан байх, эсвэл тэр германчуудтай чадлаа үзэлц гэж ван тушаагуузай гэж бие зайлсан ч магад хэмээтэл, Хөхтариа хүү нэг үзэгджээ.

Олны шуугих чимээ агшин зуур түр намдмагц, хэрмийн ёроолоос гэнэт дуу нь гарч, олон цөм, түүнийг үл андах тул, тэр зүг хандацгаагаад, бор царайтай, хар үстэй, улаан хувцастай тэр Хөхтариа хүүд зам тавьж өгтөл, тэр баварын жигтэй юм үзүүлж байсан индэр өөд хоёр дагуулын хамт гараад өгч гэнэ. Чингээд, индрийн дунд зогсоод, ханцуйгаа шамлаад, амаа ангайн сунгаа сунгаасаар, жигтэйхэн том амтай болж ирэв гэнэ. Баварын илбэчин одоо яадаг бол? гээд харж, одоо л гүйцэгдэхээ байлаа гэж хулчийсхийн байтал, Хөхтариа хүүгийн хоёр дагалт нь германы хамгийн сүрхий толгой илбэчнийг бариад, эзэн илбэчиндээ өгч гэнэ. Тэгэхэд нь амьтны ухаан санаанд ингэнэ тэгнэ гэж огт юм ороогүй байтал, тэр багавтар нуруутай германыг тэгшхэн болгоод, хоёр гарыг нь хажууд нь шахаад, мушгин нугалаад тогос шиг том амаа нээн чихэж гарахад нь, хоёр хөлөө арваганасаар аманд нь орж далд оров гэнэ.

Харж байсан үй олон улс амьтан, баярлан шуугилдаж, шилтгээний цонхны шил нь, тэр их дуу чимээнд заяатай эс хагарав. Чингээд Хөхтариа хүүгийн хоёр зардас нь герман бавар илбэчний хэрэглэж байсан том торхтой ус авчраад өгч, Хөхтариа хүү тэр бүхэл хүн залгисандаа ядарсан байдал дүр үзүүлж, тэр торхтой ус дээр бөхийгөөд бөөлжихөд нь, амнаас нь тэр герман ус руу пал хийж ойчоод, усанд орсон хулгана шиг арвалзан шал нойтон юм, тэр торхноос гарч ирлээ гэнэ. Ойр хавьд нь байсан амьтан, түүнийг үзээд, элгээ хөштөл, унан тусан инээж, бахаа ханаж гэнэ. Усаа гоожуулж, хүн амьтнаас ичиж, час улаан болсон тэр Бавар газрын герман хүн, хөшгийн цаана далд орж нуугдахад нь амьтан, нүднээс ус гоожуулан, улайн чинэртлээ инээж, тэр байна гэж заацгааж гэнэ.

Чингээд, тэр бавар германчууд, дахиж юм үзүүлсэнгүй.

Хүн ч тэднийг тоохоо байж, амьтан бүхэн, Хөхтариа хүүг л харцгааж гэнэ. Тэр Хөхтариа хүү, вангийн өмнө бараалхах ёстой болж, ван ч түүнийг олны өмнө магтан хөхүүллээ. Чингээд, тэр овтой живтэй сүрхий илбэчнийг индрээс буухад, амьтан тэсгэлгүй баярлан бахдаж,

вангийн шилтгээн дүүрэн нижигнэтэл талархал сэтгэлээ илэрхийлсэн билээ.

Хөхтариа хүүгийн хамгийн сайхан илбэ нь саяын тэр зүйл байжээ.

Чингээд, насан эцэс болох тийшээ алдаж автагдсан гэдэг.

Автагдахдаа, шуламд биеэ тэмдэглүүлсэн учир, тэр нь биетэй сүнстэй нь аваад явчихсан гэлцдэг асан.

III. ДӨРӨВ ДҮГЭЭР ВАЦЛАВ ВАНГИЙН ДОМОГ

Цаг төр төвшин сайхан байснаа, Вацлав ван, нутгийн засаг ноёдтой тааралдахгүй болоод ирэхэд Чех газар ёс цааз алдагдаж эхэллээ. Ван тэдний үг санал үл сонсон, хот суурин хавийн гаралтай, шадар дотно хүнийхээ үгийг илүүц итгэх болж, олон ноёд, ванг нутгийн тушаалыг хөнгөмсөг үзэж, уг саналыг үл тоомсорлох боллоо гэж гомдоцгоодог боллоо.

Чингээд сэтгэл нь нэн ч үл нийлэлцэх болсонд вангийн садан болох унгарын вантай эчнээгээр хэлэлцээ байгуулж, төр төвшин энх жаргал удтал оршсоны эцэст дайн дажин боллоо. Эвдрэл ихэдсээр, ноёд, ванг гуйланчийн шилтгээнээс Прага орох замд нь хүртэл халдан дайрч, баривчлаад, Хуучин хотын яаманд аваачиж, Азар Бузар гэж алдартай гянданд хорьжээ.

Тэр хорионд арван тав гаруй долоо хоног болж, ихэд гуньхарчээ.

Бүгчим зун, богд Бартоломейн үед хотын яамнаас ойрхон нэгэн угаалын газар оруулж өгнө үү гэж сахиж байсан хүнээ явуулан хэл залгуулсанд түшмэд ноёд яахыг удтал хэлэлцээд вангийн саналд[^] нийлүүлэхээр эцэстээ тогтож, Вацлав ван түр зуур суллагдан, вангийн хувиар бус. Прагын нэгэн жирийн иргэний байдлаар энгийн борчуулын хувцастай гарч, дөрвөн хүнээр сахиулан одохоор болж гэнэ.

Тэр дагуулаа дагуулж, чулуун гүүрний тэндэх нэг халуун усны газар очсон нь, гадагшаа гарах замыг нь нэг сахиул сахиж, үүдний өрөөнд үлдээд, нэг сахиул, вангийн хувцас тайлсан газар сахин сууж, нөгөө хоёр нь вангийн хамт халуун усанд оролцжээ. Усанд ороод ван, түр салхинд сэрүүцэн гаръя гэж маш бүгчим халуун байсан юм гэнэ.

Сахиул нь, ванг нэгэнт чармай нүцгэн тул, хаашаа ч очих вэ дээ гэж бодоод, тэг гэж, зөвшөөрөөд ван, алчуураар биеэ ороогоод, яг мөрний эргийн зүг харсан тагт дээр гарч харваас мөрний ус шуугин гялалзах ажам. Мөрний тэртээ байшингийн дээвэр, мод хөхрөн харагдаж, Петшин уул цэнхэрлэн, цаана нь вангийн шилтгээний

цамхгийн алталсан орой³⁰ гялалзан харагдаж, уужим тэнгэр, чөлөөтэй сайхан бөгөөд цэлмэг тэнгэр, огторгуйн наранд их л таатай харагджээ.

Түүнийг харангуут зан гянданд хоригдсоноос илүү сэтгэл ихэд хөдлөөд, ажин харвал, хөгшин уд модны ёроолд гуя онгоц нэг сэлүүртэй үзэгдэх ажам. Тэр завсар, халуун усны газар үйлчилдэг нэгэн эмэгтэй тэр тагт дээр гараад ирсэнд, ван, түүнийг харуут, сэлүүр барьдаг уу гэж асуулаа. Тэгээд чадна гэхэд нь

— Намайг мөрний тэртээ шалавхан гаргаад өгөөч, Цаадуулыг гарч ирэхээс өмнө шамдаж үзээрэй. Би чамайг гомдуулахгүй шагнана гээд, тагт дээрээс доошоо гүйн бууж өнөөх эмэгтэй хойноос нь дагаж, ванг гуя онгоцонд суутал, тэр эмэгтэй бас суулцаад, онгоцыг уяанаас нь салгаж, яаран сэлээд, мөрний тэртээ эргийн зүг шамдаж, байдаг хүчээрээ сэлсээр, сахиулыг дотор өрөөнөөс гарахын өмнө усны цаад талд сагсгар бургас уд модны ёроолд шурган орж, хоёулаа яаран сандан шугуй дундуур мөрөн өөд зугтаасаар Хүхлийн тосгоны ойр хүрээд, эрэг дээр эзгүй гуя онгоц олоод, Зузаана гэдэг тэр үйлчлэгч эмэгтэй сэлүүр барьж, мөрний нөгөө талд нь дахиад азтай сайхан гарч, ван дайсанд мэдэгдсэнгүй.



Ойд шурган ороход нь, мод дунд хүн амьтанд огт сэрэгдэлгүй хорогджээ. Урьд ан гөрөө хийж байхдаа ван тэр хавь газрыг сайн мэддэг байсан тул үдэш орой болсон ч, төөрөлгүй явсаар хоёр цагийн дотор Күнратицийн ойн захад гарч, вангийн шинэ шилтгээн босгосон уулын хормой дахь голын тэнд хүрчээ. Тэр шилтгээнд вангийн бат журамт цэрэг сахин суудаг байжээ. Цэргийн дарга нь хэрмийн хаалганы өмнө ванъеэ биеэр зогсож байна гэж харуулын хүнээс сонсоод, итгэсэнгүй биеэр гарч үзвэл, үнэхээр ван байх ажээ. Чингээд хүндэтгэн ёсолж, вангийн хувцсыг шилтгээнээс авчруулан оройн сайхан зоог өргөж, тэр зоог барихад ван өнөөх Зузаана эмэгтэйг суулгаад, зоогийн сүүлээр чех алтан зоос нэгэн зууг авчруулан шилтгээний цэргийн жанжин пуркраб ноёны өмнө Зузаанад шагнал өгч, мөрөн гатлахад өгнө гэсэн минь энэ. Бусад тусламжийг нь танд

бас жич шагнана гэхэд нь пуркраб жанжин тэргүүтэй олон цөм вангаа барианаас мултарлаа гэж ихэд баярлалдав.

Вацлав ван, хожим тэр Зузааныг нээрэн ч мартсангүй. Засгийн эрхийг дахин барьж, олон нөхөдтэй учраа ололцсон хойно, гүүрний тэндэх хуучин халуун усны газрыг буулгуулж, оронд нь том сайхан халуун ус угаалгын газар бариулаад хамаг байшин барилга сэлт нь бэлэн зэлэн болсон үес Зузааныг дуудаж ирүүлээд, хорионоос сулласан ачийг чинь хариулж, энэ угаал усны газрыг чамд шагнан өглөө. Бас жилийн хорин коп зоос пүнлүү олгуулж, халуун усныхан бүхэнд өршөөлт зарлиг бичиг хайрлаж, бусад гар үйлдвэрийн хүний нэгэн адил эрхтэй болгоод, туг дээр нь алтан дэвсгэр дээр ногоон бялзуухай зогссон дундаа зангилаатай ваадан тэмдэг хэрэглүүлжээ.

Тэр цагаас одоо хүртэл, тэр чулуун гүүрний дэргэдэх халуун усыг газар, «вангийн халуун ус» гэж нэр алдаршаад тэр зоригт Зузааныг хуучин хотын цамхгийн голын адарт нь цагаан дотуур хувцастай халуун усны нэг эмэгтэй хүн, солгой гартаа сэнжтэй бортого, ич гартаа ногоон шүүр барьсан нэгэн дүрс дурсгал болон буй билээ.

Урд сайхан санаатай байсан Вацлав ван улам улам муу санаатай болж ирсэн нь, ачилсанд хорлож, элдвээр зовоохыг үзээд тийм болжээ. Хүнд итгэхээ байгаад, ялангуяа өстөн атаатан нь хор идүүлэх гэж оролдсоноос хойш тийм болж ирсэн билээ. Тэр хорыг нь мэдэлгүйгээр идэж уугаад, завшаанаа хорын ерөндгөөр амь гарсан билээ. Ингэвч тэр хороос болж гэдэс дотор нь гэмтээд, тэр өвчнөө дарах гэж сархад их уудаг болж, сархад уусаар хөлчихдөө учиргүй догшин уур хилэн бадарч хилэнгийн уршгаар хатуулан ширүүлдэг ч явдал гардаг байлаа.

Сэтгэл үргэлж зовуурьтай болж, алс хэтдээ юу болдог, яадаг юм бол гэж бодохоосоо дотор нь аягүй болж, олон ноёдоосоо айн эмээж, садан болох унгар вангаас сэжиглэж, шашин ном булаалдан хэлэлцдэгээс айн зэвүүцэж эцэс сүүлдээ юу болж салдаг бол, засаг төр, өөрийн бие хаашаа болдог бол гэж зовних болжээ.

Нэгэн шөнө, элдэв юм бодсоор, нойр хулжаад, унтаж чадахгүй болохдоо зурхайч багшийгаа дуудуулж, цонхныхоо дэргэд суугаад, вангийн шилтгээний уудам хүрээ, богд Вийтийн сүмийн гүйцээгүй барилга, тэр сүмийг тойрон босгосон урчуулын шат харж суутал нь, бараан хувцастай шадар зурхайч нь, вангийн толгой дохиход нь, цонхон тушаа очиж зогслоо. Тэгэхэд, ван, царай барайлган,

— Чи ирээдүйн юм мэддэг бол намайг юу болж, яах гэж байгааг хэлж өг гэхэд нь, өвгөн зурхайч нэг хэсэг чимээгүй байж байгаад, баруун гараа сунган тэр дуусаагүй сүмийн өндөр цамхаг огторгуйн зүг сүндэрлэн харлан харагдаж байгааг заан,

— Тэр цамхгаас л болгоомжилж бай, ванъеэ, гэхэд, ван хирдхийн айж

— Яагаад тэр вэ? гэлээ.

— Одон гарагийг үзвэл, тэр богд Вийтийн сүмийн цамхгийн тэнд үхлийн аюул тохиолдох юм байна гэжээ.

— Яаж үхэх болж байна? Миний дээр нуран унаж, намайг үхүүлэх, чулуу тэр цамхгаас над дээр ойчиж, цохиж, алах юм уу? хэмээн асууваас, зурхайч, тэр тухай одон шинжлэлд тодорхойгүй. Би үл мэднэ гэлээ.

Ван уулаас түргэн зантай тул, тэр үг сонсоод, хилэн бадарч,

— Тэгвэл, тэр цамхгийг нураан буулгуулбал яадаг байна? гэж зандран асуухад,

— За бүү мэд дээ, яадаг ч юм бол гэж зурхайч нь хариуллаа.

— За тэгвэл, зурхайч багш, мэдэж бай. Тэр цамхаг буулгаж үгүй хийвэл, цамхгийн тэнд миний үхдэг ч бас худал болох юм биш үү? гээд, дороо барилгын даргыг нь дуудуулж, тэр богд Вийтийн сүмийн цамхгийг нураа, үүрээс эхэлж буулгуул гэж тушаагаад, барилга эрхэлсэн тэр уран барилгачийг гайхан сандарч, элдвээр аргадан гуйсныг огт сонссонгүй, буулга гэж тушаагаад эрт үүрээр мориндоо мордоод, хэдэн тайж дагуулж, Шилтгээнээс Кунратицийн тэндэх Шинэ хотын зүг одлоо.

Барилгачин, арга буюу тэр сайхан цамхгийг дуртай дургүй буулгаж эхлээд, задал задалсаар цамхаг ч улам балтгар болж ирэв.

Вацлав ван, Кунратицийн бага шилтгээнд түр түдэж өдөр ирэх тусам цаг өнгөрч өгдөггүй, ан гөрөө хийгээд ч сэтгэл сэргэдэггүй боллоо. Тэгж байтал, улс даяар төвшингүй болж, ууланд улс амьтан хуран цугладаг болсон мэдээ ирж, Прагад олон даяар их л хорсон занаж байгаа сураг чимээ дуулдаж, вангийн дотор их л аягүй болж нэг л муухай хөл үймээн дэгдэх бий гэж эмээтэл тэр ёсоор боллоо.

Хишиг өдөр³¹ нэг цагийн алдад морьтой элч тэр Шинэ шилтгээнээ давхиж ирээд, ванд айлтгасан нь, үдийн өмнө аршаалах их жагсаал болж, Тэнгэрийн хөрөг биеийг Ян Желивски жагсаал ёслолын тэргүүнд залж, олон санваартан сүсэгтэн, богд Штепааны сүмээс шинэ

хотын яамны өмнө нь хүрч ирээд, шашин мөргөлийн тэмцээний учир тэнд хоригдсон бүгдийг суллана гэхэд, хотын яамны гишүүд дуулаачгүй болж, яамандаа ороод хаалгаа түгжтэл, олон амьтан дайран ороод, хотын яамны хуувийн түшмэдийг давхарлаг өндөр байшингийн цонхоор доош нь хаяцгааж, дор байсан улс нь тэднийг жад мэсийн үзүүрээр тосон авч, хотын яамны бүх хуувийн түшмэлийг алан хяджээ гэж ванд айлтгасанд, вангийн нүд бүлгийн, царай үнсэн хөх болоод, хорсон уурласандаа үг хэлж чадахгүй, хоолой нь хяхраад, арслан хүрхрэх адил нэг их муухай дуу гараад, үхэтхийн ойчиж амьсгал нь төдхөн тасарлаа.

Яг л өвгөн зурхайчийн айлдсан ёсоор, тэр богд Вийтийн сүмийн цамхгийн өмнө нь буюу чухамдаа хэлбэл, буулгаж дуусаагүй байсан үлдцийн нь талд байж насан эцэс болжээ. Тэгээд ван нас барсан тул, цамхгийг буулгах нь зогсоод³² барилгачин нь, тэр эвдэн буулгах ажилд мөдхөн цуцаад, нэг хэсгийг нь буулган эвдсэнээ дахин залган босгосон нь, үзтэл илэрхий байдаг.

Вацлав ван, нас бараад бас амар заяа үзүүлсэнгүй³³ нэлээд хэдэн жил болсон хойно, буянт эцгийнхээ яс тавьсан богд Вийтийн сүмд сая ясаа тавиулсан гэдэг. Вангийн авсны газар чиг чимээгүй болж дээр нь байгаа сүмд ч гэсэн, сүмийн хавь газар ч гэсэн хөл үймээнгүй нам гүм болж, алх лантууны тас няс хийх нь дуулдахгүй болж чулуучны сүх нь чулуу цавчин цохихоо байж, чулуу засдаг газар хүнгүй болоод, элс чулуу ачсан тэрэгний чимээ ч гарахгүй болж, сүмийн барилгад ажиллах хүний дээр дороос дуу авалцах нь дуулдахаа байгаад, Карл вангийн эхэлж суурийг нь тавиад, хүү Вацлав вангийн үргэлжлүүлсэн тэр сайхан сүмийн барилга нь зогсож, олон он хойш тавигджээ.

Аррасын Матээ, Петр Парлеш, түүний хүү уран Яны үргэлжлэн барьж байсан богд Вийтийн сүм бүтэн нэг зуун жил дутуу хэвээрээ хоцорсонд олон амьтан, тэр сайхан сүмийг арай ч тэгээд байлгахгүй, эрхбиш нэг гүйцээж, дөрөвдүгээр Карл Вангийн хүссэн байдалд нь хүргэх нэг цаг байх бий. Чадамгай сайн хүн төр барьж, богд Вийтийн их сүмийн үйлтгэл гүйцээд, Европоос түүргийг үүрд үлдэн зайлуулж, Хаан балгасыг байлдан олж аваад, Хутагтай Софийн сүмд христосын хурал номыг дахин сэргээх болно гэж хэлэлцэн боддог байжээ.³⁴

Ром чехийн ван нэгдүгээр Леополд тэр хуучин домог үг сонсоод, түүргийг Европоос үлдэн зайлуулах асан гэж өдрийн бодол, шөнийн зүүд болсон хүн тул, тэр домгийн бэлгэ дэмбэрэл гүйцэлдэг гэж, Карл

вангийн босгож байсан тэр сүмийг гүйцээх гэж оролдоод, хамаг бэлтгэлийг нь хийж байтал Түүргийн цэрэг Унгар улсыг халдан идэж Леополд хаан, тэдний халдахаас эмээгээд, богд Вийтийн сүмийн үйлтгэлд зориулсан мөнгө хөрөнгөө цэргийн зардалд цутгасан учир богд Вийтийн сүм дуусгаж чадсангүй, Түүрэг ч Европт үлдсэн гэдэг.

IV. ХУУЧИН ХОТЫН ОР ЛОЙ ЦАГ

Хуучин хотын яаманд газрын эзэн тайж нар хуралдаагүй олон хотын төлөөлөгч ч хуралдаагүй, олон нийтийн хурал чуулган ч болоогүй, ямар нэгэн хэрэг таслан шүүх явдал ч тохиолдоогүй атал, хотын амьтан тэр хотын хуувийн яамнаа үүрээс эхлэн өдөржин цуваад, нэг хүрч ирсэн хүн, ер явахгүй, олон дунд чихцэлдэн, түлхэлдэн зарим нь бүтэн цаг, зарим нь бүр ч удаж, хүн амьтан цөмөөрөө хотын яамны цамхгийг гайхан сонирхоцгоож шинэ орлой цаг бий боллоо гэж шагшин хэлэлцэх ажээ. Тэр сонин цагийг Прагын хороо бүхэнд хэлэлцэн вангийн орд хавьд ч гайхалцан ноёдын өрөөгөөр ч амьтан тэр орлой цаг гэдгийг л ярьцгаан, айл гэр гуанз дэн, гудамж зээл, хааяагүй түүнийг сонирхож, тэр Хуучин хотын шинэ орлой цаг болбол, бүх дэлхийд хосгүй сонин гайхамшигт цаг юм гэж шаагин хэлэлцэж гэнэ.



Хотын ард, урчуул, хөгшин залуу эмс охид нөмрөгтэй оюутан бүгдээрээ тэр хотын яамны цамхгийн өмнө овооролдон, өөдөө өлийж, өлмий дээрээ өндийж бүлтийглээ гөлрөн харах нь ганц тэр орлой гэдэг цагийн хорин дөрвөн цаг хувааж, алтан зураас хүрээ, тоо, сонин гайхалтай тэмдэг дүрс дүүрсэн том толийг нь сонирхож, тэр толины доорх бөмбөгөр самбарт арван хоёр орд зурсан байдал, давтмал навчин хүрэнээ хоёр талд нь босоо хөрөг урлан бүтээснийг нүд хужирлан харж, ялангуяа хохимойн дүрс, бас бус зүйлийн сонин түүрэг хүний дүрс, уут дүүрэн мөнгө зоостой ховдог хариг хүний дүрсийг шохоорон, тэр цугласан олон амьтан дуу шуу болж, их хөлтэй чимээтэй байлаа. Тэгж байтлаа, орлой цагаас хонх цохих дуу гармагц, олон бүгдээрээ дуу чимээгээ ганц мөсөн дарж, хааяа нэг гайхсан хүн энд тэнд ганц нэг дуу алдаж, өнөөх эрлэгийн элч хохимой нь үүний наслах насны нэг цаг өнгөрлөө гэж хонх чадамгай цохиж байхыг улс амьтан гараараа энд тэндээс гайхан зааж, байтал гэнэт бүр ч бүгдийн гайхах сонин юм үзэгдэж, орлой цагийн дээр хоёр бяцхан гэгээвч шиг юм нээгдэж, христосын ёсны арван хоёр батад агч Найдан жүдэг Ставира нар баруун талаас зүүн тийшээ цувран явж Найдан жүдэг бүр нь харж байгаа олны зүг нэг эргээд цаашаа ороход нь хамгийн сүүлээр Христос адисалсаар гарч иржээ.³⁵ Түүнийг үзээд, зарим хүн малгайгаа авч ёслол, зарим хүн залбирч, зарим нэг нь эрлэгийн элч хохимойн эрүүгээ унжуулан амаа ангайхыг нь гайхан зааж, зарим нь, тэр эд мөнгөнд шунаг ховдог Юуда, гэгчийг толгойгоо хэрхэн сэргэсэн, эрлэг хохимойг цаг цохиж, амьсгалын тоо харагдаж байгааг заахад нь тун ч дурамжхан байдалтай байгааг харан сонирхож байлаа. Тэгж байтал, тэр хохимой дээр, цонхны дээд талд эр тахиа донгодоод орхисонд улс амьтан хөхрөлдөн шуугилдаж, олны гайхан хэлэлцэх дуу чимээ ер тасрахгүй үргэлжиллээ. Хүн бүхэн, тэр цагийг маш сайхнаар бүтээсэн уран Ханзшийг шагшин магтаж, ийм авьяастай тийм уран чадалтай хүн бас байх гэж сонин сайхан юм аа ингэж урлаж бас болдог юм аа гэж бишрэн магтаж хэлэлцэх ажээ.

Бараан жанч, дүрэмт хувцаст багш догмор эрдэмтэн, олны түрүүнд зогсож орлой цаг харж байсан нь бас л тэр цаг хийсэн хүнийг магтан хэлэлцэж, байдаг ихэмсэг шалхгар тарган, зарим нь тув туранхай цөм латин чех хэлээр хэлэлцэн, орлой цагийн хүрээ, дүрс тэмдгийн нарийн учрыг хэлэлцнэм билээ. Эр тахиа, хүний дүрс, эрлэгийн дүрс, Найдан жүдгийн дүрийг хараад инээцгээж, нэг нь тэр

эрлэгийг түгшүүрийн хонх цохиж, түргэл түргэл гэсэн дүрэм үзүүлж, эр тахиа донгодоход олон оюутан, дэд эрдэмтэнд энэ элдэв шалдав юм хум нь эгэл олныг гайхуулах гэж хийсэн юм даа гэж тоомсоргүй дуугарчээ.

Тэгээд цааш нь тайлбарлахдаа тэр орлой цаг бол, эрдэмтэн хүнд ялангуяа одон судлагч нарт тэр элдэв шалдав чимэггүй сонирхолтой болж байгаа нь нар, арван хоёр орд дамжин, өрнөөс дорнын зүг тэр цаг дээр үзэгдэхдээ, жил бүр, өдөр бүр ямар ордонд байж, хэдэн цагт хаа нар гарч хэдэн цагт үдийн наран хаа байдаг, зүүнээ тэнгэрийн хормойгоос аль хэр дээгүүр гарч үдийн шугамд аль зэрэг ойр, баруунаа аль хэр хэлбийж, тэнгэрийн хормой доогуур яахин шургалан шөнө яаж газар доогуур яваад, биднээс холдон явах замдаа, өвлийн цаг наран яаж холдож, зун болохын үес бидний зүг яаж ойртон ирдгийг заан үзүүлдэг нь соньхон байна гэж ярьж байтлаа тэр номч багш дуугаа хурааж Хуучин хотын хуувийн яамнаас хуувийн түшмэд, дээлтэй берет малгайтай шовгор малгайтай гарч ирцгээн, орлой цагийн зүг алхахад нь цөм зам тавьж, харц олон, эрдэмтэн багш нар зэрэг мяндагтан, оюутан, цөм тэдний зүг харцгааж, ялангуяа бичгийн эрдэмтний бараан хувцастай нэгэн хижээлхэн насны хүнийг сүрхий сонирхон харцгаалаа. Тэр хүн, үс бараан, царай ихэмсэг цайвгар бөгөөд, хотын сайдын хамт зэрэгцэн явнам бүлгээ.

Амьтан шуугилдан үймэлдэж, гайхамшигтай шинэ орлой цаг бүтээсэн Хануш багш гэдэг хүн тэр явж байна гэж өнөөх хүнийг харах асан гэж чихцэлдэн үймж өлөлзөн түлхэлджээ.

Хүн бүхэн түүнийг найрсаг сайхнаар ёсолсонд олон багш нар мөн нэгэн адил ёсолцгоож, тэр хүн байдал маш төв даруу, хариу тал өгч, хотын сайд, олон хуувийн түшмэдийн хамт, орлой цагийн тушаа очиж эгнэн зогссонд, тэдний асуун хүссэн ёсоор, цагийн нарийн учир, элдэв хүрээ, ордын утга ухааныг заан тайлбарлаж, одон, наран сарны явдлыг хэрхэн орлой цаг зааж, сарны шинэтгэл, тэргэл, хуучдыг яаж үзүүлдэг учир, мөн арван хоёр ордын зургаа нь газрын дээр үзэгдэн, зургаа нь дор нь үл үзэгдэх учрыг тайлбарлаад, орлой цаг бүтэн жилийн дотор тэмдэглэвээс зохих дүйцэн өдрийг цөм заан үзүүлдэг, арван хоёр сарын тоо бүрэн алтан үсгээр тоог нь заасан учрыг тайлбарлан хэлэхэд, орчин тойрны олон хүн чимээгээ намдан сонсож, олон багш нар, сүрхий номчийн дүрэм үзүүлэн, толгойгоо байн байн, дохин дохин чагнаж байлаа.

Чингээд, Хануш багшийн ярьж гүйцэхэд олон бүгд шагшин магтжээ. Хануш багш түүнд огт ажиггүй, ахмад сайд түшмэдийг, цамхаг өөд гарч, мөдхөн цаг цохино, тэгэхэд ямар ямар, хүрд эргэж, яаж цаг явж байгааг сонирхон толилмуу гэж, дотогш дагуулан, оруулбаас гайхамшигтай сонин урлан бүтээсэн орлой цагийн доторх хүрд, бяцхан араа, тэгнүүр тэргүүтнийг хараад хүний ухаанд ийм нарийн юм яаж багтдаг юм бэ? Энэ бүгдийг ухаандаа зохион тогтоож, хүрд араа бүрийн шүд нь тийм үүрэг гүйцэтгэнэ гэж яаж ухаалан оноож болдог юм бэ? гэж үзэх тусмаа улам гайхаж, нэн ялангуяа Хануш багшийн тэр орлой цагийн оньс нь, дөрвөн ангиар бүтсэн юм. Дөрвөн анги нь тус тус биеэ даасан үүрэг бүхий оньс, жин, хүрд бүхий гэж тайлбарлахад бүр ч гайхаж бүгдээрээ хамгийн нийлбэртэй бэрх нарийн гол дөрөвдүгээр ангийг нь сонирхож, түүний гол хуанлийн хүрд гэдгийг үзвэл, гурван зуун жаран таван араатай, жилд нэг бүтэн эргэж хоногийн нэг араа эргэдэг тийм хүрд байжээ. Тэр нарийн хэцүү оньс, ухаан оюун төгөлдөр мэт, огт саадгүй сайхан ажиллаж, эрдэмтэн багшийн нарийн ухаан бодлоор бүтсэн тул, гагцхүү Хануш багш л тэр орлой цагийн оньсого учир утгыг бүрэн мэдээд, өөр хэн ч үл мэдэх ажээ.

Хотын хуувийн түшмэлийн нэг нь өөрөө цагчин хүн тул, Ян цагчин гэдэг хүн бөгөөд, тэр орлой цагийн байдлыг үзэхдээ, ер учир ухааныг нь олохгүй юм байна. Энэ нарийн цаг бүтээхдээ тэнгэрээс хувьтай билгүүн нүдтэй хүн бүтээхээс биш жирийн цагч хүн ийм цаг зохиох хөдөлгөх байтугай, ажиллуулна гэхэд ч ухаан санаа солиормоор юм байна гэж хэлжээ.

Тэгэхэд нь Карлын сургуулийн багш, Итали Франц улсаар явахдаа алдартай их орлой цаг үзсэн, ийм орлой цаг л хаа ч үзээгүй гэж хэлээд, дэлхийн аль ч өнцөгт ер энэ тун гайхамшигтай орлой цагийг гүйцэх цаг байж болно гэгчийг би дуулаагүй, Хануш багш л дахиад нэг ийм орлой цаг өөр газар хийж өгөөгүй бол өөр газар байна ч гэж би бодохгүй гэхэд нь хотын дарга гайхаж, ахмад настан өөд харахад нь, тэд нь нэгэн зэрэг өөдөөс нь харж, арай тэгээгүй биз дээ гэсэн юм шиг сочисхийж, Хануш багшийн зүг харваас, уран Хануш инээмсэглэж, ийм түмэн төвөгтэй нарийн ажил хийж гүйцээсэндээ баярлаж, Эзэн Тэнгэрийн ачид залбирч байна гэлээ.

Гэтэл хотын дарга, өнөөх сонин цагийг үзэх гэж айван тайван орж ирсэн хүн, тэндээс гарахдаа сэтгэлд нь сэв орж, бас зарим ахмад ч

хотын даргаа нэгэн адил, дотроо уран Хануш багш, өөр нэгэн газар ийм орлой цаг хийж өгөөд, ондоо ямар нэгэн хот бас ийм гайхамшигт юмтай болуузай гэж зовсхийжээ.

Чех улсын нутаг даяар Прагын орлой цагийг хэлэлцэж, харийн газар ч гайхан хэлэлцлээ. Тэгээд Прагад ирсэн хүн болгон, өнөөх орлойг юуны өмнө үзэх асан гэж шамдаж, үзсэн хүн бүр нутаг усандаа түүнийг гайхан магтаж явдаг болж гэнэ.

Чингээд гадаад дотоодын олон хотоос элч ирцгээж, Хануш багшийг бидэнд бас ийм цаг урлан бүтээж өгнө үү? гэж гуйдаг боллоо. Тэр чимээ сонсоод Прагын дарга, хуучин хотын яамны зөвлөх түшмэд сандарч, дэлхий даяарт ганц Прага маань ийм хосгүй цагтай байвал зохих юм асан гэж нууцаар хуралдан, яадаг ийдэг билээ? Хануш маань хүний үгэнд орж алт мөнгөнд нь автагдаж, үгэнд нь орвол яана даа? Бас нэг орлой хийж байгаа бололтой. Манай орлой цагаас лав илүү сайхан юм хийх гэж байгаа шинжтэй, ажлынхаа газар нэг юм оролдоод л байна. Нэг л арга хэрэглэх цаг болж гэж муухай хэрэг сэджээ.

Уран Хануш, ажилладаг байшиндаа том ширээний ард сууж, алд цаас дэлгэн, ямар нэгэн нарийн орлой цагийн зураг зохиож байв гэнэ. Ширээ дээрээ хоёр лаа бариад, цонхоо хаагаад, зуухандаа гал түлж, суух үед, гадаа шөнө болж, гудамжинд харанхуй бөгөөд, хүн амьтангүй гэрт нь чимээ аниргүй байжээ.

Тэр уран хүн ажилдаа хамаг санаа хүчээ гаргаж, гаднаас шатаар хүн айсуйн чимээ огт анзаарсангүй. Ажиггүй сууж байтал нь, хаалга гэнэт онгойж, нүүр амаа битүүлсэн, нөмрөг нөмөрсөн гурван хүн орж ирсэнд сочиж, юун улс, яах гэж ирэв гэж асуухын завдалгүй, тэр гурван хүний хоёр нь Ханушийг барьж аваад, нэг нь лааг нь унтраагаад, амыг нь боож, зуухны тэнд чирч аваачсанд, гэрийн хүн дээд давхарт нь Хануш багшийн тэр өрөөнд тийм хэрэг гарч байгааг огт мэдсэнгүй зүсээ буруулсан гурван хүн гаднаас хаалганы түгжээ нээж, хоромхон зуур байшинд харанхуйгаар сэмхэн орсныг ер мэдсэнгүй.

Өглөө эрт сая тэр шөнийн муухай явдлыг мэдэж, Хануш багшийг ор дээрээ ухаангүй хэвтэж байсныг нь олж үзвэл, нүд нь боолттой байв. Айл хөршийн хүн, Ханушаас учрыг нь асууж, шөнө нүүр амаа битүүлж, зүс царайгаа буруулсан хүн дайрч ороод, нүдийг нь сохолсныг хирдхийн сочиж сонсов. Хануш нүдээ сохлуулаад, ухаан

алдаж унасанд, тэр дайрсан улс нүдийг нь боогоод явчихсаныг мэдсэнгүй байжээ.

Тар муухай явдлыг сонсоод Прагынхан бүгдээрээ их л сочиж, ямар муу хортон хүн тэгсэн юм бол олох юм асан гэж хичээвч, ер ор сураг гарсангүй. Тэгээд, Хануш багш, ухаан орж, баахан бие гайгүй болохдоо, тэр муу харгис хүнийг эрж сураглахын хэрэггүй, ойр боловч олдохгүй гэж хэлсэн гэнэ гэж улс амьтан шивнэн хэлэлцдэг боллоо.

Хануш багш цааш нь хэлбэл хэлэх юм байсан боловч, хэлсэнгүй, тор дотроо дуугүй суудаг сохор бялзуухай шиг, урьд тун их ажил хийж байсан байшингийнхаа ёроолд чив чимээгүй уйтгарлан суудаг болжээ. Багаж хэрэгсэл нь эзэнгүйдэж, хөрөө хуурай зэрэг тоног нь дэмий л өлгөөстэй орхигдоод ном судар, зурж байсан зураг юм нь тоосонд дарагдан хэвтэх боллоо. Хоёр нүд нь ширгээд, юу ч харахгүй, битүү хар юм дотор сууж байсантай адил болоод, юу ч хийж чадахаа байж, сэтгэл зовон бие нь чилж муудах боллоо.

Сайхан юм бүтээж өгсний хариуд муухайгаар хариулсныг санах бүр дотор нь аягүй болж,

— За дахиад ийм орлой цаг хийх чинь өнгөрлөө! гэж тэр аюултай шөнө өнөөх зүс буруулсан улсын нэг нь хэлсэн үг хангинан дуулдаж байх шиг, гайхалтай юм хийж өгсний шан тэр боллоо гэж бодох бүр дотор аягүй болж, зовлого бие нь улам мууддаг боллоо. Чингээд наслахгүй болсноо мэдэнгүүт нэг шавиараа хөтлүүлэн үлдсэн чадал хүчээ гаргаж, Хуучин хотын яамны зүг очиход нь, өнөөх орлой цагны цохихыг хүлээж өчнөөн төчнөөн амьтан овооролдон цуглаад алдарт тэр уран багшийг дэргэдүүр нь өнгөрөхөд нэг ч хүн таньсангүй. Бие нь хүн танихын аргагүй туржээ. Мах мариа нь шуурч, нүүр нь шарлаж хацар нь хонхойгоод үс нь бууралтжээ. Хотын яамны тэнд хэдэн хуувийн түшмэл дайралдавч, зайлаад өгч, хотын яаманд Хануш урныг хэн ч амар мэндийг нь асуусангүй, Түрүүнд нь, орлойгоо очиж үзнэ, шинэ юм нэмж, засаад улам сайн явуулах болгоно гэхэд нь, дуртай дургүй сонссон байж гэнэ.

Чингээд, тэр орлойн хамгийн төвөгтэй нарийн дөрөвдүгээр хэсэгт нь намайг оруулж өг гэж тэнд нь очоод нүд харахгүй тул, нэг олон том бага хүрд баадуу пүрш, хөшүүр байна гэж мэдэхээс өөр юмгүй, чагнаад үзэхэд хөдөлж, сайн явж байгаа чимээ нь дуулдаж ажиллаж байгаа нь дуулдаж байлаа.

Нүд балай, бие өвчтэй үс нь сэтгэлийн зовлонгоос болж
бууралтсан уран багш, тэр бүтээсэн цагийнхаа өмнө гуньхран зогсоод,
чимээг нь чагнаж байхдаа хотын яам хуувийн түшмэдийг бодож,
дэлхий дэх олны өмнө цагаа гайхуулах гэж бүтээсэн хүний нүдийг нь
сохлоод, өвчин эрүү тулгаж тамлахаас буцахгүй өөрөөс нь ч зовохгүй
байсныг тунин санаж зогстол, цагийн хонх цохиж, гадаа орлой цагийн
хохимой хөдөлж, өнгөрч байгаа цагийг мэдэгдэн, хонх хангинуулам
цохиж, эрлэг цаг нөгчиж байгааг сануулан, батад агч Найдан жүдэг
нар гарч ирэв гэнэ.



Уран Ханушийн хамаг бие нь чичрээд, баруун гараа сунгаж цагийн оньсны дээр хоромхон зуур өрсөөд байснаа, хамаг юмыг нь тод харах болсон мэт, сарвайгаад, хатангир хуруугаараа нэг юм эргүүлээд орхих шиг болж гараа сугалаад авахад нь оньсны олон хүрд харчигнаад, нэг юм гэмтээсэн шинжтэй тар няр хийж, том бага хүрд нь хий эргэлдэж, их чимээ дуу шуу гарч, хангинаж жингэнээд эрлэг хохимой нь харангаа цохиж цохиж нэгмөсөн чимээгүй болж, хонх ч дуугарахаа байж, хүрд баадуу, хөшүүр хөдлөхөө зогсоод, задарч явсан батад агч нар зам зуур зогтусаад, тахиа ч донгоддог нь байчихжээ.

Орлой цагийг гаднаас харж байсан улс гайхан шуугилдаж, хотын яамнаас хүн сандан мэндэн цагийн цамхгийн зүг гүйлдэж яаран орж үзвээс, цаг хэдийн зогсоод, бүтээсэн эзэн нь царай үнсэн хөх болоод, ухаан алдаад газар хэвтэж байв. Гэрт нь арай чарай хүргэтэл амьсгал нь тасарчээ.

Орлой цаг нь зогсоод, тэр их уран хүний бүтээсэн оньсны учрыг олж засах хүн ер олдсонгүй.

V. ЯМААНХОРЫН ДАЛИБ ОРЫН ДОМОГ

Богд Вацлавын шилтгээн гэдэг Прагын вангийн шилтгээнд чимээгүй гунигтай байж гэнэ. Хүсынхны дайны хөлд шилтгээний хавийнхан баларч, богд Вийтийн сүм эвдэрч, дөрөвдүгээр Карл вангийн гоо сайхан чимсэн өрөө тасалгаа нь эзэнгүйдэн муудсаар, хааяа л ванг хуучин хотод суудаг ордноосоо хүрч ирэхэд түр сэргэдэг байлаа.

Ван түр ирээд, удалгүй буцдаг байж, залуу Ладислав Похробек ч гэсэн түүнийг залгамжилсан алдарт Ирши ван гэдэг буянтай дурсгалт ваньэ цөм хотдоо суудаг байжээ. Иршийн сүүлээр Ягеллоны хоёрдугаар Владислав ч анхны хэдэн жилдээ тийм байгаад, сүүлээр нь их өөрчлөлт болжээ.

Арван хоёр жил төр бариад, суурин газраа өөрчилж, хуучин хотын орд харшдаа сайхан чимсэн цамхаг босготол, ³⁶тэр суурин газар аминд аюултай гэж бодоод, шилтгээнд чех вангийн хэдийн суудаг газар эргэж зүүгээд, муудаж доройтсон бүгдийг сэлбэн засуулахад нь Лоуны Бенеш уран, гайхалтай сайхан танхим босгосон нь Владиславын танхим гэдэг нэртэй болж, бас богд Вийтийн сүмд тахилын их газрын баруун талд

вангийн мөргөлийн газар гэж уран чулууны сайхан чимэгт төгөлдөр газар байгуулж билээ.

Ван бас, сүмийн цулгүй туургыг ялангуяа богд Вацлавын мөргөлийн газар чимэглүүлж гоёод, вангийн шилтгээний өрөө тасалгаа нь туурганы наамал чимэг, зураг гоёлоор өнгө орж нэг тасалгаанд нь чех ноёд вангийн зураг өлгөөтэй байж билээ.

Ван, шилтгээнийг чимэхээс гадна бас бат бэх болгохыг санаа тавьж, хэрмийг бөхлөн засуулаад, хүрдэлсэн гууг гүн болгож, шороон даланг өндөрлөх газар өндөрлөөд Михүлцийн цамхгийг өндөр оройтой болгож, паалантай ваараар дээвэрлэж, орой дээр нь мөнгөлсөн арслан гялалзуулан босгожээ.

Дараа нь удалгүй Владислав ван, хэрмийн ар хаалгад ойролцоо, шилтгээний даргын байшингийн ард шинэ дугариг нэг цамхаг Бутын гууны захад хэрэм хамгаалах гэж, цаг самууны учир, босгуулжээ. Дотор нь бас гурван давхар гяндан хийсэн нь, хамгийн доод талын гяндан газар дор үүрд цонхгүй байгуулж, хорих хүнийг тэр гяндан дундах гяндангийн шал дахь нүхээр олс татуулан буулгаж оруулахаар хийжээ.

Цамхаг босгоод, дээд хөнгөн ялтны гяндан, доод хоёр хүнд ялтны гянданд ч оруулах хүн үгүй байв. Тэр цагт цамхагт нэр өгөхдөө доторх гяндангийн босгыг нь анх давсан хоригдлын нэрээр нэрлэдэг заншилтай байсан цаг ажээ. Тэр шинэ цамхаг, нэр үгүй нэг их удсангүй.

Хөдөөгийн ард олныг их л дарлаж байсан цаг байж, эзэд ноёд урьд дуулдаагүй их алба гувчуураар хяхаж, тэр бэрх албыг зарим газар залгуулах хүч хөрөнгө хүрэхгүй болоод гацаа суурин хүнгүй болж, амьтан ой хөвчөөр оргон тархаж, өөр газар амь зуух арга эрэх хулгай дээрэм хийх болж, зарим нь ноёдынхоо эсрэг хөдөлжээ.

Литомершицийн нутагт Драхоницын Плошковски Адам гэдэг Ноён албат хамжлагаа маш харгисалж шударгагүй алба оноох зэргээр нэн их зовоох болсонд, ардууд нь гар хөдөлж ноёныхоо батлан суусан газар дайран халдаад, гууг нь тулалдан давж, хэрмийн хаалга эвдэж, харгис ноёны эсэргүүцэн байлдахад шархтуулж олзлоод авсанд, тэр ноён, амиа аргалахын эрхээр аясыг нь дагаад, албат хамжлагаа сулдан тавьж, дураар нь болголоо. Тэднийг дарлан зовоож, Зарга заалхай хийхгүй гэж ам тангаргаа өгч, батлах бичиг өгч салсан байжээ.

Плошковски ноёны нутагтай зах нийлсэн Ямаанхорын Далибор тайж гэж, эртний сурвалжит гэрийн нэг эр байжээ. Түүний дээд өвөг нь Янвантай хамт Крешчакийн тэнд цэрэгт явж баатарлан байлдаад, тэр вангийн хамт тэнд амь үрэгдсэн хүн байжээ. Түүний угсааны Далибор тайжид өнөөх Плошковскийн Адам ноёны сул болсон ардууд хүрч ирэн, бид Далибор танай албат болохыг хүснэ. Шударга ноён гэж биширч, дуртай дагаж орно гэж гуйжээ.

Плошковскийн тэр албат нь, Ямаанхор нутагтай тэр Далибор тайж өөрийн албатад өршөөлтэйгөөр үл барам, бусад харгис ноёдоос амь зулбаж гарсан ядуусыг багтаан оршуулж, тэтгэн тэнхрүүлснийг андахгүй байлаа.

Далибор тайж, тэдний гуйж ирэхэд цааргалалгүй хүлээж аваад хуучин ноёноосоо зөвшөөрөл бичигтэй гэж сонсонгуут албатныхаа хүн амын дансанд оруулж гэнэ. Тэгтэл өнөөх хуучин ноён нь, амь зулбаж гармагц, алдсан албат хөрөнгөө нэхэж, дээд засаг ноёдын газар заргалдсанд, нутаг орны эрх баригчид, Далиборыг хүчиндээ эрдэж, бусдын албатыг авлаа, Плошков ноёны албат нь ноёндоо халдаж тэрсэллээ гэж үзээд, Литомершиц хязгаарын цэрэг дайчилж, тэр газрын олон тайжийн захирсан цэрэг эр, литомершицийн хот суурин газрын эрчүүлийг татаж өнөөх тэрслэн урвалаа гэсэн тариачин ардыг дайран орж, их олон хүнийг алаад, барьж олзолсон хүнээ хатуу цээрлэл үзүүллээ. Бас тэдэнтэй санаа нийлсэн Далибор тайжийг барьж авсан тул, хяхагдан дарлуулсан хүн ардыг хамгаалдаг залуу эр гав гинж зууж, Прага хүргэгдээд, Бугын гууны дэргэдэх шилтгээний даргын шинэ дугариг шилтгээний гянданд оржээ.

Далибор, тэр гяндангийн босго анх алхаж орсноор цамхгийг Далиборын цамхаг гэж нэр өгсөнд, шилтгээнийхэн, бүх Прагынхан, залуу тайжийг амнаас ховхлохгүй хэлэлцэж, шинэ цамхагт анх хоригдсон хүн гэж нэгд хэлэлцэв. Хоёрт бас гянданд орсон учрыг нь харамсан хэлэлцэв. Мангуу ноёд баярлаж, хоригдох нь түмэн зүй гэж байхад, ардууд Далиборыг хөөрхийлдөг байв гэнэ.

Далибор гянданд их л сэтгэл чилж зовж, зузаан хэрэмтэй, бяцхан цонхтой, зууван адартай гянданг эзлэн суух болжээ. Гэртээ баталсан орон сууцаасаа уудам сайхан нутгаа харж суудаг хүн, гянданд ороод, тэнгэрийн нэг зурвас харж, доошоо өнгийхөд нь өвс ургасан гүн гуунаас өөр юм харагдахгүй. Тэр гууны өвс навч нь шарлаж, уйтгартай намрын шинж оржээ.

Цамхагт чимээ аниргүй, орчин тойронд нь нам гүм. Шувуу бялзуухай жиргэн донгодох нь дуулдахгүй болж, салхи л шуугинан, шугуй мод ганхуулнам бөгөөд навч унаж, гүн гуунд өглөө оройн бүрэнхийд манан чийг татаж, бороо намирна, нүцгэн болсон модны оройг хурын усан цохих ажам. Богино болсон өдөр, гянданд маш урт мэт санагдаж урт шөнө эцэс хязгааргүй мэт бодогдон, залуу тайж уйтгар гунигт дарагджээ.

Тэгээд, хоол нийлүүлэхэд зарж байсан зоосоороо хуур хийлгэж³⁷ хуяг нь тэр хуур авчирч өгөхөд, урьд нь хуурын хэл барьж үзээгүй хүн, хуурдаж оролдох боллоо. Хуурд хуурдсаар сурч, цаг өнгөрөх нь амархан мэт болоод хуурдах тусмаа улам сайжран сурч, сүрхий хуурч боллоо. Гяндангийн дарга хуяг нь, Далиборыг хуурдахад хаалганы гадаа очиж чагнадаг болж, тэг тэгсээр шилтгээний ноёд тушаалтан хүртэл ирж, хуурдахыг нь чагнадаг боллоо. Хотынхон мэдээд, өндөр газар босгосон шилтгээнээ хүрэлцэн ирж, ялангуяа үнэмшдэггүй хүн зориуд ирэх боллоо. Шилтгээний орон хэрэмд, хоёр замын хооронд богд Вацлавын усан үзмийн тариалан байдаг тэр газар өдөр ирэх тусам амьтан улам ихээр цуглаж, Далиборын хуурдахыг хүлээдэг боллоо.

Тэр бол хавар тийшээ, үдийн найрт салхи хөдөлж, модны орой мөчир гөлөглөж, цэцэг навч дэлгэрч, Петшин болон хавь орчмын өндөр газар цөм навч намаа хөхрөн гарч, Бугын гууг ч хөх ногоо бүрхээд, шувуу донгодох нь юутай сайхан байв. Гэвч, шувууны донгодохоос тэр дугариг цамхгийн хуурын аялгуу илүү сайхан байсан тул, хүн бүхэн тэр хөндий бэрх гяндан дотроос тийм уяралтай сайхан хуурын дуу гарах гэж юутай вэ? гэж гайхан чагнацгаах тусам сэтгэл улам улам уярсгаажээ. Гунил зовлонгийн ая хангинан байснаа, өнгө нь өөрчлөгдөж, шастир дууны аялгуу болж, хүлцэнгүй номхон горьдол эгээрэл, зовлонд автагдсан сэтгэлийн хүсэл эрмэлзэл тэр аялгуунаа тодрон заримдаа төрийн дуу, янаг амрагийн ая, дайчин аялгуу хангинан дуурьсах ажээ.

Далибор бас Ян ван, залуу Кимберк Жеротины Плихт, Страконицын Баворын зэрэг өнөөх Кресчакийн дайнд вантайгаа Далиборын элэнц өвгийн адил амь үрэгдсэн чех ноёд тайж нарын хуучин дуу үе үе хуурддаг байжээ.



Прагынхан цамхгийн тэнд овооролдоод тэр хуурдахыг нь чагнаж байдаг бөгөөд харахад нь гяндангийн онигор цонхоор бүдүүн муу даавуун уут олсоор доошоо унжуулан буулгасан байв. Тэгэхэд нь зоос мөнгө биедээ юу л бэлэн байснаа өгцгөөжээ. Урьд нь хүн тэр Далибор тайжийг өөрийнхөө мөнгөөр хоол олж иддэг чадалтай гэж бодож байснаа, тэр уутыг хараад мөнгө барагдаж зүдрэх цаг болсныг мэдэцгээж, хотоор гуйж явахаасаа зовоод, гянданд хүн юм авчирч өгдөггүй, хамаг юмаа бараад, ганц, хууртайгаа л хоцорсон цаг байж л дээ.

Тэгээд хожим нь, хуурдаад, даавуун муу уутаа доош нь буулгах бүр дор цамхгийн ёроолд хуурдахыг нь чагнаж байсан хүн бүр мөнгө, элдэв юм өгч, өлсөх гачигдахгүй сууг гэж уутыг нь дүүргэдэг боллоо. Өр нимгэн бүсгүйчүүд, айл хөршийн хүн, дэрлэх дэр, унтахдаа хэрэглэх хувцас хучлага идэх идээ, хааяа лонх сархад хүртэл уутанд нь хийж өгдөг байлаа. Тэгэхэд нь ачийг нь хариулж, тэр олон хүнд үдээс хойш, бас үдэш орой хуурддаг болсонд, амьтан, амьсгаагаа даран чагнацгаагаад, тарахдаа, ер бүх Прагад ингэж сайхан хуурдах хүн байхгүй гэж гайхан магтах хүн байдаг байжээ. Гянданд хоригдож, зовлон эдэлсээр Далибор хуурч болж, өдөр нь олныг цэнгүүлж, шөнө нь өөрийнхөө уйтгар сэргээдэг болжээ.

Чингээд, вангийн шилтгээнд нам гүм болж, харанхуйд харлан үзэгдэж, үлгэрт гардаг буурал хөх сүүдэр шиг шөнийн тэнгэрийн зүг сүндэрлэн сарын цайвар гэрэлд Бугын гуу жалгын мод шугуй шуугинах чимээ намдаж ирэх үес, дугариг цамхгаас Далиборын хуурын сайхан эгшиг хангинах нь, уярах уянгатай, уурлах чимээтэй, эрх чөлөөгөө мөрөөдөх гунилтай бөгөөд, тэр хуурын ая нь, хуурчийн сэтгэлийг сэргээх авч, эрх чөлөөг олгож чадахгүй, тэнгэр өндөр, ван хол, олон ноёд өрөвдөхийг үл мэдэх хатуу сэтгэлтэй байжээ.

Ямаанхорын тайжийг гянданд удтал хорьж, шүүхээр хэргийг нь шүүгээд шийтгэсэн нь Далибор шударга бусаар булаан авсан газар өмчийг эзэгнэж тэр газар очиж байсан нь буруутай бөгөөд хууль ёсонд харштай болсон тул, тэр буруу муу явдлыг толгойн цаазаар цээрлүүлбэл зохино гэж тогтоод, тогтоолоо сонсгохдоо хэн уг хэргийг үүсгэж, хууль ёс зөрчин ард олны самууран хөдлөхөд хүргэсэн бэ? Далибор миний бие гагцхүү тэр дарлагдсан ардыг тэнхрүүлэн хамгаалсан билээ. Уг гэм хамаг буруу нь тэр дарлал үүсгэсэн хүнд бий

гэж учир байдлыг гаргахад нь огт хэрэгссэнгүй, тогтоолоо тулгаад, гагцхүү хэдийд цаазаар аваачих өдөр цагаа хэлж өгсөнгүй.

Тэр цаазаар авахын урьд шөнө нь Далиборын хуурын дуу сүүлчийн удаа дуулдаж, ханхай гяндангаас нам гүм шөнө харанхуй зовлонг нимгэрүүлэн саатуулдаг хуурын эгшиг нь сарны саруулд Бугын гууны тэнд чимээ нь тасарч байлаа. Тэгээд маргааш өглөө нь Прагынхан, өнөөх цамхгийн тэнд хүрээд ирвээс Далиборын гяндангийн цонхны тороос унждаг уут нь үзэгдсэнгүй. Цамхаг дотроос огт чимээ гарахгүй, эзгүй юм шиг байсанд, юу болж, яачхав гэж асуухад, гянданч нь, одоо тэр тань зовлонгоо барсан, үүрээр цаазаар авхуулсан шүү.

— Гяндангаас гаргахад нь, туурганд өлгөөтэй хуураа авч, хагацан салах ёс хийсэн юм шиг, харж, харж, өлгөж орхиод, цаазлах газар зоригтой очиж, толгой авах модны өмнө сөгдөөд, бужгар үстэй толгойгоороо тэр мод дэрлээд, үнэн чин зоригтой, христостон эр шиг нас нөгчсөн дөө гэж хэлж өгсөнд, тэр гянданчийн үг сонссон улс, нулимс унагааж, Далиборын цамхгаас гэр гэрийн зүг гунин буцацгаасан гэдэг.

Шилтгээний даргын байшингийн ард, хэрмийн арын хаалганы тэндэх тэр цамхаг одоо хүртэл, хөөрхий тэр тайж, гайхалтай хуурчийн дурсгалтай холбосон домогт ороод сүндэрлэж байдаг байна.

VI. ЖҮҮД ХОТООС

Жүүд хот болбол, Хуучин хотын нэг хэсэг нь байжээ. Зах нийлж, нэг хот болдог байсан боловч, Хуучин хотоос салгаатай, зургаан хэрэм Жүүд хотыг Хуучин хотоос салган тусгаарлаж, хэрмийн хаалгыг нь зовлон эдэлсэн гэдэг дүйцэн долоон хоногийн өдөр шөнө хаалттай байлгадаг байжээ. Тэр хаалганы дотоод дахь Жүүд хотын байдал шинж нь Хуучин хотынхоос тас ондоо, орон сууц нь өөр байдалтай, муухан барилгатай, үзэмж муутайхан бөгөөд, чулуугаар барьсан байшингаас модоор барьсан хуучин барилга арай илүүтэй, үзэгдээгүй хачин залгаа байшин, тагттай хуучирч харласан бяцхан хашаа хүрээтэй бөгөөд гудамж нь ч ондоо, нарийхан богинохон, ийш тийшээ мушгиралдан нугачсан, шавар шавхай болсон шалдаж чулуу модоор хулдаагүй. Явж байгаа амьтан нь дан жүүд гэдэг еврей хүн, зан байдал, аж төрөл нь шал өмнөө, өмссөн хувцас хунар нь ч этгээд. Нүдэнд өөр үзэгддэг шар

өнгөтэй жүүд шовоодой малгайтай, дээл дээрээ цэмбэн шар буюу улаан хүзүүвч зах зүүдэг заавартай улс ажээ.



Амьтанд дарлуулж, ганц Жүүд хот дотроо л суудаг улс бөгөөд. тэр хотоо үе улиран хэлэлцэхдээ, их зантай омог бардам Прага хотоос ч хуучин хот юм. Либүшийг Прагын шилтгээний суурь тавихаас өмнө дээдэс өвгөд маань, аль хэдийн энд оршин сууж байсан юм гэж хэлэлцдэг агаад, христосын шашинтай тэмцэл зарга заалхай хийхдээ босго дээр нь ариун родал гэдэг хөлгөн судраараа тангарагладаг байсан хуучин шинэ синагог гэдэг дуган сүм³⁸ нь богд Вийтийн сүм, Прага хотын бүх дуган сүмээс урьд байсан юм гэж их л хавархан хэлэлцдэг! байжээ.

Цаг самууныг ихэд үзсэн эрт дээр үеийнхэн хийсэн дурсгал болж, нарийхан олон гудамжны дунд ганцаараа сүрхий сүртэй сүндэрлэж, он удаад гандаж хүрэн болсон ваар дээвэр, өндөр гэгчийн туурга, нарийн цонхтой, он маш удсан зэвүүн хачин барилгатай тэр сүмийг хүн бүхэн нэн бишрэн үзэх ажээ.

Жүүдчүүд, тэр сүмийг Вормсын мөргөлийн сүмийг эс оролцуулбал жүүдийн хамгийн хуучин сүм даруй мөн, суурийг нь

тавихад эртний Орислимын³⁹ эвдэрсэн сүмийн чулуу тавилцсан юм. Тэр чулууг тэндхийн элч, нэн эрт цагт тэр арилагсан догшин орноос залан авчирч, тэр сүмийн суурин босох газар тавьсан юм. Тэгээд, прагын жүүдийн ахлах нарт тэнгэрийн элчис, тэр жүүд сүмийг уг ариун орноос залж авчирсан байдлаас нь өөрчлөлгүй, үүрд тэр л байр байдлаар нь байлгавал зохих юм гэж зарлигласан юм гэж жүүдчүүд итгэдэг байжээ.

Чингээд, хожим хойно тэр сүмийг сэлбэн өөрчлөх гэж оролдогсод, өөрчлөх гэж оролдсоноо гүйцээж чаддаггүй, дор нь гэсгээлт цээрлэл амсан эдэлдэг байжээ. Өөрчилнө гэж оролдож байтал, хөл үймээнд бут дайруулчихдаг буюу гэнэтийн үхлээр амиа алддаг байсан гэж хэлэлцдэг байжээ.

Тэр эртний сүмийг анх бий болгож босгосон тухай бас өөрөөр ярих хүн ч байж, анх тэр сүмийг модоор босгосон юм гэдэг. Хожим, хуучирч элэгдэхэд нь ахмад дээдэс, нэг бяцхан довцог толгой байсан газар шинэ сүм чулуугаар босгоно гэж газар шинжин сонгож, довцог толгойг ухаад гартал, чулуун суурь, лут том засмал чулуугаар босгосон хэрэм газар дороос гарч ирсэн. Цааш нь ухаад үзтэл, тун ч их эртний жүүд сүм байсан шинж тодорч, хэрэм туурга гарч ирсэн. Ухсаар байтал, бас эртний еврей үсгээр пергамен гэдэг бичгийн арьс дээр бичсэн ном гарч ирсэнд, гарцаагүй сүм байж гэж танин мэдсэн гэдэг.

Тэр үес Прагад Орислимын хоёр жүүд байсан нь, шашин нэгтэй Прагын жүүдийг сүм босгохдоо, Орислимын сүмийн үлгэрээр босгомуу. Зузаан хэрмийн цонхыг гаргахдаа, гадна талаасаа уудам, дотогшлох тусмаа нарийсах тийм байдалтайгаар гарга. Хөлгөн сударт, эзэн тэнгэр ээ, дороос дуудан залбирнам! гэж өгүүлсэн тул, сүмийг дотогш нь шатаар доошоо орох байдалтай болгож босго⁴⁰ гэсэн юм гэдэг. Чингээд, тэр ёсоор нь, босгож, уг сүмийг уран барилгач Лиренскийн бүтээл гэдэг бөгөөд, өөрчлөлгүй хэвээрээ байсаар байгаа юм гэдэг⁴¹ Тэр сүмд олон үеийн хүн мөргөж залбирсаар ирсэн хуучин сүм байжээ.

Өөр шашинтан хүн ч тэр сүмийн газар орж ирдэг байсан байна. Тэхдээ хар хүчээр түрэн орж ирээд, жүүдийн тахилын орон болсон тэр газрыг бузарладаг байжээ. Тэр сүмийн тамид гэдэг нэртэй мөнх зулыг нь хоёр удаа бөхөөсөн удаа бий. Алтан хатгамал эрдэнийн хөшиг порохес гэдгээр бүтээсэн Арон хакодэш гэдэг гүнгэрвааг нь христосын олон дайран орж сүйтгэсэн юм гэдэг.

Анх удаа Ян вангийн үед, жүүдчүүдийн сүмдээ нууж булсан эрдэнийг вангийн зарлигаар ухахад, алт мөнгөн хоёр мянга гаруй зоос ухаж гаргахдаа сүмийг сүйтгэсэн юм гэнэ билээ. Тэр вангийн үес тэр сүмд хүний цус нөж ч урсгаж, тэр вангийн ач Дөрөвдүгээр Вацлав вангийн үед бас тийм хэрэг гарсан гэдэг. Чингэхэд, (1389 онд) их шөнийн дүйцэн өдрийн үес найман талтай хоёр баганат тэр сүмийн дотор дайруулан алуулж байгаа жүүдийн ёолон гасалж, амь тавин бархирах дуу шуу хангинаж, хядуулж байгаа тэдний цус нь сүмийн хана туурга өөд харван тусч, шүтээн номын үсэгт нь үсрэн туссан билээ.

Жүүд хотынхон, хожим хойно болтол, тэр шөнийн айхавтар аюултай муухай явдлыг айн эмээн дурдаж, тэр бэрх цагийн тухайд хилэнцээ наманчлан тэнгэр шүтээндээ амь даатган залбирах селиха гэдэг наманчлал уншин мөргөж, хүлцэл номхотголын өдөр уншдаг байжээ. Христосын шашинтны тэр дайран орж хядахыг өөрөө ч мэдэх Авигдор Каро гэдэг жүүд лам, тэр наманчлал залбирлыг зохиосон юм гэдэг.

Хуучин сүм, тэр олон амьтны амь хороосон хэцүү явдлын тэмдгийг одоо хүртэл үзүүлэх оромтой байдаг байна. Тэхэд алуулсан амьтны цус сүмийн туурганд олгойдон харвасныг хэн ч арчиж арилгасангүй, тэр хэвээрээ үлдээд, он удах тусам улам харлан цоохортож харагднам бөгөөд, лам, нь тэр цус туссан газрыг хүн битгий гар хүр. Сүсэгтэн хүний цус үсэрч, наалдан хатсан юм шүү гэж үлдээгээд, тэр амь үрэгдэгсдийн үетэн хүн, тэдний ач үр нь, тэр наалдан хатсан цусыг нь, шашныхаа төлөө амь үрэгдсэн улсын цус гэж маш хүндэтгэн үздэг байжээ.

Тэр хуучин сүм, хожмын үед ч гэсэн бас элдэв аюул үзэж өнгөрүүлсэн байнам. Гурван зуун жилийн өмнө 1558 онд Жүүд хотод их гал гарах үес, хамаг юм татаж, гал дөл болоод байхад, хуучин сүм галын далай дунд ганцаараа бүтэн үлдэж, орчин тойронд нь их галд хамаг юм хайлан шатаж, утаа гал манаран шуугьж байхад, ганц ч оч, тэр шүтээний газар унасангүй, сүмийн оройн ваараас ганц ваар ч унасангүй билээ.

Сүмийн бараан саравч дээр хоёр цагаан хүүрзгэнэ суугаад, огт хөдөлсөнгүй, цоргим халуун, бүтэм утааны дунд огт ажиггүй байж, аюулт галын догшин эрч хор нь намдсан хойно, сая цагаан өдөт

далавчаа дэлгэн, хойно хойноосоо дэгдэн, үүлэн цаана замхран одсон билээ.

Одоогоос гурван зуугаад жилийн өмнө, тэр үеийн Жүүд хотын дарга Йизхак лам нэгэн намар Прагадаа буцаж явсан байжээ. Ажил хэргээр нэг хөдөө суурин газар хүрээд буцаж явсан юм байж л дээ. Замын нэг хэсэг нь мод дундуур гардаг юм байж өөрөө ч ажсангүй, жолооч дэлбэгч ч таньсангүй, замын салаа дээр буруу замаар ороод төөрч орхисноо удалгүй мэдэвч, зөв замаа эрээд олсонгүй.

Бүрий баруй болж, мод дотор харанхуй болох гэдэг нь, бөөн, хар юм бууж байгаа юм шиг төлөөгүй пад хар болж, зам мөр харагдахаа байжээ. Чингэж байтал, урд нь, модон завсар нэг юмны гэрэл гарах шиг болтол, морь ч өөрөө зогсоод, чихээ хулмалзуулан, хамраа тачигнуулж цаад гэрэл нь ч улам их бол болохоор, сүрхий улаан туяа татаж гэнэ.

Жолооч дэлбэгч ч айж сандарлаа гэнэ. Хотын дарга л айсангүй мориныхоо нүд уяад, дэлбэг жолоог нь сайн барьж бай. Би очоод, учир байдлыг нь заншлан үзээд ирье гэж, модон дундуур, яг л тэр гэрэл гарч байсан зүг чиглэн очтол, ойн цоорхой дунд овоолоотой алтан мөнгөн зоос гялалзаж байх сонин жигтэй юм үзжээ. Хоёр бичил биетэн хүн, хоёулаа буурал сахалтай, тэр овоолоотой зоос уутанд хийж байхыг үзэж, дэргэд нь ойртон ирэхэд, зоосоор ноцолдсон тэр хоёр бяцхан хүн, огт мэдсэнгүй. Жүүд хотын дарга, тэр хоёрыг баахан гайхан харж байгаад, энэ хэнд очих зоос вэ? гэж асууваас, тэр хоёр бичил хүний нэг нь муухай хараад,

— Чамд хүртээлгүй! гэж дуугармагц, нүдэнд үзэгдэхгүй болчихлоо. Өнөөх овоолоотой алт мөнгө ч алга болж, уутаар дүүрэн зоос ч үгүй болж, газар ганц нэг алтан зоос хоцорчээ. Хоёр бичил хүний нэг нь үлдсэн тул, юманд дуртай жүүд, тэр хүнээс бас, хэнд гэж уутанд зоос хийж байсан юм бэ? гэж ахин асуугаад үзтэл,

— Чамд л хүртээлгүй гэж гэнэ.

— Хүртээлтэй эзэн нь хэн юм бэ? гэж ахин шалгаахад нь, тэр хүн,

— Танайхны л нэг хүний хувь юм даа гээд, асуухгүй юм асууж, манай ажилд саад хийлээ. Тэгсэн дээрээс эзэнд нь ойртуулж өгсөн дөө гэхэд нь,

— Үүний эзэн болох тэр азтай хүн чухам хэн юм бол доо? Надад хэлж өгвөл ямар вэ? гэхэд нь,

— Хэлж болохгүй юм даа гэлээ.

— Нэрийг нь хэлж болохгүй бол, ямар шуу хүн болох шинж тэмдгийг нь хэлж болох болов уу? гэхэд,

— Хэлж болохгүй ёстой юм даа гэж гэнэ.

— Тэгвэл, бас нэг юм асууя. Энэ юмаа эзэн нь хэзээ олж авах түүхтэй юм бэ? гэж шалгаахад нь,

— Чиний охин хүнд очих цагт л эзэн нь олдоно доо гэж гэнэ.

Хотын дарга гайхлын ихээр гайхаад, бас л ахин асууж,

— Миний охин ямар хамаатай юм бэ?

— Санаанд орохгүй учир бий гэлээ. Тэхэд нь,

— Ийм их эрдэнийн сан байх гэж! Тэнгэр минь! Надад юу ч оногдохгүй байх гэж! Тэр газар хэвтэж байгаа ганц нэг зоос авбал яана? тэхэд нь,

— Өгдөг эрх надад байхгүй. Золиосыг нь өгөөд авбал ав гэхэд нь, гурван дукат зоос газар тавиад, өнөөх хөсрийн алтан зоос тонгойж авах хооронд, өнөөх хүн ч үгүй болж, гэрэл гэгээ гарч байсан юм ч үгүй болж, харанхуй ой модонд гагцхүү хүйтэн салхи л шунгинан салхилж байв. Йизхак лам яаран буцаж, хөсөг дээрээ хүрч ирээд, дэлбэгч хүндээ юу ч хэлэлгүй үзсэнээ нуугаад, нэг юм займруулан хэлэгчээ болж, одоо явж үзье гэж хөдөлтөл, морь нь айх үргэхээ байж, зам таних мэт яваад байх нь сонин бөгөөд, удалгүй тэнгэр ч цэлмэж, хар шугуй модон дотроос төдхөн гарч, замдаа оржээ. Тэгээд цагаан тал дундуур шөнөжин явсаар, үүрээр Жүүд хотын хаалганд хүрч ирсэн билээ.

Йизхак лам, тэр явдлаас хойш, тэр их эрдэнийн эзэн гэгч нь ямар азтай хүн байдаг билээ? Миний охиныг дурдаж тэр бичил хүний хэлсэн үг, ямар учиртай үг болдог билээ? гэж бодол болжээ. Бодохдоо, тэр мод дотор олсон гурван алтан зоосоо харж, элдвээр бодовч, учрыг нь олохгүй. Яаж тэр юмны ухааныг олдог билээ гэж сэтгэл чилээтэй болоод, нэг шинж тэмдэг үзэгдэхийг нь оролдоод орхивол, учир ургаж магад гэж бодоод, өнөөх ойн бяцхан биет хүнээс зольж авсан гурван зоосоо тус тус нэг цаасанд боогоод, нэгийг нь цонхоороо гудамжинд хаяад, хэн олж авдаг бол гэж нууцгайгаар сэм ажиж байваас, хотын даргын байшингийн дэргэдүүр өдий төдий амьтан цаашаа наашаа сэлгүүцэн явавч, хөсөр цаасанд ороосон тэр юм хэвтэж байхыг анзаарсан хүн нэг ч үгүй. Нар шингэх шахсанд, хотын дарга лам, хүн явуулж, тэр гудамжинд хаясан зоосоо авчруулья гэж бодтол, нэг уранхай ноорхой хувцастай хиртэй халтар жаал хүү гэнэтхэн гүйж

ирээд, харангуут тэр цаастай зоос ажиглаад, ухасхиймэгц — шүүрч аваад алга болоод өгчээ.

Тэр эрдэнийн сангийн эзэн нь, энэ муу хүү болох гэж даанч дээ гэж хотын даргын сэтгэлд маш тааламжгүй болоод, арай ч тэхгүй байлгүй гэж сэтгэлээ тэжээн, маргаадар нь бас нэг зоосоо цаасанд ороолттой хэвээр нь хаяад, одоо яадаг бол гэж өдөржингөө сахин ажиж суутал, элдэв шалдав амьтан хөлхөж цувран, сэлгүүцэвч, тэр цаастай юм хөсөр хэвтэхийг огт ажиглалгүй өнгөрч, орой болоход, өнөө муу жаал гүйж ирээд, бас л өнөөх цаастай юм шүүрч аваад, гүйн оджээ. Хойд өдөр үлдсэн нэг зоосоо бас хаяад, ажин сахиж суутал, мөн л өнөө муухай халтар жаал хүрч ирээд, аваад явчихлаа. Тэр байдлыг үзэхэд, санамсаргүй дайралдсан хэрэг биш, нэг учиртай юм болох шинж мэдэгдэж, цаанаасаа ийм заяатай юм байна гэж бодоход нь дотор урамгүй болоод, тэр муу жаал хүү, чухам хэний үр, хэн гээч нь бол? гэж бодол боллоо. Чингээд, бүх Жүүд хотоор зарлаж, хотын дарга, гурван алтан зоос алдсан тул, хэн олсон хүн авчран тушаа гэж зар тавиулжээ. Албаны зарлага мешореш тушаалтай хүн тэр зарлалыг олонд сонордуулан гүйцмэгц, өнөө муу хүү давхиж ирээд, хоёр алтан зоосыг нь бариад, нэгийг нь ээждээ зах ороход нь өгчихсөн, ээж л түүнийг мэднэ. Оронд нь юм хийж өгдөг болов уу, уг нь эзнийг нь мэдсэн болбол, би гурван зоосыг тоо ёсоор эргүүлж өгөх юм сан, даанч мэдсэнгүй дээ. Яагаад тэр гурван зоос олсон юм бэ? гэвэл, хотын даргын байшингийн тэнд очвол, цаасанд ороосон алтан зоос олно гэж гурван шөнө дараагаар зүүд зүүдэлсэн билээ гэжээ.

Йизхак лам гайхахын ихээр гайхаад, Шалум Майзл гэдэг нэг муу ядуу жүүдийн хүү болох, нэрийг нь асуувал, Мордехай гэдэг тэр муу жаал, өнөөх их эрдэнийн сангийн хувьтай эзэн болох нь дээ гэж дамжиггүй таньж авлаа. Тэгээд, чи сайн жаал байна гэж магтаад, нөгөө хоёр алтан зоосыг нь буцааж өгөөд, чи манайд суу, би чамд хувцас хунар өгнө, өөрийн хүүгийн адил үзэж ном сургана гэлээ.

Жаал Мордехай тэр үг сонсоод баярлавч, танайд байж чадахгүй байна. Ээж өдөржингөө мухлаг лангуугаа сахин суудаг, аавын бие нүд сохор.

— Аав гэртээ ганцаараа, өдөрт гурван удаа сүмд очиж мөргөхөд нь дагуулж аваачих хүн надаас ондоо амьтан байдаггүй гэж лам даргад айлтгахад нь, хотын дарга,

— Тэгвэл, сүмд хөтөлж аваачих хүний хөлсийг нь өгнө гэжээ.

— Ондоо хүн, яаж өөрийн хүнтэй адил байх вэ дээ? гээд тэр жаал болж өгсөнгүй. Тэгээд, хотын дарга, нэгэн өдөр тэр жаалын эцэг эхийнд очиж, хүүгээ манайд явуулж бай, өдөрт хэдэн цаг манайд байж, ажил төрөлд сураг, та нараас дээр аж амьдралтай болог. Танай жаал хүү миний сэтгэлд их таатай байна. Үгийг минь дагавал өсөж торнисон хойно нь, би охиноо ч танай хүүгийн хань болгож болно гэжээ.

Шалум авгайтайгаа хоёулаа хотын баян дарга морилон орж ирсэнд сандарч мэгдээд, тэр үгийг нь сонсохдоо бүр ч гайхан баярлаж, дуулаагүй юмаа дуулж, зөв дуулав уу, буруу дуулав уу? гэж гайхан, тэгвэл ямар сайхан юм бэ, гялайх маань тэр гэж зөвшөөрөөд, Йисхакийн тэр амласан үгийг хэнд ч задруулан хэлэхгүй гэж ам шүдээ алдаж гэнэ.

Арван таван настай Майзл овогт Мордехай тэгж хотын даргын гэрт ордог болжээ. Өдөр нь аавыгаа сүмд нь хөтөлж аваачаад, ээждээ чадлаараа туслалцан, сургууль наймааны арга ухаан сүрхий сурч, хорин нас хүрэхэд нь, Йизхак ламбугай, тэр жаал хүүд үнэн сэтгэлээс хайртай болсон охиноо гэргий болгож өгөөд, найр хурим хийснээс хойш долоо хоног өнгөрүүт, морио тэргэнд оруулж, залуу хүргэнээ аваад, Прагаас гарч, зургаан жилийн өмнө жигтэй сонин юм үзсэн модонд очихдоо, ямар учиртай очиж явааг нь хэлсэнгүй, урьдаар алт мөнгө үзсэнээ олох санаатайгаа ч дурдсангүй, тэр ой модонд шөнөжин байж, үүр цайлгатал, юу ч мэдэгдсэнгүй. Өнөөх гэрэл гэгээ ч үзэгдээгүй, бяцхан хүн ч дайралдсангүй.

Чингээд йизхак ламбугай сэтгэл дурамжхан буцаж Прагадаа ирээд, арай горь тасраагүй, дараа нэг явбал, учир ургаж магадгүй гэж бодсон нь, дараа яваад бас юм бүтсэнгүй. Бас нэг очоод үзсэн мөн л аанай хоосон буцжээ. Байсхийгээд, дахиад хүргэнтэйгээ яваад, бас л юм мэдэгдсэнгүй. Хүргэндээ ч тэр явдаг учраа хэлсэнгүй. Чингээд, эцэст нь, ер тэр модонд үзсэн сонин жигийн юм бол, чөтгөр ордослож, ёрын юм үзүүлээд, охиныг минь гуйлгачинтай суулгах гэж дамшигласан болов уу? гэж бодох болж, сэтгэл гутарчээ.

Чингээд, алдаа хийлээ гэж боддог болсноо далдлан эс чадаж, урьд нь сүрхий дотнолж энхрийлдэг хүргэндээ дургүй болж, муухай зангаа гаргаж, цаашлах тусам улам ч гадуурхдаг болжээ. Залуу Майзл түүнд нь сэтгэл чилээд, хотын даргын гэрт дараа болж байгаа учир, ер зайлаад өгье гэж шийджээ. Залуу эхнэр нь ч татгалзсангүй, тэгээд хадмынхаасаа яваад өгчээ.

Тэндээс Майзл Мордехай хүү, эхийнхээ төмөр эдлэлийн лангууг эрхлэн, худалдаа наймаагаа сайжруулсаар, төдхөн Жүүд хот байтугай, бүх Прагаад нэртэй худалдааны хүний нэг нь төдхөн болж, ажлаа ч сайн сайхнаар зохиож, Тэнгэр ч тэтгэн ивээж, төдхөн баян чинээлэг болоод, зангаа хувиргаж, харамч харуу ч болсонгүй. Ядуу зүдүүг хэзээд бодож, өглөг хишиг түгээн, өр ширэнд баригдаж, хилсдэн үгүүрч, шорон гянданд орогсдыг зольж гаргадаг байжээ. Чингэтэл, нэг зун, тариа хадах үес, дэлгүүрт нь нэг үл таних тариачин эр хүрч ирээд, билүү, хадуур шилж аваад, одоо бэлэн мөнгө байхгүй байна. Тариа хадсаны сүүлээр өгье. Зээл тавина уу? гэхэд нь Майзл, тэгвэл тэг гээд, тэр тариачны байдлыг харахад томоотой хүн үзэгдсэнд итгэжээ. Тэр тариалангийн эр баярлаад,

— Танихгүй намайг итгэмжилснийг чинь үзээд, чамайг дотор сайтай хүн байна гэж би ч итгэлээ. Манай гэрт нэг хуучин том авдар бий. Тэр төмөр авдрын цоожийг нээх гээд чадаагүй юм. Надад түүний хэрэг алга. Чамд тэр төмөр авдраа ачиж авчраад, өрөндөө бодуулж өгсүү гээд, гурав хоноход, өнөөх авдраа ачаад ирж, нээрэн ч тун хүнд төмөр авдар байсан тул, тэр тариачин эрийн зээлээр авсан юмны үнэд хүрээд, цаана нь бас мөнгө илүү гарч, түүгээрээ юм авч гэнэ.

Үдэш нь Майзл, тэр авдраа нээх гээд, цүүц аваад, алхаар цохин гэтэл, авдрын нээлгэ нь өөрөө суга үсэрч онгойсонд Майзлын гайхан харахад, төмөр авдраар дүүрэн алт мөнгө байжээ. Ихэд баярлаад, сэтгэлээ тогтоонгуут, авдрын нээлгийг хааж, цоожлоод, хэнд ч эхнэртээ ч гэсэн тийм юмтай болсноо хэлсэнгүй. Өнөөх тариалангийн эр, тэр авдартай юмаа авах гэж ирэх байх гэж хэдэн хоног хүлээгээд, цааш нь долоон хоног, нэг сар хүлээгээд суутал, сар хоног өнгөрөвч, авдрын эзэн ирдэггүй, юмаа авна гэж нэхдэггүй, Майзл, тэр тариалангийн эрийг танихгүй, нутаг усыг нь мэдэхгүй тул, сураглах аргагүй суусаар, нэг жил болоход, тэр эрдэнийн зүйлийг өөрийн боллоо гэж үзжээ.

Чингээд яав гэхэд, тэргүүлэгч рабин гэдэг ламд очиж, шинэ сүм босгох зүйлд зориул гэж, өнөөх алт мөнгөний ихэнхийг өгөөд, намайг сүмийн үйлтгэлд мөнгө хөрөнгө өгсөн гэж амьтанд бүү хэлээрэй гэж захижээ. Гэтэл, барилга үйлтгэлийг дуусгаад, шинэ мөргөлийн газрыг амилахад, лам, хурсан олонд, тэр шинэ дуган сүм босгох хөрөнгө нийлүүлсэн өглөгийн эзэн энэ байна гэж, сүмийн буланд даруухан зогсож байсан Майзлыг заажээ.

Олон амьтан цөм Майзлын зүг овооролдон ерөөх нь ерөөж, магтах нь магтаж, хамгийн түрүүнд хадам эцэг Рабби лам Йизхак сүрхий болов гэнэ. Зан аашаа ондоо болгож, найрсаглан элсэглэхэд нь, хүргэн хүү нь учраа хэлж, нэг тийм тариачин ирээд, нэг тийм төмөр авдар өгсөн гэхэд нь, хотын дарга лам,

— Тэгвэл, тэр тариачин хүнийг авдраа нэхэж ирнэ гэж бүү хүлээ! Тэр миний үзсэн бяцхан хүний нэг нь тариачны дүрээр ирсэн байна гээд, хүргэндээ урьд тэр ойд юм үзээд, хожим хүргэнтэйгээ хэд хэдэн удаа явсан учраа хэлж өгөөд,

— Тэр юм, цөм ёсоороо болохыг хэн мэдэв. Ийм жигтэй юм байх гэж! Шадай тэнгэр үүрдийн үүрд ерөөлт болтугай! гэжээ.

Майзл Мордехай, насан эцэс болтлоо баян элбэгийг эдэлж, эд зөөртөө огт харамгүй, шашин нэгтэндээ тус болохыг чармайж, их ч сайн сайхан юм хийсэн дээ.

Хөрөнгөөрөө босгосон сүм нь одоо хүртэл нэрийг нь дурсгаж, бас Жүүд хотод тэр хүн, хотын даргын яам босгож, эмэгтэйчүүдийн рашаан угаалын газар бий болгоод, жүүдчүүдийн өнчин өрөөсөн, ядуу зүдүүгийн асрамжийн газар байгуулж, Жүүд хотын шавар шавхайтай, муруй муухай гудамжийг нь тэгшлэн зассан хүн гэдэг. Бас, хүүр оршуулах газрыг өргөтгөн уутгаж, 1601 онд насан элэгдтэлээ буян үйлдэж, ядууст үргэлж тусалдаг байжээ.

Хоёрдугаар Рудолф вангийн төр барих үес Прагын Жүүд хотод Йехуда Лев бен Безалел гэдэг маш их эрдэм чадалтай рабби лам байжээ. Бие өндөр тул, «өндөр рабби» гэж олон өргөмжлөн дуудах ажгуу. Талмуд судар, тарнийн номд маш мэргэшсэн бөгөөд бас тооны ухаан, тэнгэрийн зурхайд гарамгай ажээ. Түмэн бодисын далд нууцыг усан нүдтэй амьтан үл мэдэх атал, тэр рабби ламтан мэдэж, гайхамшигтай жигтэй юм болгон таньдаг байсан тул, хүн амьтан, түүний тэр илбийн чадлыг гайхдаг байжээ.

Тийм айхавтар чадалтай хүн бий гэж олны ам дамжсан үг цуу дамжин дэлгэрсээр богд Вацлавын шилтгээнд, Рудолф вангийн сонорт хүрчээ. Вангийн шадар зурхайч Тиходе Брахе тэр номч Йехуда бен Левийг хүндэтгэдэг байсан бөгөөд, ван ноён, түүнтэй их сонин жигтэйгээр учирсан байжээ.

Шилтгээнээсээ Хуучин хот морин тэргээр орж морьтой тайж нар бараа бололцон явж байсан тэр цагт, яг бүх жүүдийг Прагаас зайл гэж вантан тушаасан үе байж, Лев рабби лам, тэр тухай шашин нэгтэй

шавь нарынхаа төлөө зуучлах гэж ванд бараалхахаар очоод, дэргэдийн улс оруулсангүй вантай золгож чадсангүй тул, үүгээр ван заларна гэж осолгүй мэдээ олж аваад, яг явах зам дээр нь, чулуун гүүрний дунд зогсож байсан ажээ.

Гүүр дээр байсан амьтан, алсаас хударга хөмөлдрөг нь гялалзсан сайхан дөрвөн морь хөлөглөсөн, бас бараа бологч олон морьтонтой вангийн хөсөг айсууг хараад, рабби ламыг зам зайлж өг гэтэл, ламтан огт сонсоогүй юм шиг ажиг сэжиггүй, яг вангийн тэрэгний зам дунд голлон зогсжээ.

Чингэхэд, амьтан, тэр номч хүнийг чулуу шавраар цохин халдваас, хувцас хунар, бие тэргүүнд нь, хөл дор нь цэцэг болон тусч байтал, вангийн жагсаал хүрээд ирж, рабби огт зайлж өгсөнгүй. Вангийн тэрэгний довтлогч морь, дайрч халдалгүй, өмнө нь зогтусан, дэлбэгч нь дэлбэг жолоогоо огт татаагүй байтал зогсжээ.



Рабби урагш давшиж, сарнай цэцгийн зэрэг цэцэг барьж толгой нүцгэн гуйж, шашин нэгтэй олныхоо төлөөнөөс өршөөл өчихөд нь, ван түүний байдлыг гайхан харж, шилтгээнд хүрч ир гэсэн нь их л нүүр шагнасан хэрэг болжээ.

Чингээд, дараа нь вангийн ордноо бараалхаж, айлтган гуйх зүйлээ ёсоор болгуулсан билээ.

Жүүдийг хөөн зайлуулахыг байж, багш рабби ламыг нь ван шилтгээндээ хэд хэд залан аваачиж, илбийн чадлыг нь гайхан үзэж уйтгараа сэргээдэг байлаа. Нэгэн удаа ван, тэр рабби багш Безалелийг чи надад богд өвөг Абрахам, Исак, Иакуб, йакубын үр хөвүүдийг үзүүлж өг гэлээ. Рабби цааргалж ядаад, арга буюу зарлиг дагах болж, гагцхүү богд өвгөдийн аригуун дүр тодрон үзэгдэхэд чимээ гарч, инээж ханиаж огт болохгүй шүү гэж захисанд, ван тэргүүтэй ноёд тайж нар, захиаг нь зөвшөөгөөд, ордны нэг дотоод танхимд цуглан, цонхны тэндэх хөндийн зүг, их рабби лам сүртэйеэ зогсож байгааг, юу үзүүлдэг бол? гэж ширтэн хартал, рабби ламын бие манан буданд далд орсон юм шиг үл үзэгдэн, харанхуй булангаас гэнэт хүний биеийн хэмжээнээс хэтэрсэн үлэмж биет өтгөсийн дүр гарч ирэв. Хуниастан жанч нөмрөөд, гэрэл гэгээтэй жигтэйхэн тодхоноор ганцаараа гарч ирээд, олны өмнө маш их жавхлантайгаар өнгөрөн, будан мэт харанхуйд замхран одлоо. Тэр бол Абрахамын дүр байжээ. Хойноос нь Исак, чингээд Иакуб үр хүүтэйгээ гарч ирэн, хүүгээс нь йуда, Рүбен, Симеон, Изахар тэргүүтэн дараа дараагаар цувран үзэгдсэнд ван тэргүүтэй тайж нар, жүүд түмний өндөр өвөг дээдсийн тэр дүр, христосын номд гардаг богд нарын байдлыг нам гүм, айван тайван харж суутал, харанхуй дотроос Иакубын хүү Нафталийн гэгч, улбар шар үстэй, нүүр дүүрэн сэвхтэй бүдэнтэй, тийм нэг байдалтай гэнэт годгосхийн гарч ирээд, яарч шамдсан байдалтай, бусдынхаа хойноос хөөн гүйсэн юм шиг алцганан шогшиход нь, вангийн инээд тэсгэлгүй хүрч, инээмэгц нь юм ч үзэгдэхээ байж, харанхуй ч үгүй болж, уудам танхим дүүрэн айж сандран бархиралдах дуу дуулдав.

Олон тайж нар, суудлаасаа ухасхийн босоцгоогоод, зураг зурмал адрын зүг өөдөө эмээн харцгаав.

Ноён нуруу нь доошоо хотойж, адар нь дорогшлон улам улам бууж өндөр танхим нам бол болсоор, тайж нар, зүс царай нь зэвхийрээд, хаалга тийш гүйх гэтэл, нэг нь ч байраасаа хөдөлж чаддаггүй, мөс дээр хөлдөн авалцаж орхисон юм шиг зогсоцгоон, бүгдээрээ Безалелийг наана, өршөөн тогтоож хайрла гэж хашхиралдахад, ван бас адрог тогтоо гэж бархиралдлаа.

Рабби багш, тэр Хөндий дотроос гарч ирээд, гараа сунган нэг юм дуугартал, танхимын адар доошлон буух нь зогсоод тогтосхийсэнд,

ван цаашаа юу болохыг бодох завгүй бушуухан танхимаас гараад өгсөнд, бараа болсон ноёд тайж нар хойноос нь год хийгээд гарцгаажээ.

Танхимын ноён нуруу нь эргээд дээшээ болсонгүй, өнөөх тогтсон газраа тэр хэвээрээ үлдээд, ван, түүнээс хойш ер тэр танхимд орохоо байжээ. Хаалгыг нь түгжээд, түгжээтэй чигээрээ байдаг болжээ.

Рабби багш Лев бен Безалел, тэр явдлаас болж вангийн өмнө ял олсонгүй. Харин ч ван өөрөө гэрт нь очсон удаа бий. Тийм хишиг хүндэтгэлийг урьд өмнө Жүүд хотынхон үзээгүй байжээ.

Лев багшийн орон байшин нь үзэмж байдлаар тааруухан юм санжээ. Хуучирсан бөгөөд барилга нь муухан байшин байжээ. Гэтэл, ванг хүрч ирээд, намхан хаалгаар нь дотогшлон ортол, гайхлын ихээр гайхаж эхэлсэн билээ. Ерийн айлын танхим өрөө огт биш, ноёд ихсийн ордны маш гоёмсог зураг хуар болсон чимэг бүхий адар таазтай сайхан танхим байжээ. Зочлох танхимд ордог шатны байдал нь, нарийн нандин хивсний цаанаас зарим газраа мод, зарим газраа гантиг чулуу гялалзан, тэр шатаар орохдоо зэргэлдээ танхимд оролгүй, сайхан зураг чимэг, гоёмсог торгомсгоор чимэглэсэн жигтэйхэн үзэсгэлэнтэй танхимд ортол, нээлттэй хаалгаар нь үзэхэд, гоё гэгчийн олон тасалгаа харагдаж, нэг хаалгаар италийн урчуудын бүтээсэн тагт харагдлаа. Лев рабби ламтан, ванг тайж нарын сэлт угтан тосож аваад, морилон гийгүүл гэж сайхан ширээ зассан нэг том тасалгаанд оруулжээ. Ван ширээлэн сууваас, рабби ламтан, идээ зоог барихдаа ванг бараа бологсдын хамт тун сайхнаар зочлон хүндэлж, барьсан идээ зоог нь вангийн ширээнийхээс ялгаагүй нарийн байж ван Лев ламыг бяцхан байшингаа гайхамшиг илбийн чадлаар маш том болгож, үзэгдээгүй сайхнаар чимсэнд нь ихэд сонирхон таашааж, ламын гэрт нэлээд удаан саатаад сэтгэл санаа амсхийн буцсан гэдэг. Чингээд, тэр номч ламд талтай болсноо олон удаа илт үзүүлж байлаа. Ламтан, чех ван гэрт нь өөдлөн морилсны тэмдэг дурсгал үлдээнэ гэж байшиндаа усан үзмийн хонгорцог тэмдэгтэй байсны дэргэд нь арслан сийлүүлж, тэр чулуун тэмдэг хадуулан дурсгажээ.

Вангийн шилтгээнд богд өвгөдийн дүр илт үзүүлсэн сонин жигтэй юмнаас Йехуда Левийн зарц Голем гэдэг нь бүр ч жигтэй юм байж гэнэ. Чадал эрдэм ихтэй рабби ламтан, тэр Голем зарцаа өөрөө шавраар бүтээгээд, «шем» гэдэг тарнийн үсэг аманд нь хийж амь оруулан зардаг байжээ.

Тэр голем нь ажил хийхдээ, хоёр эрийн дайтай ажиллаж, гарын дор зарагдан, эзнээ үйлчлээд, ус барьж, түлээ хагалж, хог шүүрдэн, аль л бүдүүн хар ажил бүгдийг нь хийдэг байжээ. Чингэхдээ, юм уух идэх, амран завсарлахыг мэдэхгүй зүтгэдэг зарц байжээ. Гагцхүү, баасан гарагийн үдэш, аливаа ажлыг зогсоодог шабеш гэдэг цаг болохын үес рабби лам, голем гэдэг зарцынхаа амнаас «шем» гэдэг тарнийн үсгийг сугалан аваад орхиход нь тэр Голем зарц нь, хөдлөхгүй болж, буланд амьгүй шавар хүн хэвтдэг бөгөөд, шабеш гэдэг цагийг өнгөрмөгц, рабби ламтан, ангайсан аманд нь «шем» гэдэг тарнийн үсэг хиймэгц, дахин амилан босдог байжээ.

Нэгэн цагт Лев бен Безалел, хуучин шинэ сүмдээ шабешийн зул барих гэж яараад, өнөөх Голем зарцаа мартаад, амнаас нь «шем» тарнийн үсэг авалгүй явчихжээ. Чингээд, сүмдээ ороод, уншлага залбирлаа үүсгэтэл, ар гэрээс нь, ах дүүгийн хөрш хүн сандан мэндэн гүйж ирээд, өнөөх Голем орон байшин нурааж, хүн амьтныг хавьтуулахгүй, сүйд сүржин болж байна гэж хашхиран шуугилдаж, ихэд үймэлдэв.

Рабби лам нэг хэсэг яахаа ч мэдэхгүй, шабешийн цаг болж, нэгэнт залбирал уншиж эхэлсэн тул, тэр цаг болсноос хойш ер ямар ч өчүүхэн ажил хэмээвч хийж болдоггүй, их нүгэл гэж үздэг ёстой байсан тул, гэрийн зүг гүйж болохгүй, яана гэж сандартлаа, нэгэнт залбирал уншин гүйцээгүй тул, ажил хэрэг хориултай болдог шабешийн цаг арай эхлээгүй гэж ухаараад, яаран гэрийн зүг гүйтэл, пижигнэн нижигнэх муухай чимээ дуулдаж, хойноос нь дагаж гүйгсэд, айсандаа хойноос нь хөндийхөн дагаж явтал, лам ч гэртээ ороод өгч гэнэ. Хамаг юмыг нь өнөөх Голем эвдэн сүйдэлж, аяга шанага, ширээ сандал, гэрийн хогшлыг хиар цохиж, ном судрыг нь хийсгэн хаялж байв гэнэ. Чингэж гэр дотор сүйдлэхийн өмнө гадаа нь бас «ажиллаж», тахиа шувуу, муу нохойг нь цөмийг нь цохиж алаад, бүдүүн гэгчийн эм дом гэдэг модыг газраас суга татаж хаясан байжээ. Царай зүс нь час улаан болоод, үс нь сагсайн хийсэж, тэр том мод суга татахдаа бяцхан гадас сугалсан шиг ховх татаж орхисон байжээ.

Рабби ламтан, шууд тэр Големын зүг эрслэн очиж, өөдөөс нь ширтэн, гараа сарвайхад нь, цаадах нь, ламын догшин харцанд хөдөлж чадахгүй болоод, дэмий л нүдээ бүлтийн мансуурч зогсов. Ламтан, аманд нь гараа хийгээд, өнөөх «шөм» гэдэг тарнийн үсэг угз татан автал, Голем гол нь тасарсан юм шиг, хөсөр пид хийтэл ойчоод, амьгүй

шавар хүн болон хэвтлээ. Тэр хавьд байсан хөгшин залуу олон жүүдүүд дуу алдан баярлаж, хөсөр хэвтэж байгаа Големын дэргэд нь хүрч ирээд, шоолох нь шоолон, хараах нь харааж гарчээ. Рабби ламтан, амьсгаагаа нэг уртаар татаад, үг дуугүй сүмдээ яаран очиж, зулын гэрэлд залбирлаа эгшиглэн уншиж, шабеш гэдэг дүйцэнгийн зул барьжээ.

Чингээд, саницар гэдэг дүйцэн гараг өнгөрөхөд, Лев бен Безалел рабби ламтан, өнөөх голем зарцынхаа аманд «шем» гэдэг тарнийн үсэг хийсэнгүй. Тэр шавар зарц нь дахин амилж боссонгүй, хуучин сүмийн дээвэр саравч дор хэвтсээр, бутран салжээ.

Олон зуун жил өнгөрч, Жүүдийн хот ч бас их ондоо болжээ. Бусад хүнтэй харилцахгүй гэж цаазлан хашсан зүйл хүчингүй болж, хэрэм нь үгүй болж, уг хотын байдал ч өвөрдөж, гудамж, байшин, хүн амьтан нь цөм ондоо болж ирлээ.

Гагцхүү хуучин шинэ сүм л уг хэвээрээ байсаар, тэр хавийн шинэ орон байшингийн завсар бас үхэгсдийн яс тавих газар л⁴² мөн өөрчлөлгүй үлджээ. Прага хотын бий болохоос урьд Жүүд хотод сууж байсан хүнээс эхлэн, гетто гэж жүүд хүний суух гортиг хороо тогтоосон хэрэм хүрээ дотор сууж байсан жүүдчүүд хожим тэр гетто хороог устгаж, доторх хүн амыг нь чөлөөтэй суух явах болгосон үе хүртэлх өчнөөн төчнөөн үеийн хүн, цөм тэр үхэгсдийн яс тавих газар багтан шингэж, амсар нээлттэй хүүрийн дээр кадиш гэдэг нөгчигсдийн тонилгол залбирал сүүлчийн удаа уншсан газар байжээ. Тэр яс тавих газар, мод сөөгийн дунд өдий төдий чулуун хөшөө босгоотой байгаа нь, зарим маанийн чулуу бүдүүхэн хийцтэй, зарим нь тун нарийн төвөгтэй хийцтэй, хавтгай босоо самбар шиг ч бий, байшингийн дээвэр шиг налуу юм бий. Цөм бүр нэг нэг тэмдэгтэй: зарим нь усан үзмийн хонгорцог сийлээтэй, тэр бол, жүүд угсааны хүн гэсэн тэмдэг, заримд нь нүүр гар угаагуур тэмдэгтэй, тэр нь Лев омгийн хүн гэсэн тэмдэг, зарим нь гар тэмдэгтэй, тэр нь Ароны омгийн хүн гэсэн утгатай байжээ. Зарим чулуунд авхай хүн, зарим чулуунд арслан, заримд нь чоно, заримд нь буга гэх мэтийн дүрс сийлээтэй нь, нас элэгдсэн хүний нэрийн дагуу сийлсэн байжээ. Хөшөө тутам еврей үсгийн бичээстэй зарим нь товчхон үгтэй, зарим нь сүрхий дэлгэр, ямар эцгийн ямар омгийн хэн гэгч, хэдийд нас барсан зэрэг мэдээ тодорхойлсон зүйлтэй. Тэр олон нэрийг үзэхэд янзын сонин нэр гарч,

еврей нэр ч байж, герман нэр ч гарч, бүр хуучных нь, 16 дугаар зууны үеийн нэр болоод ирэхдээ, тэр цагийн жүүдчүүд, чех хүнд элэгтэй байсан учир, чех нэр ч бас дайралдах ажээ. Энд нэг Краса гэдэг чехээр Сайхан гэсэн нэртэй жүүд хүний булш, тэнд нэг Чех гэсэн нэртэй, Черны буюу чехээр Хар гэсэн нэртэй хүн, тэнд Сладка буюу Амттайхан гэсэн нэрт жүүд эмэгтэй, Чарка буюу чехээр Зураахай гэсэн хүн, Мамила буюу Өдөөлэй, Либүше Амрагжин Слава буюу Алдарай, цаана нь Незамысл буюу Санаандгүй, Мата буюу Батраш цэцэг, Влк буюу Чоно, Добрушка буюу Сайнсанаа гэх мэт чех нэрс дайралдах аж.

Дээр цагаас, тэр хүүр тавих газар их хүн оршуулж байсан үес, жүүдчүүд тэр хөшөө чулуу дээр сэмхэн зоос мөнгө тавьдаг заншилтай байжээ. Тэр нь ямар учиртай юм бэ? гэвэл ядуу зүдүү хүн юм гуйхаас ичиж зовдог байвал, тэр тавьсан юм түүж аваг гэж сэм өглөг өгдөг ёс байжээ. Бас, зарим хөшөө дээр чулуу тавьсан нь, зарим газар нэлээн олон чулуу овоолоотой, зарим газар цөөвтөр байдаг нь, хүндэтгэж, чулуу тавьдаг ёс байсан байна. Шүтлэгтэй хүн тэр газраар явахдаа, булш дээр чулуу тавьдаг байж. Чингээд, олон чулуутай нь, олны сэтгэлд дурсагддаг хүний булш байдаг бөгөөд, Сехер заддиг ливрохо гэж залбирч чулуу тавилдаг нь, шударга журамтны нэр дурсгал нь ерөөл төгөлдөр болтугай гэж олны ерөөл хүлээсэн хүний булш, чулуу ихтэй байдаг ажээ.

Хуучин жүүд хотын олон үеийн хүн, цөм, тэр хүүр тавих газар далд орж, ядуу баян, нэр дурсгалгүй хүн, алдар их цуутан цөм тэнд шингэж, 1439 онд нас барсан эрдэмт рабби багш Абигдор Каро ч тэр булшны газар оршиж, уг нь Дөрөвдүгээр Вацлав вангийн үед маш олон жүүд хядуулсанд гашуудлын залбирал зохиосон хүн юм санж, бас шашин нэгтэй угсаатандаа ихэд тус хүргэсэн Шалумын хүү Майзл Мордехай ч тэр хүүрийн газар яс нь тавиатай, мөн их алдарт Иехуда Лев бен Безалел (1609 онд нас барж) ясаа тавиулсан зэрэг жүүд хотынхны олон сүрхий сайчуул цөм тэнд оршуулаатай ажээ. Тэд булт, анхилам сайхан үнэртэй бут сөөгийн сүүдэрт мөнхжин оршиж, нойрыг нь юу ч үймүүлэн сэрээхгүй ажээ. Нэг л юм, үхэгсдийн тэр хүрээлэнд амар хэвтэх газраа олоогүй, «Шалом алехем» буюу амгалан болтугай гэсэн ерөөлийн үг, түүний хоосон авс дээгүүр дэмий л дуурьсах ажам.

Тэр жүүд багаасаа омог угсаанаасаа хөндийрч, христосын ном шашинд ороод, хожим христосын лам болсон нь, богд Вийтийн сүмийн дэд лам байжээ. Чингээд, насан эцэс болох үес биеэ жүүд

гаралтай хүн билээ би гэж санаад, ясаа жүүд хотын «үхэгсдийн хүрээлэнд» тавиулах юм сан гэж бодсон байжээ. Залуу бага насанд нь хайртай сэтгэлтэй явсан нэг жүүд залуу хүүхний ясыг тэнд тавьсан юм байж л дээ. Тэгээд, тэр лам, нас барахдаа, жүүд хүний ёсоор өнгөрөөд, жүүдчүүд нь түүнийг оршуулахдаа гэрээс захиа ёсоор нь, амьд явахдаа урьд хайртай байсан өнөөх жүүд хүүхний ойр хавьд нь оршуулжээ. Гэтэл, тэр лам, амьд явахдаа амар заяагаа үзэхгүй өнгөрөөд, авсанд орсон хойноо бас амар заяагаа үзэж чадсангүй. Шөнө бүр авснаасаа босоод, Влтав мөрөнд очих ёстой болж, мөрний захад хүрэхэд нь суман онгоцонд түүнийг сүүмэлзсэн хохимой үсчин хүлээж байдаг байж гэнэ.

Сартай саруул шөнө ч, харанхуй, саргүй шөнө ч ялгаагүй, шөнө бүр мөрний цаад талд гарч, шашнаа алдсан тэр лам суман онгоцноосоо гараад, усчнаараа хүргүүлэн, дээшээ шилтгээний зүг, богд Вийтийн сүмд очдог байжээ. Сүмд ороод, өнөөх жүүд лам бадралт бишгүүр хөгжимдөн, хохимой нь тэр бадралт бишгүүрийн хөөргийг дардаг байж гэнэ. Хөндий харанхуй, чив чимээгүй сүмд залбирах мөргөлийн эгшиг чимээ наманчлах тамлагын эгшиг хөгжөөж, хир хилэнц, нүгэл уналаа нимгэрүүлэн хэлтрүүлэхийг тэнгэрийн зүг залбиран хөгжимддөг бөгөөд, сэтгэл уярам гашуудалт тэр эгшиг залбирал нь хүрдэг эзэнд нь хүрэлгүй хангинасаар, богд Вийтийн сүмийн гонхны цаг нь шөнө дундын цаг болсныг цохиход, бадралт баг бишгүүрийн дуу нь тасарч, хөгжимчин нь гуньхарч, доошоо мөрний зүг бууж очдог байжээ.

Өнөөх хохимой нь мөрнийг онгоцоороо гаргаж өгөөд, лам, эцэг өвгөдийнхөө яс тавьсан газар, өөрийнхөө авсанд очиж ороод, хойд шөнө нь дахиад л босож, мөрөн гатлаад богд Вийтийн сүмд гэмээ наманчилсан залбирал тамлагаа хөгжимддөг байжээ гэдэг асан.

VII. ГУНИЛТ Г АЗАР

1621 оны зургаадугаар сарын 20-ны шөнө Прага хотод сэтгэл гуньж, зүрх шимширмээр аягүй байжээ. Амьтан хаа ч үзэгдэхгүй, хөл чимээ тасраад, гудамжинд гадагшаа нэг ч амьтан гарч зүрхлэхгүй, гагцхүү харь газрын цэргийн эргүүл, хотоор явж, хөлийн чимээ нь сүртэй дуулалдан, зэр зэмсэг нь айдас хүрмээр хангинах ажээ.

Хуучин хотын талбайд шөнийн харанхуйд юм ачсан тэрэг зогсоцгоож банз гуалин тэр тэрэгнээс зах зээлийн дунд модоч дархан юм хийж байгаа газар буулгаж байлаа. Чив чимээгүй тэр газар сүх

цавчих, алх лантуу цохих дуу шуу гарч, шөнийн харанхуйд бамбарын гэрэлд нэг том индэр шиг юм боссоор, үүрээр гэгээ орж цайх үес гүйцэж, хар цэмбээр бүтээлгэн, нэг талд нь модон загалмай босгон зоосон юм болжээ.

Хүн цаазлах индэр юм асанж. Түр сул цулгүй байж, нар гармагц, шилтгээнээс буун дуу нижигнэж, цаазаар авах явдал үүсэхийн дохио өгчээ. Талбай дээр хааны морьтой явган цэрэг жагсаж, гашуудалтай тэр индэр дээр авгалдай баг өмссөн ясчин, бас зандалчны туслах нар зогсоцгоож, Ян Мыдларж гэдэг нэртэй зандалчин ч төдхөн хүрээд иржээ. Хааны төлөөний түшмэд суудлаа эзэлж, хуучин хотын яаманд урж шөнө хоригдсон бөгөөд цаазаар авхуулахаар болсон дарга нарын түрүүчийн нэр дуудаж, Шлик авгай цаазлуулахаар зоригтой алхав.

Цэрэг, хэнгэргээ цохиж, хотын байшингуудаар гутрам чимээгүй болж, шударга чехчүүд, тэр хар бүтээлэгтэй цаазын индэр дээр буюу дэргэд нь дүүжлүүр дээр амиа алдаж, байгаа чех дарга нараа, тэдний нөхөр сүүдрийг өрөвдөн гашуудаж, залбирал уншлагаа уншиж байв. Тэр цаазаар авхуулах хүн хорин долоо байв.

Хуучин хотын зах зээлийн тэр газар, өнөөх хүн цаазаар авсан бууринд нь арван зургаан том чулуу дөрвөлжлөн өрсөн байжээ. Хуучид өтгөс чехчүүд, тэр газраар явахдаа тэр чулуу дээр гишгэдэг ч үгүй, тэр дөрвөлжин дотор ордог ч үгүй, чех ноёд сайдын цус урсгасан газар гэж хайрлан харамсаж, тойрон гардаг байжээ.⁴³ Тэр газар өнөөх цаазаар авхуулсан тайж, хотын хүн, жилд нэг удаа, өнөөх цаазаар авхуулсан өдрийнхөө урьд шөнө үзэгдэж, бүгдээрээ цуглаж ирээд, тэргүүнд нь хамгийн ахмад нь болох, бараг ер шахсан настай Сүлевицийн Каплирж ноён үзүүрлэж, дараа нь урт буурал сахалтай, Будовын нутгийн Будовец ноён, Конецхлумски гэдэг өвгөн, Праховын Кохан, Криштоф Харант ноён, Дивиш Чернин, Михайловицийн ноён Шлик, Лосын Отто, Билийн ноён Хоштиалек, Йесенски, Водниански, Вокач, Йиржи Речицки, Кобр, Йизбицки зэрэг (арван хоёр өтгөс) бас тэднээс нас дүү хүн тэр нас дүү хүний дунд хамгийн дүүмэд нь дөч шахам явсан бөгөөд, цаазлуулахдаа эр зоригтой, дуу дуулсаар амиа алдсан Ян Күтнар, цөм тэр цаазын газар цуглаад, дуу чимээгүй, Тыны сүм хүртэл тэр талбайгаар явж, шүтээний нь өмнө сөгдөөд, рашаан зоог бишрэн хүртээд үзэгдэхгүй болчихдог байжээ.

* * * *

Урд малын зах дунд бас байшин байдаг асанж. Тэр байшингийн нэг нь, Шинэ хотын яам өөд харсан байшин байсан юм асан. «Цоожчиний тэндэх» гэдэг нэртэй тэр байшингаас гучаад алхам газар, хотын яамны зүг явахад өргөөшөө нэг тохой, өндрөөрөө тохойн тавны дөрвөн хувь өндөр нэг чулуу зоолттой. Тэр чулуу дээр загалмай сийлээтэй, загалмайн дор нь хохимой толгой, 1627 он гэсэн үсэг байжээ.

Тэр газар, тэр чулууны тушаа элэр балар цагт шөнө хүн цаазаар авдаг байжээ. Тэр 1627 онд зандалчийн юлдэд хэдэн лам хүн толгойгоо авхуулсан, бас 1743 онд хэдэн чех ноёд толгойн цаазад эрэтсэн нь, баварын курфист ноён Карл Албертыг францын хамт Прага хот эзлэн орж, биеэ чехийн ван өргөмжлөн, богд Вийтийн сүмд ширээнээ залрах ёс хийхэд, тэр ноёны талд орсон учраас цаазлуулсан байжээ.

Арван есдүгээр зуун хүртэл байсан тэр чулуу хүртэл Шинэ хотын яамнаас газар доогуур явдаг хонгил замтай байж, тэр зам нь тэндээс цаашаа гөрөөчний захын доогуур нь явсаар өөдөө фаустын байшинд хүрдэг байжээ.

VIII. Ф АУСТЫН Б АЙШИН

Тэр хуучны байшин, гөрөөчний захын үзүүрт нь, На Слованех гэдэг хийдийн тушаа гудамжны өнцөгт байжээ. Хүн суухаа байсаар их удаж, байдал нь зэвүүн жигтэй болчихсон байжээ. Дээр цагт улаан өнгөтэй байсан ваар дээвэр нь харлаад, туурга нь хагаран цавтаад шороо бороонд цохиулсан цонх нь, аалзны шүлс татуулж, нүдгүй сохор юм шиг үзэгдэх бүлгээ. Том тавтай хадаастай хүнд гэгчийн царсан хаалга нь, цаг ямагт түгжээтэй, хаалганы хавтас доторх бага хаалга нь ч үл нээгдэн, оръё гэж, хаалганд хадаастай, сайхан урласан төмөр тоншуурыг нь тогших гэж хаалганы өмнө зогсох хүн ч ер байдаггүй ажээ.

Хаалганы цаана хүнгүй, чих хулга, хашаа дотор ган хийх нохой, гон хийх тахианы дуу дуулдахгүй. Хаалганы өмнөх шалын чулууны завсраас ногоо ургажээ.

Тэр байшингийн ар хажуугаар нь На Слованех гэдэг хийдэд орох зам тушаах цэцгийн хүрээлэн ч бас нүдэнд хүйтэн үзэгдэн, тэр лүү харж шагайдаг хүнгүй. Тэр хүрээлэнд цэцгийн мандал ч байхгүй, цэцэг ногооны тавиур ч байхгүй. Хүн явдаг зам нь ч өвс хамхагт

дарагдан эдгэрч, хагд хөвд ургачихсан хөгшин эм дом мод, жимсний модод, өндөр шарилж, өвс ногоонд шавуулсан байдалтай байх бүлгээ.

Гагцхүү хавар цаг, цэцэг навч дэлгэрч, сахлаг өвс ногоо дунд алтан зос цацсан юм шиг шар шанам цэцэг, цагаан цэцэгт ямаан ханшаар, дүйрэн цэцэг мэтэс дэлгэрэхэд тэр цэцэрлэг арай нүдэнд дулаан болдог байжээ. Тэгээд, намар навч унаж, цэцэрлэг нь дарагдаад, үүлтэй бүрхэг тэнгэр доошоо буусан юм шиг харагдаж, нүцгэрсэн модны орой найлзуурыг хуй салхи мушгируулж, эрт гэгээ тасрахад, тэр модны дор, мөн тэр байшинд юутай харанхуй болдог байж вэ!

Тэр цэцэрлэг байшин хоёрын хажуугаар нь гарах хүнд их л аягүй, жигтэй юм санагдаж, өлзий бусын газар тул, шөнө нь тэрүүгээр Фауст доктор буг болж үзэгдэн, амьд байхдаа амар заяа үзээгүй нь үхээд бас амарч чадахгүй байжээ. Тэр Фауст доктор гэдэг нь эрт урьд цагт тэр байшинд байсан юм гэдэг. Тэнд элдэв илбэ жилбэ хийж, илбийн судар ном үзэж, чөтгөр шулам урин дуудаж, сүнсээ өгнө гэж амласан учир, шулам хариуд нь зарагдаж, тэр докторын юу л гэж хүсэн санасныг нь гүйцэтгэдэг байж гэдэг.

Тэгээд, цаг хугацаа нь гүйцэхэд, тэр чөтгөр шулам нь,
— Одоо боллоо, яв! гэсэн гэдэг.

Фауст доктор нь талийх дургүй, чадлаараа амиа хаацайлах гэж тарнидаж, гуйж гувшиж, элдвээр аргалж ядаж гэнэ. Чөтгөр нь ноцон шүүрч, савар хумсаараа тас атгаад, Фауст тулалдаад болж өгөхгүй тул, хаалгаар чирэлгүй, өөдөө дээвэр лүү нь нэвт шаагаад гарч, Фауст анх чөтгөрт биеэ өгнө гэж хэлэлцсэн ёсоор нь, цаадах нь аваад явчхаж гэнэ.

Дээвэр нэвт дайран гарсан нүх нь тэр янзаараа үлдээд, хэдэн удаа таглан засаж оролдовч, өглөө нь тэр нүх нь дахиад гарчхаад байдаг болжээ. Тэгээд амьтан айж, ялангуяа тэр байшинд Фауст нь буг болж үзэгдэх болсонд, амьтан халдахаа байж, шөнө бүр буг үзэгдэх тул, тэр байшинг хөлслөн суух ямар ч их зүрхтэй хүн байж чадахгүй болж гэдэг.

Суух хүн олдохгүй болоод ирэхэд, тэр хуучин байшин эзгүй сул, ханхай хоосон болж, мууджээ. Амьтан зүглэж орохоо байгаад, зайлж, тойрч явдаг болоод, ялангуяа үдэш буюу шөнө ер хавьтахгүй болжээ. Тэгтэл, нэг намар, үдшийн бүрийгээр тэр фаустын байшингийн үүдэнд нэг залуу оюутан хүрч иржээ. Гурван хошуут элэгдсэн малгай, барагтайхан дээл, өвдөгтөө хүртэл түрийтэй гялалзчихсан өмд,

нөхөөстэй оймс, майжгий гутлыг нь харвал, үгүйтэй ядуу шинж илэрхий.

Гуйлга гуймаар ядарсан, ер золбин нохой шиг, орох оронгүй, хөлслөх мөнгөгүй тул, амьтан оруулахгүй, Прагаар явж, явж байр хоног гуйж гуйж, хүн хавьтуулахгүй тул, өдөржин яваад, эцэж туйлдаж, тэр Фаустын байшингийн тэнд хүрч ирсэн хүн байжээ. Яагаад ч тэнд хүрч ирснээ өөрөө мэдэхгүй.

Харанхуй бүрхэг болж, намираа бороо ороод, жихүүн салхи сэнгэнэж, өнөөх муу дээлийнхээ зах заамыг яаж ч битүүлсэн горьгүй, муу гутал нь нов нойтон болж, бээрч даарч, бороо ч улам ширүүсээд, улам ч харанхуй болж, намрын орой хаа очиж хоног олох билээ?

Толгой түших газаргүй гайхтлаа, нэг харан гэхэд нь, хуучин гэгчийн муухай байшингийн тэнд хүрч ирсэн тул, эндээс ч хөөнө гэж хэлэлцэхгүй дэг ээ гэж бодоод, дотор маш гашуун болж, нэг хэсэг гайхасхийснээ, хаалганы бариул түлхээд орхитол, бага хаалга онгойж, хаалганы асар дотор ороод орхиход нь, бороо дуслахгүй, салхи ч сэнгэнэхгүй бөгөөд, баахан зүрх ормогц, цаашаа яваад үзжээ.

Шат өөд явахад, хоёр талын хөмөг дотор янзын хөрөг харагдаж, хонгилд хүрвээс, уртаас урт бөгөөд цаад үзүүр нь харанхуйд үл үзэгдэн, тэр хонгилоор өрөө тасалгаанд орох олон хаалга харлан харагдав. Чив чимээгүй, ханхай хоосон тэр байшинд гаднаас, эзгүй цэцэрлэгээс салхи шуугинах чимээ л дуулдаж байв.

Өнөөх оюутан, нэг хэсэг бодож байгаад, тэр өрөөнүүдийн ойрход хүрч, нэг тасалгаанд ороод үзвэл, бөмбөгөр адар дор нь харанхуй бөгөөд туурганы хагаст нь хүртэл царсаар хулдаж, хуучин сандал, шүүгээ мэт гэрийн хэрэглэл цөм бараан модоор хийсэн тул, тэр тасалгаанд бүр ч харанхуй юм шиг үзэгдэн, ардаа өндөр түшлэгтэй нэг сандал, ширээний тэнд харлан харагдаж байв.



Өнөөх оюутан, үүдэнд зогсосхийснээ, цааш нь явсаар, тэр сандалд хүрч очоод, ийшээ тийшээ харж чагнавал, байшин дотор хүн байгаа шинжгүй, үзэгдэх дуугарах юмгүй байв гэнэ. Гагцхүү гадаа салхи шуугинан, бороо цонх цохих ажээ. Өнөөх оюутан, тэр түшлэгтэй сандалд суугаад чагнаж байтлаа, бие нь ядарсандаа болж, бас бороо салхины чимээнд бүүвэйлүүлсээр унтчихаж гэнэ.

Арван нэгэн цаг хүртэл унтаад, шөнө дунд хүртэл унтаад, шөнө дундаас хойш нэг цаг хүртэл унтаад, цааш нь үүр цайтал унтаж, ер түүнийг өчүүхэн ч түйвээж үймүүлсэн юмгүй. Өглөө нь сэрээд, би хаа орчхоод байна гэж гайхан бодтол, орсон газраа санаж, энд ирээд амар сайхан унтсан юм байна гэж бодож олоод, айж зугтаасан ч үгүй, харин ч бас нэг тасалгаанд ороод сонирхон үзвээс, гэрийн хогшилтой, бас туургандаа хэдэн харласан, удаж гандсан зураг харагдаж, сахалтай эрчүүлийн царай л тэр зурагт арай тодхон харагдах шиг. Урьд нь тэр байшинд сууж байсан Фауст докторын тухай санаанд ороод, ажин харваас, ер түүнийг дурсган санагдуулах юм юу ч байхгүй.

Бас нэг тасалгаанд ороод үзтэл, хуучин ор, дээд талд нь лавиртай, лавирын даавуу нь гандчихсан бөгөөд, газар хуучирчихсан дэр хэвтэж, шороо тоос дарсан хоёр бандан сандал ойчоод хэвтэж, урьд нь цагаан

савхин хавтастай байгаад, хавтас нь шарлачихсан уранхай хуучин ном хэвтэж, адар дээвэрт нь том нүх, хар хүчээр цөм цохисон юм шиг харлаж харагдав гэнэ.

Өнөөх оюутан, түүнийг үзмэгц, бие зарс хийж, буг чөтгөр, тэр Фауст докторыг аваад явчихдаа тэгсэн тэгсэн юм гэж дуулсан нь яг тэр ёсоор байгааг үзэхдээ хулчийсхийж, тэр ванданг ноцолдож унагаасан юм байж, тэр номоороо буг чөтгөрийг цохиж байсан юм байж гэж бодонгуут, гар хүрч үзэхээсээ ч айж, бушуухан зайлав. Дараах нэг өрөөнд ороод үзвэл, онцын жигтэй юм үгүй, дээшээ адар өөд модон шат байхыг хараад, авиран гарсаар, бөмбөгөр адарт нь хүрээд, цаашаа орох нүхэнд тулж, тэр шатны хамгийн дээд талын гишгүүрт гараад орхитол, хойноос нь нэг чимээ гарсанд ухаан алдан айгаад, эргэж, хартал, өнөөх шат нь, цаасаар хийсэн юм шиг атираад, адартаа шингэчхэж гэнэ. Тэгээд, өнөөх оюутан нэг урьд үзээгүй бөгөөд, түрүүчийн хэдээс шал өмнөө тасалгаанд байж байв гэнэ.

Сандарсандаа, тэр газраа яаж хүрч ирснээ ч мартаж, өнөөх шатаа ч мартаад, дэмий л гайхан харваас, тэр тасалгаа маш уудам. Адарт нь нар сар, од гараг зэрэг огторгуйн элдэв бэлэг тэмдэг зураатай байв гэнэ. Хана дагуу, хуучны хавтастай том жижиг ном судартай ташингат тавиуртай, хэдэн ширээ дээр төмөр шил мэтээр хийсэн элдэв сав хэрэглэл, улаан, шар, хөх, тунгалаг ногоон уусгамал шингэн юмтай шил сав өрөөтэй байв гэнэ. Тэр том тасалгааны голд нь ногоон цэмбээр бүтээсэн бөгөөд солбицсон гурван хөлтэй нэг урт ширээ байж, тэр ширээ дээр зэс гуулин сав гялалзаж, янз бүрийн хэмжих хэрэгсэл, ном бичдэг саарь арьс, цаас, цөм шарлачихсан байдалтай, зарим нь бичигтэй, зарим нь бичиггүй баахан асааж байсан шинжтэй лав лаатай цагаан тугалган хатгуурын дэргэд нэг ном дэлгээтэй байж байгаа нь, нэг хүн урьд эрт тэнд байсан шинжтэй.

Өнөөх оюутан, тэр тасалгаанд нэлээд удаж, өнөөх буух онгорхой нүхний амсарт хүрээд очиход нь, өнөөх модон шат нь өөрөө гарч ирээд, доошоо бууж болох боллоо. Доод өрөөнөөс нь өнөөх Фаустын унтдаг газар оролгүй, өөр хаалгаар үүдний тасалгаанд хүрч үзвэл, сураар нэг тал хэнгэрэг мөрөвчилсэн жаалхүүгийн хөрөг хөшөө байж байгааг хараад, дэргэд нь очиж, тэр тал хэнгэрэг хэцэд нь гар хүрээд орхитол, тэр жаал хүү нь амьд юм шиг хөдлөөд, хэцээ пижигнүүлэн цохиж, хуруу нь жирэлзэн, хэц гэдэг тал хэнгэрэг нь цонх доргимоор

нижигнэв гэнэ. Чингээд, тэр жаал хүүгийн хэцээ нүдэж байхад нь оюутан айж сандрахдаа, яаран хонгил руу гүйж гарав.

Тэндээс гадагшаа үүдээр нь гарч, эзгүй хашаанд орвол, цэцгийн хүрээлэнгийн захад нь худаг байв гэнэ. Элсэн чулуун хашлаганд нь шар хаг ногоон хөвд ургаад, эм дом, тэргүүтэн модны унасан навч, шар улаан алаглан дарж, тэр худгийн маш хачин хийцтэй хуучин чулуун хөргийг хучжээ.

Тэндээс өнөөх цэцгийн хүрээлэнгээр явж үзээд, тэнд асар удсангүй.

Хөгшин модон дор, долоогоно, өтгөн шугуй сөөг дунд намрын жихүүн өдөр эвгүй санагдаж, бушуухан байшиндаа ороод үзвэл, чив чимээгүй. Өнөөх хэцчин хүү, хэцээ цохиж гүйцээд намдаж орхисон тул дахиж дэргэд нь очилгүй, өнөөх бөмбөгөр адартай том тасалгаанд ороод бичиг цаасыг нь үзтэл, тэр цаасан дор нэг цоо шинэхэн гялалзсан мөнгөн талир зоостой хар гантиг чулуун сав олжээ.

Мөнгө олсондоо баярлаад, бас гайхан эмээж, одоо яадаг билээ гэж нэг баахан зогсож бодохунаа, өвөрт нь сохор зоос ч байдаггүй, бас гэдэс нь өлсөж байгааг хэлэх үү? Заа, өнөөх Фауст ч байг, буг нь ч байг дүүрсэн хэрэг! гээд, айж айж, гайхаж гайхаж, тэр талир зоосыг нь аваад хот оржээ. Орой нь юу ч гэсэн буцаад ирж, гэдэс цаггалан болсон боловч, шөнө буг чөтгөр үзэгдэх болов уу? гэж баахан дотроо айж байшиндаа ороод, урьд шөнийн адил өнөөх түшлэгтэй сандалдаа суугаад унтах гэтэл, урьд шөнийн унтсантай адил санаа амар унтаж чадаагүй, сэрэн барин хэвтэвч, Фаустын сүнс ч үзэгдсэнгүй, ондоо чөтгөр шулам ч үзэгдсэнгүй гэнэ.

Чингээд, дахиад өнөөх номын санд очиж, юм хүмийг нь үзтэл, мөн л өнөө хар гантиг саванд ахиад нэг талир зоос байв гэнэ. Өчигдөр ганц зоос байсны нь аваад, хот орж задлаад, үлдсэн хэдэн мөнгө нь өвөрт нь байтал, тэр хар сав дотор бас нэг зоос, сүү шиг цагаан юм хэвтэж байгаа нь надад л зориулсан юм байна даа, Фауст доктор юм уу, ондоо нэг юм надад шагнаж байгаа юм биз дээ гэж бодоод авч гэнэ.

Үдийн өмнө гадагшаа гараад, орой буцаж ирэхдээ бас тэр хоёр удаагийн зоосноос үлдсэн мөнгө өвөртөлсөн хүрч ирээд, өнөөх байшиндаа урьд шөнийн адил айван унтаж хонов гэнэ. Өглөө нь өнөөх номынхоо санд яаран очиж, ширээний зүг ойртож хартал, бас нэг талир зоос, сав саяхан дэлдэж хийсэн юм шиг гялалзаж, өнөөх л хар

сав дотор хэвтэж байв гэнэ шүү. Энэ лав надад л зориулаатай юм гэж бодоод, ний нуугүй аваад орхиж гэнэ.

Чингээд, өглөө бүр л тэнд нэг талир зоос бэлэн байдаг болж гэнэ. Тэр оюутан өдөр бүр тийм мөнгө зарж бардаггүй тул, үлдсэнийг нь хураасаар байгаад, шинэ хувцас, цув, малгай, шинэ гуталтай болж аваад, юмаар дутаж гачигдахгүй, орон сууц гэж санаа зовохгүй болоод, Фаустын байшин гэж айхаа ч болиод, ямар нэгэн хий юм асарч харгалздаг болсон, айван тайван газар суухдаа, тэр юм нь ч үзэгдэж нэхэхгүй, өвлийн цаг түлш гадаа хашаанд мөн цэцэрлэгт мод элбэг, гал өрдөж, нэг бол дор задгай галын хөмөгт галлаж, нэг бол, дээр номын санд гал түлээд Фаустын номын сангийн номоос, бас тэр ном ширээнд байсан номоос, дор унтдаг өрөөнд байсан ном судраас дураараа уншдаг болж гэнэ. Тэр унтдаг тасалгааны номд нэлээн дасаад ирсэн хойноо зүрхлэн хүрч үзвэл, жигтэй жигтэй харын зүгийн тарнийн үсэг зураг, янз бүрийн тамлага дуудлага ихтэй ном байв. Тэр харын зүгийн судрыг айж эмээж уншихдаа, заримдаа үс нь сөхүйн босож, ар нуруугаар нь хүйт даадаг байв гэнэ.

Чингээд, ганцаараа суухдаа уйсаад, өөр газар нүүж очихоосоо бас дургүй. Үймүүлэх юмгүй, санаа амар сууж сураад, өдөр бүр нэг талир зоос, ажил төвөггүй олддог нь таатай байлаа. Их сургуулийн нөхөд нь, яван яван тэр оюутны шинж байдал ондоо болж, гоёмсог ганган болох тусам нь энэ маань яачхаж байна гэж гайхдаг болжээ. Суудаг газрыг нь мэдээд зэвүүцэн хэлмэгдэж, урихад нь ч очиж зүрхлэхгүй байснаа, зарим нэг нь хачирхан сонирхоод, зориглож очиход нь орон байраа цөмийг нь үүдний тэндээс дээд тасалгаа, үүдний танхим, олон өрөө, номын сангаар дагуулан үзүүлээд, өөрөө унтдаг болсон учир дэр дэвсгэрийг нь сэлбэж засаад, унтдаг болсон хонох тасалгаагаа үзүүлж, адар дээврийн нүхийг нь хивсээр тагласнаа харуулаад, цэцгийн хүрээлэнгээр дагуулан явж, тэр хуучин байшинд суухдаа мэддэг болсон бүгдийг харуулжээ.

Тэд нь, тэр битүүлэг нууц төгөлдөр байшингийн гайхалтай юмыг тун жигтэй гэж сүр бадруулан ярьж, өөрөө хэц цохидог жаал хүү байдаг юм, аяархан дуулдаг хачин сонин хөрөг байдаг юм, гар угаах ус хийж өгдөг төмөрлөг авхай байдаг юм, нэг тасалгаанд нь оч гялалзуулан, гар хүрсэн хүнийг цохидог өрөө байдаг юм, дээр нь нэг байр байдаг нь, доошоо шат нь өөрөө буугаад, дахиад дээшээ хураагдчихдаг юм, жигтэй сонин сав хэрэгсэл, илбэ жилбэний ном

судар байдаг юм гэж ярьцгааж, байшин доорх зооринд, урт гүн хонгил руу ордог төмөр хаалга бий гэж мэдээд авчээ.

Өнөөх оюутан, гагцхүү цагаан талир зоостой хар савынхаа л учрыг мэдэгдсэнгүй. Чингээд, таних хүнээ тэр байшинд удаан байж болохгүй, нэгэн цагт л биш болж, буг чөтгөрт алуулна гэхэд нь инээдэг байжээ.

Цаадуулын тэр үг дэмий хоосон үг биш байж, тэр хар саванд сэтгэлийг нь татах далд учир байж л дээ.

Тэр оюутан өдөр бүр нэг талиртай болоод, аж төрөх гэж арга саам эрэх, ажил хийх хэрэггүй, бэлэн зэлэн юманд амтшин дасаад, элдэв юм санаанд нь орох болж, гоёх гангалах болж, зардал нь нэмэгдээд байх болж, тэгтэл, өнөөх саванд нь юм нэмэгдэхгүй тул, ганц талир нь хаашаа ч хүрэхгүй болж ирлээ.

Тэр оюутан, хэмжээтэй бор байдлаа алдаж, анх хүрч ирэхдээ ямаршуу байснаа бүр мартаад, ажил хичээл хийх дургүй болоод, их өрөөний ширээ дээр байсан ном, бас унтдаг тасалгаанд хэвтсэнийг нь олж авсан номд шунаж, яаж чөтгөр дуудан урих тарнидах юманд нь хорхойтох боллоо. Тэр юм нь өөрт нь одоо хүртэл халдан үзэгдээгүй, үймүүлж түйвээдэггүй бөгөөд, өөрөө ч бас тэднийг дуудахаас арай баахан гайхдаг зовдог байснаа, алтанд шунах тусмаа, мөнгө нь хүрэлцэхгүйд дуудан оролдоод үзмээр санагдаж, өнөөх саваар дүүрэн талир бий болсон ч ханамгүй, алттай л болох юм сан гэж шунаг сэтгэл улам хөдлөөд, тэр увдисын номын хүчээр хүслээ ханах сан гэдэг болжээ.

Нэгэн өдөр Прагаар шувт наргин завхайраад, арвилан хураасан мөнгөө цөмийг нь үржээ. Наргихдаа уруу татах хоромжит нөхдийнхөө өмнө сайрхаж, нарийлалгүй ууж нарги, маргааш би бүр ч их мөнгөтэй болно. Хүнээс зээлдэлгүй, өөрийнхөө алт зарна, надад зарагдаж байсан тэр бугийг урьдын адил мөнгөн талир өгөлгүй, ёстой шижир дукат зоос өг гэж шахна гэж сагсуурчээ.

Үдэш орой болсон хойно Фаустынхаа байшинд хүрч очиход нь, хэдэн согтуу нөхөд нь хамт дагалцсанд, болохгүй, би ганцаараа байж, хийх ажил их байна гээд халгаасангүйд, лут хүнд хаалганы хавтас дахь бяцхан явган хаалга хойноос нь хаагдсаныг хараад хоцорч, дахин тэр оюутантай уулзаж чадсангүй. Бусад хүн ч олж уулзсангүй. Сургуульдаа ч үзэгдсэнгүй, шал дэмий найз нарынхаа дунд ч үзэгдсэнгүй.

Чингэхэд нь, урьд түүнтэй өнөөх Фаустын байшинд орж үзсэн танил хүний зарим нь, очиж тэр байшинд нь хайгаад олсонгүй. Байшин нь юу ч үгүй, хоосон, ханхай, эзгүй бөгөөд өнөөх оюутан яачихсан нь ч мэдэх ор мөргүй. Гагцхүү унтдаг тасалгаанд үзвэл, ор дэвсгэрийн юм сандаргаж, дэр нь газар хаяатай, хувцас хунар нь энд тэнд шидэлчихсэн, цув нь навтас болтол уруулчихсан, сандал суудал нь хөмөрчихсөн, илбэ тамалгын нэг хагархай хуучин ном шал дээр хаяатай, дэргэд нь шатаж урссан лаатай хөмөрчихсөн суурь байхыг олж үзлээ.

Тэр бүх байдлыг шинжвэл, ямархан нэг юм сүрхий ноцолдон тэмцсэн шиг. Чингээд, адар дээвэр өөд харвал, өнөөх хивс таглаа нь газар урагдан тасран ойчоод, адарт онгойсон нүх харлан харагдах нь, ухаараа нэг муухай юм болчихсон нь, цус олгойдсон юм шиг. Ажиглавал, удсан, тас харласан нөж биш, саявтархан наалдан үсэрсэн цусны шинжтэй.

Түүнийг үзээд, сандран наманчлаад, Фаустын тэр байшингаас бушуухан гэгчийн зайлж гарч, нөхрөө үхлийн муугаар үхсэн юм байна гэж хирдхийжээ. Чөтгөр бугийг тамлан дуудаад, ихэрхэн авирлахад нь, цаадах нь гижиг нь хүрч, урьд цагт Фауст докторыг аваад цөм цохин гарсан дээд адрын нүхээр өнөөх оюутныг аван шүүрээд алга болон одсон байжээ.⁴⁴

* * * *



Прага сайхан эх хот оо, чиний сан дотор эртний домог тууж юутай олон бэ!

Манай анхны дуртгал маань Чи шүү. Чи эх нутгийн маань гол зүрх, эх тэргүүн нь шүү. Чиний яруу алдар, Чиний муугаа үзэх чинь, бүх улсын маань яруу алдар, бүх улсын маань муугаа үзэх нь юм шүү. Журамт Чех бүхэнд чи хайртай халуун дотно шүү. Түмэн үе тогтносоор, манай олон хотын эх болсон чи, түмэн үеэр чимэг хийсэн шүү.

Нарны гэрэл туяанд намбатай сүрлэг үзэсгэлэнтэй шүү, чи минь, үлгэр домогт гардаг юм шиг, сэтгэл татаж сайхан шүү чи, саран гэрэлд орсон сайхан зүүд шиг таатай шүү чи, түмэн үеийн түүх сэтгэл хөдлөлтэй чамаар тодорно шүү.

Буянаа дэлгэрэн хөгж! Манай вангуудын ууган нийслэл болсон чи минь эсэн атугай!

Бид одоо цаашаа өөр газар нутгаар, олон үеийн мөр даган, эртний түүхнээ дуурьсах олон өнгөрсөн үеийн чимээг сонссоор одлоо.

Эх болсон Прага маань эсэн атугай! Слав алтан Прага аа!

* * * *

Хэмээсэн энэ уяралт домгоор чехийн алдарт эх оронч их зохиолч Йираасекын Алоис «Эртний чех домог» гэдэг нэрт зохиолын эхний хэсгийг төгсгөв. Дэд дэвтэр болгож, төгсгөлийн домгийг нь жаран нэгнийхээ хөхөгчин могой жил ороход орчуулан барж чех хэлээр нэгэн дэвтэр байдаг энэ зохиолын нэгэн хэвлэлд чехийн утга зохиолын судлалтан Шинжлэх ухааны Академийн нь ерөнхийлөгч бүлгээ Неедлы Зденек агсны хавсарган бичсэн төгсгөлийн үгийг монголчилж гаргая.

Зав муутайн учраас, энэ сайхан зохиолыг орчуулахдаа ахиж эргэн шүүх цаг олдож өгсөнгүй. Насны наран хэлбийж, монгол хэл бичгийн судлалын хувьд хийх зүйл өдий төдий. Түүнийгээ барьж бичих насны хэмжээ гүйцэмгүй цагийн хясаанд хавчигдсанаас сайхан зохиол орчуулах санаа байвч, цаг зав олдохгүй, амсхийх цагаа хасаж орчуулснаа нягтлан үзэх аргагүй болсон учраа гаргаж дахин хүлцэл өчье. Ардын төрийн ачаар хэдэн хэл сурсныхаа ачийг ард түмэндээ номоор хариулья гэж ингэж чадан ядан орчуулаад, энэ төрийн эхээр дэлхийн утга зохиолын сангаас монгол уншигч нартаа зориулан орчуулга хийж байсан хэдхэн орчуулагчийн нэг нь болсон өтгөс миний

бие, одоо насан залуу, авьяас төгөлдөр хойч үедээ халаагаа өгч, өвгөн буурал орчуулагч нараасаа улам ч сайхан, улам ч их орчуулга хийж, урьд гарсан чихнээс хойно гарсан эвэр гэж, бидний алдсан оносон зүйлээс алдсаныг гээж, оносныг улам бадруулж, монгол зохиолдоо дэлхийн их зохиолын сангаас бидний үеийнхээс зүйрлэшгүй ихээр орчуулах биз ээ гэж итгэн баярлана.

Дэлхийн их уран зохиолоос залуу үеийн эх оронч эрдэмт орчуулагчийн зүтгэлээр монгол зохиолын далайд мөрөн гол мэт цутган орох болтугай! гэж өтгөс дуун хөрвүүлэгч Ринчен ерөөл дэвшүүлэв.

1965 оны хэвлэлийн Хэв лэн нийт лэлийн мэдээлэл:

Йираасек Алоис

ЭРТНИЙ ЧЕХ ДОМОГ ТУУЖ

Alois Jirasek

STARE POVESTI CESKE

Орчуулсан Б. Ринчен

Редактор Г. Амар

Зургийг Черны Веценслав (Věnceslav Černý)

Техник редактор Ж. Сүх баат ар

Хянагч Ж. Жамьян

Хэвлэлтэ д 1964 оны 10-р сарын 20-ны өдөр

Хэвлэсэн тоо 3048

Цаасны хэмжээ 70X108 1/16

Хэвлэлийн хуудас

Хэв нэгж хуудас

А— 20028

Зах № 35

Сүхбаат арын нэрэмжит Хэвлэлийн юмбинат
Улаанбаат ар, Сүхбаат арын т албай 2.

Notes

[←1]

Жип уулын тэндхэн Цтинеvсийн хавьд тэр Чех өвгийн булш байсан юм гэдэг. 18 дугаар зууны үед хуучны дурсгалын зүйлд дуртай хүн, Цтинеvсийн цогчин дуганд буй хүүрийн оршилд булш нь бий гэж үзээд ухаж үзэвч ор мөр ч олдсонгүй. Зарим хүн бас Цтинеvсийн ойр хавьд «зүүн зүг» Желивын оройд Чех евөөг оршуулсан болов уу? гэдэг уул Желети гэж хайлан гашуудах гэсэн утгатай үгнээс гарсан юм гэж ухаад бас булшийг нь олсонгүй.

[←2]

Косма түүхчийн тэмдэглэсэн нь Пшемыслын тэр дурсан чархи Өндөр шилтгээн — Вышеград гэдэгт ноёны өрөөнд одоо хүртэл хадгалсаар үүрд нандигнана гэжээ. Өндөр шилтгээнээ ноёдыг ширээнээ залахад, Пшемыслын тэр дурсан чархи заан үзүүлдэг байжээ. Вангуудыг ширээнээ залахад, мөн тэгдэг бөгөөд гагцхүү Вацлавыг ширээнээ залахад, түүний зарлигаар чархи үзүүлэхийг байлгасан гэдэг. Тэр чархи өндөр шилтгээнээ 15-р зууны үе, хүсынхны дайн хүртэл байсан гэдэг.

[←3]

* Чонын хаалга гэж, Богд Аполинааржийн цаадах оргил.
«Баруун гар талын өргөн өндөр» гэж — одоогийн Шинэ хот —
Нове Место гэдэг Прагийн хэсэг байгаа гаар.

[←4]

Гурван оргилт уул гэж, Кутна Хора буюу Хүдэрт уул гэдгийн хойд зүгт буй гурван оргил бөгөөд хуучин уурхайчин түүнийг Куклик, Каньк, Труканийн уурхай гэж нэрлэдэг байжээ. (Гурван удаа эрдэнэ нь хаягдаж гурав дахин сэргэнэ) гэсэн нь гурав дахин уурхайг халж гурав дахин сэргээнэ гэсэн үг. Анх удаа нь хоёрдугаар Пшемьсл ван, Хансбургийн Рудольфтай байлдах цэрэг хөдөлгөхдөө Кутна Хора гэдэг Уурхайт уулын тэнд хэрэглэж байсан (500) адууг цөмийг нь дайчилсан уурхай нэг хаягджээ. Түүний хүү хоёрдугаар Вацлавын үес уурхай дахин сүрхий сэргэн ван тэр уулнаас их мөнгө ухуулж авсан билээ. Хоёрдугаар удаад Хүсынхн дайны үес тэр уурхай хаягдаж, сүүлд нь ван Иржиг, хоёрдугаар Владиславын үед сэргээд, гучин жилийн дайнд өртөж, 16 дугаар зууны хоёрдугаар хагас, 17 дугаар зууны эхээр хаягдсан тэр гуравдугаар удаа нь Либүшийн бошиг үзүүлсэн гуравдугаар удаа хаягдах нь тэр боловч, гуравдугаар удаа сэргэх нь одоо хүртэл болоогүй хэрэг

[←5]

Цтирадын тэр нөхөд, хадны оройд ясаа тавиулж одоо тэр газар булш дунд нь богд Матээн бяцхан дуган бий.

[←6]

Цтирадыг алсан газар Өндөр шилтгээний тушаа нэг өндөрт одоо Цагаан хад гэж нэртэй. Урьдын улс Цтирадын тэнд гэж тэр газрыг нэрлэдэг байжээ. Өвгөд одоо ч тэгж нэрлэдэг.

[←7]

Бецковский, хуучин домог заан дурдсан нь Жлиховын оройд, “Прагаас Збраслав орох замын солгой талд одоо Филип Якуб хоёрын дугуй сүм байгаагийн тэнд тэр хүлэг морины мөр нь байсан” гэжээ. Тэр дугуй үгүй болоод, одоо байгаа нь арван наймдугаар зууны үед босгосон дуган билээ. Неуметелд Шемийкийн авсыг их нандигнан хадгалдаг бөгөөд хэн ч хамаагүй хүрч болдоггүй. Хуучин домогт тэр авс булшийг эвдвэл тэр нутагт их аюул учирна гэж хэлэлцдэг бөгөөд, өнгөрсөн зууны далаад оны үед Прагийн нэгэн эртний судлагч хүн тэр булшийг ухах гэхэд хавийн амьтан цуглаж, тэр эртний судлагчийг хөөсөн билээ. Шемийкийн авс дээр бичээс бий нь: «Неуметелийнхэн энд Хоримийр морьтны журамт хүлэг Шемийк булаатай гэж итгэсээр ирсэн» гэж бичээтэй бөгөөд булшны дээр босгосон бяцхан хөшөө дээр зарим хүн үзэхдээ морины толгойн дүрс бий гэж үздэг. Неуметелийн таг дор буюу босго дор нь Хоримийрийн эрдэнийн сан булаатай бий гэж хэлэлцдэг үг бас бий.

[←8]

Властислав шилтгээн Литомешицед Ловосицийн тойрогт байжээ. Космаагийн дурдсан тэр уулсыг Далимал сударт Ээвэр уул гэдэг Пшипек Ловос уул гэж нэрлэжээ. Ловос уул нь одоо Вхницийн тэнд Овчин гэдэг уул. Дээр дурдсан эртний шилтгээн Властиславын гацаа айлын ойр голын дээрх ууланд байсан бөгөөд одоо далан нь үлджээ. Шинэ үес тэнд бага сага шинжилгээ хийж эртний төмөрлөг эдийн зэрэг зүйл ухаж олсон билээ.

[←9]

Лүкүүд нутаг Космаагийн тэмдэглэлээр таван отог байжээ. Нэн эрхэм их нь Лүкүүд отог гэж одоогийн Жатекийн талд нутаглажээ. Тэр отгийн нэрээр бүх аймгийг Лүкүүд гэж нэрлэдэг билээ. Нөгөө нэг отог нь Бшеснице буюу Броцнице гол, одоогийн Блшаны тэндэх голд нутаглаж гуравдугаар отог хомуутовсхад, Охаркад Постолопрын тэнд цутгадаг Үүзкес буюу Нарийн горхийн хавь нутагтай, дөрөвдүгээр отог нь Локет хязгаарын нэг хэсгийг эзлэн, тавдугаар отог уулын Мжа голын модон захаар байсан байжээ.

[←10]

Властиславын шилтгээн гэдэг Лүкүүдийн төв суурин, Охарка голын тэндэх уулын оройд байсан бөгөөд хожим тэнд нь Жатекийн отгийн шилтгээн осолгүй байсан бололтой.

[←11]

Хөө хуяг гэдгийн хөө гэдэг үг нь угтаа жижиг цагаригийн нэр тул хөө хуяг, хө халхавч гэж жижиг цагаригаар хийсэн хуяг, халхавч гэсэн үг. Тэр хөө гэдэг цагаригийн нэр бол тогооны хар хөөтэй дуудлага ижил, утга өөр үг.

[←12]

Эртний словууд хүүхдийн даахийг долоон насанд нь авч, найр хийдэг байжээ.

[←13]

Постолопртийн тэнд Охарка голын зах дахь нэг намхан шиг хадан хошуу дээр тэр шилтгээн босгожээ.

[←14]

Тэр Кирил гэдгийн слов хэлээр ном номлох гэж зохиосон үсэг нь дэлхий дахинд одоо түүний нэрээр Кирил үсэг гэж алдаршиж, улс болгонд нэршсэн билээ (Орчуулагчийн тэмдэглэл)

[←15]

Анхны тамлуулагч гэж Христостон Христосын ном дэлгэрүүлэх гэж яваад бөө мөргөлтөнд тамлуулан үхэгсдийг нэрлэдэг. Христосын шашнаа тийм хүнийг богдоо хэмээн өргөмжлөн шүтэх бүлгээ. (Орчуулагчийн тэмдэглэл)

[←16]

Бенедикт, Матоуш, Изаак, Кршитиан, Ян энэ танан номын ах дүү даяанч нар Польш нутагт 1004 онд дээрэмчинд тамлуулсныг хэлжээ.

[←17]

Юдит гүнжийн чулуун гүүр, 1342 оны үерээр идэгджээ.

[←18]

Одоогийн шинэ хотын байгаа буурь нь юм.

[←19]

1348 оны гуравдугаар сард Вышеград гэдэг Өндөр шилтгээнээс Поршицигэдэг мөрний зах хүртэл хотын хэрэм босгож эхэлсэн билээ.

[←20]

1372 онд гүйцжээ.

[←21]

Германы фашистууд чехийг түрэмгийлэн эзэлсэн үес тэр эртний дурсгалт сүм хийд бөмбөгөнд сүйрсэн билээ. (Орчуулагч)

[←22]

Карл вангийн 1351 онд

[←23]

Карлын тэр сүмийн гаднах байдал нь одоо анхны хэвээс ондоо болчихсон. Х үеийн дайнд их гэмтээд, хожим сэлбэх засах үед нэлээд өөрчлөгдөж, сайхан чимэг засал нь үүдэнд нь хүртэл эвдэрч, гагцхүү нуман нуруу нь уулын байдлаар үлдсэн.

[←24]

Тэр Вийтийн сүмийг 1343 онд босгож эхэлсэн билээ.

[←25]

Тэр гүүрний суурийн чулууг хуучин хотын талд нь 1357 онд тавьсан гэдэг.

[←26]

IV Карл ван, тэр гүүр дуусахыг үзсэнгүй гэдэг. 1406 онд тэр гүүр дээгүүр улс амьтан явдаг болсон боловч, гүйцэд барьж арай дуусаагүй. Хуучин хотын талд байдаг гүүрний цамхаг арай босоогүй байсан бүлгээ.

[←27]

Юдит хатны үеийн баг дурсгал ажээ. Тэр толгойгоор мөрний ус үерлэхийг хэмжин мэддэг байсан үүнд, Сахалтын хамарт ус хүрвэл, айхавтар үерлэсний хэмжээ байдаг бөгөөд 1481 онд нэг их үер болоход Сахалтын толгой нь бүр далдарсан гэдэг.

[←28]

IV Вацлав ван, Ротлевын тэр байшин худалдаж аваад, 1383 онд Карлын сургуулийг Лазар Жидын байшинд байсныг оруулж, чингээд Ян Ротлевын тэр байшин Каролиnum гэдэг нэртэй болжээ. 1718 онд тэр байшингийн танхимуудыг Фр. Канька өөрчлөн зассан учраас, урьдын байдал эвдэрч, угийн барилгаас богд Косма Дамиан хоёрын бяцхан сүмийн гулдан багана нь л үлджээ.

[←29]

Монголоор өдөр шөнийн зургаан цаг гэдэг нь, өглөө, үд, үдэш, үдшийн шөнө, шөнө дөл, үүрийн шөнө гэж зургаа хуваадаг хувиар, бас үд, шөнө дөлийг хасаад, өглөө, үдэш үдшийн шөнө, үүрийн шөнө гэдгийг өдөр шөнийн дөрвөн цаг гэж дөрөв хуваан, түүнээс товчоор хэлбэл өдөр шөнө хоёр гэдэг.

[←30]

Хоёр цамхгийн оройг дөрөвдүгээр Вацлавын зарлигаар алталсан юм байжээ.

[←31]

1419 оны долоон сарын 30-нд

[←32]

Богд Вийтийн сүмийн цамхаг, уг хүргэвэл зохих өндөртөө хүрэлгүй 1541 оны их галд гэмтээд тэр галын сүүлээр сэлбэснийг саях домог баахан ондоогоор тайлах ажээ.

[←33]

Вангийн ясыг Шинэ шилтгээнээс Өндөр Шилтгээнд аваачаад тэндээс богд Вийгийн сүмд оршуулах гэтэл, их салхи хөдлөөд, явж болсонгүй, арга буюу Збрасловын хийдийн сүмд түр оршуулсан билээ.

[←34]

Түүрэг улс Европод цөмрөн орж, Бизаант улсын нийслэл Константинополь гэдгийг эзлэн, тэндэх Софийн дуганг лалын дуган болгосонд, Христосын шашинтан, түүргийг үлдэн зайлуулж Хаан балгас гэдэг Константинополь хотод Софийн дуганд дахин христосын хурал хурна гэж домоглон хэлэлцдэг байжээ.

(Орчуулагчийн зүүлт үг)

Орлой цаг гэж цонж цамхагт зоодог маш том цаг. Эртний чехийн орлой цаг нь өдөр шөнийн 24 цаг заасан хуваарьтай байжээ. 15 дугаар зууны сүүлээр тал орлой гэж арван хоёр цаг хуваасан орлой цаг гарч ирснийг герман орлой цаг гэж нэрлээд, 17 дугаар зууны үе хүртэл тэр хоёр зүйлийн орлой цаг хэрэглэж байгаад 1623 оноос тал орлойг албан ёсоор хэрэглэх болжээ. Хуучин хотын эл орлой цагийг сохор залуугийн урласан цаг гэж бас хэлэлцдэг домог бий. Чухамдаа 1490 онд хоёрдугаар Владислав вангийн үеийн цаг бөгөөд, шавь Якублугын хамт урласан алдарт зурхайч багш Хандшийн бүтээл даруй мөн. Түүний нас элэгдсэн хойно тэр орлой цагийн мэдээч Ирши Званек гэдэг хүн эвдэж орхиод, Парчигнаат уулын Таборски Ян гэдэг бичээч зураач хүн зассан гэдэг. Тэгээд нэгдүгээр Фердинанд вангийн үед тэр орлойд 12 цаг заасан толь хавсаргаж, Таборскийн нас нөгчсөн хойно орлой цагийн оньс нь муудаад хэн ч засаж эс чаджээ. Тэгээд 18 дугаар зууны үес Прагийн хотын албаны хүмүүс тэр орлой цагийг эвдэрхий төмрийн үнээр худалдах гэтэл, алдарт зурхайч профессор Антонин Стрнад татгалзаж, эвдүүлсэнгүй, Ландсбергер гэдэг цагчин хүнийг олж, орлой цагийн бүх оньсыг засуулсан нь, хожим бас эвдрээд, 1865 онд Холуб гэдэг цагчин хүн сайн засаад, одоо хүртэл явж байгаа нь тэр. Тэгж зассанд 1866 оны шинэ жилийн шөнө цаг тааруулан явуулсан бөгөөд цагийн тооны том толины дор хуанлийн цаг улирал заадаг арван хоёр ордтой хүрээг нь Йозэф Манешийн уран чадлаа гаргаж бүтээсэн зүйл билээ. Одоо тэр хүрээг нь Прагийн хотын музейд хадгалж, орлой цагт түүнийг Е. Лишке гэдэг хүний дуурайн зурсан хүрээ тавьжээ. Тэр орлой цагийн байдлыг Таборски Ян 1570 онд чехээр маш тодорхой бичсэн бичиг нь хотын хуучин дансны газар Таборскийн биеийн дүр зургийн хамт бий. Тэр Таборскийн зохиолоос авч Балбин гэдэг хүн, тэр хоёрын, зохиолоос авч, орлойн түүхийг германаар бичжээ. Балбины Бохуслав гэдэг хүн, орлойн түүхийг латинаар бичээд, 18 дугаар зууны үес Ригер гэдэг хүн орлойн түүхийг германаар бичжээ. Балбины тэмдэглэлд бас нэг бор шувуу, орлой цагийн хохимой нь цохиж амаа ангайхад нь, нэг бор шувуу аманд нь нисэн ортол, цаг цохиж гүйцээд хохимой,

амаа жимийж, өнөөх бор шувуу ам дотор нь бүтэн нэг цаг суугаад,
цаг цохих цаг болж, хохимойн ам ангайхад баярлан нисэж гарсан
юм гэнэ билээ гэж бичсэн зүйл бий.

[←36]

Тэр нь одоо Дарийн хаалга гэж нэртэй цамхаг 1475 онд
Простеповын алдарт уран Матээ Рейсек босгож эхэлсэн юм гэдэг.

[←37]

Тэр үеийн хоригдол хоолоо өөрийн хөрөнгөөр авдаг байсан тул, мөнгөгүй буюу нөхдийн тусламжгүй хүн их л өлсдөг байлаа. Тэгээд идэх юм гуйх гэж гарч, гинж тушаатайгаа айл дамжин хоол гуйж явдаг байсан билээ. Зарим нь гяндангийн цонхоор уут унжуулан өлгөж, өрөвдсөн хүн тэр уутанд нь амь залгах юм хийж тусалдаг байжээ.

[←38]

Тэр синагог гэдэг жүүд сүмийн анхны хуучин барилгыг шинэтгэн сэлбэж зассан боловч, анх босгосон нь нэн эртний тул, хожим шинэтгэсэн учир, хуучин шинэ гэж нэрлэжээ. 1142, 1316 оны үес их гал гарсанд, хоёр удаа тийнхүү хайлсан дуганы барилгыг сэлбэж босгосон билээ. (Чехүүд еврейг жид гэж чех хэлээр нэрлэдэг үүнд, хуучин монгол эртний судар бичигт, дундад эртний үес мөнхүү еврей угсаатныг монголчууд жүүд гэж нэрлэдэг байснаар Йирасекийн энэ домог монголчлохдоо, тэр жил гэдэг үгтэй холбоотой бөгөөд, дундад эртний үес нэрлэж байсан жүүд гэдэг монгол нэр хэрэглэлээ. Монголын жүүд гэдэг нь орос хэлнээ иудей гэдэг нэр (мөн еврей, угсаатныг нэрлэдэг нэр), германаар йүдэ гэдэгтэй, чех польшийн жид гэдэгтэй гарал холбоо нэгтэй үг болой. Орос хэлэнд тэр жид гэдэг үг бас бий боловч, утга нь дарлан доромжлох санаатай болсон муу үг болон сунжирчээ. Чех дундад эртний монгол хэлнээ доромжлох утга үгүй, нэгэн улс угсаатны нэр ажгуу, Тэр учир, одоогийн чех хэлнээ оросоор еврей гэдгийг жид гэдэг бөгөөд, монголчууд дундад эртний үес эл угсаатантай танилцахдаа, тэр үед дэлхийд тархсан нэрийг нь монгол аялгуунаа нийцүүлэн жүүд гэдэг байжээ. Монгол, орос-герман гэсэнтэй адил, нэгэн зүйл угсаатны монгол нэр ажээ. (Орчуулагч)

[←39]

Орислим гэж дээр цагаас монгол бичгийн дурсгалд нэр нь гардаг еврейн эртний түүхт хотын нэр. Чехүүд Иерусалем, оросууд Иерусалим, Францууд Жерүзалем, хятадууд Елусален, англиар Джерүсалэм, унгарууд Ерүжаалэм гэх зэргээр улс улс өөр өөрийн хэлний аялгуунд оруулан нэрлэдэг хот. Христосын шашны сударт нэр их гардаг нь, монголчууд, дундад эртний үеэс Орислим гэж нэрлэн заншсан бөгөөд, тэр түүхт хот одоо хүртэл хэвээр буй тул, манай хэлэнд нэр нь орсоор бас л олон зуун жил болсон соёлын уламжлал байгаа хэрэг (Орчуулагч)

[←40]

Анхны тэр сүмийн барилга нь сэлбэн шинэтгэсээр, өнөөх л суурь дээр нь шинэтгэсээр ирсэн тул, шинэ сүм болж, тэр учраас хуучин шинэ сүм гэдэг нэр олсон гэдэг. 1142, 1316 оны хоёр их гал гарах үес хайлсан тул, хоёр удаа шинэтгэн босгосон байжээ. Орох шат нь 9 гишгүүртэй.

[←41]

Чухам үнэнийг нь магадалбал, XII зууны үеийн сүм болно.

[←42]

Тэр хуучин жүүд оршлын газар 1781 он хүртэл хүн оршуулж байсан байна. Жүүдийг гетто гэдэг гортигтой газраас гарч суух эрхийг нь, Хоёрдугаар Иосеф хааны үед олгосон билээ. Жүүд хотыг Прагаас хуучин хот байсан гэдгийг Ароны угсааны лам йосеф Кацын авгай Сарын хүүрийн гэрэлт хөшөөний үсэгт 606 дугаар он гэснээс үндэслэж хэлэлцэх хүн бий. Зарим хүн, тэр оны тоог 1606 гэсэн байх ч гэж боддог хүн бий.

[←43]

Хуучин хотын талбайг 1848 онд шалдан засахад нь тэр чулууны ихэнхийг зайлуулсан билээ. Нэг хэдэн чулуу Урт гудмын зүг үлдээд байсан нь, ойрмог үес үгүй болон салжээ.

[←44]

Орчуулгын үг: Фауст докторын энэ домог бол, Европ зүгт тун алдартай бөгөөд, боловсролтой хүн бүхэн цөм мэддэг домог. Германы нэг илбэчин магус гэж монголоор бичдэг бөгөөд муус ч гэж зарим газар монголчуудын дууддаг энэ үг бол, оросоор «маг», францаар «мажисьен» (үүнээ латин үсгийн «г»-ээг францаар «ж» гэж дууддаг юм), (германаар бас магикер гэх зэргээр нэрлэдэг байна) Фауст доктор гэгч, Мефистофелес гэдэг шимнуст бугт энэ насанд намайг элбэг хангалуунаар жаргуулбал, сүнсээ чамд өгнө гэж наймаа таарсан гэж хэлэлцдэг домог байснаас германы дэлхийд нэрт зохиолч, яруу найрагч Гөте, Фауст гэдэг жүжиг болгон зохиосон нь, орчин үеийн боловсролт аль ч улсын хүн цөм мэддэг зохиол бөгөөд, Фаустын тухай олон жүжиг, уран зураач нарын зураг, дуурь мэт зүйл байдаг. Праг хотод, энэхүү Фаусттай холбогдолтой домог бүхий байшин байсныг Йираасек үүнээ өгүүлжээ.